



УУР АМЬСГАЛЫН
ӨӨРЧЛӨЛТИЙН
ТАЛААРХ
МОНГОЛЧУУДЫН
МЭДЛЭГ, ХАНДЛАГА,
ДАДАЛ БОЛОН
МЭДЭЭЛЛИЙН
ХЭРЭГЛЭЭНИЙ
СУДАЛГАА

2023 оны 6-р сар



БАЙГАЛЬ ОРЧИН,
АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ЯАМ





АГУУЛГА

ТАЛАРХАЛ VI

1

1. ТАНИЛЦУУЛГА 1

1.1 Үндэслэл 1

1.2. Зорилго 3

1.3. Ашигласан гол нэр томьёо 3

2

АРГА ЗҮЙ, АРГАЧЛАЛ 5

2.1. Судалгааны хамрах хүрээ ба гол асуултууд 5

2.2 Судалгааны дизайн ба мэдээлэл цуглуулах аргууд 10

2.3. Түүвэрлэлтийн арга зүй болон жинлэл 12

2.4. Тоон болон чанарын дүн шинжилгээ 13

2.5. Техникийн зөвлөгөөн 14

2.6 Хүрээ ба хязгаарлагдмал тал 14

3

НӨХЦӨЛ БАЙДАЛ 16

3.1. Уур амьсгалын өөрчлөлтийн өнөөгийн нөхцөл байдал 16

3.2 Уур амьсгалын өөрчлөлтийн бодлого, байгууллагын зохицуулалт 19

3.3. Судалгааны хүрээнд тодорхойлсон эмзэг байдал 23

4

УУР АМЬСГАЛЫН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЛААРХ ОЙЛГОЛТ, МЭДЛЭГ 29

4.1 Цаг агаар, байгаль орчинд ажиглагдсан өөрчлөлтүүд 30

4.2 Хүмүүсийн дундах уур амьсгалын өөрчлөлтийн тухай ойлголтууд 33

4.3 Уур амьсгалын өөрчлөлтийг бий болгож буй хүчин зүйлийн талаарх ойлголт 36

Зохиогчийн эрх хамгаалагдсан © 2023 оны 5 дугаар сар

Даян дэлхийн ногоон хөгжлийн институт

Чеондонги Барилга, 19 давхар, 21-15

Чеондонги гудамж, Жунгу хороолол, Сөүл хот, БНСУ 100-784

Даян дэлхийн ногоон хөгжлийн институт нь энэхүү тайланд тусгагдсан аливаа мэдээлэл, материал хэрэгсэл, бүтээгдэхүүн, үйл явцын үнэн зөв байдал, бүрэн бүтэн байдал, эсвэл дээрх дурдагдсан зүйлсийн гуравдагч этгээдийн ашигласан байдал, түүнээс гарах үр дүнгийн талаар шууд болон далд хэлбэрээр ямар нэгэн баталгаа гаргахгүй бөгөөд хууль ёсны хариуцлага хүлээхгүй.

Энд байгаа мэдээллийг задруулах буюу ашиглах нь хувийн өмчийн эрхийг зөрчөөгүй болохыг илтгэнэ. Энд дурдсан зохиогчдын үзэл бодол, байр суурь нь Даян дэлхийн ногоон хөгжлийн институтийн байр суурийг илэрхийлэх эсвэл тусгах шаардлагагүй болно

5

УУР АМЬСГАЛЫН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЛААРХ ХАНДЛАГА

42

- 5.1 Уур амьсгалын өөрчлөлт, түүний үр дагавартай холбоотой асуудлууд 44
- 5.2 Хамгийн ихээр санаа зовоож буй гол асуудлууд 46

6

БАЙГАЛЬ ОРЧИН, УУР АМЬСГАЛЫН ӨӨРЧЛӨЛТТЭЙ ХОЛБООТОЙ ДАДЛУУД

49

- 6.1 Байгаль орчин, цаг агаар болон нөөцөд гарч буй өөрчлөлтүүдэд хариу арга хэмжээ авахад чиглэсэн даван туулах стратеги 50
- 6.2 Уур амьсгалын өөрчлөлтийн үр нөлөөг бууруулах дадлууд 53
- 6.3 Уур амьсгалын өөрчлөлтөд арга хэмжээ авах эрмэлзэл 56

7

СЕГМЕНТИЙН ШИНЖИЛГЭЭ

59

- 7.1 Үндсэн бүрэлдэхүүн хэсгүүдийн шинжилгээ (PCA) 57
- 7.2 Энгийн хамгийн бага квадратын үнэлгээ 59

8

ХЭРЭГЖҮҮЛЭХ ШААРДЛАГАТАЙ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТАЛААРХ ОРОЛЦОГЧ ТАЛУУДЫН ХҮЛЭЭЛТ

62

- 8.1 Уур амьсгалын өөрчлөлт нэн тулгамдсан асуудал болох нь 62
- 8.2 Хариуцлага хүлээж буй байгууллага, институт 64
- 8.3 Уур амьсгалын өөрчлөлтийг бууруулахад чиглэсэн Засгийн газраас хэрэгжүүлж байгаа арга хэмжээний талаарх судалгаанд оролцогчдын үзэл бодол 67
- 8.4 Монгол дахь итгэлцэл, хамтын үйлийн тухай ойлголт 70

9

УУР АМЬСГАЛЫН ӨӨРЧЛӨЛТИЙГ ТҮГЭЭН ДЭЛГЭРҮҮЛЭХ БЭЛЭН БАЙДАЛ БОЛОН ЧАДВАРЫН ХЭРЭГЦЭЭНИЙ ТАЛААРХ ОРОЛЦОГЧ ТАЛУУДЫН ҮЗЭЛ БОДОЛ

75

- 9.1 Уур амьсгалын өөрчлөлтийг түгээн дэлгэрүүлэх бэлэн байдлын талаарх оролцогч талуудын үнэлгээ 75
- 9.2 Оролцогч талуудын уур амьсгалын өөрчлөлттэй холбоотой гүйцэтгэж буй гол үйл ажиллагаа, санаачилга 82
- 9.3 Оролцогч талуудыг чадваржуулах хэрэгцээ 84

10

ЕРӨНХИЙ БОЛОН БАЙГАЛЬ ОРЧНЫ ТУХАЙ ХЭВЛЭЛ МЭДЭЭЛЛИЙН ХЭРЭГЛЭЭ

87

- 10.1 Хэвлэл мэдээллийн ерөнхий хэрэглээ 87
- 10.2 Хэвлэл мэдээллийн хэрэгсэлд итгэх итгэл болон буруу ташаа мэдээлэл 93
- 10.3-Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлттэй холбоотой хэвлэл мэдээллийн хэрэглээ 95

11

ХҮН АМЫН БҮЛГҮҮДИЙН МЭДЛЭГИЙГ ДЭЭШЛҮҮЛЭХ СТРАТЕГИ БОЛОН ГОЛ ОРОЛЦОГЧИД

102

- 11.1 Олон нийтэд чиглэсэн стратеги төлөвлөгөө 104
- 11.2 Гол оролцогч талуудын чадварыг бэхжүүлэх стратеги төлөвлөгөө 113

ХАВСРАЛТУУД

120

ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

БОАЖЯ	Байгаль Орчин, Аялал Жуулчлалын Яам
ГЯ	Ганцаарчилсан ярилцлага
ДДНХИ	Даян Дэлхийн Ногоон Хөгжлийн Институт
ЗД	Засаг дарга
ЗДТГ	Засаг даргын тамгын газар
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал
МУЗГ	Монгол Улсын Засгийн Газар
НҮБ	Нэгдсэн Үндэсний Байгууллага
НҮБУАӨСК	НҮБ-ын Уур амьсгалын өөрчлөлтийн суурь конвенц
ОБЕГ	Онцгой Байдлын Ерөнхий Газар
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
ТББ	Төрийн бус байгууллага
УАНС	Уур Амьсгалын Ногоон Сан
УАӨ	Уур амьсгалын өөрчлөлт
УАӨСХАТ	Уур амьсгалын өөрчлөлтийн судалгаа, хамтын ажиллагааны төв
УЦУОСМХ	Ус цаг уур, орчны судалгаа, мэдээллийн төв
ҮТХН	Үндэсний тодорхойлсон хувь нэмэр
ФБЯ	Фокус бүлгийн ярилцлага
ХАА	Хөдөө аж ахуй
ЦУОШГ	Цаг Уур, Орчны Шинжилгээний Газар
IRIM	Хараат Бус Судалгааны Хүрээлэн

ТАЛАРХАЛ

Энэхүү судалгааны ажлын хүрээг тодорхойлох болон судалгаа хийх үйл явцыг зохион байгуулах бүхий л үе шатанд ерөнхий удирдамж, чиглүүлэг, үнэ цэнтэй зөвлөгөө өгч, дэмжлэг үзүүлж байсан Даян Дэлхийн Ногоон Хөгжлийн Институтийн (ДДНХИ) Монгол дахь суурин төлөөлөгч Аннака Петерсон, Хөтөлбөрийн ахлах ажилтан Энхбаярын Баярмаа нарт судалгааны багийнхан талархал илэрхийлж байна. Мөн, судалгааны хэвлэл мэдээллийн хэрэглээний хэсгийг боловсруулахад үнэ цэнтэй дэмжлэг үзүүлсэн ДДНХИ-ийн төв байгууллагын Мэдээлэл-Олон нийттэй харилцах хэлтсийн дарга Мона Лакзо, Монгол дах хөтөлбөрийн Төсөл хөгжүүлэлт, хяналт шинжилгээ үнэлгээ хариуцсан ажилтан Хён Лим Со нарт талархал илэрхийлье.

Судалгааны бэлтгэл ажлаас хэрэгжүүлэх шат хүртэл чухал дэмжлэг үзүүлсэн БОАЖЯ-ны Уур амьсгалын өөрчлөлт, бодлого төлөвлөлтийн газрын дарга Шагдарсүрэнгийн Цэрэндулам, Уур амьсгалын өөрчлөлт, судалгаа, хамтын ажиллагааны төвийн дарга Баярын Эрдэнэчимэг, техникийн зөвлөгөөн болон эцсийн тайланд үнэтэй санал, шүүмж өгсөн ҮТХН-ийн чиглүүлэгч Мижидсүрэнгийн Сүхрагчаа нарт талархал илэрхийлье.

Мөн, уур амьсгалын өөрчлөлтийн тухай үндсэн ойлголт, холбогдох бодлогын талаарх сургалтыг судлаачдад зориулан зохион байгуулж, судалгааны эхний шатанд үнэ цэнтэй олон санал, зөвлөгөө өгч байсан Уур амьсгалын өөрчлөлтийн судалгаа, хамтын ажиллагааны төвийн төслийн зохицуулагч Хүрэлбаатарын Ундармаа, зөвлөх Замбын Батжаргал, БОАЖЯ-ны Уур амьсгалын өөрчлөлтийн мэргэжилтэн Алтангэрэлийн Нарангаравуу нарт талархал илэрхийлж байна.

Олон нийттэй ярилцаж, чанартай мэдээлэл цуглуулсан судлаачид, тэдний зохицуулагч нар болон судалгаанд сонгогдож, өөрсдийн түүх, туршлагаасаа хуваалцсан орон нутгийн иргэд, олон нийтэд чин сэтгэлээсээ талархаж байна. Монгол оронд төдийгүй, өөр өөрийн салбарт

тулгарч буй уур амьсгалын өөрчлөлттэй холбоотой асуудлуудыг ойлгуулахад цаг хугацаа зарцуулж, туршлага, үзэл бодлоо хуваалцан ярилцсан үндэсний болон орон нутгийн түвшний төрийн байгууллага, судалгааны хүрээлэн, иргэний нийгмийн бүх байгууллагын ажилтан, албан хаагчдад талархал илэрхийлж байна. Түүнчлэн, судалгааны дизайн боловсруулахад үнэ цэнтэй саналууд өгсөн IRIM судалгааны хүрээлэнгийн төлөөлөл болох Лхагвын Цэлмэгсайхан (Гүйцэтгэх захирал), Ганзоригийн Жаргалмаа (Үйл ажиллагааны захирал), Цэдэндамбын Батсугар (Зөвлөх), Нямсүрэнгийн Янжинпагма (Ахлах судлаач) нарт талархал илэрхийлье.

СУДАЛГААНЫ БАГ

Алдарын Долгион (Багийн ахлагч), Түмэнжаргалын Элбэрэл (Ахлах судлаач), Цогтбаатарын Гэрэлт-Од (УАӨ-ийн бодлогын зөвлөх), Гантулгын Ариунзул (Хэвлэл мэдээллийн зөвлөх), Баяржаргалын Мөнх-Ирээдүй (Дата судлаач), Лхагваноровын Дашзэвэг (Ахлах судлаач), Пүрэвдоржийн Цэдэн-Иш (судалгааны зохицуулагч), Дашнямын Номуунбилэг (Туслах судлаач)

IRIM судалгааны хүрээлэнгийн дата багт Алтансүхийн Очбадрал (Дата менежер), Болдын Болор (Дата судлаач) нар, Мэдээлэл цуглуулах дэмжих багийн бүрэлдэхүүнд Эрдэнэбатын Цэрэндорж (Менежер), Баянбатын Шинэцэцэг (Менежер) болон Төмөрхүүгийн Бямбацэрэн (Чанарын хяналтын менежер) нар тус тус ажиллав. Тайлангийн Монгол эхийг доктор Баатарын Хурцтуяа хянан тохиолдуулав.

ХУРААНГУЙ

Нөхцөл байдал

Уур амьсгалын өөрчлөлт ирэх хэдэн арван жилийн хугацаанд эрчимжих төлөвтэй байгаа бөгөөд энэ нь хүн, байгалийн харилцаа хамаарал, зүй тогтолд ихээхэн нөлөөлөхөөр байна.¹ Ялангуяа, Монгол оронд уур амьсгалын өөрчлөлтийн нөлөө ихсэж, цөлжилт, усны хомсдол, хур тунадасны хэмжээ өөрчлөгдөх, цаг агаарын эрс тэс үзэгдлүүдийн давтамж нэмэгдэх зэрэг үзэгдэл аль хэдийн үүсээд байгаа билээ. Сүүлийн 80 жилийн хугацаанд Монгол орны жилийн дундаж температур 2.25°С-аар нэмэгдсэн.² Хүн ам, тэр дундаа эмзэг бүлгийнхэн уур амьсгалын өөрчлөлтөд өртөөд зогсохгүй, түүний нөлөөгөөр бий болсон гамшиг, эрсдэлд тэсвэрлэн үлдэх, хариу арга хэмжээ авах чадвар нь хязгаарлагдмал байгаагийн улмаас ихээхэн хохирол амсаж болзошгүй байна.

Нийт хүн ам, гол оролцогч талууд, мөн бодлого боловсруулагчдын зүгээс үр нөлөө бүхий үйл ажиллагаануудыг дэмжсэнээр Монголын уур амьсгалын өөрчлөлтийг сааруулах, дасан зохицох бодлогын зорилтууд амжилттай хэрэгжиж, тогтвортой байж чадна. 2019 онд Уур Амьсгалын Өөрчлөлтийн тухай НҮБ-ын Суурь Конвенцод тайлагнасан Монгол Улсын Үндэсний Хэмжээнд Тодорхойлсон Хувь Нэмрийн,³ зорилтод уур амьсгалын өөрчлөлтөд эмзэг бүлгийг нэн тэргүүнд хамгаалах, уур амьсгалаас үүдэлтэй эрсдэлд хариу үйлдэл үзүүлэх олон нийтийн чадварыг нэмэгдүүлэх нь нэг зорилт болох тухай дурдсан байдаг. Гэвч, хүн ам болон эмзэг бүлгүүдийн дунд энэ талаарх мэдлэгийг нэмэгдүүлэх, эерэг хандлага, дадал хэвшлийг бий болгох ямар боломж байгааг тодорхойлсон судалгаа Монгол Улсад дутмаг байна.

Байгаль орчин, аялал жуулчлалын яам (БОАЖЯ), Уур амьсгалын өөрчлөлтийн судалгаа, хамтын ажиллагааны төв (УАӨСХАТ)-өөс захиалсны дагуу, Хараат бус судалгааны хүрээлэн (IRIM) нь энэхүү “Монгол дах уур амьсгалын өөрчлөлтийн талаарх мэдлэг, хандлага ба хэвлэл мэдээллийн

^[1] Ategeka, John, and others, Хөгжиж буй орны хөгжил болон байгаль орчны талбар дах зан төлөвийн шинжлэх ухааны нөлөөллийн үйл ажиллагаа: 2022.

^[2] БОАЖЯ, Парисын хэлэлцээрийг хэрэгжүүлэх үндэсний тодорхойлсон хувь нэмрийн зорилт, 2020

^[3] БОАЖЯ, UNFCCC, Үндэсний тодорхойлсон хувь нэмэр, 2019

хэрэгслийн хэрэглээний судалгаа” (Цаашид “Судалгаа” гэх)-г ДДНХИ-ийн санхүүжилтээр хийж гүйцэтгэлээ. Энэхүү судалгааны зорилго нь нийт хүн ам, тэр дундаа нийгмийн эмзэг бүлгийнхний уур амьсгалын өөрчлөлттэй холбоотой ойлголт, мэдлэг, хандлага, дадал, мөн хэвлэл мэдээллийн хэрэгслийн хэрэглээг үнэлэхэд оршино. Судалгааны үр дүнг үндэсний болон орон нутгийн бодлогод уур амьсгалын өөрчлөлтийн асуудлыг тусгах, олон нийтийн ойлголт, мэдлэг, чадварыг сайжруулах үндэсний хэмжээний олон нийтийг хамарсан үйл ажиллагааны стратеги төлөвлөгөө боловсруулахад ашиглах юм. Тиймээс юуны түрүүнд, иргэдийн цаг агаар, байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлттэй холбоотой ажиглалтууд, уур амьсгалын өөрчлөлтийн шалтгаан, үр дагаврын талаарх ойлголтууд, санаа зовж буй асуудлууд гэх мэт ерөнхий ойлголт, мэдлэг, хандлагын асуудлуудыг тусгасан. Хоёрдугаарт, судалгаа нь төрийн болон төрийн бус оролцогч талуудын чадварыг бэхжүүлэх хэрэгцээ, уур амьсгалын өөрчлөлтийг сааруулах, дасан зохицоход чиглэсэн хувь хүн, нийгмийн бүлгүүд, үндэсний түвшинд шаардлагатай нэн тэргүүний зорилт, үйл ажиллагааг тодорхойлон гаргасан. Гуравдугаарт, иргэдийн уур амьсгалын өөрчлөлттэй холбоотой мэдээллийн хүртээмж, мэдлэг олгох үр дүнтэй олон нийтийг хамарсан үйл ажиллагааны стратеги төлөвлөгөө боловсруулахад түлхүү анхаарсан болно.

Арга зүй

Энэхүү судалгаа нь холимог арга бүхий, туршилтын бус, хөндлөн огтлолын судалгаа юм. Судалгааны түүврийн загварчлал нь үндэсний хэмжээг төлөөлөхүйц байхаар боловсруулагдсан бөгөөд бүх бүсийн төлөөллийг хамруулсан. Судалгааг Улаанбаатар хот болон 13 аймгийн 2804 (үүнээс 51.9% нь эмэгтэй, 48.1% нь эрэгтэй) иргэнээс 2022 оны 9-өөс 11-р сарын хооронд биечилсэн байдлаар цуглуулсан. Судалгааны талбарууд болон судалгаанд оролцогчдыг сонгохдоо давхраат, олон үе шаттай кластер түүврийн аргыг хэрэглэсэн.

Нийт 49 гол оролцогч талуудыг үндэсний болон орон нутгийн засаг захиргаа, төрийн бус байгууллага, эрдэм шинжилгээний байгууллага, хэвлэл мэдээлэл, хувийн хэвшлийн салбараас зорилтот байдлаар сонгосон. Ярилцлагаар, эрэлт

хэрэгцээ, удирдлага, нөөц бололцоо, техникийн чадвар, байгууллагын удирдлага зохион байгуулалт зэрэг уур амьсгалын өөрчлөлтийг түгээн дэлгэрүүлэхэд нөлөөлөхүйц асуултуудыг тавьсан юм. Эрэгтэй, эмэгтэй, залуу, ахмад настан, малчин, газар тариаланч, үндэстний цөөнх болон уул уурхайн нөлөөллийн бүс нутаг, алслагдсан хилийн бүс нутгийн иргэд зэрэг олон төлөөллийг хамруулсан фокус бүлгийн ярилцлагыг 9 удаа зохион байгуулсан.

Түүнчлэн, уур амьсгалын өөрчлөлтийн талаарх ойлголт, мэдлэг, мэдээллийн хэрэгцээ, мэдээлэл боловсруулах чадвар зэрэгт нийгэм, эдийн засгийн байдал хэрхэн нөлөөлж буйг судалсан. Ингэхдээ уур амьсгалын өөрчлөлтөөс үүдэн эдийн засгийн гачигдал, эрүүл мэндийн асуудал, нийгмийн тусгаарлалтад өртөх эрсдэл өндөртэй хүмүүсийн шинж чанар болон тоог хэмжих эмзэг байдлын индексийг боловсруулж ашигласан. Индекс боловсруулахдаа өндөр настай, хөгжлийн бэрхшээлтэй, архаг өвчтэй, орлого багатай, боловсролын түвшин доогуур, шилжилт хөдөлгөөн, амьжиргаа нь уур амьсгалын өөрчлөлтөөс хамааралтай, өртөмтгий байдал зэрэг нийт 13 шинж чанарыг үндэслэсэн. Индексийг ашиглахдаа судалгаанд оролцогчдыг “эмзэг байдал бага”, “эмзэг байдал өндөр” гэсэн хоёр бүлэгт хувааж, харьцуулсан дүн шинжилгээ хийсэн.

Судалгааны мэдлэг, хандлага, дадал (КАР) гэсэн бүрэлдэхүүн хэсэгт уур амьсгалын өөрчлөлтийн талаарх нийт асуултад өгсөн зөв, эерэг хариултуудыг ашиглан КАР индексийг гаргасан (мэдлэг-10 асуулт, хандлага-15 асуулт; дадал-9 асуулт). Энэхүү индексийг хувь хүмүүсийн мэдлэгийг “сайн”, “хангалтгүй” гэж оноож, хандлагыг “эерэг”, “сөрөг” гэж үнэлэхээс илүүтэй мэдлэг, хандлага, зан үйлд нөлөөлөх гол хүчин зүйлсийг тодорхойлоход голчлон ашиглав.

Гол үр дүнгүүд

Эмзэг байдлын индексийг тооцож үзэхэд, судалгаанд оролцогчдын 1313 (46.8%) нь “эмзэг” бүлэгт багтаж байна. Эмзэг бүлгүүдийн дунд хэд хэдэн эмзэг байдлын шинж байгаа нь судалгаагаар илэрсэн. Жишээлбэл, бага орлоготой хүмүүсийн ихэнх нь эмэгтэй (62.1% эмэгтэй, 37.9% эрэгтэй); хадгаламжгүй (61.9%); дунд, түүнээс доош боловсролтой, хөдөө

орон нутагт юм уу, хотын гэр хороололд амьдардаг иргэд байна. Тиймээс мэдлэг, чадварыг нэмэгдүүлэх олон нийтийг хамарсан үйл ажиллагаа зохион байгуулахдаа дээрх эмзэг бүлгийн хэрэгцээ, тулгамдсан асуудлыг чухалчлан харгалзан үзэх хэрэгтэй.

Ойлголт, мэдлэг, хандлага, дадал

Монголчуудын уур амьсгалын өөрчлөлтийн талаар ойлголт харьцангуй сайн (67.3% нь уур амьсгалын өөрчлөлтийн талаар сонссон) байна. Бараг тал хувь нь уур амьсгалын өөрчлөлт сүүлийн 10 жилд тэдний амьдрал, амьжиргаанд нөлөөлсөн гэж хариулсан байна (46.6%). Мөн, судалгаанд оролцогчдын ихэнх нь уур амьсгалын өөрчлөлтийн гол шалтгаан нь хүний буруутай үйл ажиллагаа болохыг бүрэн хүлээн зөвшөөрч байна (84.0%). Гэсэн хэдий ч хот, хөдөөгийн аль алинд уур амьсгалын өөрчлөлтийн талаарх иргэдийн мэдлэг, хандлага, дадал тааруу байна. Тухайлбал, судалгаанд оролцогчдын ердөө 23.6% нь уур амьсгалын өөрчлөлтийн талаарх мэдлэгээ хангалттай гэж үнэлж, 6.8% нь уур амьсгалын өөрчлөлтөд аж үйлдвэржсэн орнууд нөлөөлж байгаа тухай дурдсан байна. Харин 35.9% нь Монголын иргэд өөрсдөө уур амьсгалын өөрчлөлтийг бий болгож байна гэж үзжээ. Байгалийн гамшиг, уур амьсгалын өөрчлөлтөд нөлөөлөгч гол зүйлс нь үйлдвэрлэлийн буруу үйл ажиллагаа, ой мод огтолж тайрах, хог хаягдлын буруу менежмент зэрэг аж ахуйн нэгж болон иргэдийн сонголт, үйл ажиллагаанаас хамаарсан зүйлс болохыг дурдаж байлаа. Мөн, таван хүн тутмын нэг нь (22.5%) уур амьсгалын өөрчлөлт бол далдын хүч, байгаль эх шийтгэж буй дохио гэж үзэж байна.

Уур амьсгалын өөрчлөлт нь ноцтой асуудал болохыг Монголчууд ухамсарлаж байгаа бөгөөд судалгаанд оролцогчдын 92.7% нь уг асуудалд санаа зовниж, цаашид хэвлэл мэдээллийн хэрэгслээр (85.1%) энэ талаар илүү их мэдээлэл авах сонирхлоо илэрхийлж байсан. Уур амьсгалд нөлөөлөгч эдгээр зүйл цаашид үргэлжилбэл тэдний амьжиргаанд сөргөөр нөлөөлнө гэж хариулжээ. Ялангуяа, байгаль

орчин (51.6%), нийгмийн эрүүл мэнд (38.6%), мал аж ахуй болон газар тариалангаар дамжин амьжиргаанд нөлөөлөхийн (31.0%) зэрэгцээ, эрчим хүчний зардал нэмэгдсэнээр (20.3%) хүнсний аюулгүй байдалд заналхийлж (19.1%), улс орны хэмжээнд эдийн засгийн томоохон асуудлууд бий болоход ихээр нөлөөлнө. Мөн уур амьсгалаас үүдэлтэй шилжилт хөдөлгөөн, залуучуудын боловсролын хүртээмжгүй байдал, шилжилт хөдөлгөөнөөс үүдэлтэй гэр бүлийн гишүүд тусдаа амьдрах байдал (13.5%) зэрэг нийгмийн сөрөг үзэгдлийг дурдсан байна. Гэхдээ судалгаанд оролцогчид уур амьсгалын өөрчлөлт болон нийгэм-эдийн засаг, байгаль орчны гэх мэт бусад асуудал хоорондын хамаарлын талаарх ерөнхий ойлголт харьцангуй бага байсан юм (асуулгад оролцогчдын 13.5% нь уур амьсгалын өөрчлөлтийг нийгэм, 20.3% нь эдийн засаг, 51.6% нь байгаль орчны асуудалтай холбож тайлбарласан).

Судалгаанд оролцогчид уур амьсгалын өөрчлөлтийг ноцтой асуудал мөн гэж үзэн, санаа зовниж байгаа хэдий ч, өөрсдөөс нь хамааралгүй хол болж байгаа зүйл гэж үзэх хандлага хүчтэй байсан бөгөөд уур амьсгалын өөрчлөлтийн сөрөг нөлөөлөл байгаа (78.6%) боловч энэ нь ойрын ирээдүйд тохиолдохгүй (67.1%) гэж үзсэн байна. Энэ нь уур амьсгалын өөрчлөлтийн одоо бий болоод байгаа, цаашид тохиолдох үр нөлөөний талаарх мэдээлэл дутмаг байгаатай холбоотой төдийгүй, хүмүүсийн амьдралд эрүүл мэнд (бүх судалгаанд оролцогчдын 50.7% нь эрүүл мэндийг гол 3 асуудлын нэг гэж нэрлэсэн), ажлын байр (46.6%), орлого (46.6%, 44.3%), агаарын бохирдол (46.0%) зэрэг нэн тулгамдсан бусад асуудал байгаатай холбоотой юм. Тиймээс, хүн амын ихэнх нь байгалийн гамшиг, уур амьсгалын өөрчлөлтөөс үүдэлтэй урт хугацааны бусад нөлөөллөөс өөрсдийгөө хамгаалахын тулд идэвхтэй эрэл хайгуул хийж, урьдчилан сэргийлэх арга хэмжээ авахгүй байна.

Судалгаанд оролцогчдын ихэнх нь уур амьсгалын өөрчлөлтийн талаар ойлголттой, харьцангуй эерэг хандлагатай байсан ч, дөрөвний нэг хүрэхгүй хувь нь л гамшгаас хамгаалах арга хэмжээ авсан байна (76.9% нь сүүлийн хэдэн жилд ямар ч арга хэмжээ аваагүй). Гамшгаас хамгаалах, урьдчилан сэргийлэх арга хэмжээ авсан иргэдийн ихэнх нь өмнө нь гамшигт өртөж байжээ. Цаашилбал, ердөө цөөн тооны хүмүүс (9.9%) уур амьсгалын өөрчлөлтийн үр дагаврыг

шийдвэрлэхэд чиглэсэн стратегийн талаар мэддэг гэж хариулжээ. Энэ нь Монголчуудад өөрийгөө, өрх гэрээ, олон нийтийг хамгаалахад шаардлагатай мэдлэг дутмаг байгааг харуулж байна.

Ихэнх хүмүүс уур амьсгалын өөрчлөлт нь ус, цахилгааны хэрэглээ, нүүрс түлэх зэрэг өдөр тутмын үйлдлээс үүдэлтэй гэж үзэж байна. Гэсэн хэдий ч, судалгаанд хамрагдсан эмзэг бүлгийнхэн гэр бүлээ тэжээхийн тулд нүүрс түлж халаалтын зардал хэмнэх, байшингаа дулаан байлгахын тулд цахилгааны төлбөр их төлөх, нялх хүүхдүүдээ дулаацуулахын тулд цахилгаан тень тавих нь тэдэнд хүндээр тусдаг болохыг илэрхийлжээ. Энэ нь мэдлэг, хандлага, дадлын түвшин доогуур, эмзэг бүлгийнхэн ихэвчлэн амьдардаг, хотын гэр хороолол болон хөдөө орон нутгийн өрхүүдийн хувьд хоёрдмол байдлыг бий болгож байна.

Хүмүүсийн ойлголт, мэдлэг, хандлага, дадлын түвшинд тухайн хүмүүсийн нас, оршин суудаг байршил, боловсролын түвшин (ялангуяа мэдлэгийн хувьд) болон эмзэг байдлаас хамаарсан мэдэгдэхүйц ялгаа байна. Хүйсээс хамаарсан зарим ялгаа ажиглагдсан ч статистикийн хувьд ач холбогдолгүй байна.

- Уур амьсгалын өөрчлөлтийн талаарх ойлголт, дадлын хувьд эмэгтэйчүүд, эрчүүд хоорондын ялгаа харьцангуй бага байна. Гэхдээ, эрчүүдээс илүү эмэгтэйчүүд нь уур амьсгалын өөрчлөлтөд санаа зовж байсан. Тэд уур амьсгалын өөрчлөлт амьдралд нь тодорхой хугацаанд нөлөөлдөгт итгэж байгаа учраас тэр талаарх нэмэлт мэдлэг, үр чадвар эзэмшихийг хүсэж буйгаа илүү их илэрхийлжээ. Эмэгтэйчүүд уур амьсгалын өөрчлөлтөд илүү санаа зовдог ч, тэр талаарх тэдний субъектив үнэлгээ илүү доогуур, цаашид уур амьсгалын өөрчлөлтийн талаарх мэдлэг, үр чадвар эзэмших хүсэл нь илүү өндөр байна. Өдөр тутмын дадлын тухайд эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн туршлага ихээхэн ялгаатай байв. Эмэгтэйчүүдийн хувьд дахин ашиглах боломжтой бүтээгдэхүүн хэрэглэх, усны цорго хаах, цахилгаан хэрэгслийг салгах, нэг удаагийн хуванцар бүтээгдэхүүн бага хэрэглэх зэргээр байгаль орчныг хамгаалах өдөр тутмын дадлыг сурталчлахад илүү эерэг үүрэг гүйцэтгэж байна. Улмаар, эмэгтэйчүүд уур амьсгалын өөрчлөлтөөс

бий болох хохирлоос урьдчилан сэргийлэх, нөлөөг бууруулахын тулд зохих арга хэмжээ авах талаар мэдлэг, байгалийн гамшгаас өөрсдийгөө хамгаалахын тулд урьдчилан сэргийлэх арга хэмжээ авсан туршлага бага байна.

- 18-24 насны залуучууд бусад насныхантай харьцуулахад “уур амьсгалын өөрчлөлт” гэсэн нэр томъёог илүү сонсож, уур амьсгал өөрчлөгдөж байгаад илүү итгэж байна. Гэхдээ, тэд уур амьсгалын өөрчлөлтөд хамгийн бага санаа зовж байгаа бөгөөд уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох талаарх нэмэлт мэдлэг, үр чадвар эзэмших сонирхол бага байна. Тун бага хувь нь уур амьсгалын өөрчлөлтийг улс орны тулгамдсан асуудал гэж үзэж байна. Энэ нь тэднийг улс орны бодлогод нөлөөлөх дараа үеийн сонгогчид болохынх нь хувьд онцолж, хандлагыг нь өөрчлөх чухал шаардлага байгааг харуулж байна.
- Боловсрол болон орлогын түвшин: Судалгаанд оролцогчдоос, боловсролын түвшин доогуур хэсгийнхний дунд “уур амьсгалын өөрчлөлт”, “хүлэмжийн хийн ялгарал” зэрэг шинжлэх ухааны, сүүлийн үеийн нэр томъёог мэдэж буй хувь харьцангуй бага байна. Түүнчлэн, боловсролын түвшин доогуур байх тусмаа эмзэг бүлэгт хамаарагдах магадал өндөр бөгөөд “уур амьсгалын өөрчлөлтийн талаар хэзээ ч сонсож байгаагүй” гэж хариулсан хувь өндөр байх хандлагатай байна. Тиймээс боловсролын түвшин доогуур, орлого багатай судалгаанд оролцогчдын хувьд, байгаль орчны өөрчлөлтийг уур амьсгалын өөрчлөлттэй холбож ойлгох, уур амьсгалын өөрчлөлтийн амьжиргаанд нөлөөлөх нөлөөг ойлгохгүй байх магадлал өндөр байна. Тэд уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох, даван туулах, урьдчилан сэргийлэхийн тулд зохистой арга хэмжээ авах, уур амьсгалын өөрчлөлтийн учруулах хохирлыг бууруулах талаарх чадвараа бага хэмээн үнэлж байна.
- Хөдөө, орон нутгийн иргэдийн уур амьсгалын өөрчлөлтийн шалтгаан, үр дагаврын талаарх мэдлэг бага, дэлхий дахин болон Монголд уур амьсгалын өөрчлөлт болохгүй гэдэгт

итгэх магадлал өндөр байна. Хэдийгээр тэд байгалийн янз бүрийн өөрчлөлтийг илүү анзаарч, байгалийн гамшигт илүү их өртөж байсан ч, энэ нь ихэвчлэн арван жилийн мөчлөгөөр тохиолддог байгалийн үзэгдэл гэдэгт итгэх хандлагатай байна. Гэхдээ, тэд байгаль орчны өөрчлөлтийн сөрөг нөлөө, тэр дундаа, амьжиргаанд нь ихээхэн нөлөөлж байгаагаас улирлын шинж чанарын өөрчлөлтөд илүү санаа зовж байна. Мөн, уурын амьсгалын өөрчлөлтийн талаар мэдээллийг хэвлэл мэдээллийн хэрэгслээс авах хүсэл эрмэлзэл их байна.

Уур амьсгалын өөрчлөлтийн талаар авах арга хэмжээ

Судалгаанд оролцогчид, бизнес эрхлэгч болон иргэдийг уур амьсгалын өөрчлөлтөд нөлөөлөгч гол хоёр тал (38.3% ба 35.9%) гэж үзэж байна. Тэдний ихэнх нь аж үйлдвэр, бизнесийн байгууллагууд уур амьсгалын өөрчлөлтөд хамгийн их нөлөөлдөг гэж тодорхойлсон ч, дөнгөж 9.8% нь үүнийхээ төлөө хариуцлага хүлээх ёстой гэж хариулсан байна.

Уур амьсгалын өөрчлөлттэй холбоотой асуудлыг шийдвэрлэх тухайд, судалгаанд оролцогчдын ихэнх (62.9%) нь Монгол Улсад уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөг бууруулахад чиглэсэн үйл ажиллагааг хэрэгжүүлэх нь Монгол Улсын Засгийн газар (МУЗГ), түүний дотор орон нутгийн засаг захиргаанаас ихээхэн хамаарна гэж үзжээ. Эрүүл мэнд, агаарын бохирдол, эдийн засгийн асуудлууд нь хүмүүсийн санааг хамгийн ихээр зовоож байна. Цаг агаар, байгаль орчин, байгалийн нөөцөд гарч буй өөрчлөлтийн нөлөө илүү урт хугацаанд ихсэж, байгаль орчин, эрүүл мэнд, хөдөө аж ахуй, эдийн засагт сөргөөр нөлөөлнө гэж үзэж байна.

Уур амьсгалын өөрчлөлтийг шийдвэрлэх үүрэг бүхий хоёр дахь чухал оролцогч талыг “Иргэд” (29.8%) гэж нэрлэсэн. Судалгаанд оролцсон хотын иргэдийн 33.1%, хөдөө орон нутгийн иргэдийн 23.9% нь уур амьсгалын өөрчлөлтийн асуудлыг иргэд өөрсдөө шийдвэрлэх ёстой гэж хариулсан байна. Судалгаанд оролцогчдын боловсролын түвшнээс шалтгаалсан мэдэгдэхүйц ялгаа ажиглагдаж байна. Тухайлбал, бага боловсролтой иргэдтэй харьцуулахад дээд боловсролтой хэсэг нь “Иргэд өөрсдөө арга хэмжээ авах шаардлагатай” гэж үзэх хандлагатай байна.

Нийт судалгаанд оролцогчдын ердөө 12.0% нь аж үйлдвэржсэн орнууд уур амьсгалын өөрчлөлтийг бий болгож байна, 6.8% нь тэдгээр орнууд уур амьсгалын өөрчлөлтийн асуудлыг шийдвэрлэх үүрэгтэй гэж үзжээ. Фокус бүлгийн ярилцлагын үр дүнгээс харахад, аж үйлдвэржсэн орнуудын уур амьсгалын өөрчлөлтөд үзүүлэх нөлөө, түүнийг шийдвэрлэх чадварын талаарх ойлголт дутмаг байгаа нь зарим иргэд уур амьсгалын өөрчлөлтийг зөвхөн үндэсний хэмжээнд авч үзэж байгаагаас харагдаж байсан. Энэ нь уур амьсгал өөрчлөгдөх шалтгааныг бууруулах хүчин чармайлтыг эрчимжүүлэхдээ, аж үйлдвэржсэн улс орон, үндэстэн дамнасан корпорацуудын гүйцэтгэх үүргийн талаарх иргэдийн дундах ойлголтыг нэмэгдүүлэх шаардлага байгааг харуулж байна.

Судалгаанд оролцогчдын бодлоор, Засгийн газраас авч хэрэгжүүлэх ёстой хамгийн түгээмэл арга хэмжээ бол эрчим хүчний хэмнэлт, сэргээгдэх эрчим хүч, мал аж ахуй, газар тариалангийн менежмент, хог хаягдлын менежмент болон байгаль орчныг хамгаалахтай холбоотой асуудлууд байна. Эдгээр арга хэмжээг онцлон сонгож буй байдал нь хот, хөдөөгийн судалгаанд оролцогчдын дунд ихээхэн ялгаатай байв. Хотын оршин суугчид эрчим хүч, хог хаягдал, тээврийн асуудлыг дурдсан бол, хөдөөгийн оршин суугчид мал аж ахуй, газар тариалан, байгаль орчныг хамгаалах арга хэмжээг түлхүү нэрлэжээ.

Хэвлэл мэдээллийн хэрэгслийн хэрэглээ ба харилцаа холбоо

Судалгаанд оролцогчдын хувьд улс төр, эдийн засаг, эрүүл мэнд, боловсрол, байгаль орчин зэрэг чухал сэдэвтэй холбоотой мэдээлэл авч буй үндсэн хоёр эх сурвалж нь зурагт (73.6%), интернэт (63.7%) болж байна. Ажлын хамт олон, орон нутгийн удирдлагууд зэрэг нүүр нүүрээ харсан харилцаа нь суурь мэдээлэл авах гурав дахь нийтлэг эх сурвалж болж байгаа ч, телевиз, интернэттэй харьцуулахад бага (8%) байна.

Судалгаанаас харахад, өдөр тутамд интернэт хэрэглэгчдийн тоо, зурагт хэрэглэгчдийн тооноос их байна (n=1212). Бусад төрлийн эх сурвалжтай харьцуулахад, өдөр тутамд хамгийн их ашиглагддаг эх үүсвэр нь интернэт (бүх санал асуулгад оролцогчдын 49.3% нь өдөр тутам интернэт ашигладаг) бөгөөд ерөнхий

мэдээлэл авахын тулд зурагт ашиглаж буй хувь нь интернэтээс бага (43.2% нь өдөр бүр ашигладаг) байна. Залуучууд, хотын хүн амын дунд интернэтийн хэрэглээ түгээмэл байна. Харин зурагт нь ахмад настан, хөдөө орон нутгийн иргэд, дунд боловсролтой хүн ам, гэр хорооллынхон зэрэг эмзэг бүлгийн иргэдэд мэдээллийн хамгийн хүртээмжтэй эх сурвалж нь болж байна. Гар утас нь бүх насны хүмүүст хүрэх хамгийн хүртээмжтэй төхөөрөмж болж байна. Судалгаанд оролцогчдын 99.1% нь өөрийн болон хэн нэгний утсыг “өдөр бүр”, “хааяа” ашигладаг гэж хариулжээ. Мэдээллийн эх сурвалжийн найдвартай байдлын хувьд, сургалт, уулзалт (87.3%), орон нутгийн удирдлага (83.6%), гэр бүл, найз нөхдийн (73.9%) дараа зурагтаас авсан (67.5%) мэдээлэл нь хамгийн найдвартайд тооцогдож байна. Интернэтэд итгэх итгэл хамгийн бага (29.8%) байна.

Уур амьсгалын өөрчлөлт, хэвлэл мэдээллийн хэрэгслийн хэрэглээний хувьд, судалгаанд оролцогчдын 44.1% нь “уур амьсгалын өөрчлөлт” юм уу, “дэлхийн дулаарал” гэсэн нэр томъёоны талаарх ямар нэгэн мэдээллийг хэвлэл мэдээллийн хэрэгслээр хүлээн авсан бол, 45.3% нь энэ талаар ямар нэг мэдээлэл аваагүй байна. Хот суурин газрынхантай харьцуулахад, хөдөө орон нутгийн иргэд уур амьсгалын өөрчлөлттэй холбоотой мэдээллийг илүү их авч байжээ. Энэ нь орон нутгийн иргэд хот суурин газрын иргэдээс илүү цаг агаарын мэдээнд анхаарал хандуулж, байгалийн үзэгдлийн өөрчлөлтийг анзаарч байдагтай холбоотой байж болно. Статистикийн хувьд ач холбогдолгүй ч, эрэгтэйчүүд эмэгтэйчүүдээс илүү (47.0%-эрэгтэйчүүд, 41.3%-эмэгтэйчүүд) мэдээлэл авчээ. Эдгээр үр дүнг мэдлэг, хандлага, дадлын нийт оноогоор харьцуулж үзвэл мэдээлэл хүлээн авсан хүмүүсийн мэдлэг, хандлагын түвшин өндөр байна. Энэ нь хэвлэл мэдээллийн хэрэгслээр мэдээлэл авах нь хүн амын мэдлэгийг нэмэгдүүлэх, эерэг хандлага төлөвшүүлэх үр дүнтэй арга байж болохыг харуулж байна.

Олон нийтийн хүртээл болсон хоёр гол эх сурвалж нь “Хүрээлэн” байгаль орчны баримтат нэвтрүүлэг, “Ногоон шошго” нэвтрүүлэг байна. Судалгаанд оролцогчдоос байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлттэй холбоотой хөтөлбөр, сүвгуудаас ямар нэгэн мэдээлэл авч байгаа эсэхийг тодорхойлохын тулд өмнө нь

мэдээлэл авч байсан эх сурвалжаа сонгохыг хүссэн. Дараагийн хоёр нийтлэг эх сурвалж нь Экологийн цагдаагийн газар болон Байгаль орчин, аялал жуулчлалын яамны албан ёсны фейсбүүк хуудас байна

Монгол дахь уур амьсгалын чиглэлээр хэрэгжүүлж буй арга хэмжээ, түгээн дэлгэрүүлж, нэвтрүүлэхтэй холбоотой оролцогч талуудын үзэл бодол

Оролцогч талуудтай хийсэн ганцаарчилсан ярилцлагаас харахад, төрийн албан хаагч болон хараат бус зөвлөхүүд уур амьсгалын өөрчлөлтийн нөлөө хийгээд тус тусын салбар дахь хариу арга хэмжээний талаар ерөнхий ойлголт, мэдлэг сайтай байна. Судалгаанд оролцогчдын ихэнх нь уур амьсгалын өөрчлөлт нь байгаль орчин, хөдөө аж ахуй, ойн аж ахуй, эрүүл мэнд зэрэг олон салбарт сөрөг нөлөө үзүүлж буй нэн тэргүүний анхаарах шаардлагатай сэдэв гэж үзэж байна. Тэд уур амьсгалын өөрчлөлтийн шалтгаан, нөлөө, үр дагаврын хоорондын уялдаа холбоог үндэсний болон дэлхийн дахины хэмжээнд ойлгож байна.

Цаашлаад, хүлэмжийн хийн ялгарал, түүнийг бууруулах арга хэмжээ, нүүрстөрөгчийн шингээлт болон багасгал, дасан зохицол зэрэг уур амьсгалын өөрчлөлттэй холбогдох гол нэр томъёонуудыг мэдэж байгаагаас гадна, Киотогийн протокол, Парисын хэлэлцээр зэрэг олон улсын тогтолцоог мэдэж байна.

Уур амьсгалын өөрчлөлтийн асуудлыг дээд түвшинд шийдвэрлэх нь илүү чухал болохыг бүх оролцогч илэрхийлж, ялангуяа Засгийн газрын зүгээс хариуцаж буй Байгаль орчин, аялал жуулчлалын яамнаас манлайлах, нэгдсэн бодлого хэрэгжүүлэх, уур амьсгалын өөрчлөлтийн хүчин чармайлтын хүрээнд дотоод, гадаад оролцогч талуудын хооронд уялдаа холбоог хангаж зохицуулах чиг үүрэгтэйг онцолсон байна. Цаашлаад, уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөллийг бууруулах гарц, шийдлийг олоход бүх түвшний оролцогч талуудын оролцоог тэгш хангаж, сайжруулах шаардлагатайг онцолж байв.

Судалгаанд оролцогч салбарын мэргэжилтнүүд, ялангуяа эрчим хүчний салбарынхан ногоон эрчим хүч, цэвэр эрчим хүч, технологи, сэргээгдэх эрчим хүчний гэрчилгээ, хүлэмжийн

хий бууруулсны нөхөн төлбөр гэх мэт салбарын ойлголтуудын хүрээнд уур амьсгалын өөрчлөлтийн нэр томъёог зарим тохиолдолд тайлбарлаж чадаж байна. Зарим салбарын мэргэжилтнүүд, уур амьсгалын өөрчлөлтийн талаар ярихдаа дэлхийн дулаарал, цаг агаарын өөрчлөлт зэрэг нэр томъёог голдуу ашиглаж байна. Харин багахан хэсэг нь уур амьсгалын өөрчлөлтийг агаарын бохирдолтой андуурах хандлагатай байна.

Эрдэм шинжилгээний болон төрийн бус байгууллагын оролцогчид уур амьсгалын өөрчлөлтийн талаар техникийн мэдлэг, тус тусынхаа салбарт хамаарагдах мэдээллийг авах чадвартай байсан. Улмаар, тэд үндсэн бодлогын хүрээ, стратеги төлөвлөгөө, арга хэмжээ төдийгүй, олон улсын түвшний конвенц, гэрээний талаарх мэдлэгтэй байна. Гэвч Засгийн газрын тогтворгүй байдал, уялдаа холбоогүй үйл ажиллагаа, оролцогч талуудын оролцоо бага, санхүүгийн дэмжлэг хязгаарлагдмал зэрэг нь уур амьсгалын өөрчлөлтийг шийдвэрлэхэд тулгамдаж буй гол асуудал гэдгийг тодруулж байна. Монгол Улс уур амьсгалын өөрчлөлтийг сааруулах, дасан зохицох чиглэлээр олон улсын байгууллага, хандивлагч орнуудаас дэмжлэг авч байгаа хэдий ч уг асуудлыг бүхэлд нь шийдвэрлэх Засгийн газрын хүчин чармайлт хангалтгүй байна. Энэ нь олон нийтийг гэгээрүүлэх, мэдлэг чадварыг сайжруулах бодлого хэрэгжүүлэхдээ олон талт оролцоо, хамтын ажиллагааг хангах үйл явц дутмаг байгаатай холбоотой гэж үзэж байна.

Хэдийгээр олон улсын байгууллага, хандивлагч орнуудаас хэрэгжүүлж буй төсөл хөтөлбөрүүдээр уур амьсгалын өөрчлөлтийн талаарх мэдээллийг түгээн дэлгэрүүлэх чиглэлээр ихээхэн арга хэмжээ авч байгаа ч, энэ нь олон нийтэд төдийлөн хүртээмжгүй байгааг оролцогчдын дийлэнх нь дурдаж байлаа.

Уур амьсгалын өөрчлөлтийн асуудлыг бүх түвшний анхаарлын төвд аваачихын тулд долоон хүчин зүйлийг харгалзан бэлэн байдлын үнэлгээг хийсэн. Үүнд ойлголт, мэдлэг, манлайлал, уур амьсгалын өөрчлөлтийг хэмжих эрэлт хэрэгцээ, нөөц, техникийн чадавх, байгууллагын зохион байгуулалт, үнэт зүйл, стандарт зэрэг долоон хүчин зүйл багтана. Монголын уур амьсгалын

өөрчлөлтөд бэлэн байдлын түвшнийг оролцогч талуудаар 1-ээс 4 хүртэлх оноогоор үнэлүүлэхэд дунджаар 2.6 оноог өгсөн байна. Гэхдээ, бараг бүх оролцогч зарим зайлшгүй хүчин зүйлс нь учир дутагдалтай, яаралтай сайжруулах шаардлагатай байгааг онцлон дурджээ. Байгууллагын зохион байгуулалт болон мэргэжлийн/техникийн чадварт хамгийн бага үнэлгээ (2.1 ба 2.2) өгсөн байна. Ярилцлагад оролцогчдын ихэнх нь салбар тус бүрийн байгууллагын чиг үүрэг, хариуцлага тодорхой болоогүй, хараахан тогтворжоогүй байгааг онцлон дурдсан юм.

Салбарын түвшинд, олон улс дахь санхүү, техникийн дэмжлэгээр уур амьсгалын нөлөөллийг сааруулах эрэлт хэрэгцээ, шаардлага нэмэгдэж байгаатай холбогдуулан салбарын хэмжээндээ уур амьсгалын өөрчлөлтийн асуудлыг шийдвэрлэхэд бэлэн гэж эрчим хүчний салбарынхан илэрхийлжээ. Цаашлаад, уур амьсгалын өөрчлөлтийн талаарх мэдлэг, мэдээллийг салбарын төлөвлөлтийн үйл явцад хангалттай ашиглаж байна. Оролцогч талуудтай хийсэн ярилцлагаас харахад, уур амьсгалын өөрчлөлтийн асуудлыг шийдвэрлэхэд манлайлж байгаа салбараар Эрчим хүчний яам, Эрчим хүчний зохицуулах хороог нэрлэсэн байна. Харин улсын хэмжээнд уур амьсгалын цогц стратеги төлөвлөгөө, түүний хэрэгжилтийг сайжруулах, эрчим хүчний үр ашгийг дээшлүүлэх, сэргээгдэх эрчим хүчний хэрэглээг нэмэгдүүлэхэд чиглэсэн арга хэмжээнүүдэд санхүүжилт хязгаарлагдмал байгааг талууд онцлон дурдаж байна.

Хөдөө аж ахуйн салбарынхан, тус салбарыг уур амьсгалын өөрчлөлтөд хамгийн өртөмтгий гэж үзээд, малын тоо толгойг тэнцвэржүүлэх, мах, ноолуур, сүүн бүтээгдэхүүний үйлдвэрлэлд тавих хяналтыг сайжруулах зохицуулалт шаардлагатай байгааг онцлон дурдаж байв. Уур амьсгалын өөрчлөлтийг хөдөө аж ахуй, мал аж ахуйтай холбож тайлбарласан их сургууль, эрдэм шинжилгээний байгууллагуудын судалгааны бүтээлүүд хангалттай байна гэж салбарынхан нь дүгнэжээ. Харин, уур амьсгалын өөрчлөлтийн асуудалд тусгайлан мэргэшсэн, чадварлаг боловсон хүчин, шинжээч (салбарын ба байгууллагын түвшинд) дутмаг байгаа тул цаашид анхаарах шаардлагатай байна. Мөн, уур амьсгалын өөрчлөлтийн талаар ерөнхий ойлголт, мэдлэгтэй мэргэжилтэн ялангуяа хөдөө орон нутагт хангалтгүй байгаа асуудлыг хөндсөн байна.

Судалгаанд оролцогч эрүүл мэндийн салбарынхан, агаарын хэмийн хэт өсөлт, хэт халалтын үргэлжлэх хугацаа, байгалийн гамшгийн давтамж нэмэгдэх, амьжиргаанд үзүүлэх нөлөөлөл зэрэг уур амьсгалын өөрчлөлттэй холбоотой нийгмийн эрүүл мэндийн тулгамдсан асуудлыг шийдвэрлэхэд чиглэсэн стратеги төлөвлөгөө байгаа учраас уг салбарын уур амьсгалын өөрчлөлтөд үзүүлэх хариу арга хэмжээг хангалттай гэж үнэлж байна. Халдварт бус өвчин, халдвар тээгч, зоонозын өвчлөлийн өсөлтийг уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөтэй холбон тайлбарласан. Хэдийгээр Засгийн газраас сургалт, семинаруудад хамруулж байгаа ч байгууллага, хувь хүний гэх мэт янз бүрийн түвшинд чадвар сайжруулах арга хэмжээг нэмж авах шаардлагатай байна.

Орон нутгийн хэмжээнд, орон нутгийн засаг захиргаа болон ТББ-уудын төлөөллүүд гэх мэт олонх оролцогчдын хувьд уур амьсгалын өөрчлөлтийн талаар ойлголтой байсан. Орон нутгийн удирдлагууд нь уур амьсгалын өөрчлөлтийн тухай сонссон, мөн уг асуудлыг шийдвэрлэхийн ач холбогдлыг онцгойлон дурдаж байсан ч, бусад асуудлаас чухалчлан авч үзэхгүйгээр бодлогын томоохон баримт бичгүүдэд тусгагдсан байгаль орчин, ногоон хөгжлийн асуудлын хүрээнд тайлбарлах нь их байв. Гол бэрхшээл нь хүний нөөцийн хязгаарлагдмал байдал, орон нутгийн манлайлах чадвар дутмаг зэрэг багтаж байна. Уур амьсгалын өөрчлөлтийн эсрэг арга хэмжээг хэрэгжүүлэх эсэх нь тухайн орон нутгийн Засаг даргын мөрийн хөтөлбөрт уг асуудлыг тусгасан эсэхээс ихээхэн хамааралтай болохыг онцолж байв.

Мэдлэг, чадварыг сайжруулах олон нийтийг хамарсан үйл ажиллагааны стратеги төлөвлөгөө

Уур амьсгалын өөрчлөлтийн тухай ойлголт, өөрчлөлтийн үр нөлөөг даван туулах арга замуудын талаарх ихэнх хүмүүсийн мэдлэг дутмаг байгаагаас энэ талаарх ойлголтыг нэмэгдүүлэх шаардлага тулгарч байна. Энэ нь уур амьсгалын өөрчлөлттэй холбоотой найдвартай, тууштай мэдээллийн эрэлт хэрэгцээ өндөр болохыг харуулж байна. Судалгаанд оролцогчдын ихэнх нь (85.4%) уг сэдэвтэй холбоотой илүү их мэдээллийг хэвлэл мэдээллийн хэрэгслээс авах хүсэлтэй байгаагаа илэрхийлсэн байна. Энэ

талын мэдээллийн эрэлт хэрэгцээг хангахад орон нутгийн төрийн байгууллага, сэтгүүл зүй, хэвлэл мэдээллийн салбар зэрэг гол оролцогч тал чухал үүрэг гүйцэтгэх төлөвтэй байна. Гэхдээ, нийтэд мэдээлэл түгээж, татан оролцуулах үүрэгтэй хүмүүс ч гэсэн энэ талаарх ойлголт бага, уг ажлыг хэрэгжүүлэх нөөц хомс байгааг анхаарах хэрэгтэй. Мэдлэг, чадварыг сайжруулах олон нийтийг хамарсан үйл ажиллагааг улсын хэмжээнд тодорхойлсон стратеги төлөвлөгөө, арга хэмжээ, хэрэгжүүлэх ажиллагааны төлөвлөгөөнд заасан зорилтуудтай нийцүүлэх шаардлагатай.

Судалгааны багийнхан мэдлэг, чадварыг сайжруулах олон нийтийг хамарсан үйл ажиллагааны эцсийн үр нөлөөг “Хүн амын дасан зохицох чадвар, дадлыг дэмжихийн тулд нийгмийн бүх давхаргад уур амьсгалын өөрчлөлтийн талаар үнэн зөв мэдлэг олгох” гэж томъёолж, санал болгож байна.

Компанит ажлын зорилго буюу үр дүнг дараах байдлаар томъёолж болно:

- Уур амьсгалын өөрчлөлтийн тухай ойлголт, түүний нөлөө нь хүмүүсийн анхааралд өртсөн асуудалтай хэрхэн холбогдож байгаа талаарх ойлголтыг сайжруулах – Стратегийн эхний зорилго нь уур амьсгалын өөрчлөлтийн шалтгаан, шууд ба шууд бус нөлөөлөл зэрэг үйл явцын талаар мэдээлэл өгөх замаар олон нийтийн дунд уур амьсгалын өөрчлөлтийн талаарх нийтлэг ойлголтыг бий болгоход оршино. Судалгаанаас харахад, ихэнх хүмүүс уур амьсгалын өөрчлөлтийг мэдэж байсан ч, өөрчлөгдөх үйл явц, нөлөөлөх хүчин зүйлсийн талаарх суурь ойлголт дутмаг байдаг. Цаашлаад, уур амьсгалын өөрчлөлтийн ерөнхий ойлголтууд өөр хоорондоо ялгаатай, хязгаарлагдмал шинжтэй байна. Тухайлбал, зарим тохиолдолд уур амьсгалын өөрчлөлт, агаарын бохирдол гэсэн нэр томъёог ижил асуудал гэж үзсэн байна. Тиймээс олон нийт болон оролцогч талуудад уур амьсгалын өөрчлөлтийн талаарх нэгдсэн ойлголт, тайлбарыг өгөх нь чухал юм.
- Уур амьсгалаас шалтгаалсан байгалийн гамшгийн талаар мэдээлэх, сэрэмжлүүлэх – Хоёр дахь зорилго нь цаг уурын өөрчлөлтөөс үүдэлтэй өнөөдөр ба ирээдүйд

тохиолдож болзошгүй үйл явдлууд, гамшгаас хамгаалахад бэлтгэх мэдээлэл өгөх, сэрэмжлүүлэх явдал юм.

- Уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох чадвар, дадлын талаарх мэдлэгийг дээшлүүлэх – Судалгааны үр дүнгээс үзэхэд, Монголчуудад уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох арга түршлага, мэдлэг, мэдээлэл хангалтгүй байна. Уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох үйл ажиллагааны талаарх олон нийтийн мэдлэгийг дээшлүүлэх нь Монгол Улсын уур амьсгалын өөрчлөлтөд хариу арга хэмжээ авахад чухал ач холбогдолтой.
- Олон нийтээр дамжуулан уур амьсгалын өөрчлөлтийн бодлогод нөлөөлөх – Стратегийн сүүлчийн зорилго нь орон нутгийн болон засгийн газарт уур амьсгалын өөрчлөлтийн бодлого боловсруулах, хэрэгжүүлэхэд олон нийтийн нөлөөллийг ашиглах, цаашлаад олон улсын түвшинд Монголчуудын асуудал, хэрэгцээг илүү сайн төлөөлөхийг Засгийн газраас шаардах, уриалах явдал юм.

Олон нийтэд сурталчлах компанит ажлын дөрвөн үндсэн стратегийг дараах байдлаар тодорхойллоо:

- Хэвлэл мэдээллийн хэрэгслээр хүмүүсийн өдөр тутмын амьдралд үзүүлэх уур амьсгалын өөрчлөлтийн нөлөө, эрүүл мэнд, эдийн засаг, үндэсний аюулгүй байдал, байгаль орчны асуудал зэрэг тэдний санааг зовоож буй гол асуудалтай холбож танилцуулах нь энэ талаарх олон ойлголт өөрчлөгдөхөд нөлөөлж чадна.
- Сонирхлыг татахуйц түүхүүд нь уг асуудалд олон нийтийн анхаарлыг чиглүүлэх, уур амьсгалын өөрчлөлтөд даруй хариу арга хэмжээ авах сэдэл төрүүлэхэд түлхэц болж өгөх чухал хэрэгсэл юм. Уур амьсгалын өөрчлөлтөд өртсөн хувь хүн юм уу, олон нийтийн түүхүүд нь уур амьсгалд дасан зохицох чиглэлийн түршлагыг илүү өргөн хүрээнд хуваалцахад үр дүнтэй байх болно.
- Фокус бүлгийн хэлэлцүүлэгт оролцогчдын санал болгосноор, тодорхой зан үйлийг өдөөх зорилгоор уур амьсгалын

өөрчлөлтийг ухуулан таниулагчдын түгээмэл ашигладаг стратеги болох Fear Appeal нь мэдлэг дээшлүүлэх компанит ажилд үр дүнтэй байх болно. Хүмүүс айдас хүйдсээсээ болоод сонирхох, оролцохоос татгалзаж болзошгүй тул, түүнээс урьдчилан сэргийлэхийн тулд “үр ашигтай” гэдэг мессежээр хариу арга хэмжээ авах шаардлагатай. Энэхүү стратегийг судалгааны хүрээнд зохион байгуулсан олон удаагийн фокус бүлгийн хэлэлцүүлгээр санал болгож байсан.

- Нийгмийн хэм хэмжээний нөлөөллийн үйл ажиллагаа, үе тэнгийнхний хандлага, зан үйлийн талаарх төсөөлөл нь бидний хандлага, зан төлөвт ихээхэн нөлөөлдөг гэсэн үндсэн зарчимд суурилсан нийгмийн маркетингийн арга юм. Энэ нь уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох үйл ажиллагааны талаарх мэдлэг дээшлүүлэх, хандлагыг өөрчлөх, зан төлөвт нөлөөлөхүйц чухал стратеги юм.

Олон нийтийн хэрэгцээ шаардлага (цаг агаар, хүрээлэн буй орчин, уур амьсгалын өөрчлөлттэй холбоотой арга хэмжээ авахад дэмжлэг үзүүлэх), хэвлэл мэдээллийн хэрэгслийн хэрэглээний хэв маяг, мэдлэг, хандлага, дадлын түвшинд нь үндэслэн зорилтот бүлгийг сонгохдоо байршил/оршин суугаа газар (хөдөө, хот) болон нас (залуучууд, дундаж насныхан, ахмадууд) гэсэн хоёр хүчин зүйлд суурилах нь оновчтой.

Хөдөөгийн хүн амд, аж амьдрал нь уур амьсгалын өөрчлөлтөд өртөмхий малчид, тариаланчид болон бусад бүлэг (малчдын 89.8% нь хөдөө орон нутагт амьдардаг), бага боловсролтой бүлгийнхэн (хөдөөд амьдрах магадлал нь илүү өндөр) багтаж байна. Мөн мэдлэг, хандлага, дадлын түвшин нь наснаас хамаарч ялгаатай байдаг тул насаар нь ялгах хэрэгтэй.

Иймд шийдвэр гаргагч болон төрийн байгууллагуудын түвшинд дараах асуудлуудын талаар мэдлэг, мэдээллээр хангах, энэ чиглэлээр үр чадварыг нь дээшлүүлэх шаардлагатай байна. Үүнд- Монгол улсын уур амьсгалын өөрчлөлтийн өнөөгийн нөхцөл байдал, цаашдын чиг хандлага, нөлөөлөл нь урт хугацаанд эдийн засаг, нийгмийн хөгжилд хэрхэн нөлөөлөх вэ, мөн бодлого төлөвлөлт, шийдвэр гаргалтад уур амьсгалын өөрчлөлтийн асуудлыг хэрхэн тусгах, салбар хоорондын уялдаа холбоог хэрхэн хангах

вэ гэх мэт асуудлыг багтаан ойлгож болно. Мөн шийдвэр гаргагчид, төрийн албан хаагчдыг тухайн салбарын судалгаа, статистик мэдээллээ ашиглан үндэслэл бүхий, нотолгоотой, шинжлэх ухааны үндэслэлтэй шийдвэр гаргахад дэмжих шаардлагатай байна.

Үндэсний түвшний чадвартай холбоотой тодорхойлсон гол хэрэгцээнд: Засгийн газрын оролцогч талуудын техникийн чадварыг (шинжлэх ухааны тусгай арга зүй, мэдээллийн систем, шинэ технологи) сайжруулах; уур амьсгалын чиглэлийн өнөөгийн засаглалыг бэхжүүлэх, банкнуудаас олгож буй бүх салбарын сөрөг нөлөөллийг бууруулах, дасан зохицоход нь дэмжлэг үзүүлэх ногоон зээлийг өргөжүүлэх зэрэг багтана. Засаглалын хувьд уур амьсгалын өөрчлөлтийг ухуулан таниулах нь нарийн төвөгтэй, олон талт бөгөөд салбар хоорондын өндөр оролцоог шаарддаг тул одоо байгаа Уур амьсгалын өөрчлөлтийн үндэсний комиссыг гол чиг үүрэг бүхий байгууллага болгон бэхжүүлэх нь ихээхэн ач холбогдолтойг гол оролцогч талууд, нэн ялангуяа төрийн болон төрийн бусын мэргэжилтнүүд, эрдэм шинжилгээний салбарын төлөөллүүд онцлон дурдсан. Цаашилбал, гол оролцогч талууд болох төрийн түвшний эрх бүхий байгууллагуудын чиг үүрэг, эрх мэдлийг илүү тодорхой болгох, бэхжүүлэх шаардлагатай байна. Төсөв болон жилийн төлөвлөгөөг төлөвлөхдөө уур амьсгалын асуудлыг хэрхэн авч үзэх талаар тодорхой зааварчилгаа гаргаж өгөх нь ихээхэн чухал түлхэц болно.



I. ХЭСЭГ. ТАНИЛЦУУЛГА, АРГА ЗҮЙ, АГУУЛГА

1. ТАНИЛЦУУЛГА

1.1 Үндэслэл

Далайд гарцгүй, хөгжиж буй орны хувьд Монгол улс цөлжилт, усны хомсдол, хур тунадасны хэмжээ өөрчлөгдөх, улирлын чанартай цаг агаарын эрс тэс үзэгдлүүд зэрэг бусад улс орнуудад ч тохиолдож буй цаг уурын эрсдэлт хүчин зүйлүүдтэй тулгарч байна. Хүн амын бүлгүүд, тэр дундаа эмзэг бүлгийнхэн уур амьсгалын өөрчлөлтөөс шалтгаалсан хямрал, дарамтад илүү өртөхөөс гадна гамшиг, эрсдэлийг даван туулах, хариу арга хэмжээ авах чадвар хязгаарлагдмал тул илүү хор уршиг амсах магадлалтай байдаг.

Монгол Улсын Засгийн газар уур амьсгалын өөрчлөлтийн сөрөг нөлөө бууруулах арга хэмжээг нэн даруй авах шаардлагатай байгааг хүлээн зөвшөөрч 1993 онд НҮБ-ын Уур амьсгалын өөрчлөлтийн суурь конвенц, 1999 онд Киотогийн протокол, 2016 онд Уур амьсгалын өөрчлөлтийн тухай Парисын хэлэлцээрт нэгдсэн. Монгол Улс 2015 оны 9-р сард НҮБ-ын Уур амьсгалын өөрчлөлтийн тухай конвенцын анхны Үндэсний хэмжээнд тодорхойлсон баримт бичгийг өргөн барьж, хүлэмжийн хийн ялгарлыг 2030 он гэхэд 14%-иар бууруулах амлалт өгсөн. Дараа нь энэхүү зорилтоо ахиулан 2030 он гэхэд хүлэмжийн хийн ялгаралтыг 22.7%-иар бууруулах болгож шинэчилсэн. “Алсын хараа-2050”, “Шинэ сэргэлтийн бодлого”, “Монгол Улсын хөгжлийн таван жилийн үндсэн чиглэл (2021-2025 он)”, удахгүй хэрэгжих “Салбарын хөгжлийн зорилтот хөтөлбөр” зэрэг нь уур амьсгалын өөрчлөлтийг шийдвэрлэх төрийн өндөр түвшний бодлогын

гол баримт бичиг юм. УИХ-аас 2011 онд баталсан “Уур амьсгалын өөрчлөлтийн үндэсний хөтөлбөр” нь уур амьсгалын өөрчлөлтийн бодит байдал, түүний талаарх олон нийтийн ойлголт хоорондын уялдаа холбоог судлахын ач холбогдлыг онцолсон бодлогын баримт бичгүүдийн нэг юм.

Олон нийт, оролцогч талууд, бодлого боловсруулагчдын дунд мэдлэг, чадварыг сайжруулж, шинжлэх ухааны мэдээллийг түгээн дэлгэрүүлэх замаар тэдний оролцоог сайжруулж чадвал Монгол Улсын уур амьсгалын өөрчлөлттэй холбоотой бодлогын зорилтууддаа хүрэх боломж бүрдэнэ. Нийгмийн эмзэг бүлгийн уур амьсгалын өөрчлөлтөд өртөмтгий байдлыг бууруулах, эрсдэлд хариу үйлдэл үзүүлэх чадварыг сайжруулах нь тэргүүлэх чиглэлүүдийн нэг болохыг Уур амьсгалын өөрчлөлтийн тухай 2019 онд НҮБ-ын суурь конвенцид хүргүүлсэн Үндэсний тодорхойлсон хувь нэмрийн тайланд мөн онцолсон байна.¹ ТОдоогоор, хөдөө аж ахуй, эрүүл мэнд, боловсролын салбарт уур амьсгалын өөрчлөлтийн үзүүлэх нөлөө, иргэдийн амьжиргаа болон эмзэг байдлын нөлөөллийн судалгааг эс тооцвол Монгол Улсад уур амьсгалын өөрчлөлтийн талаарх мэдлэгтэй холбоотой эрдэм шинжилгээ, бодлогын судалгаа цөөн хийгдсэн байна. Өмнөх судалгаануудын орон нутгийг хамрах хүрээ, түүврийн хэмжээ бага, цөөн хэдэд нь уур амьсгалын өөрчлөлтийн талаарх хүмүүсийн ойлголтыг тодорхойлохыг оролдсон байна. Уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох, даван туулах чадвар, ялангуяа нийгэм, эдийн засгийн хувьд, эмзэг бүлгийн хүмүүсийн мэдлэг, ойлголтыг нэмэгдүүлэхэд хэвлэл мэдээллийн байгууллагын оруулах хувь нэмэр, ач холбогдлыг одоогоор доогуур үнэлсэн байна.

Иймд дээрх орон зайг нөхөх зорилгоор энэхүү судалгааг Даян дэлхийн ногоон хөгжлийн институтын санхүүжилт болон Байгаль орчин, аялал жуулчлалын яам, Уур амьсгалын өөрчлөлтийн судалгаа, хамтын ажиллагааны төвийн захиалгаар IRIM судалгааны хүрээлэн хийж гүйцэтгэлээ.

Судалгаа нь Монгол улсын хөгжлийн бодлого, төлөвлөлтөд уур амьсгалын өөрчлөлтийн асуудлыг тусгах, үндэсний хэмжээнд

тодорхойлсон хувь нэмрийг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх үндэсний болон орон нутгийн төрийн байгууллагын чадварыг бэхжүүлэх зорилго бүхий Уур амьсгалын ногоон сангийн бэлэн байдлын төслийн хүрээнд хэрэгжиж байгаа юм.

Судалгаагаар иргэдийн, тэр дундаа нийгмийн эмзэг бүлгийнхний уур амьсгалын өөрчлөлтийн талаарх ойлголт, мэдлэг, хандлага, дадал зуршил, хэвлэл мэдээллийн хэрэглээг үнэлэх зорилготой бөгөөд үр дүнг уур амьсгалын өөрчлөлтийн асуудлыг улсын ба орон нутгийн салбарын бодлогод тусгах, олон нийтийн мэдлэг, чадварыг бэхжүүлэх үйл ажиллагааг сайжруулах, олон нийтийг хамарсан үйл ажиллагааны стратеги төлөвлөгөөг боловсруулахад ашиглах юм. Түүнчлэн, судалгааны өгөгдөл мэдээлэл, тайлан нь уур амьсгалын өөрчлөлтийн чиглэлд хэрэгжүүлэх бодлого, үйл ажиллагааны үр дүн, ахицыг үнэлэх суурь болох ба олон нийтэд мэдээлэл түгээх, дэлгэрүүлэхэд гарч буй өөрчлөлтийг хэмжих боломж бүрдүүлнэ. Өргөн утгаараа, бодлого боловсруулагчдын уур амьсгалын өөрчлөлтийн талаарх ойлголт, мэдлэгийг сайжруулж, уур амьсгалын өөрчлөлтийг сааруулж, нөлөөллийг бууруулахад чиглэсэн шийдвэрлэх арга хэмжээ авахад түлхэц болно.

Судалгаа нь хосолмол арга зүйг ашиглан нийгмийн эмзэг бүлгийнхний уур амьсгалын өөрчлөлтийн талаарх мэдлэг, хандлага, дадлыг илрүүлэх зорилго бүхий улсын хэмжээнд хийгдэж буй анхны судалгаа гэдгээрээ онцлог юм. Улаанбаатар, Зүүн, Баруун, Хангай, Төв гэсэн таван бүст суурилсан олон үе шаттай, давхаргат түүврийг ашигласан. Судалгаанд оролцогчдыг нийт хүн амын төлөөлөл болгож 13 аймаг, Улаанбаатар хотын бүх дүүргээс санамсаргүй түүврийн аргаар сонгосон. Мэдээлэл цуглуулах ажлыг 2022 оны 9-11 дүгээр сарын хооронд хийж гүйцэтгэсэн. Судалгаанд сонгогдсон 2,804 иргэнээс мэдээллийг асуулгын аргаар цуглуулж, фокус бүлгийн ярилцлагыг 65, ганцаарчилсан ярилцлагыг олон салбарын төлөөлөл 49 хүнтэй тус тус зохион байгуулсан.

Судалгаа нь уур амьсгалын өөрчлөлтийн талаарх олон нийтийн мэдлэгийн түвшнийг “шалгах”-аас илүүтэй олон нийт ба эмзэг бүлгийнхэн уур амьсгалын өөрчлөлтийг хэрхэн хүлээн авч, мэдэрч байгаад илүү нягт, цэгцтэй ойлголт

авахад анхаарсан. Уур амьсгалын өөрчлөлтийн бодлого, хөтөлбөрүүд амжилттай хэрэгжих эсэх нь иргэдийн тэр талаарх мэдлэг, мэдээллийн түвшин, уур амьсгалын өөрчлөлт тэдний өдөр тутмын амьдралд хэрхэн нөлөөлөх тухай ойлголтоос ихээхэн хамаардаг тул судалгааны асуултуудыг өргөн хүрээтэй боловсруулахыг зорьсон. Тухайлбал, иргэдийн уур амьсгалын өөрчлөлтийн талаарх ойлголтыг тандахын тулд тэдэнд илүү ойлгомжтой дөхүүлэх байдлаар, цаг агаар, нутаг орон, байгалийн гамшиг, амьжиргааны байдал, түүнд үзүүлж буй сөрөг нөлөөг хэрхэн даван туулах чадвар, арга барил, ямар арга хэмжээ авсан зэрэг асуултуудыг оруулсан. Тайлангийн 9, 10 дугаар бүлэгт Засгийн газар, хувийн хэвшил, иргэний нийгмийн салбар, хэвлэл мэдээллийн хэрэгсэлд зориулсан зөвлөмжийг боловсруулж тусгасан.

1.2 Зорилго

Энэхүү судалгаа нь дараах хэдэн зорилготой. Үүнд:

1. Уур амьсгалын өөрчлөлт, түүний шалтгаан, сааруулах арга замын талаарх иргэд олон нийт, нийгмийн эмзэг бүлэг, оролцогч талуудын мэдээлэл, мэдлэгийг үнэлэх,
2. Уур амьсгалын өөрчлөлттэй холбоотой хүмүүсийн хандлага, дадлыг тодорхойлох,
3. Уур амьсгалын өөрчлөлтийн талаарх мэдлэг, мэдээллийн хүртээмж, хариу арга хэмжээ авах чадвар боломжид хүйс, нийгэм-эдийн засгийн эмзэг байдлаас үүдэлтэй тэгш бус байдал нөлөөлж буй эсэхийг шинжлэх,
4. Уур амьсгалын өөрчлөлтийн эсрэг авах шаардлагатай арга хэмжээний талаар иргэд, гол оролцогч талуудын хүлээлтийг тодорхойлох,
5. Уур амьсгалын өөрчлөлтийн асуудлыг авч үзэхэд бэлэн байгаа эсэх талаарх оролцогч талуудын ойлголтыг үнэлэх,
6. Хүн амын тодорхой бүлэг, оролцогч талуудад чиглэсэн уур амьсгалын өөрчлөлтийн талаарх мэдлэг дээшлүүлэх компанит ажлыг зохион байгуулахад анхаарах хүчин зүйлсийг тодорхойлох,
7. Уур амьсгалын өөрчлөлттэй холбоотой тулгарч буй сорилтод хариу өгөхийн тулд

аль бүлэгт нэн тэргүүний тусламж хэрэгтэй байгааг тодорхойлох.

1.3 Ашигласан гол нэр томьёо

Уур амьсгалын өөрчлөлт. Уур амьсгалын өөрчлөлт гэдэг нь температур, цаг агаарын төлөв байдалд гарч буй урт хугацааны өөрчлөлтийг хэлнэ.² Энэхүү судалгаа нь хүний үйл ажиллагаанаас үүдэлтэй хүлэмжийн хийн ялгарлын талаарх судалгаанд оролцогчдын ойлголт, мэдлэгийг судлахад голлон чиглэсэн.

Цаг агаарын өөрчлөлт. Судалгаанд оролцогчдын ажиглалт, өнгөрсөн арван жилийн хур тунадас, температур, шуурга, цаг агаарын эрс тэс уур амьсгал нэмэгдсэн, буурсан талаарх ойлголт.

Хүрээлэн буй орчны өөрчлөлт. Судалгаанд оролцогчдын ажиглалт, өнгөрсөн арван жилд биологийн төрөл зүйл, бохирдол, байгалийн нөөцийн өсөлт, бууралтын талаарх ойлголт.

Ойлголт. Ямар нэг зүйл байгаа гэдгийг мэдэх, эсвэл мэдээлэл, туршлага дээр үндэслэн тухайн үеийн нөхцөл байдал, сэдвийг ойлгох.³

Мэдлэг. Шинжлэх ухаанч, цогц ойлголтыг илэрхийлнэ. Мөн хүний төсөөлөх чадвар, ойлгох байдлыг илэрхийлж болно.⁴ Уур амьсгалын өөрчлөлтийн талаарх мэдлэгийг голчлон, шалтгаан ба/эсвэл үр дагаврын талаарх мэдлэг, уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөллийн талаарх мэдлэг зэрэг олон талаас авч үздэг.⁵

Хандлага. Хандлага гэдэг нь тодорхой нөхцөл байдалд тодорхой байдлаар хариу үйлдэл үзүүлэх байдлыг хэлдэг; үйл явдлыг тодорхой урьдач нөхцөл байдлын дагуу харж, тайлбарлах; эсвэл санал бодлоо харилцан уялдаатай бүтэц болгон зохион байгуулахыг илэрхийлнэ.⁶

Дасан зохицох чадвар. Уурамьсгалын өөрчлөлтөд

2 НҮБ, Уур амьсгалын өөрчлөлт гэж юу вэ? 2022 <https://www.un.org/en/climatechange/what-is-climate-change#:~:text=Cli-mate%20change%20refers%20to%20long,like%20coal%2C%20oil%20and%20gas.>

3 Роберт Треветхан, Нийгмийн эрүүл мэндийн судалгааны талаарх мэдлэг, ойлголтыг задлан шинжлэх нь, 2017

4 Монде Дү Медесини, Мэдлэг, хандлага, дадлын судалгаа, 2011

5 Gazzaz & Aldeseet, (2021) Assessment of the Level of Knowledge of Climate Change of Undergraduate Science and Agriculture Student. Available at: <https://files.eric.ed.gov/fulltext/EJ1322610.pdf>

6 Ибрахи Г.Бардин, Мэдлэг, хандлага, дадал нь шилдэг байдал, мэргэн ухааны гурван тулгуур багана болох нь, 1995

1 БОАЖЯ, НҮБ-ын Уур амьсгалын өөрчлөлтийн суурь конвенц, Монгол Улсын үндэсний хэмжээнд тодорхойлсон хувь нэмэр, 2019

дасан зохицох (уур амьсгалын өөрчлөлт, эрс тэс нөлөөг оролцуулан), болзошгүй хохирлыг бууруулах, боломжуудыг ашиглах чадвар бөгөөд даван туулах чадвартай олон талаараа (цочрол, уур амьсгалын өөрчлөлтийг тэсвэрлэх чадвар) холбоотой ойлголт юм.⁷

Хариу арга хэмжээ. Энэхүү нэр томъёо нь уур амьсгалын өөрчлөлттэй холбоотой сэдвийн хүрээнд хүлэмжийн хийн эх үүсвэрийг багасгах, шингээгчийг нэмэгдүүлэх хүний оролцоог илэрхийлнэ. Тухайлбал, аж үйлдвэр, эсхүл цахилгаан эрчим хүч үйлдвэрлэхэд түүхий түлшийг үр ашигтай ашиглах, сэргээгдэх эрчим хүч рүү шилжих, барилга байгууламжийн дулаалгыг сайжруулах, агаар мандал дахь их хэмжээний нүүрстөрөгчийн давхар ислийг бууруулахын тулд ойжуулах, бусад “шингээгч”-ийг өргөжүүлэх зэрэг арга хэмжээ багтана.⁸

Дадал. Дадал, зан үйл нь өдөөлтөд хариу үйлдэл үзүүлэх хувь хүний ажиглагдахуйц үйлдэл юм.⁹

Даван туулах стратеги. Үүнийг даван туулах стратеги гэдэг нь “хямрал, нөхцөл байдал, бэрхшээлийг даван туулахад ашигладаг зан үйл, танин мэдэхүйн аргыг” хэлдэг.¹⁰

Эмзэг бүлгүүд. Өрхийн гишүүдийг хүн ам, нийгэм-эдийн засаг, газар зүйн хувьд цаг уурын өөрчлөлтөд илүү өртөмтгий, эмзэг болгож буй байдлаар нь тооцох.

Уур амьсгалын өөрчлөлтийг гол чиглэл болгох. Уур амьсгалын өөрчлөлтийг сааруулах, дасан зохицох зохих арга хэмжээг аль ч үед салбар бүрийн бодлого боловсруулах, хэрэгжүүлэх, төсөвлөх, үнэлэх үйл ажиллагаанд чухалчлан тусгах, хэвшил тогтоох

Хэвлэл мэдээллийн хэрэглээ. Зурагт, сонин, радио, интернет зэрэг олон нийтийн мэдээллийн хэрэгслийн платформ дээр хуваалцсан мэдээллийн хэрэглээ, хэрэглэгчдийн (үзэгчдийн) зан үйлийн байдал.

7 НҮБ-ын Уур амьсгалын өөрчлөлтийн конвенц, Уур амьсгалын өөрчлөлтийн нэр томъёо, товчилсон үгийн тайлбар <https://unfccc.int/process-and-meetings/the-convention/glossary-of-climate-change-acronyms-and-terms>

8 Дээрхтэй ижил эх сурвалжийг ашиглав.

9 Монде Дү Медесини, Мэдлэг, хандлага, дадлын судалгаа, 2011 <https://www.im-portal.org/help-library/the-kap-survey-model-knowledge-attitude-and-practices>

10 Д.Карр, Т.Пудровска, Дунд насны болон хожим үеийн хямрал, 2007 (<https://www.sciencedirect.com/science/article/pii/B0123708702001268>)

1.4 Тайлангийн бүтэц

Уг тайлан нь таван хэсгээс бүрдэнэ. 1-р хэсэгт тайлангийн үндэслэл, зорилго, гол нэр томъёог багтаасан. Тус хэсгийн 2-р бүлэгт судалгааны агуулгын хүрээ, тоон ба чанарын судалгааны гол үзүүлэлтүүд, арга зүйг тайлбарлаж харуулсан. 3-р бүлэгт Монгол орны уур амьсгалын өөрчлөлтийн нөхцөл байдал, уур амьсгалын өөрчлөлттэй холбоотой эмзэг байдлын тодорхойлолт, судалгаанд хамрагдсан эмзэг бүлгийг танилцуулсан. Харин 2-р хэсэгт мэдлэг, хандлага, дадалтай холбоотой гол үр дүнг танилцуулсан ба 3 бүлгээс бүрдсэн. Уур амьсгалын өөрчлөлттэй холбоотой ойлголт, мэдлэгийн талаарх судалгааны дүнг 4-р бүлэгт; уур амьсгалын өөрчлөлтөд хандах хандлагын тухай 5-р бүлэгт, уур амьсгалын болон байгаль орчны өөрчлөлтийн бусад асуудалтай холбоотой зан үйлийн тухай үр дүнг 6-р бүлэгт тус тус танилцуулсан. 3-р хэсэгт шаардлагатай бодлого, арга хэмжээнүүдтэй холбоотой талуудын үзэл бодол, хүлээлтийн үр дүнг танилцуулсан бол 7-р бүлэгт нийт хүн ам болон эмзэг бүлгийн дундах уур амьсгалын өөрчлөлттэй холбоотой арга хэмжээ авч хэрэгжүүлэх үүрэг бүхий талууд, мөн цаашид авч хэрэгжүүлэх шаардлагатай бодлогын чиглэлийн талаарх үзэл бодол, хүлээлтийг хураангуйлан харуулсан. 8-р бүлэгт гол оролцогч талуудын дунд явуулсан уур амьсгалын өөрчлөлтийн чиглэлд үйл ажиллагаа авч хэрэгжүүлэх, түгээн дэлгэрүүлэх бэлэн байдлын үнэлгээ болон чадвартай холбоотой хэрэгцээг тодруулан авч үзсэн байна. 4-р хэсэгт хэвлэл мэдээллийн хэрэглээ, чадварыг бэхжүүлэх стратегид голчлон төвлөрсөн. 9-р бүлэгт хүн амын ерөнхий болон байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлттэй холбоотой хэвлэл мэдээллийн хэрэгслийн хэрэглээний үр дүнг танилцуулна. 10-р бүлэгт цаашид хэрэгжүүлэх мэдлэг, чадварыг сайжруулах олон нийтийг хамарсан нэгдсэн үйл ажиллагаануудад анхаарах шаардлагатай зүйлсийг стратегийн хамт тодорхойлсон.



2. АРГА ЗҮЙ, АРГАЧЛАЛ

2.1 Судалгааны хамрах хүрээ ба гол асуултууд

Энэхүү судалгаа нь хүн амын дундах уур амьсгалын өөрчлөлтийн талаарх мэдлэгийг үнэлж, оноо өгөхөөс илүүтэйгээр эмзэг бүлгүүд, оролцогч талуудын дундах энэ талаарх ойлголтыг таньж мэдэх зорилготой. Тиймээс, нэг талаараа мэдлэгийн суурь түвшнийг тогтоох зорилготой байв. Өөр хоорондоо ялгаа бүхий нийгмийн бүлгүүд, тэдгээрийн уур амьсгалын өөрчлөлтийн талаарх хэрэгцээ, эн тэргүүнд тавьж буй асуудлуудыг нь тодорхойлоход илүү төвлөрлөө. Судалгааны агуулгын хүрээг боловсруулахад суурилсан таамаглалуудыг дараах Зураг 1-т харуулав. Үүнд:

Иргэд талаас авч үзвэл:

1. Иргэдийн мэдлэг, хандлага, дадал нь шийдвэр гаргагчид ба эдийн засгийн салбарынхны бодлого, үйл ажиллагаандаа уур амьсгалын өөрчлөлтийн асуудлыг тусгахад нь нөлөөлөхүйц хамгийн чухал хүчин зүйл юм. Иргэд уур амьсгалын өөрчлөлтийн шалтгаан, үр дагаврыг мэдэж, ойлгож, байгаль орчныг хамгаалах зан үйлд дадаж, уур амьсгалын өөрчлөлтийг бууруулах, дасан зохицох арга хэмжээ авахад бэлэн байгаагаа илэрхийлэн харуулах тусам шийдвэр гаргагчдын хариу арга хэмжээ түүнд чиглэх болно. Ингэснээр илүү зохистой бодлого боловсруулах, шийдвэр гаргагчдаас хариуцлага шаардах нөхцөл бүрдэнэ.
2. Судалгаанд оролцогчдын хүн ам зүй болон нийгэм-эдийн засгийн нөхцөл байдлаас хамааран уур амьсгалын өөрчлөлттэй холбоотой мэдлэг, хандлага, дадал харилцан адилгүй байна. Судалгаанд оролцогчдын хүйс, нас, боловсролын түвшин, ажил мэргэжил, орлогын байдал, нийгмийн харилцаа, амьдрах орчин, байгалийн үзэгдэл болон гамшигтай холбоотой өмнөх туршлага зэрэг бусад олон онцлогоос хамааран мэдлэг, хандлага, дадал өөр өөр байж болзошгүй.

3. Мэдлэг, хандлага, дадал:

- Байгаль орчин, цаг агаарын төлөв байдалд гарч буй өөрчлөлтийн талаарх ойлголттой байх нь эерэг хандлагыг бий болгох, илүү мэдлэг чадвартай болоход зарим талаар нөлөөлж болзошгүй.
- Уур амьсгалын өөрчлөлтийн талаар илүү ойлголт, мэдлэгтэй хүмүүс энэ асуудалд илүү санаа зовдог байх магадлал, хамаарал их байж болзошгүй.
- Хандлага, дадлын хооронд урамшуулал, зардал, бодлого гэх мэт бусад нөлөөлөх хүчин зүйлстэй адил шууд хамаарал байхгүй.

4. Байгаль орчны асуудлуудын талаарх мэдээллийн хүртээмж, хэвлэл мэдээллийн

хэрэгсэл ашиглах зан үйл нь мөн судалгаанд оролцогч бүлгүүдийн ойлголт, мэдлэг, хандлага, дадалд нөлөөлдөг.

Засаглал ба оролцогч талуудын хувьд:

1. Олон салбарын (байгаль орчин, эрчим хүч, хүнс хөдөө аж ахуй, санхүү, хэвлэл мэдээлэл г.м), өөр өөр түвшний (үндэсний болон орон нутгийн г.м) оролцогч талуудын уур амьсгалын өөрчлөлтийн асуудлыг нэвтрүүлэх талаарх үзэл, хандлага харилцан адилгүй байна.
2. Уур амьсгалын өөрчлөлтийн талаарх асуудлыг бүх шатанд амжилттай гаргаж ирэхийн тулд дараах хүчин зүйлийг чухал ач холбогдолтой гэж таамаглаж байна. Үүнд: гол оролцогч талуудын ойлголт мэдлэг, манлайлал, уур амьсгалын өөрчлөлтийн


талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээний хэрэгцээ шаардлага, техникийн болон санхүүгийн нөөц, чадвар, институтийн зохион байгуулалт, үнэлэмж, стандарт г.м. Эдгээр хүчин зүйл нь төрийн, төрийн бус аль ч салбарт хамааралтай бөгөөд институтууд, үйл ажиллагааны хэрэгжилтэд ч хамаатай.

3. Чадаврыг бэхжүүлэх нөлөөллийн үйл ажиллагаа нь өөр өөр түвшинд хэрэгжих тул институтийн ба хувь хүний чадварыг тусад нь ялгаж үзэх шаардлагатай.

Иргэдийн мэдлэг, чадварыг дээшлүүлэх компани ажлын хүрээнд, уур амьсгалын өөрчлөлтийн талаарх мэдээллийн хүртээмжийг нэмэгдүүлэхээс гадна, гол оролцогч талуудын чадвартай холбоотой хэрэгцээг хангахад чиглэсэн ажлуудыг гүйцэтгэх хэрэгтэй. Ингэснээр, иргэдийн ойлголт, мэдлэг, чадвар дээшилж, хандлага, дадалд эергээр нөлөөлнө. Улмаар энэ нь уур амьсгалын өөрчлөлтийн талаарх ойлголтыг амжилттай түгээн дэлгэрүүлэхэд эергээр нөлөөлөх юм.

Үүний хүрээнд, дараах дэд асуудлуудыг тодорхойлсон

Зураг 1 Судалгааны хүрээ



Хүснэгт 1 Судалгааны хүрээ, шалгуур үзүүлэлтүүд

Ангилал	Дэд сэдвүүд
Уур амьсгалын өөрчлөлтийн талаарх ойлголт, мэдлэг	<ol style="list-style-type: none"> 1. Уур амьсгалын өөрчлөлттэй холбоотой нэр томъёог сонссон байдал 2. Уур амьсгалын өөрчлөлтийн учир шалтгааны тухай 3. Уур амьсгалын өөрчлөлтийн үр нөлөөний тухай 4. Цаг агаар, уур амьсгалын өөрчлөлтүүдийн талаарх ажиглалт 5. Байгаль орчны өөрчлөлтүүдийн талаарх ажиглалт 6. Уур амьсгалын өөрчлөлтүүдийн чиглэлд авч хэрэгжүүлж буй арга хэмжээний тухай
Уур амьсгалын өөрчлөлтийн талаарх хандлага	<ol style="list-style-type: none"> 1. Уур амьсгалын өөрчлөлтийн талаарх эерэг, сөрөг хандлага 2. Уур амьсгалын өөрчлөлтийн тулгамдсан асуудал 3. Уур амьсгалын өөрчлөлтөд хариу арга хэмжээ авахад хэрэгжихүйц, үр дүнтэй сонголт байгаа талаарх итгэл үнэмшил
Уур амьсгалын өөрчлөлт, байгаль орчинтой холбоотой дадал	<ol style="list-style-type: none"> 1. Уур амьсгалын өөрчлөлттэй холбоотой эрсдэл, байгалийн онц ноцтой үзэгдлүүдээс өөрийгөө хамгаалах, урьдчилан сэргийлэх арга хэмжээнүүд 2. Хөдөө орон нутаг ба хотын оршин суугчдын авч хэрэгжүүлж буй арга хэмжээ- уур амьсгалын өөрчлөлтийн үр нөлөөг бууруулах юм уу, түүнд дасан зохицохын тулд дадал зуршлаа өөрчилсөн хүмүүсийн хувь г.м 3. Ирээдүйд хэрэгжүүлэх арга хэмжээний тухай ойлголт

Ангилал	Дэд сэдвүүд
Хэвлэл мэдээллийн хэрэгслийн хэрэглээ	<ol style="list-style-type: none"> Хэвлэл мэдээллийн ерөнхий хэрэглээ (эх сурвалжийн төрлөөр- Зурагт, радио, нийгмийн сүлжээ) Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлттэй холбоотой хэвлэл мэдээллийн хэрэглээ Уур амьсгалын өөрчлөлттэй холбоотой хэвлэл мэдээллийн хэрэглээний хандлага Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлттэй холбоотой буруу ташаа мэдээллийг хэвлэл мэдээллээр дамжуулан тархааж буйтай холбоотой үзэл бодол Цаашдын хэрэгцээ ба эхлэх цэг Ойлголт, мэдлэг нэмэгдүүлэх ажлыг үр дүнтэй болгоход хувь нэмэр оруулах итгэж болохуйц эх сурвалж, олон нийтээс түүчээлэн ажиллах манлайлагчид
Газар зүйн мэдээлэл/ гамшигтай холбоотой өмнөх туршлага	<ol style="list-style-type: none"> Гамшгийн талаарх сүүлийн үеийн туршлага (төрөл, давтамж, үр нөлөөний тухай ойлголт) Гамшигт үзүүлэх хариу арга хэмжээ Гамшигтай холбоотой туршлага, экологийн бүс, газар зүйн бүсээр
Нийгмийн сайн сайхан байдал	<ol style="list-style-type: none"> Бусдад болон олон нийтэд итгэх итгэл Институтэд итгэх итгэл Бусдад туслах, тусламж авах Байгууллага болон институт хоорондын хамтын ажиллагаа / гишүүнчлэл
Уур амьсгалын өөрчлөлтийг бүүруулах, дасан зохицох арга хэмжээ	<ol style="list-style-type: none"> Уур амьсгалын өөрчлөлтийн талаар хэрэгжүүлж буй ажил, арга хэмжээг дэмжиж буй байдал Уур амьсгалын өөрчлөлтийн хөтөлбөрийн хүртээмж ба дэх сэтгэл ханамж Оролцогч талуудын санаачилгууд Засгийн газраас цаашид авч хэрэгжүүлэх ажлуудад өгөх санал Орон нутгийн түвшин дэх удирдлага, зохион байгуулалт, хэрэгжүүлэлт
Засаглал – уур амьсгалын өөрчлөлтийг түгээн дэлгэрүүлэх хүчин зүйлс.¹¹	
Хэрэгцээ, шаардлага	Урт хугацааны хөгжлийн ба салбарын бодлого, хөтөлбөрийг боловсруулахад уур амьсгалын өөрчлөлтийг харгалзахыг эрмэлзсэн хэрэгцээ шаардлага нь бодлого боловсруулагч, шийдвэр гаргагчид эсвэл, иргэний нийгмийн/төрийн бус байгууллагаас үүдэж болно.

¹¹ Эдгээр тодорхойлолтуудыг "Тогтвортой Хөгжлийн төлөөх Үнэлгээний Ахиц: Үндэсний Үнэлгээний Тогтолцоо ба Чадвар" дүн шинжилгээнд дурдсан улс орнуудын кейс судалгаануудад зориулсан арга зүй номоос авав. UNDP/UNICEF, 2017, Evan Green and Dorothy Lucks, UNDP/UNICEF, 2017.

Ангилал	Дэд сэдвүүд
Манлайлал	Улс төрийн ба засаглалын түвшний эсхүл, бусад салбарын манлайлагчид уур амьсгалын өөрчлөлтийг анхаарч буйгаа илэрхийлэн дэмжих явдал юм. Мөн аль хэдийнээ олонд танигдсан байгууллага, хувь хүний манлайлал байж болно. Манлайлал хүчтэй байх нь бусад хүчин зүйлийн нөлөөг дэмжиж өгдөг.
Нөөц	Уур амьсгалын өөрчлөлттэй холбоотой тогтолцоо, чиг үүргүүдийг тодорхой болгох, хүний нөөц бүрдүүлэх, хяналт үнэлгээ болон мэдээллийн систем бий болгох, санхүүгийн нөөц боломж бүрдүүлэх, тогтвортой байдлыг хангах гэх мэт.
Мэргэжлийн/ Техникийн чадавх	Хэрэгжихүйц, үр дүнтэй бодлогыг дэмжихүйц хувь хүний мэдлэг, үр чадвар, тогтолцооны техник технологийн дэд бүтэц (өгөгдлийн систем гэх мэт) болон институтийн нөөц боломж (тогтолцоо, боловсон хүчний г.м), чадварууд
Институтийн бүтэц, зохицуулалт	Төрийн ба төрийн бус салбарын олон түвшний байгууллага, нэгжүүдэд хэрэгжиж буй бодлого, үйл ажиллагааны уялдаа холбоо, хамтын ажиллагаа бүрдсэн байдал
Үнэт зүйлс ба стандартууд	Уур амьсгалын өөрчлөлтийн бодлогын хэрэгжилтэд оролцож буй бүхий л талуудын ёс зүйн хэм хэмжээ, үнэт зүйлийн албан болон албан бус хэм хэмжээг бий болгож, түүнийг ойлгон ухамсарлаж, дагаж мөрдөж буй байдал
Институтийн чадамж	Уур амьсгалын өөрчлөлтийн бодлогын төлөвлөлт, удирдлага зохион байгуулалт, хэрэгжүүлэлт, ашиглалтыг дэмжихэд шаардагдах байгууллагын тогтолцоо, бүтэц, нөөц
Хувь хүний чадамж	Хувь хүн аливаа хүлээн зөвшөөрөгдсөн стандарт, зарчмуудын хүрээнд уур амьсгалын өөрчлөлтийн тухай ойлголтуудыг ашиглах, шаардах, дагаж мөрдөх, хэрэгжүүлэхэд шаардлагатай мэдлэг, үр чадвар, чадамж, үнэт зүйл

Судалгааны асуултууд

Судалгаагаар оновчтой, бодит хариулт авахын тулд олон төрлийн арга, хэрэглэгдэхүүнүүдийг ашиглан доорх гол асуултуудыг боловсруулсан. Үүнд:

- Хүн амын дунд, тэр дундаа эмзэг бүлгийн уур амьсгалын өөрчлөлтийн талаарх өнөөгийн ойлголт, мэдлэг ямар байна вэ?
 - Хүмүүст байгаль орчин, цаг агаарын ямар өөрчлөлт ажиглагдаж байна вэ?
 - Судалгаанд оролцогчдын амьжиргаа, сайн сайхан байдалд нөлөө үзүүлж буй байгаль орчны ямар өөрчлөлтүүд байна вэ?
 - Уур амьсгалын өөрчлөлтийн учир шалтгааныг хүмүүс юу гэж боддог вэ?
 - Уур амьсгалын өөрчлөлтөөс үүдэх үр нөлөөг хүмүүс юу гэж ойлгодог вэ?

- Хүн амын ялгаатай бүлгүүд уур амьсгалын өөрчлөлтийг өөрсдийн амьдрал, нийгмийн хүрээлэл, улс орны хэмжээнд ямар үр нөлөөтэй болохыг хэр мэдэж байна вэ?
- Уур амьсгалын өөрчлөлт, түүнд өртөмхий байдлыг хэрхэн бүүруулах, дасан зохицож, даван туулах чадварыг бэхжүүлэх талаарх иргэдийн ерөнхий хандлага ямар байна?
 - Уур амьсгалын өөрчлөлттэй холбоотой эрэгтэйчүүд, эмэгтэйчүүдийн дунд давамгайлж буй байгаль орчны ба зан үйлийн ямар дадлууд байна вэ?
 - Байгаль орчны өөрчлөлтөд дасан зохицохын тулд ямар нэг арга хэмжээ авч байсан өмнөх туршлага байгаа эсэх?
 - Өдөр тутмын мэдээлэл, ялангуяа уур амьсгалын өөрчлөлттэй холбоотой

мэдээлэл авдаг сувгууд, хэвлэл мэдээллийн хэрэгсэл түүнтэй холбоотой ямар дүр зураг ажиглагдаж байна вэ?

5. Нийгэм олон нийт, ялангуяа эмзэг бүлгүүдийн дунд уур амьсгалын өөрчлөлтийн талаар мэдээлэл түгээх, ойлголтыг нь нэмэгдүүлэх ямар үр дүнтэй аргууд байж болох вэ?

- Олон нийтийн ойлголт, мэдлэгийг нэмэгдүүлэх компанит ажлыг түгээн дэлгэрүүлэх, брэнд/тогтмол үйл ажиллагаа болгох шаардлагатай юу?

- Уур амьсгалын өөрчлөлтийн тухай асуудлыг гол оролцогч талуудад хүргэхдээ тэдэнд хамаатай, чухал гэдгийг хэрхэн ойлгуулах вэ?

- Олон нийтэд нэр хүндтэй, итгэл үнэмшил төрүүлэхүйц институт юм уу байгууллагууд байна уу?

6. Иргэд, олон нийт, гол оролцогч талуудын хувьд уур амьсгалын өөрчлөлттэй холбоотой асуудлыг шийдвэрлэхийн тулд ямар арга хэмжээ авч хэрэгжүүлэх шаардлагатай гэж үзэж байна вэ?

- Олон нийт болон оролцогч талуудаас уур амьсгалын өөрчлөлттэй холбоотой үйл ажиллагаануудад дэмжлэг үзүүлж байна уу?

- Олон нийт болон оролцогч талууд ямар асуудлыг нэн тэргүүнд авч үзэж байна вэ?

7. Уур амьсгалын өөрчлөлттэй холбоотой асуудлыг түгээн дэлгэрүүлэхэд Монгол Улс бэлэн эсэхийг оролцогч талууд хэрхэн үнэлж байна вэ?


- Оролцогч талуудын дунд чадвартай холбоотой ямар хэрэгцээ байна вэ?

2.2 Судалгааны дизайн ба мэдээлэл цуглуулах аргууд

Судалгааны асуултуудад бүрэн хариулахын тулд энэхүү хөндлөн огтлолын судалгааны загварчлалын хүрээнд тоон ба чанарын арга хосолсон загварыг ашигласан. Юуны түрүүнд, судалгааны баг судалгааны арга зүй боловсруулах, асуултуудыг томъёолохын тулд холбогдох баримт бичиг, тайланг уншиж судлан, дүн шинжилгээ хийсэн. Судалгааны асуулга боловсруулахын өмнө, Улаанбаатар хот, хөдөө орон нутгийн 5 хүн оролцуулсан туршилтын ярилцлага хийсэн. Дараа нь, олон нийт, түүний дотор эмзэг бүлгүүдийг хамруулсан тоон асуулга боловсруулсан. Мөн фокус бүлгийн ярилцлага (ФБЯ), гол оролцогч талуудын дунд хийсэн ганцаарчилсан ярилцлага (ГЯ) зэрэг гүнзгийрүүлсэн, чанарын судалгааны аргуудыг ашиглаж мэдээлэл цуглуулсан.

Энэхүү судалгааны дизайныг хүйсийн харьцааг тэнцүү байхаар боловсруулсан. Эрэгтэй, эмэгтэйчүүдийн төлөөллийг тэгш хамруулахын

Зураг 2 Судалгааны дизайн ба арга



зэрэгцээ, эмэгтэйчүүдэд өөрсдийгөө бүрэн илэрхийлэх боломж олгохын тулд нийт 9 фокус бүлгийн ярилцлагын 2-т нь зөвхөн эмэгтэйчүүдийг хамруулсан. Мөн хүйс хоорондын ялгаатай хэрэгцээ, асуудлыг тусгаж харуулахуйц байдлаар асуулгыг боловсруулсан.

Баримт бичгийн дүн шинжилгээ. Судалгааны баг баримт бичгийн дүн шинжилгээг дөрвөн чиглэлд хийж гүйцэтгэсэн. Үүнд:

1. Судалгаанд ашиглах гол ойлголт, нэр томъёо, арга зүйн хандлагыг тодорхойлох зорилгоор эрдэм шинжилгээний ба эрдэм шинжилгээний бус байгууллагуудаас сүүлийн 20 жилийн хугацаанд хийсэн уур амьсгалын өөрчлөлтийн мэдлэг, хандлага, дадлын судалгаануудад дүн шинжилгээ хийсэн.

2. Монгол Улс дахь уур амьсгалын өөрчлөлтийн экосистем, хөдөө аж ахуй, эрүүл мэнд, боловсрол, амьжиргаа болон эмзэг байдал бий болоход үзүүлж буй нөлөөтэй холбоотой ялгаатай сэдвүүдээр үндэсний ба олон улсын байгууллагуудаас хийсэн судалгаануудад хийсэн дүн шинжилгээ. Энэхүү дүн шинжилгээ нь мэдлэгийн зөрүү болон нөхцөл байдлын хувьд хамааралтай асуудал, асуултуудыг сонгож судлахад тус болсон.

3. Уур амьсгалын чиглэлд хэрэгжүүлсэн Засгийн газрын бодлого, хөтөлбөр болон зохицуулалтуудад дүн шинжилгээ хийсэн.

4. Уур амьсгалын өөрчлөлтийн талаарх мэдээлэл, харилцааг судлахад чиглэсэн олон улсын судалгаа, мөн Монголын хэвлэл мэдээллийн судалгаануудад дүн шинжилгээ хийсэн.

Асуулга. Асуулгыг компьютерын тусламжтайгаар авдаг ганцаарчилсан ярилцлагын (CAPI) аргыг ашиглан нүүр тулсан ярилцлага хэлбэрээр зохион байгуулсан. Асуулгаар дамжуулан хүн ам зүйн мэдээлэл, өрхийн онцлог шинж байдал, байршил, уур амьсгалын өөрчлөлтийн талаарх мэдлэг, хандлага, дадал болон хэвлэл

мэдээллийн хэрэглээ, харилцаа холбоотой гол мэдээллүүдийг цуглуулсан. Асуулгын хүрээнд нийт 13 аймгийн 18-аас дээш насны эрэгтэйчүүд, эмэгтэйчүүдтэй ярилцлага хийсэн.

Үндсэн дүрэм нь, судлаач судалгаанд оролцогчоос асуулт асууж, хариулт өгөхийг хүлээх ба таблет дээр гарч ирж буй хариултын сонголтуудыг чангаар уншиж өгөхгүй. Ялангуяа, эмзэг асуудлуудын хувьд, бусдад хүлээн зөвшөөрөгдөх гэж аль болох зөв хариулт өгдөг хандлагаас сэргийлэхийн тулд таблетын дэлгэц дээр 'бүү уншиж өг' гэсэн зааварчилгааг гарч ирэхээр тохируулсан. Мөн, зайлшгүй уншиж өгөх шаардлагатай сонголт бүхий цөөн асуултууд багтсан. Ийм тохиолдолд, судлаачийг хариултыг чанга уншиж өгөх тухай тухайлсан зааварчилгаа дэлгэц дээр гарч ирэхээр тохируулсан.

Зураг 3 Баян-Өлгий, Өвөрхангай аймгийн малчдаас судалгаа авч буй нь.



Фокус бүлгийн ярилцлага (ФБЯ). Олон нийтийн төлөөллийг хамруулсан нийт 9 ФБЯ-ыг зохион байгуулж, уур амьсгалын өөрчлөлттэй холбоотой итгэл үнэмшил, түршлага, санал нийлж буй, нийлэхгүй байгаа зүйлсээс гадна, уур амьсгалын өөрчлөлтийн шалтгаан, үр нөлөө, байгаль орчны өөрчлөлтүүд, тэдний авсан дасан зохицох арга хэмжээнүүдийн талаар ярилцсан. Уг ярилцлагын бас нэг зорилго нь оролцогчид аливаа мэдээллийг хэрхэн авдаг, хэвлэл мэдээллийн хэрэгслийг хэрхэн ашигладаг, ямар хэрэгцээ байгааг тодруулах явдал байсан. ФБЯ-д оролцогчдыг нийгэм-эдийн засгийн хувьд ялгаатай олон бүлгийн төлөөллийг хангах үүднээс эрэгтэй, эмэгтэй, залуу, өндөр настан, малчин, фермер, Цаатан болон Казак, уул уурхайн бүс нутаг болон хил орчмын алслагдмал газар амьдарч буй иргэд гэх мэт зорилтот байдлаар сонгож хамруулсан.

Хүснэгт 2 Ганцаарчилсан ярилцлагын тоо, оролцогч талуудаар

#	Оролцогч талууд	Ярилцлагын тоо
1	Шийдвэр гаргагчид	2
2	Засгийн газар, салбар яам, хэрэгжүүлэгч болон тохируулагч агентлагууд	13
3	Аймаг, сумдын удирдлагын төлөөлөл	14
4	Хувийн хэвшил-жижиг, дунд бизнес эрхлэгчид	4
5	Академи, судлаач, зөвлөхүүд	2
6	Медиа болон хэвлэл мэдээллийн төлөөлөл	6
7	Хөгжлийн түншүүд, дотоод болон олон улсын ТББ-ууд	8
	Нийт	49

2.3 Түүвэрлэлтийн арга зүй болон жинлэл


Түүврийн загварчлалыг судалгааны үр дүнг үндэсний түвшинд төлөөлөхүйц байхаар боловсруулсан. Судалгаанд, 2020 оны хүн ам, орон сууцны тооллогын дүнг эх олонлог болгож, давхраат, олон шатлалт кластер түүврийн аргыг ашигласан. Нийт түүврийн давхрааг харьцангуй ижил төрөл рүү шилжүүлэх нь давхраа доторх хазайлт, холбогдох түүврийн алдааг багасгаж, улмаар судалгааны үр дүнг илүү нарийвчлах боломж олгодог. Энэ нь хамгийн үр ашигтай, зардал хэмнэдэг арга юм. Түүврийн эхний шатанд, санамсаргүй байдлаар аймаг, сумдын таван бүс (Баруун, Зүүн, Төв, Хангай, Улаанбаатар)-ийг сонгосон. Түүврийн үндсэн нэгж (ТҮН) нь баг, хэсэг бөгөөд тэдгээрийг

пропорциональ магадлалт түүврийн аргаар сонгосон. Гурав дахь шатанд, 20 өрхийг системт түүврийн аргыг ашиглан санамсаргүй байдлаар сонгож авсан. Кластер тус бүрээс 20 өрх сонгох нь зардал, цаг хугацаа хэмнэх үр ашигтай бөгөөд түүврийн дизайны хувьд чанартай, үр дүнтэй байдлыг бий болгодог. Сүүлийн 12 сард тэнд амьдарч байгаа, 18 ба түүнээс дээш насны, өрхийн талаар мэдээлэл өгөх боломжтой хүнийг Киш Грид аргыг ашиглан сонгосон. Энэхүү арга нь сонголтын алдаа үүсэхээс сэргийлэх ашиг тустай бөгөөд тухайн өрхийг төлөөлөх гишүүнийг санамсаргүйгээр сонгох боломж олгодог. Судлаач нь өрхийн гишүүдийн насанд үндэслэн хүн тус бүрд харгалзах дугаар өгөх бөгөөд урьдчилан санамсаргүй байдлаар өгсөн тоонуудыг агуулсан хүснэгтийг ашиглаж оролцогчдыг сонгоно.

Үзүүлэлтүүдээс хүлээгдэж буй утга, холбогдох загварын нөлөө, шаардлагатай итгэх түвшин, зөвшөөрөгдөх алдааны хэмжээ, зорилтот хүн амын тоо, эзлэх хувь, хариултгүй ирэх асуулгын тоон таамгийг харгалзан түүврийн хэмжээг тодорхойлж, хоёр үзүүлэлтээр шинжилгээ хийсэн. Шинжилгээний үр дүнд, 95%-ийн итгэх түвшинтэйгээр, үндэсний хэмжээнд төлөөлөхүйц үр дүнг гаргаж чадахуйц нийт түүврийн хэмжээг 2800 орчим өрх байхаар тогтоосон. Түүвэрт нийт 140 ТҮН (хотод 96 ТҮН, хөдөөд 44 ТҮН)-ийг сонгож авсан. Үүний дагуу, судалгааг 13 аймгийн 26 сум, Улаанбаатар хотын бүх дүүргээс авсан.

Судалгааны дүн шинжилгээнд, өрхийн тэгш бус сонголтын алдаа, судалгаанд оролцогч хариулт

Зураг 4 Судалгаанд хамрагдсан багууд, экологийн бүсээр



Тайлбар: Газрын зурагт Дархан-Уул, Дархан XVII; Орхон – Жаргалант IV; Баян-Өлгий – Ногооннуур – VIII; Хэнтий – Биндэр VI багуудыг харуулаагүй. Газрын зургийн эх сурвалж: www.eis.mn. Судалгаанд сонгогдсон багуудыг бор өнгөөр тэмдэглэсэн болно. Судалгаанд хамрагдсан орон нутгуудын багыг хавсралт 2-оос харна уу.

өгөхгүй байх, дутуу хамруулах зэрэг асуудлыг, түүврийг жинлэх замаар шийдсэн. Энэхүү тайлангийн Хавсралт 3-т судалгааны түүврийн жинлэсэн түүвэр дэх хүн ам зүйн гол бүлгүүдийн тоймыг харууллаа.

2.4 Тоон болон чанарын дүн шинжилгээ

Мэдээллийн дүн шинжилгээ хийхээс өмнө өгөгдлийн санг бэлтгэж, хянан засварласан. Судалгаанд оролцогчид чөлөөт хариулт хэлж болох 'Бусад' хувилбарыг нээлттэй хариулт авах хэлбэрээр оруулж, ирсэн хариултуудыг дахин кодолсон.

Дескриптив статистик. Харьцуулсан шинжилгээ ба үялдаа холбоог харуулах энгийн коэффициентүүдийн тусламжтайгаар олон хувьсагч хоорондын хамаарлыг судалдаг. Судалгааны баг нь янз бүрийн бүлэгт гарч буй ялгаатай хариултууд нь статистикийн хувьд ач холбогдолтой эсэх талаар тайлагнадаг.¹²

Энгийн хамгийн бага квадратын үнэлгээ (OLS) эсвэл Шугаман Магадлалын Загвар (LPM).¹³ Мэдлэг, хандлага, дадлын бүрэлдэхүүн хэсгүүдийн нийт онооны хоорондох хамаарлыг судлахдаа нийт оноонд нэгэн зэрэг нөлөөлж буй бусад хувьсагчийг хянах нь статистикийн хувьд бэрхшээлтэй байдаг. Энгийн хамгийн бага квадратын үнэлгээгээр мэдлэг, хандлага, дадлын оноог гаргасан бөгөөд хүмүүсийн мэдлэгийг 'сайн', 'муу', хандлагыг 'сөрөг' эсвэл 'эерэг' гэж оноож үзэхийн оронд мэдлэг, хандлага, зан үйлд нөлөөлөх гол хүчин зүйлсийг тодорхойлоход ашигласан. Энгийн хамгийн бага квадратын үнэлгээ нь мэдлэг, хандлага, дадлын бүрэлдэхүүн хэсгийн ерөнхий чиг хандлага нь хүн ам зүйн ялгаатай байдал, нийгэм, эдийн засаг болон газар зүйн шинж чанар, хариулагчдын хэвлэл мэдээллийн хэрэглээний хэв маягаас хэрхэн хамаардаг болохыг тодорхойлоход ашиглагдсан.

дараалал бүхий өгөгдлийн ихэнх жишээнд Kruskal-Wallis тестийг хийсэн). Корреляцийн коэффициентын шинжилгээний хувьд, хоёр тасралтгүй хувьсагчдын хоорондын шугаман хамаарлын чиглэл болон хүчийг хэмждэг учраас бид Пирсоны корреляцийн коэффициентыг ашигласан.

¹³ Энэхүү техник нь Logit болон Probit загваруудтай харьцуулагдахуйц техник юм.

¹² Харьцуулсан шинжилгээний хувьд, бүлэг хооронд мэдэгдэхүйц ялгаа байгаа эсэхийг Хи-квадрат тестийг ашиглан тодорхойлсон (дэс

ҮНДСЭН БҮРЭЛДЭХҮҮН ХЭСГИЙН ШИНЖИЛГЭЭ (РСА). Энэ нь өгөгдлийн сан дахь хувьсагчийн тоог илүү цөөрүүлж бууруулах замаар өгөгдлийн санд буй хамгийн чухал хэв маягийг гаргаж, түүний хувьслыг онцлон харуулахад ашиглагддаг олон хувьсагчийн статистикийн техник юм (Manly, 1994). Математикийн хэллэгээр РСА нь хоорондоо хамааралгүй индекс буюу хэсгүүдийг үүсгэх бөгөөд хэсэг бүр нь эхний хувьсагчуудтай жинлэсэн шугаман хослол болдог. Бид хүн ам зүй, нийгэм, эдийн засгийн боломжит хувьсагчуудыг ашиглан мэдлэг, хандлага, дадлын бүрэлдэхүүн хэсэг бүр дээр энэ шинжилгээг хийсэн.

ЧАНАРЫН МЭДЭЭЛЛИЙН ДҮН ШИНЖИЛГЭЭ. Урьдчилан боловсруулсан агуулга, асуултын хүрээнд судалгааг авсан тул мэдээллийг задлан шинжлэхэд чиглүүлсэн аргачлалыг ашиглах нь хамгийн тохиромжтой. ФБЯ болон ганцаарчилсан ярилцлагад зориулж тодорхой хэв маягийг үүсгэхэд туслахуйц тодорхой ангилал бүхий кодбүүхийг тусад нь боловсруулсан. Үр дүнд бий болсон өгөгдлийн хэв загваруудыг тоон үр дүнг батлах, тайлбарлах эсвэл дүрслэхийн тулд хураангуйлан харуулсан.

2.5. Техникийн зөвлөгөөн

Судалгааны баг нь тоон ба чанарын өгөгдлийн шинжилгээнд үндэслэн төрийн ба төрийн бус байгууллагууд, хэвлэл мэдээллийн агентлагууд, хөгжлийн түншлэгчид, хувийн хэвшлийн төлөөлөгчид болон эрдэм шинжилгээний ажилтнууд зэрэг гол оролцогч талуудад урьдчилсан үр дүнг танилцуулах, тайланд тусгасан гол санал зөвлөмжүүд дээр санал авах зорилгоор зөвлөлдөх уулзалтыг 2022 оны 11-р сарын 30-ны өдөр зохион байгуулсан.

2.6 Хүрээ ба хязгаарлагдмал тал

Энэхүү судалгааны хүрээ нь дараах зүйлсийг агуулсан:

1. Энэхүү судалгаа нь уур амьсгалын

өөрчлөлтийн тухай шинжлэх ухаанч үнэлгээ хийх эвсэл тэдгээрийн туршлагыг цаг уурын бүртгэл мэдээлэлтэй харьцуулан харуулах зорилготой бус, харин уур амьсгалын өөрчлөлттэй холбоотой хүмүүсийн ойлголт, туршлагыг харуулахад чиглэсэн юм. Энэхүү мэдлэг, хандлага, дадал болон хэвлэл мэдээллийн хэрэглээний тухай тайлан нь уур амьсгалын өөрчлөлтийн эмзэг байдлыг бууруулах, хүн ам, олон нийтийн дунд тэсвэртэй байдлыг бий болгоход чиглэсэн мэдлэг, чадавх бэхжүүлэхэд чиглэсэн үйл ажиллагаа болон улс орныг мэдээллээр хангахад тусална.

2. Өрхүүд болон олон нийтэд уур амьсгалын өөрчлөлтөөс үүдэн бий болсон нийгэм-эдийн засгийн үр нөлөөг шууд хэмжихийг зориогүй. Жишээлбэл, судалгааны хүрээнд уур амьсгалын өөрчлөлтөөс үүдсэн гамшгуудын дүнд бий болсон аюул, гарз хохирлыг үнэлээгүй.
3. Гол оролцогч талууд болон судалгааны асуултуудыг сонгохдоо, салбарын (эрчим хүрч, эрүүл мэнд, хөдөө аж ахуй, уул уурхай) онцлогийг харгалзсан. Гэхдээ, судалгаанд тодорхой салбарыг тусгайлан авч үзээгүй тул салбарын түвшинд төлөөлөхүйц байж чадахгүй юм.
4. Судалгаа нь институтийн түвшин дэх уур амьсгалын өөрчлөлтийн талаарх мэдлэг, хандлага, дадлыг зураглах, гарч буй өөрчлөлтийг мөшгөхийг зориогүй болно.

Эргэн санахтай холбоотой алдаа. Судалгаанд оролцогсдод сүүлийн арван жилд тохиолдсон байгалийн гамшиг, цаг агаарын элдэв үзэгдлийн талаар болон сүүлийн 12 сард уур амьсгалын өөрчлөлтийн талаар ямар эх үүсвэрээс мэдээлэл авч байгаа тухай асуултыг багтаасан. Өнгөрснийг эргэн сануулахуйц ийм төрлийн асуултыг аль болох хязгаарласан ч, өнгөрснийг эргэн санахтай холбоотой хазайлт, алдааг үүсгэж болзошгүй юм. Тиймээс асуултыг аль болох ойлгомжтой, өнгөрсөн зүйлсийг хялбар санах байдлаар боловсруулсан.

Түүвэр. Түүвэр хийхдээ үндэсний хэмжээнд

төлөөлөхүйц байдлыг нь хангасан боловч эдгээрийг бус, аймгийн түвшинд задлах боломжгүй юм. Цаашлаад, судалгаанд хорих газар, хамгаалах байр, сэтгэцийн эрүүл мэндийн төвүүдэд байгаа иргэд, насанд хүрээгүй хүүхдийг хамруулаагүй. Мөн өрхийн судалгаанд ЛГБТКИ гишүүдийг эсхүл хууль болон нийгмийн хэм хэмжээгээр гадурхагдсан өрхийн гишүүд бүрэн хамрагдаагүй байж болно. Эдгээрийг давах үүднээс дээрх төлөөлөл бүрэн ороогүй бүлгүүдийг ФБЯ-д хамруулахыг хичээсэн.

3. НӨХЦӨЛ БАЙДАЛ

3.1 Уур амьсгалын өөрчлөлтийн өнөөгийн нөхцөл байдал

Уур амьсгалын өөрчлөлтийн нөлөө, түүнд өртөх байдал. Монгол орон нь газар зүйн байрлалын хувьд, далайн түвшнээс дээш өргөгдөж, өндөр уулс нуруудаар хүрээлэгдсэн, Евро-Азийн төвд орших далайд гарцгүй, эх газрын эрс тэс уур амьсгалтай улс юм. Сүүлийн 80 гаруй жилийн хугацаанд Монгол орны агаарын хэм жилийн дунджаар 2.25°C-аар нэмэгдсэн байна.¹⁴ Манай улс дэлхийн уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөнд ихээр өртөж байгаа орнуудын нэгд зүй ёсоор ордог бөгөөд үүний үр дүнд цөлжилт, хөрсний доройтол, усны хомсдол, дулааны улиралд орох хур тунадасны хэмжээ буурах, уур амьсгалын өөрчлөлтөөс үүдэлтэй эрс тэс үзэгдлийн тоо хэмжээ нэмэгдэх зэрэг олон үзүүлэлтээр илэрч байна. Эдгээр цаг агаарын гаралтай, аюулт, гамшигт үзэгдэл нь өнөөгийн эмзэг экосистем, бэлчээрийн мал аж ахуй, газар тариалангийн салбаруудад ихээр нөлөөлж, хүн амын амьжиргаа, уламжлалт соёл, цаашлаад Монгол Улсын эдийн засгийг уур амьсгалын өөрчлөлтөд эмзэг, өртөмтгий болгоод байна.¹⁵ 2021 онд уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөлөлд эмзэг, өртөмтгий орныг тодорхойлох ND-GAIN индексээр Монгол Улс 53.5 оноо буюу эмзэг байдлын оноо=0.391 (0-1 оноогоор авч үзвэл бага байвал илүү сайн), бэлэн байдлын зэргээрээ 181 орноос оноо=0.460 (0-1 оноогоор өндөр байвал сайн) оноогоор 64-т жагссан байна. Уг судалгаагаар манай орныг эмзэг, өртөмтгий, сорилтуудаа тодорхойлох шаардлагатай улс орны ангилалд багтааж, эдгээрийг даван туулах, дасан зохицох боломжуудыг бүрдүүлэх боломжтой хэмээн тодорхойлсон байна.¹⁶

¹⁴ Байгаль орчин, аялал жүүлчлалын яам, 2020 оны Парисын хэлэлцээрийг хэрэгжүүлэхэд үндэсний хэмжээнд тодорхойлсон хувь нэмэр

¹⁵ Дэлхийн Банк Групп, Азийн Хөгжлийн Банк, Уур амьсгалын эрсдэлтэй орны танилцуулга: Монгол, 2021

¹⁶ Нотр Дамын их сургууль, ND-GAIN улсын индекс, 2021, <https://gain.nd.edu/our-work/country-index/> Available at:




Байгалийн гамшигт, аюулт үзэгдлүүд. НҮБ-ын Уур амьсгалын өөрчлөлтийн суурь конвенцын Үндэсний гуравдугаар тайлан-илтгэлд, эмзэг байдлын үнэлгээгээр уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөнөөс бий болох байгалийн аюулт, гамшигт үзэгдлийн эрсдэл, түүний нүүрлэх нийт хувь хэмжээ 2046-2065 он хүртэл нийт газар нутаг, дийлэнх аймгийн хэмжээнд өсөх хандлагатай гэж тодорхойлсон. (Зураг 5-д үзүүлэв). Түүнчлэн, агаарын хэмийн өсөлт зэрэг хүчин зүйлсийн улмаас хэт халалт, ган нэмэгдэх хандлагатай байгаа нь зудын (Монгол орны онцгой хүйтэн, хахир өвлийн байгалийн үзэгдэл) давтамж ихсэж, эрч нь ширүүсэхээр төлөвтэй байна. Аадар борооны ихэссэнээр, хөрсний гулсалт, элэгдэл, үер болох эрсдэл өндөр байна. Гангийн давтамж нэмэгдсэнээр, хуурайшилт, ган гачиг эрчимжиж, бэлчээрийн үржилшимийг багасгаж, цөлжилтийг хурдасгаж байна. Сүүлийн 20 гаруй жилд ган, зуд, үер зэрэг байгалийн аюулт, гамшигт үзэгдлийн тоо хоёр дахин нэмэгдсэн нь улс орны нийгэм, эдийн засагт сөргөөр нөлөөлж буй талаар олон тоо баримт, судалгаа гарсан байна.¹⁷ Үүний зэрэгцээ, уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөлөл нийгмийн эрүүл мэнд, амьжиргаанд шууд ба шууд бусаар нөлөөлж буй талаар хэд хэдэн судалгаанд дурджээ. Амьсгалын замын өвчлөл, зүрх судасны өвчлөл хүн амын дунд түгээмэл байгаа бөгөөд энэ нь уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөллөөс шалтгаалан нэмэгдэх төлөвтэй байна.¹⁸ Түүнчлэн IFRC-ээс уур амьсгалын өөрчлөлт, нийгмийн эрүүл мэндийн чиглэлээр хийсэн судалгаанд, уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөлөөгөөр зоонозын болон хачигт халдварт өвчлөлийн эрсдэл нэмэгдэж, нийгмийн эрүүл мэндэд шууд бусаар нөлөөлж болзошгүй гэж дурдсан байна.

Түүнчлэн IFRC-ээс уур амьсгалын өөрчлөлт, нийгмийн эрүүл мэндийн чиглэлээр хийсэн судалгаанд, уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөлөөгөөр зоонозын болон хачигт халдварт өвчлөлийн эрсдэл нэмэгдэж, нийгмийн эрүүл мэндэд шууд бусаар нөлөөлж болзошгүй гэж дурдсан байна.

<https://gain.nd.edu/our-work/country-index/>

¹⁷ USAID, МУ-ын уур амьсгалын эрсдэлийн танилцуулга 2017, https://www.climatechange.org/sites/default/files/asset/document/2017_USAID%20ATLAS_Climate%20Risk%20Profile%20-%20Mongolia.pdf

¹⁸ IFRC, Уур амьсгалын өөрчлөлтийн эрүүл мэнд, амьжиргаанд үзүүлэх нөлөө: Монгол улсын үнэлгээ, 2021 https://www.climatecentre.org/wp-content/uploads/RCRC_IFRC-Country-assessments-MONGOLIA-V8.pdf

Зураг 5 Монгол орны бүс нутгуудын байгалийн өөрчлөлтийн ирээдүйн зураглал

Уг судалгаагаар хүүхэд, эмэгтэйчүүд, малчид зэрэг эмзэг бүлгийнхэн уур амьсгалын нөлөөлөлд өртөх өндөр эрсдэлтэй байгааг онцолжээ.

Монгол Улсын хүлэмжийн хийн тооллогоор (2014) улсын нийт ялгарлын 50.08%-ийг **эрчим хүчний салбар**, 48.5%-ийг хөдөө аж ахуйн салбар тус тус эзэлжээ. Гэсэн хэдий ч, уул уурхайн салбартай холбоотой эрчим хүчний эрэлт, байгалийн гамшигт ихээр өртөж буй хөдөө аж ахуйн салбаруудын ялгарлын эх үүсвэрийн эзлэх хувь жилээс жилд эдийн засаг, уур амьсгалын хүчин зүйлээс хамаарч харилцан адилгүй хувьсан өөрчлөгдөж байна. Дэлхийн хүлэмжийн хийн ялгаралтай харьцуулахад Монгол улсад бага байгаа ч, эрчим хүчний салбар нь дотоодын, чанар муутай нүүрсний нөөцтэй улмаас нэг хүнд ногдох эрчим хүчний хэрэглээ өндөр хэвээр байна. Эрчим хүч үйлдвэрлэлийн 90 гаруй хувийг нүүрс эзэлдэг бөгөөд дамжуулалт, түгээлтийн алдагдал нь үр ашиггүй хэрэглээг бий болгож байна. Чанар муутай түүхий нүүрс түлж, ахуйн болон бусад хэрэгцээнд ашиглах нь нийгэмд тулгамдаж буй томоохон асуудлуудын нэг болж байгаа бөгөөд орчны болон агаарын бохирдлыг нэмэгдүүлж хүний эрүүл мэндэд сөргөөр нөлөөлсөөр байна.¹⁹

Ойн салбар, улсын нийт газар ашиглалтын 73.5 орчим хувийг хөдөө аж ахуйн зориулалтын газар эзэлдэг бол, ердөө 9 орчим хувийг ой бүхий газар эзэлдэг. Монгол орны сэрүүн бүсийн шилмүүст ойд (бореал ой) уур амьсгалын өөрчлөлтийн болон хүний үйл ажиллагааны нөлөөнд хамгийн ихээр өртөж байна. Ойн түймэр, хортон шавж, хууль бусаар мод бэлтгэх, бэлчээрийн даац

хэтрэх зэрэг хүчин зүйлээс шалтгаалан ойн эзлэх талбай багасаж байгаа талаар олон судалгаа, тайланд дурдсан. Түүнчлэн хур тунадас буурч, хуурайшилт болох эрсдэл өсөн нэмэгдсэнээр ой мод хомсдох, ойн унангийн хэмжээнд нөлөөлж, улмаар хуурайшилт, түүнээс үүдэх түймрийн эрсдэлийг улам бүр нэмэгдүүлж байна.

Газар тариалангийн салбар. 1960-аад оноос хойш хөдөө аж ахуйн салбар Монгол Улсын хөгжилд чухал байр суурь эзэлсээр ирсэн бөгөөд өнөөгийн байдлаар тус салбарын тариалангийн үйлдвэрлэлийн хэмжээ бага, дотоодын хүнсний ногооны хэрэгцээний ердөө 49 орчим хувийг хангадаг.²⁰ Гэвч энэ тоо жилээс жилд хувьсан өөрчлөгдөх магадлалтай бөгөөд ургацын хэлбэлзэл их, тогтворгүй байгаа нь эх газрын хуурай уур амьсгалт, ган гачиг давтамжаас шалтгаалж байна. Монгол Улс НҮБ-ын Уур амьсгалын өөрчлөлтийн суурь конвенцын хэрэгжилтийн үндэсний гуравдугаар тайлан илтгэлдээ улаан буудайн ургацын гарц ирээдүйд их хэмжээгээр, 2080 он гэхэд 20%-50%-иар буурах төлөвтэй гэж дурдсан байна.

Мал аж ахуй салбар. нь улс орны эдийн засаг, экспортын орлогод чухал байр суурь эзэлдэг. Гэвч малын тоо толгойн өсөлт бэлчээрийн ашиглалтыг нэмэгдүүлснээр, уур амьсгалын өөрчлөлт төдийгүй, улс орны хөгжлийн томоохон асуудал болоод байна. Мал аж ахуйн бүтээгдэхүүн (мах, сүү, ноос, ноолуур зэрэг) нь улсын эдийн засгийн чухал бүрэлдэхүүн хэсэг,

²⁰ Дэлхийн банкны групп болон АХБ, Уур амьсгалын эрсдэлтэй орны танилцуулга, 2021 он <https://www.adb.org/sites/default/files/publication/709901/climate-risk-country-profile-mongolia.pdf>

хүнсний салбарын 80 гаруй хувийг бүрдүүлдэг бөгөөд уур амьсгалын өөрчлөлтөөс үүдэлтэй хүчин зүйлүүдийн нөлөөлөлд өртөх магадлал өндөр байна.

Уул уурхай. Монгол Улсад уул уурхайн олборлолт эхэлснээр эдийн засгийн хөгжилд эергээр нөлөөлж, 2010-2014 оны хооронд эдийн засгийн оргил өсөлтийг болгосон. Аж үйлдвэрийн салбар нь манай орны ДНБ-ий гуравны нэгийг бүрдүүлдэг бөгөөд 2007-2014 онд (ялангуяа уул уурхай) эдийн засгийн эрчимтэй хөгжлийг авчирсан. Сүүлийн үед дэлхийн зах зээлд нүүрс, төмрийн хүдэр, зэс болон бусад бүтээгдэхүүний экспортын үнэ буурсантай холбоотойгоор 2012 оноос хойш эдийн засгийн өсөлт хурдацтай саарч, орлого, ажил эрхлэлт буурахад хүрсэн. Энэхүү оргил үеийн эдийн засгийн өсөлтийн үр өгөөж нь ард иргэд, олон нийт, ялангуяа нийгмийн эмзэг бүлэг, орон нутагт эрх тэгш хүртээмжтэй хуваарилагдаагүй. Дотоодын ядуурлын түвшин 27.8%-тай өндөр хэвээр байсаар байна ²¹.

Ирэх арван жилд Монголын эрчим хүчний эрэлт, цахилгаан, дулаан, түлшний хэрэглээнээс шалтгаалж хоёр дахин өсөх төлөвтэй байна. Эдгээр байгаль орчин, нийгэм-эдийн засгийн шинжтэй нөхцөл байдал нь уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох, сааруулах, хүлэмжийн хийг бууруулах арга хэмжээнд ихээхэн бэрхшээл, сорилт учруулах бөгөөд хүний нөөцийн болон байгууллагын чадвар сул, санхүүжилт дутмаг, нарийн мэргэжил, техникийн нөөц бололцоо хязгаарлагдмал, олон нийтийн мэдлэг, дэмжлэг сул зэргээс шалтгаалан улам даамжрах хандлагатай байна.

3.2 Уур амьсгалын өөрчлөлтийн бодлого, байгууллагын зохицуулалт

Уур амьсгалын өөрчлөлттэй холбоотой гол бодлого, зохицуулалтын тогтолцоо

Монгол Улс “НҮБ-ын Уур амьсгалын өөрчлөлтийн суурь конвенц (НҮБУАӨСК)”-ийг 1993 онд, “Киотогийн протокол”-ийг 1999 онд,

²¹ Үндэсний статистикийн хороо, 2022, https://1212.mn/stat.aspx?LIST_ID=976_L19

Уур амьсгалын өөрчлөлтийн тухай “Парисын хэлэлцээр”-ийг 2016 онд тус тус зөвшөөрч, нэгдэн орсон. Эдгээр олон улсын баримт бичгээс гадна, НҮБ-ийн хүрээний томоохон баримт бичгүүд болох “НҮБ-ын Биологийн олон янз байдлын тухай конвенц”, “Цөлжилттэй тэмцэх НҮБ-ын конвенц”-ийг 1993, 1996 онуудад тус тус соёрхон баталж, нэгдэн оржээ.

Парисын хэлэлцээрийн хүрээнд 2015 оны 9-р сард Монгол Улс 2030 он гэхэд хүлэмжийн хийн ялгарлыг 14%-иар бууруулах зорилтыг дэвшүүлэн анхны ҮТХН-ээ өргөн мэдүүлсэн бол, 2020 онд Монгол Улсын Засгийн газар хүлэмжийн хийн ялгарлыг өнөөгийн эдийн засгийн хөгжлийн хувилбартай харьцуулан 2030 он гэхэд 22.7%-иар бууруулахаар ҮТХН-ээ ахиулсан. ҮТХН-ийн хүрээнд авч хэрэгжүүлж буй арга хэмжээний дийлэнх нь эрчим хүчний хэмнэлтийг бий болгох, сэргээгдэх эрчим хүчийг ашиглан хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах, малын тоо толгойг тэнцвэржүүлэх зэрэг дасан зохицох зарим нэг арга хэмжээтэй уялдуулан уур амьсгалын өөрчлөлтийг сааруулахаар төлөвлөсөн. Уур амьсгалын өөрчлөлтөд эмзэг, нөлөөлөлд ихээр өртөж буй Монгол Улсын хувьд дасан зохицох, чадварыг бэхжүүлэх арга ажиллагаа, түүнд чиглэсэн хэрэгцээнд нийцсэн үйл ажиллагаанууд нэн тэргүүний арга хэмжээ боловч ҮТХН-ийн баримт бичигт төдийлөн нарийн тусаагүй байна.

Монголд уур амьсгалын өөрчлөлтийн асуудлыг зохицуулах салбар дундын шинжтэй, олон талын үйл ажиллагааг зохицуулсан тусгайлсан хууль, эрх зүйн орчин байдаггүй ч, одоо мөрдөж буй салбарын зарим нэг хууль, журмуудад тодорхой хэмжээгээр туссан. Гэсэн хэдий ч, уур амьсгалын өөрчлөлт, түүнийг сааруулах, дасан зохицох арга хэмжээ нь үндэсний хэмжээний томоохон бодлогын баримт бичиг, хөгжлийн хөтөлбөрүүд, салбарын түвшинд цогц байдлаар тусан хэрэгжиж байна.

¹⁹ IFRC, Уур амьсгалын өөрчлөлтийн эрүүл мэнд, амьжиргаанд үзүүлэх нөлөө: Монгол улсын үнэлгээ, 2021 он

“Алсын хараа-2050”: Ядуурлыг бууруулах, ногоон хөгжлийн бий болгох, нүүрстөрөгч багатай эдийн засагт шилжих, боловсролын тогтолцоо, хүйсийн тэгш байдлыг хангах, нийгмийн хөгжлийг эрчимжүүлэх, урт хугацаанд даван туулах, тэсвэртэй байдлыг бий болгох зэрэг агуулгын хүрээнд нийт есөн үндсэн зорилт бүхий урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичиг юм. Уг бодлогыг НҮБ-ын Тогтвортой хөгжлийн зорилтуудтай уялдуулж боловсруулсан бөгөөд дараагийн гучин жилд гурван үе шаттайгаар хэрэгжүүлнэ.

Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл: Ногоон хөгжил, тогтвортой санхүүжилтийн тогтолцоог бий болгох, талуудын оролцоог нэмэгдүүлэх, чадварыг бэхжүүлэх замаар уур амьсгалын өөрчлөлтийг сааруулах, дасан зохицох үндэсний чадварыг бүх түвшинд хөгжүүлэх зорилготой дунд хугацааны нэгдсэн бодлогын баримт бичиг юм. Уг баримт бичигт хүлэмжийн хийн ялгарлыг 12.3%-иар бууруулах, хог хаягдлын дахин боловсруулалтыг 27%-д хүргэх зэрэг тоон үзүүлэлтийг тодорхойлсон зорилтуудыг тусгасан байна.

Шинэ сэргэлтийн бодлого: Эдийн засгийн тогтвортой байдлыг хангах, амьжиргааг нэмэгдүүлэх, төр, хувийн хэвшлийн хамтын ажиллагаа, хөрөнгө оруулалтыг эрчимжүүлэх зорилготой энэхүү бодлогыг нь Алсын хараа 2050 бодлоготой нягт уялдаатай боловсруулжээ. Төлөвлөгөөний гол онцлог нь ногоон хөгжил, ойжуулалт, ойн нөхөн сэргээлтээр дамжуулан цөлжилттэй тэмцэх, эрчим хүчний тогтвортой эх үүсвэрийг нэмэгдүүлэхэд чиглэжээ. Гэвч уур амьсгалын өөрчлөлттэй холбоотой олон нийтийн үйл ажиллагаанд иргэдийн мэдлэг, оролцоог сайжруулах талаар цогцоор тусгагдаагүй байна.

Хөгжлийн зорилтот хөтөлбөрүүд (хүний хөгжлийн зорилтот хөтөлбөр; нийгмийн хөгжлийн зорилтот хөтөлбөр; эдийн засгийн болон дэд бүтцийн хөгжлийн зорилтот хөтөлбөр; байгаль орчны зорилтот хөтөлбөр; засаглалын зорилтот хөтөлбөр; үндэсний өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх зорилтот хөтөлбөр;) нь

“Алсын хараа-2050” зорилт, зорилтыг салбарын түвшинд хэрэгжүүлэхэд чиглэсэн бодлогын баримт бичиг юм. Уг хөтөлбөрүүд нь бүх салбарын оролцоотойгоор хэрэгжихэд чиглэсэн бөгөөд, оролцогч талуудын үүрэг, хариуцлагыг тодорхой тусгасан. Тухайлбал “Байгаль орчны зорилтот хөтөлбөр” нь уур амьсгалын өөрчлөлтийн асуудлыг шийдвэрлэх, хууль эрх зүйн болон бодлогын тогтолцоог бий болгох, нүүрстөрөгч багатай хөгжлийг бий болгох, дасан зохицох чадвар бүхий эдийн засаг, нийгмийг цогцлоох, гамшгийн эрсдэлийн менежментийг сайжруулах зэрэг стратегийн шинжтэй хамтын ажиллагааны дүнд хэрэгжих орчныг бүрдүүлсэн байна. Олон нийтийн мэдлэг дээшлүүлэх арга хэмжээнд чиглэсэн зорилтод “5.1.8. эрт сэрэмжлүүлэх тогтолцоо, дасан зохицох чадварыг бий болгох, 5.2.2. байгаль орчныг хамгаалах, уур амьсгалын өөрчлөлтийн талаарх хүүхэд, өсвөр үеийнхний мэдлэг, оролцоог санаачилга, аян өрнүүлэх замаар нэмэгдүүлэх” хэмээн тусгажээ.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилгаар “Тэрбум мод” аяны хүрээнд уур амьсгалын өөрчлөлт, цөлжилттэй тэмцэхэд олон нийтийг оролцоог бий болгох, нийгэм, залуу хойч үедээ мод тарих, ойжуулах, ойг хамгаалах ач холбогдлыг ойлгуулан, соёлыг төлөвшүүлэх зорилтыг дэвшүүлж, дараагийн 10 орчим жилд хэрэгжүүлэхээр төлөвлөжээ. Энэхүү санаачилгын үр дүнд уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох, нийгмийн амьжиргааг сайжруулах, олон нийтийн мэдлэг, чадварыг хэвлэл мэдээллээр дамжуулан нэмэгдүүлэх боломж бүрдэхийн сацуу, уур амьсгалын шийдэлд иргэдийн оролцоог эрс нэмэгдүүлэх нөхцөл бүрдэх юм.

Уур амьсгалын өөрчлөлтөөс үүсэж буй эрсдэл, өртөмтгий байдлыг хувь хүн, байгууллага, улс орон, оролцогч талууд дангаараа даван туулахад бэрхшээлтэй бөгөөд төр, хувийн хэвшил, ТББ, иргэний нийгэм, олон нийтийн оролцоо, салбар дундын хамтын ажиллагааны хүрээнд хамтран хэрэгжүүлэх нь чухал юм. Иймд судалгаа, тоо баримт, шинжлэх ухаанд суурилан одоогийн байгаль орчны тулгамдсан асуудлууд, уур амьсгалаас үүдэн гарах ирээдүйн нөлөөлөл,

Хүснэгт 3 Уур амьсгалын өөрчлөлттэй холбоотой бодлогын гол баримт бичгүүд

Олон улсын гэрээ, конвенцүүд

- Уур амьсгалын өөрчлөлтийн тухай НҮБ-ын суурь конвенц, 1993 он
- Киотогийн протокол, 1999 он
- Парисын хэлэлцээр, 2016 он

Хууль, эрх зүйн орчин

- Агаарын чанарын тухай хууль (1995, 2012 онд нэмэлт өөрчлөлт оруулсан)
- Байгаль орчныг хамгаалах тухай хууль (1995 он, 2007, 2012 онд нэмэлт өөрчлөлт орсон)
- Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль (2012)
- Хөрс хамгаалах, цөлжилтөөс сэргийлэх тухай хууль (2012)
- Газар ашиглалтын тухай хууль (2002)
- Ойн тухай хууль (2012)
- Эрчим хүчний тухай хууль (2001, 2015 онд нэмэлт өөрчлөлт оруулсан)
- Эрчим хүчний хэмнэлтийн тухай хууль (2015)
- Сэргээгдэх эрчим хүчний тухай хууль (2007, 2015, 2017 онд нэмэлт өөрчлөлт оруулсан)
- Усны тухай хууль (1995 он, 2004, 2010, 2012 онд нэмэлт өөрчлөлт оруулсан)
- Хог хаягдлын тухай хууль (2012 он, 2017 онд шинэчлэгдсэн)
- Гамшгаас хамгаалах тухай хууль (2003, 2017 онд нэмэлт өөрчлөлт оруулсан)

Бодлогын хүрээ

- Алсын хараа - 2050 (2020)
- Үндэсний тодорхойлсон хувь нэмэр (2015, 2019 онд шинэчлэгдсэн)
- Монгол улсын 2021-2025 онд хэрэгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл (2020)
- Засгийн газрын үйл ажиллагааны төлөвлөгөө 2020-2024 (2020)
- Шинэ сэргээлтийн бодлого (2021)
- Салбарын "Зорилтот хөгжлийн хөтөлбөрүүд" (2022)

хямрал, үр дагаврыг тооцож, урьдчилан сэргийлэх арга хэмжээг цогцоор авах нь урт хугацааны үр ашигтай байх юм.

Уур амьсгалын өөрчлөлт нь салбар дундын асуудал бөгөөд оролцогч талуудын хамтын ажиллагаа, харилцаа холбоонд (Зураг 6-д үзүүлсэнчлэн) түшиглэн хэрэгждэг. Уур амьсгалын өөрчлөлттэй холбоотой шийдвэр гаргах, үйл ажиллагааг хэрэгжүүлэх эрх, үүрэг хариуцлага өнөөгийн засгийн газрын бүтцээр хэд хэдэн төрийн байгууллагад харьяалагддаг.

БОАЖЯ нь уур амьсгалын өөрчлөлттэй холбоотой салбар дундын зохицуулалтыг хангах, цогцоор хэрэгжүүлэх төрийн захиргааны

төв байгууллага бөгөөд уг асуудлын хүрээнд Монгол Улсын Засгийн газрын үйл ажиллагаа, НҮБ-ын Уур амьсгалын өөрчлөлтийн суурь конвенцод нийцүүлэн дараах 4 үндсэн зорилтыг хэрэгжүүлдэг:

1. Байгаль орчин (уур амьсгалын өөрчлөлт)-ны салбарын хууль тогтоомж, бодлого, хөтөлбөрийг боловсронгуй болгох, шинэчлэх, хэрэгжилтийг зохион байгуулах, зохицуулах;
2. Уур амьсгалын өөрчлөлтийг сааруулах, дасан зохицох үндэсний бодлого, арга хэмжээг тодорхойлох, Монгол Улсын олон улс дахь

Зураг 6 Гол оролцогч талууд болон засгийн газрын одоогийн үйл ажиллагаа/санаачилгууд



конвенц, гэрээ, хэлэлцээрийн биелэлтийг удирдан зохион байгуулах, хэрэгжилтийг хангах;

3. Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлт, хөгжлийн үйл ажиллагааг удирдах, зохицуулахад дэмжлэг үзүүлэхийн зэрэгцээ олон улсын хамтын ажиллагааг бэхжүүлэх,
4. Байгаль орчны чиглэлээр хэрэгжиж буй төсөл, хөтөлбөрийн үр өгөөж, үр ашгийг нэмэгдүүлэх менежментээр хангах;

Мөн, БОАЖЯ олон улсын түвшинд уур амьсгалын өөрчлөлтийн нэгдсэн бодлогын хэрэгжилтийг хангах, тухайлбал Үндэсний тайлан-илтгэл, Хоёр жил тутмын шинэчилсэн тайлан, үндэсний хүлэмжийн хийн тооллогыг эмхэтгэж, НҮБ-ын Уур амьсгалын өөрчлөлтийн суурь конвенцын нарийн бичгийн дарга нарын газарт хүргүүлэх зэрэг нэмэлт үүрэг гүйцэтгэдэг. Эдгээр томоохон зорилтуудыг багтаасан чиг үүргийг БОАЖЯ ба УАӨСХАТ гэсэн үндсэн хоёр байгууллага гүйцэтгэдэг. БОАЖЯ-ны Уур

амьсгалын өөрчлөлтийн газар, Ногоон хөгжлийн бодлого төлөвлөлтийн газар нь нэгдсэн бодлого, стратегийн түвшний асуудалд хяналт тавьдаг бол УАӨСХАТ нь гадаад хамтын ажиллагааны үйл ажиллагааг удирдан зохион байгуулж, мэргэжлийн зөвлөгөө өгч, төсөл хэрэгжүүлэн, хяналт тавих, үнэлэх, тайлагнах ажлыг хариуцан ажилладаг. Гэсэн хэдий ч УАӨСХАТ-ийн бүтэц нь БОАЖЯ-ны үндсэн дотоод бүтэцэд хамаарахгүй, өөрийгөө санхүүжүүлэх үүрэг бүхий төрийн өмчит үйлдвэрийн газрын зохион байгуулалттайгаар ажиллаж байна.

Засгийн газрын түвшинд, Уур амьсгалын үндэсний хороог 2019 онд байгуулсан. Уур амьсгалын бодлогын хэрэгжилтийн талаар шийдвэр гаргах салбар дундын засаглалыг бүрдүүлэх зорилгоор 2021 онд “Уур амьсгалын өөрчлөлт, цөлжилттэй тэмцэх үндэсний хороо” нэртэйгээр “Тэрбум мод” санаачилгын хүрээнд байгуулсан. Түүнчлэн НҮБ-ын Уур амьсгалын өөрчлөлтийн суурь конвенц болон НҮБ-ын Цөлжилттэй тэмцэх конвенцын хэрэгжилтийг хангаж удирдах чиг үүрэг уг хороонд шилжсэн.

Хорооны бүтэц 2022 онд өөрчлөгдөж, даргаар нь Ерөнхий сайдын ажилладаг байсан бол энэ үүрэг нь Шадар сайдад шилжсэн.

Бодлого, хөтөлбөрт тулгарч буй бэрхшээлүүд

НҮБ-ын УАӨСК-ын хүрээнд Монгол Улс уур амьсгалын өөрчлөлтийн талаар олон улсын хамтын ажиллагаанд идэвх санаачилгатай оролцон Киотогийн протокол болон Парисын хэлэлцээрийг соёрхон баталж, хүлэмжийн хийг бууруулах үндэсний хувь нэмрийг олон улсын түвшинд тодорхойлсон. Хэдийгээр уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох, сааруулах арга хэмжээг цогцоор амжилттай хэрэгжүүлэх бодлогын орчин бий болсон ч хязгаарлагдмал төсөв, санхүү, техник, хүний болон институтийн нөөц, чадвараас үүдэлтэй томоохон сорилтуудтай тулгарсаар байна (энэ тайлангийн 8-р бүлэгт илүү дэлгэрэнгүй авч үзсэн):

- Уур амьсгалын өөрчлөлтийн бодлогын зорилт, арга хэмжээг үндэсний, орон нутгийн, салбарын хөгжлийн төлөвлөгөө, хөтөлбөрт тусгаж хэрэгжүүлэх нь хангалтгүй, бүрэн бус.
- Уур амьсгалын өөрчлөлттэй холбоотой арга хэмжээний санхүүжилтийг, төсөвт суулгах байдал салбарын түвшинд хязгаарлагдмал. Төсвийг хуваарилах удирдамж байхгүй, уур амьсгалын өөрчлөлтөд авах хариу арга хэмжээ, тэргүүлэх чиглэл нь тодорхойгүй.
- Төрийн байгууллагуудын үүрэг, эрх мэдлийг тодорхой болгох зохицуулалт, хууль эрх зүйн орчин сул, үйл ажиллагаа нь ихэвчлэн БОАЖЯ-ны арга хэмжээнд тулгуурлан хэрэгждэг.
- Гамшгаас хамгаалах бэлэн байдал, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох асуудал хоорондын уялдаа бага, тогтолцооны чадвар сул байна.
- Бодлого боловсруулалтад оролцох олон нийтийн оролцоо дутмаг.

Уур амьсгалын өөрчлөлт, түүний тайлагналтай холбоотой мэдээллээр олон улсын болон дотоодын төсөл хөтөлбөр, тусламж дэмжлэг, боломжуудын талаар сэтгүүлчдийн дунд мэдээлэл солилцох уулзалтуудыг тогтмол зохион байгуулах

3.3 Судалгааны хүрээнд тодорхойлсон эмзэг байдал

Энэхүү судалгааны хүрээнд эмзэг байдлыг хүн ам зүйн шинж, нийгэм, эдийн засгийн нөхцөл болон газарзүйн /хүрээлэн буй орчны хүчин зүйлс/ хүчин зүйлсээр нь тодорхойлно. Одоогийн тэгш бус байдлаас гадна, уур амьсгалын өөрчлөлтөөс үүдсэн сөрөг үр дагаварт эмзэг бүлгийнхэн илүү өртөж байгаа бөгөөд уг тэгш бус байдлыг улам ихэсгэхээр байна. Уур амьсгалын өөрчлөлтийн үр нөлөө нь хувь хүний хүн ам зүйн байдал (нас, хүйс, бэлгийн харьцаа, арьсны өнгө, соёл, ёс зүй) болон нийгэм-эдийн засгийн (цагаачлалын байдал, орлого) шинж чанар, газар зүйн байршил (хөдөө, хот, экологийн бүс, бүс нутаг)-аас шалтгаалан ялгаатай байж болдог.²² Учир нь тэгш бус байдал, ядуурал нь хүмүүсийг нийгэм эдийн засгийн хөгжил дэвшлээс хойш татаж, дасан зохицох, тэсвэртэй байдлыг бий болоход саад болдог тул эмзэг бүлгийнхэн гол төлөв уур амьсгалын өөрчлөлт, холбогдох бусад холбогдолтой гамшигт өртөмхий байдаг. Үүнээс гадна, амьжиргааны эх үүсвэр нь байгалийн нөөцөөс хамааралтай бүлгүүдийн хувьд газар зүйн байршил нь тэднийг нийгэм, эдийн засгийн байдлаас үл хамааран эмзэг болгодог.²³

Уур амьсгалын эрсдэл болон аюул, өртөлт, эмзэг байдлын уялдаа холбоог харуулсан агуулгын хүрээг Гамшгийн эрсдэлийг бууруулах Нэгдсэн Үндэстний Байгууллагын Олон Улсын Стратеги.²⁴ ийн хүрээнд боловсруулсан байдаг. Мөн Гамбл ба Балбус (2016) хоёр байгалийн гамшгийн эрсдэлийг бий болгогч гурван хүчин зүйлсийг тодорхойлсон бөгөөд түүнд уур амьсгалын өөрчлөлт болон түүнтэй холбоотой эрсдэлд мэдрэмтгий хандах, тэдгээр эрсдэлд өртөх, уур амьсгалын хувьсал, өөрчлөлтөд хариу үйлдэл үзүүлэх буюу даван туулах дасан зохицох чадвар хэмээн онцолжээ.

Цаашилбал, НҮБ-ын Хүний Эрхийн Зөвлөлийн тодорхойлсноор, уур амьсгалын өөрчлөлт нь сөргөөр нөлөөлөх магадлалтай эмзэг

22 IPCC, Уур амьсгалын өөрчлөлт 2022: Үр нөлөө, Эмзэг байдал ба дасан зохицох, 2022

23 НҮБ, Дэлхийн нийгэм, эдийн засгийн судалгаа, 2016 https://www.un.org/en/development/desa/policy/wess/wess_archive/wess2016/ExecSummary_WESS2016.pdf

24 ISDR, UNISDR, Гамшгийн эрсдэлийг бууруулах, 2009 7817_UNISDRTerminologyEnglish.pdf (preventionweb.net)

бүлэгт хөгжлийн бэрхшээлтэй иргэд, хүүхэд, эмэгтэйчүүд, цөөнх зэрэг эмзэг болон/эсвэл ядуу бүлгийн хүмүүс төдийгүй усны хомсдол, цөлжилт, газрын доройтол, ган гачиг болон цаг уурын өөрчлөлтөөс үүдэлтэй эмзэг нөхцөл байдалд амьдарч буй хүмүүс ч багтаж болно гэжээ. Тиймээс энэ бүлгийн хүмүүсийн уур амьсгалын өөрчлөлтийн талаарх тэдний мэдлэгийн түвшинд онцгой анхаарч, тэдний дасан зохицох төлөвлөлт, хэрэгжүүлэлтэд нэн тэргүүнд туслах шаардлагатай бүлэг болгох нь чухал юм. Уур Амьсгалын Өөрчлөлтийн тухай НҮБ-ын Суурь Конвенцод дурдсанаар, эмзэг бүлэг, олон нийтийг тодорхойлсны дараагаар үндэсний дасан зохицох чиглэлийн эрх үүрэг, хүрээ, институтийн зохион байгуулалтдаа эдгээр бүлгүүдийг онцгойлон анхаарч, хэрэгцээг тусгах нь илүү хялбар хэмээн тэмдэглэжээ.²⁵

Монгол улсын хууль, тогтоомжуудад, гол төлөв нийгэм эдийн засгийн дутмаг шинжид нь үндэслэж ‘эмзэг бүлгийг’ тодорхойлдог. Тухайлбал, Нийгмийн халамжийн тухай хуулийн 3 дугаар зүйлд заасны дагуу эмзэг бүлгийн хүмүүст эрүүл мэндийн доройтолтой, гэр бүлийн халамж, асрамж дутагдалтай, бие даан, эсхүл бусдын тусламжгүйгээр хэвийн амьдрах боломжгүй, өвөрмөц хэрэгцээ бүхий иргэн, нийгмийн халамжийн дэмжлэг, туслалцаа зайлшгүй шаардлагатай өрхийн гишүүн эсхүл иргэд багтаж байна.²⁶ Уур амьсгалын өөрчлөлтийн энэхүү нөхцөл байдлын хүрээнд Монгол Улсад уур амьсгалын өөрчлөлт, холбогдох гамшигтай тэмцэх тухай хуулийн төсөл боловсруулахад ахиц гарч байсан хэдий ч эмзэг бүлгийг тодорхойлох, эмзэг бүлэгт үзүүлэх сөрөг нөлөөллийг багасгах зорилго бүхий тэдэнд тохирсон зохицуулалтууд дутагдсаар л байна. Олон нийтийн оролцоотой гамшгийн эрсдэлийг бууруулах үндэсний хөтөлбөр (2015) нь өнөөдрийг хүртэл тодорхой бүлгүүдэд чиглэсэн, гамшгийн эрсдэлийг бууруулах чиглэлээр тодорхой арга хэмжээ авч байгаа

²⁵ UNFCCC, Уур амьсгалын өөрчлөлтийг шийдвэрлэх үндсэн арга хэмжээний талаарх зөвшилцөл, 2021 <https://unfccc.int/news/cop26-reaches-consensus-on-key-actions-to-address-climate-change>

²⁶ Монгол улсын хууль, тогтоомжуудад, гол төлөв нийгэм эдийн засгийн дутмаг шинжид нь үндэслэж ‘эмзэг бүлгийг’ тодорхойлдог. Тухайлбал, Нийгмийн халамжийн тухай хуулийн 3 дугаар зүйлд заасны дагуу эмзэг бүлгийн хүмүүст эрүүл мэндийн доройтолтой, гэр бүлийн халамж, асрамж дутагдалтай, бие даан, эсхүл бусдын тусламжгүйгээр хэвийн амьдрах боломжгүй, өвөрмөц хэрэгцээ бүхий иргэн, нийгмийн халамжийн дэмжлэг, туслалцаа зайлшгүй шаардлагатай өрхийн гишүүн эсхүл иргэд багтаж байна.

цөөхөн хөтөлбөрийн нэг юм. Уг хөтөлбөрийн 3.2-т заасны дагуу соён гэгээрүүлэх аян, гамшгаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс, настай иргэд, хүүхдүүд, өсвөр үе, ядуурлын түвшнээс доогуур амьдралтай иргэд олон нийтийг онцгой анхаарал хандуулан хамруулах шаардлагатайг онцлон дурдсан байна.²⁷

Тиймээс IRIM-ийн судалгааны баг нь хувь хүн, гэр бүл, газар зүйн байршлыг харуулахуйц 13 төрлийн шинж байдлыг ашиглан эмзэг байдлын нэгдсэн индексийг боловсруулсан бөгөөд энэ нь уур амьсгалын өөрчлөлт, уур амьсгалын онцгой байдлын үед тусгай хэрэгцээт, эмзэг бүлгийг хувь бусад бүлэгтэй харьцуулахад ашигласан (тодорхойлсон шинж чанаруудын талаар дэлгэрэнгүйг Хавсралт 4-өөс үзнэ үү). Хувь хүмүүсийн эмзэг байдлын оноог судалгаанд оролцогчид болон болон тэдний гэр бүлийн дунд ажиглагдсан бүхий л эмзэг байдлуудыг тооцон, түүний нийлбэрээр тооцсон юм. Эмзэг байдлын индексийг ашиглан эмзэг байдал их (дунджаас дээш оноо авсан хувь хүмүүс) болон эмзэг байдал бага (бүх 0 биш оноо авахын тулд дунджаас доош оноо авсан хувь хүмүүс) гэсэн хоёр ангилалд хуваасан. Уур амьсгалын нөлөөнд өрх болон хувь хүний түвшинд бий болох эмзэг байдалтай холбоотой бусад хүчин зүйлийг бүрэн хамруулж судлаагүй учраас эмзэг байдлын ганц оноо авсан эсвэл дундаж онооноос бага авсан бүлгүүдийг эмзэг бус гэж тодорхойлохоосоо илүүтэйгээр ‘эмзэг байдал бага’ хэмээн тодорхойлсон болно.

Судалгаанд хамрагдсан эмзэг бүлэг

Судалгааны багийн боловсруулсан эмзэг байдлын ерөнхий индексээр²⁸ нийт судалгаанд оролцогчдын 1313 (46.8%) нь ‘эмзэг’ гэж тодорхойлогдсон.

Ахмад настан

Судалгаанд 60-аас дээш насны эрэгтэйчүүд, 55-аас дээш насны эмэгтэйчүүдийг ахмад настан гэж үзэв. Судалгаанд 264 ахмад настан хамрагдсан нь нийт оролцогчдын 9.4% нь байсан. Хүйсийн хувьд судалгаанд оролцсон ахмад настай

²⁷ Гамшгийн эрсдэлийг олон нийтийн оролцоотой бууруулах үндэсний хөтөлбөр, 2015 <https://legalinfo.mn/mn/detail?lawId=206872&showType=1>

²⁸ Тайлангийн Хавсралт 4-д индекс хэрхэн боловсруулсан талаар дэлгэрэнгүй харуулав.

оролцогчид бүгд эмэгтэйчүүд байв. Судалгаанд хамрагдсан нийт өрхийн 11.9% нь наанадаж 65-аас дээш насны ахмад настантай байсны 8.5% нь нэг ахмад настантай, 3.3% нь хоёр ахмад настантай байв.

Хөгжлийн бэрхшээл, архаг хууч өвчин

Судалгаанд үндэсний хэмжээний судалгаа, тооллогод өргөн ашиглагддаг ‘Вашингтон Группийн Биеийн Функцийн Богино Асуултууд’-ыг хөгжлийн бэрхшээлтэй эсэхийг тодорхойлоход ашигласан²⁹ Нийт оролцогчдын 74 буюу 2.6% нь хөгжлийн бэрхшээлтэй гэж тодорхойлогдсон. Судалгаанд хамрагдсан нийт хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн 8.2% нь 18-24 насныхан, 6.8% нь 25-34 насныхан, 56.8% нь 35-59 насныхан, 35.1% нь 60 ба түүнээс дээш насныхан байна. Хүндрэл бэрхшээлийн хувьд, нас ахих тусам илүү тархалттай байсан ба 60 болон түүнээс дээш насныхны хувьд тархалт эрс нэмэгдэж байв. Нийт хөгжлийн бэрхшээлтэй оролцогчдын 59.5% нь эрэгтэй, 40.5% нь эмэгтэй байна. Түүнчлэн, хөгжлийн бэрхшээлгүй оролцогчдын 0.7% нь боловсролгүй байсан бол хөгжлийн бэрхшээлтэй оролцогчдын 2.7% нь боловсролгүй байв. Мөн хөгжлийн бэрхшээлгүй иргэдийн 28.4% нь дээд боловсрол эзэмшсэн байсан бол хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн 9.6% нь л дээд боловсролтой байлаа.

Цаашилбал, нийт оролцогчдын хувьд хөгжлийн бэрхшээлтэй гэж тодорхойлогдсон эсэхээс үл хамаарч 20.4% нь архаг хууч өвчтэй юм уу, эмийн хамааралтай байв. Харин хөгжлийн бэрхшээлтэй оролцогчдын 55.4% нь архаг хууч өвчтэй эсвэл эмийн хамааралтай байхад хөгжлийн бэрхшээлгүй иргэдийн 19.5% нь архаг хууч өвчтэй байсан. Эндээс харахад, хүндрэл бэрхшээл нь ихэвчлэн өвчин эмгэг, архаг хууч өвчинтэй холбоотой байна.

Боловсролын түвшин доогуур

Уур амьсгалын өөрчлөлтөд өртөх эрсдэл нь боловсрол болон орлогын үзүүлэлтээр өөр өөр байдаг байна. Судалгааны түүврийн хувьд 63%

²⁹ The Washington Group Short Set on Functioning, 2022 <https://www.washingtongroup-disability.com/question-sets/wg-short-set-on-functioning-wg-ss/>

нь бүрэн дундаас (n=1767) доогуур боловсролын түвшинтэй байв. Эдгээр иргэд хөдөө орон нутагт, гэр хороололд илүүтэй амьдардаг. Тодруулбал, доогуур боловсролтой иргэдийн 40.8% нь (харин өндөр боловсролтой иргэдийн 26.5% нь) хөдөө орон нутагт, 17.9% нь (харин өндөр боловсролтой иргэдийн иргэдийн 10.1% нь) гэр хороололд амьдардаг байна. Түүнчлэн, доогуур боловсролтой оролцогчдын 19.7% нь мал малладаг, хөдөө аж ахуйн салбарт ажилладаг бол өндөр боловсролтой оролцогчдын хувьд 5.0% нь мал малладаг, хөдөө аж ахуйн салбарт ажилладаг байна.

Өрхийн орлогын түвшин доогуур

Ойролцоогоор судалгаанд оролцогчдын гуравны нэг (32.7%) нь “Амьжиргаагаа залгуулахад хэцүү, суурь хэрэгцээгээ л хангадаг” гэж хариулсан бол 18.3% нь л “үнэ цэнтэй зүйл худалдан авч, хуримтлал үүсгэж чаддаг” гэж хариулсан байна. Харин хот хөдөөгийн иргэдийн орлогоо тодорхойлж буй субъектив байдалд нь мэдэгдэхүйц ялгаа ажиглагдаагүй (Хотын иргэдийн 33.1%, хөдөөгийн иргэдийн 32.0% нь “Амьжиргаагаа залгуулахад хэцүү, суурь хэрэгцээгээ л хангаж чаддаг” гэж хариулсан). Эдгээр оролцогчдын олонх (61.9%) нь өрхийн гишүүд нь хуримтлалгүй гэж мэдээлсэн.

Суурь хэрэгцээгээ л хангаж чаддаг гэж мэдээлсэн иргэдийн 62.1% нь эмэгтэй, 37.9% эрэгтэй байв. Боловсролын доогуур түвшинтэй иргэд орлогын хүрэлцээгээ хамгийн доогуур тодорхойлсон байна (суурь хэрэгцээгээ хангаж чадахгүй байгаа иргэдийн 23.5% нь боловсрол багатай, 47.5% нь бүрэн дунд боловсролтой, 17.5% нь дээд боловсролтой байна). Нийт судалгаанд оролцогчид болон өрхүүд дунджаар хоёр орлогын эх үүсвэртэй байв. Өрхийн орлогын голлох хоёр эх үүсвэр нь нийгмийн хамгааллын тэтгэмж (71.4%) болон цалин хөлс (60.4%) байна.

Малчид, тариаланчид

Малчин, тариаланчдын амьжиргаа цаг уурын өөрчлөлтөөс ихээхэн хамаарч байдаг. Нийт

судалгаанд оролцогчдын 402 буюу 14.3% нь малчин байсан бол 20 буюу 0.7% нь тариаланч байв. Малчдын дийлэнх (89.8%) нь хөдөө орон нутагт, ялангуяа хээрийн бүсэд (42.5%) амьдардаг байна. Хүйсийн тухайд малчин биш оролцогчдын 46.9% нь эрэгтэй байсан бол малчин оролцогчдын талаас дээш хувь (55.2) нь эрэгтэй байв. Мөн талаас дээш хувь (52.0%) нь 35-59 настай байна. Түүнчлэн, малчдын боловсролын түвшин ихээхэн доогуур байв. Тодруулбал, малчдын 84.6% нь бүрэн дунд боловсролтой аж. Нийт малчдын гуравны нэг (34.1%) нь л амины малын даатгалтай байна.

Үндэстний цөөнх

Нийт судалгаанд оролцогчдын 541 буюу 19.3% нь үндэстний цөөнх (Халх бус) байв. Оролцогчдын 80.7% нь Халх, 4.1% нь Казак, 2.7% Буриад, 1.9% нь Баяд, 1.7% нь Урианхай, 6.2% нь бусад ястны төлөөлөл байсан. Үндэстний цөөнх болон зонхилох бүлгүүдийн хувьд хүйсийн харьцаа ижил. Өөрсдийн тодорхойлсон орлогын хүрэлцээ болон боловсролын түвшний хувьд үндэстний бүлгүүдийн хувьд мэдэгдэхүйц ялгаа ажиглагдаагүй.

Өрх толгойлсон эцэг/эхийн гэр бүл

Нийт судалгаанд оролцогчдын 520 буюу 41.8% нь өөрсдийгөө 'өрх толгойлсон эцэг/эх' гэж мэдээлсэн. Тэдгээрийн 63.3% нь эмэгтэй бол 36.7% нь эрэгтэй байна. Өрхийн тэргүүлэгчдийн олонх нь 40-өөд насны (дундаж нас нь 41.8) иргэд байв. Ганц бие бус өрх толгойлогчдын 30.8%, ганц бие өрх толгойлсон эцэг/эхийн 40.6% нь суурь хэрэгцээгээ л хангаж чаддаг гэж хариулсан байна.

Дотоодын шилжилт хөдөлгөөн

Шилжин суурьшигч болон шилжин суурьшаагүй иргэдийн насны бүтцийн хувьд шилжин суурьшигчдын эзлэх хувь 25-34 насны бүлэгт огцом нэмэгдэж, 35-59 насны бүлгийн хувьд шилжин суурьшаагүй иргэдийн тооноос дээгүүр байна.

Түүнчлэн, хотын бүсэд амьдардаг шилжин суурьшигчдын хувь (80.1%) шилжин суурьшаагүй иргэдээс (41.9%) 19.9%-аар өндөр байгаа нь хөдөөгөөс хот руу чиглэсэн хөдөлгөөнийг харуулж байна. Өндөр боловсролтой шилжин суурьшигчдын хувь (41.9%) шилжин

суурьшаагүй иргэдийн хувиас (24.1%) 17.8%-аар өндөр байна. Энэ нь хотын бүс рүү шилжин суурьших гол шалтгаан нь дээд боловсролын байгууллагад суралцах байдгаас улбаатай.

Сүүлийн 10 жилд шилжин суурьшсан оролцогчдын (47.9%) талаас илүү хувь нь Улаанбаатар хот руу нүүсэн бол тавны нэг нь аймгийн төв рүү (20.9%) болон сумын төв рүү (19.6%) нүүсэн байна. Түүнчлэн, шилжин суурьшихад боловсрол (17.4%), ажлын боломж (28.9%), дэд бүтэц (11.8%), эрүүл мэндийн үйлчилгээ (10.0%) зэрэг олон хүчин зүйл нөлөөтэйг сүүлийн 10 жилд шилжин суурьшсан оролцогчид мэдээлсэн.

Хотын гэр хорооллын бүсийн оршин суугчид

Нийт судалгаанд оролцогчдын 15.1% нь хотын бүсэд гэрт амьдардаг байна. Хотын бүсийн гэр хороололд амьдардаг оролцогчдын дөрөвний нэг нь (27.3%) сүүлийн 10 жилд шилжин суурьшсан бол хотын бүсийн гэр хороололд амьдардаггүй оролцогчдын 20.3% нь сүүлийн 10 жилд шилжин суурьшсан байв. Мөн сүүлийн 10 жилд шилжин суурьшсан хотын бүсийн оролцогчдын эзлэх хувь (26.5%) сүүлийн 10 жилд шилжин суурьшсан хөдөөгийн бүсийн оролцогчдын хувиас (11.9%) бараг хоёр дахин их байна. Хотын бүсийн гэр хороололд амьдардаг оролцогчдын 52.6% нь эмэгтэй байв. Өөрсдийн мэдүүлсэн орлогын түвшин болон боловсролын түвшний хувьд хоёр бүлгийн хооронд ач холбогдолтой ялгаа ажиглагдсан. Хот бүсийн гэр хороололд амьдардаг оролцогчдын дунд дээд боловсролтой хүмүүсийн хувь (12.8%) хотын бүсийн гэр хороололд амьдардаггүй оролцогчидтой (30.6%) харьцуулахад бага байна. Үүний адилаар, хотын бүсийн гэр хороололд амьдардаг оролцогчдын дунд "үнэ цэнтэй зүйл худалдан авч, хуримтлал үүсгэж чаддаг" гэж үзсэн оролцогчийн тоо (20.3%) хотын бүсийн гэр хороололд амьдардаггүй хүмүүстэй (6.4%) харьцуулахад гурав дахин бага байна.

Гамшиг/аюулд өртсөн түүх

Нийт оролцогчдын 196 буюу 7.0% нь оршин суугаа газартаа ноцтой үйл явдал, гамшигт өртсөн байна. Тэдгээрийн гуравны нэгээс их хувь нь шуурга (35.0%), үер (32.0%) -т өртсөн бол

аравны нэг нь зудын аюулд өртсөн байв. Ноцтой үйл явдал, гамшигт өртсөн хотын бүсийн оролцогчдын хувь (58.5%) хөдөөгийн бүсийн оролцогчдоос (41.5%) 17.0 хувиар их байна. Ноцтой үзэгдэл, гамшигт өртсөн оролцогчдын хувь ойн бүс (49.5%), хээрийн бүс (25.5%), говийн бүсэд (15.8%) амьдардаг оролцогчдын дунд өндөр байв.

II ХЭСЭГ. УУР АМЬСГАЛЫН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЛААРХ ОЙЛГОЛТ, МЭДЛЭГ, ХАНДЛАГА, ДАДАЛ

Энэхүү тайлангийн хоёрдугаар хэсэгт ойлголт, мэдлэг, хандлага, дадалтай холбоотой судалгааны үр дүнг танилцуулах бөгөөд дараах гол асуултуудад хариулт өгөхийг эрмэлзэнэ:

- Хүн ам, тэр дундаа эмзэг бүлгийнхний дундах уур амьсгалын өөрчлөлтийн талаарх ойлголт, мэдлэг ямар байна вэ?
- Уур амьсгалын өөрчлөлт, эмзэг байдлыг бууруулах, холбогдох нөлөөг тэсвэрлэх тэдний ерөнхий хандлага ямар байна вэ?
- Уур амьсгалын өөрчлөлттэй холбоотой эрэгтэйчүүд, эмэгтэйчүүдийн дунд байгаль орчны эсхүл бусад төрлийн ямар зан үйл давамгайлж байна вэ?

Энэхүү 2-р хэсгийн үр дүнг хүйс, нийгэм-эдийн засгийн олон талт бүлэг (боловсрол, ажил мэргэжил, орлого, нийгмийн сүлжээ, эмзэг байдал) болон оршин суугаа байдлаар нь задалж харьцуулалт хийсэн. Бүлэг бүрд нөхцөл байдлын талаар илүү их ойлголт өгөхүйц чанарын өгөгдлийг нэмж оруулсан.



4. УУР АМЬСГАЛЫН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЛААРХ ОЙЛГОЛТ, МЭДЛЭГ

Уур амьсгалын өөрчлөлтийн талаарх мэдлэгийг олон талаас нь, тухайлбал, уур амьсгалын өөрчлөлтийн талаарх ерөнхий мэдлэг, шалтгаан ба/эсвэл үр дагавар, үр нөлөөний талаарх мэдлэг гэх мэт олон талаас нь судалсан.³⁰ Тиймээс энэхүү бүлэгт, иргэд уур амьсгалын өөрчлөлтийг мэдэж байгаа эсэх, өөрсдийнхөө авсан мэдээлэл, туулсан туршлагад үндэслэн уур амьсгалын өөрчлөлтийн өнөөгийн төлөв байдлыг ойлгож байгаа эсэх талаарх олон асуултаар дамжуулан уур амьсгалын өөрчлөлтийн талаарх ойлголт, мэдлэгийг нь тодруулсан. Түүнээс гадна, хүлэмжийн хий, дэлхийн дулааралтай холбоотой тодорхой асуултуудыг асуух замаар тэдний дэлхийн дулаарлаас үүдэлтэй суурь ойлголт, болзошгүй эрсдэл, аюул заналын талаарх мэдлэгийг тодорхойлсон. Танин мэдэхүйн энэ хэсэгт, хүмүүс уур амьсгалын өөрчлөлтийн мөн чанар, уур амьсгалын өөрчлөлт нь тэдэнд хэрхэн нөлөөлөхийг ойлгож байгаа эсэхийг тодруулсан. Мэдлэгийн асуултууд нь голдуу, уур амьсгалын өөрчлөлтийн талаарх асуултуудын зөв хариултуудад суурилсан мэдлэгийн түвшнийг үнэлэх, иргэдийн дундах буруу ойлголтыг илрүүлэхэд чиглэсэн.

Энэхүү бүлэгт дараах гол асуултууд багтана:

- Та уур амьсгалын өөрчлөлт, дэлхийн дулаарал, озоны цоорол, хүлэмжийн хийн ялгарал зэрэг уур амьсгалын өөрчлөлттэй холбоотой нэр томъёоны талаар сонссон уу?
- Монголчууд “Уур амьсгалын өөрчлөлт” гэж ярихдаа юуг ойлгодог вэ?
- Уур амьсгалын өөрчлөлтийн учир шалтгааныг хүмүүс юу гэж боддог вэ?
- Хүмүүс байгаль орчин, цаг агаар, цаг ууртай холбоотой ямар өөрчлөлтийг ажигласан бэ?

³⁰ Gazzaz & Aldeseet, Шинжлэх ухаан, хөдөө аж ахуйн бакалаврын оюутнуудын уур амьсгалын өөрчлөлтийн талаарх мэдлэгийн түвшний үнэлгээ, 2021

- Байгаль орчны өөрчлөлт тэдний амьжиргаа, сайн сайхан байдалд ямар нөлөө үзүүлж байна вэ?
- Уур амьсгалын өөрчлөлтөөс бий болох нөлөөг хүмүүс юу гэж ойлгодог вэ?
- Хүн амын ялгаатай бүлгүүд, уур амьсгалын өөрчлөлт тэдний амьжиргаа, олон нийт, улс оронд бүхэлдээ ямар нөлөө үзүүлэх талаар хэр зэрэг ойлголтоотой байна вэ?

Дараах хүснэгтэд уур амьсгалын өөрчлөлтийн талаарх мэдлэгтэй холбоотой гол асуултуудыг хүйс, нас, оршин суугаа байршил болон эмзэг байдлын түвшнээр харьцуулан задаргааг харууллаа.

Хүснэгт 4 Уур амьсгалын өөрчлөлтийн талаарх ойлголт, мэдлэгийн гол асуултуудын үр дүнгийн хураангуй, хүйс, нас, байршил, эмзэг байдлаар (%), n=2804

#	Хэмжигдэхүүн	Хүйс		Насны бүлгээр				Байршил		Эмзэг байдал	
		F	M	18-24	25-34	35-59	>60	U	R	LV	V
1	“Дэлхийн дулаарал” гэсэн нэр томъёог сонссон	66.8	67.8	76.7	68.3	63.3	64.5	72.9	57.0	73.8	59.9
2	“Озоны давхаргын цооролт” гэсэн нэр томъёог сонссон	82.2	84.6	83.8	85.3	82.1	83.0	87.4	75.8	88.1	78.0
3	“Хүлэмжийн хийн нөлөө ба хүлэмжийн хийн ялгаруулалт” гэсэн нэр томъёог сонссон	69.1	71.2	66.9	73.6	70.4	67.5	76.9	57.9	76.9	62.4
4	УАӨ явагдаж байна	55.1	58.0	57.8	55.1	56.3	57.5	62.4	45.6	62.7	49.4
5	УАӨ-өөс шалтгаалсан асуудлуудын гол шалтгаан нь хүний буруутай үйл ажиллагаа	63.5	66.5	71.3	67.8	62.5	57.2	65.5	64.0	70.5	58.6
6	УАӨ-ийн талаар хангалттай мэдлэгтэй гэж үзсэн	83.1	85.0	82.5	83.7	84.9	83.6	87.1	78.3	86.0	81.7
7	УАӨ-ийн талаар нэмэлт мэдлэг, үр чадвар хэрэгтэй гэж үзсэн	21.0	26.3	26.0	26.8	20.8	22.9	26.2	18.8	27.9	18.6
9	УАӨ-ийн талаар нэмэлт мэдлэг, үр чадвар хэрэгтэй гэж үзсэн	58.6	50.5	45.7	56.8	58.5	51.1	53.7	56.6	55.4	54.0

Тайлбар: Статистикийн хувьд ач холбогдолтой үр дүнг өнгөөр тодруулсан болно. (p < 0.01).

4.1 Цаг агаар, байгаль орчинд ажиглагдсан өөрчлөлтүүд

Монголчуудын гуравны хоёроос дээш хувь (67.9%) нь улсын хэмжээнд бий болсон байгаль орчин, цаг агаарын өөрчлөлтийг ажигласан байна. Өөрчлөлт, өөрчлөлтийн төрөл, хэлбэрийг ажигласан хүмүүсийн хувьд байршлаас шалтгаалан өөр өөр байна. Тухайлбал, хотод болон экологийн хуурай бүсэд амьдардаг хүмүүсийн дунд энэхүү хувь өндөр байна.

Зураг 7 Монгол орны цаг агаарын төлөв байдлын өөрчлөлтийг анзаарсан судалгаанд оролцогчдын хувь, байршлаар

67.9%

Цаг агаар, байгаль орчинд гарч буй өөрчлөлтийг анзаарсан хувь



Цаг агаарын төлөв байдалд гарч буй өөрчлөлтөд говь цөл болон хээрийн бүс нутгийн оролцогчид илүү мэдрэг байна. Учир нь, говь цөлийн бүсүүдэд ган, үер, элсэн шуурганы давтамж, хүндрэл сүүлийн хэдэн арван жилд нэмэгджээ.³¹

31 Jie Han, Han Dai & Zhaolin Gu, Монгол орны элсэн шуурга, цөлжилт, ирээдүйн цаг уурын үйл явдлын тойм, 2021 <https://doi.org/10.1007/s10311-021-01285-w>


Хөдөө орон нутагт зохион байгуулсан ФБЯ-уудын үр дүнгээс харахад, малчид цаг агаарын төлөв байдал, орчны өөрчлөлтийг тодорхой давтамжтайгаар болдог байгалийн үзэгдэл (сайн эсхүл муу цаг үе нь арван жилийн мөчлөгтэйгөөр байнга тохиолддог) гэж ойлгох хандлагатай байна.

“Настай хүмүүс арван жил тутамд усны түвшин нэмэгддэг гэж хэлдэг. Уур амьсгал 3-аас 4 жилийн өмнө муудахад ган гачиг ихээхэн том асуудал болсон. Гэхдээ, усны түвшин өнгөрсөн жилээс хойш, 2022 онд нэмэгдсэн. Тиймээс, бид усны түвшний өөрчлөлтийг тодорхой давтамжтайгаар гарч буй өөрчлөлт л гэж харж байна.” (Малчин, Дорнод аймаг, эрэгтэй)


Хамгийн түгээмэл ажиглагдаж байгаа уур амьсгалын өөрчлөлт бол цөлжилт, бороо/хур тунадас, цаг уурын эрс тэс хэм байна. Байршлаас хамаарч бага зэрэг ялгаатай байна. Ялангуяа, хөдөө орон нутгийн иргэд салхи/шуурга, илүү хүйтэн өдрүүд, температурын эрс тэс байдлыг ажигласан бол, хот суурин газрын иргэд үер, бороо, хээрийн түймэртэй холбоотой өөрчлөлтийг түлхүү анзаарсан байна.

Зураг 8 Монгол орны цаг агаарын төлөв байдлын өөрчлөлтийг анзаарсан судалгаанд оролцогчдын хувь, экологийн бүсээр

Цаг агаар, байгаль орчинд гарч буй өөрчлөлт, бүс нутгаар



Зураг 9 Сүүлийн 10 жилд дараах байгалийн үзэгдлүүдэд гарч байгаа өөрчлөлтийг анзаарсан оролцогчид, байршлаар, (n=1906)




Цаг агаарын төлөвт гарч буй өөрчлөлтийг анзаарах нь уур амьсгалын өөрчлөгдөж байгааг ойлгох нэг арга зам юм. ФБЯ-ын үеэр Дорнод аймгийн эмэгтэй малчны тайлбарлаж байгаагаар:

“Сүүлийн хоёр жилд бараг зун болсонгүй. Бас их хүйтрэхээ ч больжээ. Хүмүүсийн хэлж байгаагаар, уур амьсгалын өөрчлөлтөөс болоод бид дөрвөн улирлын оронд гурван улиралтай болох нь ээ”. (Малчин, Дорнод аймаг, эмэгтэй)

Байршлаас хамаарч ажиглагдсан өөрчлөлтүүд олон нийтэд ялгаатай байна. Зураг 10-т үзүүлсэнчлэн, нийт судалгаанд оролцогчдын 47.4% нь байгаль орчны ямар нэгэн өөрчлөлтийг (n=1330) амьдарч байгаа газар нутагтаа ажиглажээ. Тэдний эзлэх хувийг нь хот суурин газрынхтай харьцуулахад (45.7%) хөдөө орон нутгийн оролцогчдын дунд (52.4%) илүү байна. Ажиглагдсан өөрчлөлтүүд гэвэл, зураг 11-т

үзүүлсэнчлэн, бэлчээр, газрын доройтол (96.7%), мал, амьтны усны хүртээмж (94.7%), хөрсний чанар (94.1%), агаарын чанар (93.3%) болон гол мөрөн, нуур (92.8%) зэрэг нь ямар нэг хэмжээгээр багассан байна.

Зураг 10 Байгалийн өөрчлөлтийг анзаарсан орон нутгийн оролцогчдын хувь, байршлаар (n=2804)



Зураг 11 Байгалийн орчны сөрөг өөрчлөлтийг ажигласан байдал, байршлаар (n=1330)



Ялангуяа, хөдөө орон нутгийн иргэд ахуйн хэрэглээний усны хүртээмж (92.9%), мөсөн гол, мөнх цаст уулын цасан бүрхүүлд (89.4%) гарч буй өөрчлөлтийг ажигласан бол, хотын иргэд зэрлэг ан амьтан, шувуу, шавжийн төрөл зүйлд (89.3%) илүү өөрчлөлт гарч байгааг анзаарчээ.

Хөдөө орон нутагт зохион байгуулсан ФБЯ-уудын үр дүнгээс харахад, дээр дурдсан байгаль орчны өөрчлөлтүүд орон нутагт нь нийтлэг ажиглагдаж байгааг нэгэн оролцогч дурджээ:

“Манай аймаг уулархаг учраас уулын оройд байнга мөстэй байдаг байлаа. Харамсалтай нь, сүүлийн жилүүдэд улирлын мөчлөг өөрчлөгдсөнөөс юм үү, хүмүүсийн буруутай үйлдлээс болоод ч тэр үү, тэр уулын орой дахь мөс хайлж, юу ч үлдсэнгүй. Саяны оролцогчдын дурдаж байгаатай адилаар бороо бараг орохгүй, харин нэг орохоороо аадар болж байна. Түүнээс гадна, огт өвөл болохгүй байна. Дээр дурдсан бүх үзэгдэл аймагт маань ноцтойгоор нөлөөлж байна”. (Өрхийн тэргүүн, Баян-Өлгий аймаг, эмэгтэй)

4.2 Хүмүүсийн дундах уур амьсгалын өөрчлөлтийн тухай ойлголтууд


Судалгаанд оролцогчдын харьцангуй их хувь нь уур амьсгалын өөрчлөлт (67.3%) гэсэн нэр томъёог мэдэж байгаагаа илэрхийлсэн ч, уг нэрлэлтийн жинхэнэ утгыг мэддэг нь бага байна. Судалгааны асуулгын эхэнд ‘уур амьсгалын өөрчлөлт’ гэсэн ойлголт хэр танил болохыг асууж, дараа нь, буруу ташаа ойлголтуудыг багтаасан асуултуудаар тандаж үзсэн.

Хэдийгээр, судалгаанд оролцогчдын олонх нь уур амьсгалын өөрчлөлттэй холбоотой гол нэр томъёо, ойлголтуудыг мэдэж байгаа

Зураг 12 Уур амьсгалын өөрчлөлттэй холбоотой нэр томъёо/эсвэл ойлголтын талаар сонссон оролцогчдын хувь, байршлаар (n=2804)



Зураг 13 Уур амьсгалын өөрчлөлттэй холбоотой нэр томъёо/эсвэл ойлголтын талаар сонссон оролцогчдын хувь, боловсролын түвшнээр (n=2804)



ч 'уур амьсгалын өөрчлөлт', 'хүлэмжийн хийн ялгарал' зэрэг шинжлэх ухааны, сүүлийн үеийн нэр томъёог, ялангуяа хөдөө орон нутгийн, боловсролын түвшин доогуур иргэд мэдэх нь ихээхэн бага байна.

Нийт 9 ФБЯ-ын үр дүнгээс харахад, оролцогчдынхувьдуураамьсгалынөөрчлөлтийг байгаль орчин, цаг агаарын нөхцөлд гарч буй өөрчлөлт болон агаар, хөрсний бохирдолтой


тодорхой хэмжээнд холбон үзсэн байна. 'Уур амьсгалын өөрчлөлт' гэдэг нэр томъёог сонсоод танд хамгийн түрүүнд юу бодогдож байна вэ? гэж асуухад, дэлхийн дулаарлын тухай, дараа нь температурын өсөлт, ялгаатай байдал, улирлын мөчлөгийн өөрчлөлт зэрэг цаг агаарт гарсан өөрчлөлтийг дурдаж байлаа. Зарим оролцогчид, агаарын ба орчны бохирдолтой, цөөн хэсэг нь байгалийн гамшигтай холбон тайлбарлаж байна. Эдгээр хариултаас харахад, уур амьсгалын өөрчлөлтийг гол төлөв сөрөг үзэгдэлтэй холбон тайлбарлаж байна.

Зураг 14 Уур амьсгалын өөрчлөлийн талаарх фокус бүлгийн ярилцлагын үр дүн




Зураг 15 Уур амьсгалын өөрчлөлтийн талаарх мэдлэгээ үнэлсэн байдал, боловсролын түвшнээр

Та уур амьсгалын өөрчлөлтийн талаар хэр ойлголттой вэ?



Зураг 16 Уур амьсгалын өөрчлөлтийн талаарх өөрийн мэдлэгээ үнэлсэн байдал, нийгэм, эдийн

Та уур амьсгалын өөрчлөлтийн талаар хэр ойлголттой вэ?



Судалгаанд оролцогчдын ердөө 23.6% нь уур амьсгалын өөрчлөлтийн талаар 'хангалттай' мэдлэгтэй гэж үзсэн байна. Зураг 15-д үзүүлсэнчлэн, бараг тал хувь нь (47.5%) уур амьсгалын өөрчлөлтийн талаар 'хэзээ ч сонсож байгаагүй' эсвэл 'бүдэг бадаг ойлголттой' гэж хариулжээ. Харин дөрөвний нэг нь л өөрсдийгөө уур амьсгалын өөрчлөлтийн талаар ерөнхий (21.3%), эсхүл маш сайн ойлголттой (2.2%) гэж үзжээ.

Түүнчлэн, боловсролын түвшин бага байх тусмаа 'уур амьсгалын өөрчлөлтийн талаар огт сонсож байгаагүй' байх магадлал нь өндөр байна.


Уур амьсгалын өөрчлөлтөөс үүдэх эрсдэлд хамгийн өртөх магадлалтай хүн амын бүлгүүд нь уур амьсгалын өөрчлөлтийн талаар арай бага мэдлэгтэй байдаг. ТУур амьсгалын өөрчлөлтийн талаар 'хэзээ ч сонсож байгаагүй', 'бүдэг бадаг ойлголттой' гэж хариулсан хувь нь

эмэгтэйчүүд, малчид, газар тариаланчид, эмзэг бүлгийнхэн зэрэг уур амьсгалын өөрчлөлтөд илүү эрсдэлд байдаг бүлгүүд гэж тооцогддог.

Уур амьсгалын өөрчлөлтийн талаар мэдлэг дутмаг гэж өөрсдийгөө үнэлсэн оролцогчид, хүлэмжийн хийн ялгарал (82.0%), озоны цоорол (68.0%) зэрэг уур амьсгалын өөрчлөлттэй холбоотой нэр томъёог сонсож байгаагүйгээ илэрхийлжээ. Түүнээс гадна, оролцогчдын орлого багатай байх тусам уур амьсгалын өөрчлөлтийн талаар 'огт сонсож байгаагүй' гэж хариулах магадлал өндөр байна.

4.3 Уур амьсгалын өөрчлөлтийг бий болгож буй хүчин зүйлийн талаарх ойлголт

Зураг 17 Уур амьсгал өөрчлөгдөх шалтгааны талаарх судалгаанд оролцогчдын үзэл бодол (n=2804)



Судалгаанд оролцогчдын олонх нь (84.0%) уур амьсгалын өөрчлөлтийн шалтгаан нь хүний үйл ажиллагаа гэдэгтэй санал нийлж байгаа бөгөөд голдуу үйлдвэрийн хор хөнөөлтэй үйл ажиллагаа, ой мод огтлох зэрэг нь нөлөөлж байгааг дурджээ. Хариултын явцад үүсэж болзошгүй аливаа нөлөөллөөс сэргийлэхийн тулд уур амьсгалын өөрчлөлтийн учир шалтгааныг тодруулахдаа тэдний түршлага, ажиглалттай холбох замаар шууд бус асуулт асуусан. Байгалийн гамшиг, байгаль орчин, цаг агаарын өөрчлөлтийг нэмэгдүүлэхэд нөлөөлж буй гол нөлөөлөгч зүйлийг асуухад гуравны нэг нь 'аж үйлдвэрийн зохисгүй үйл ажиллагаа, бохирдол' (35.1%)-ыг нэрлэжээ. Хоёр дахь түгээмэл хариулт нь 'ой мод, мод огтлох' (28.3%) байв. Мөн судалгаанд оролцогчдын тавны нэг нь хүний буруутай үйл ажиллагаа нь байгалийн, бурхны шийтгэл бий болоход нөлөөлдөг гэж үзсэнийг онцлон дурдаж байна.

Уур амьсгалын өөрчлөлтийн шалтгаанд 'аж үйлдвэрийн буруу дадал, бохирдол', 'хог хаягдлын зохисгүй менежмент'-ийг эс тооцвол, бусад нөлөөлөгч хүчин зүйл нь хот, хөдөөгөөс хамааран ихээхэн ялгаатай байна. Ялангуяа, 17-р зурагт үзүүлснээр, хотын оролцогчид, уур амьсгалын өөрчлөлтөд гол нөлөө үзүүлэгч нь 'ой мод, модыг тайрах', 'нүүрс түлэх' явдал гэж хариулсан хувь илүү өндөр байна. Хөдөө орон нутгийн оролцогчид, 'байгаль эх хүн төрөлхтнөөс хариугаа авч байгаа', 'малын тоо толгой нэмэгдэх/ бэлчээрийн даац хэтрэх' зэрэг нь гол нөлөөлөх хүчин зүйл гэж хариулсан хувь өндөр байна. Хүйсийн хувьд, ялгаа ажиглагдахгүй байна.

Дорнод аймгийн нэгэн малчин байгаль дэлхийгээ хүндэтгэж, уул, овооныхоо сахиусыг тахин шүтэхэд эерэг хариу үйлдэл үзүүлдэг гэдэгт итгэдгээ илэрхийлжээ. Үүнд:

Зураг 18 Судалгаанд оролцогчдын уур амьсгалын өөрчлөлтийн талаарх тодорхойлолтуудад хариулсан



Зураг 19 Уур амьсгалын өөрчлөлт, түүний шалтгаануудын тухай



“Хүн хаа явсан газрынхаа уул, овоо, газарт цайны дээж, өргөл өргөж, хүндэтгэл үзүүлж явах нь хамгийн чухал. Өргөл сайн өгөх нь мүүхан ламд даатгуулснаас дээр. Байгаль орчноо ч бас хамгаалах нь зүйтэй. Сүүлийн үед байгаль орчин сайхан сэргэж, манай суманд мод, чулуу эрс өөрчлөгдөж байна. Бид сумынхаа уулыг жил болгон л тахиж байна” (Малчин, Дорнод аймаг, эрэгтэй)

Судалгаанд оролцогчид уур амьсгалын өөрчлөлттэй холбоотой сөрөг хандлага, буруу дадал хэвшилтэй болоход нөлөөлж болзошгүй ташаа ойлголттой байгаа нь харагдаж байна. Тэдний дөрөвний нэг нь ‘уур амьсгалтын өөрчлөлт’ болоогүй, гуравны нэг нь хэдхэн градус дулаарах нь бидэнд нөлөөлөхгүй (35.9%), дэлхийн дундаж хэмийн өөрчлөлт нь уур амьсгалын өөрчлөлттэй холбоогүй, тийм байсан ч уур амьсгалын өөрчлөлтийн цорын ганц шинж тэмдэг биш (29.8%) гэж хариулж байна. Харин 10% орчим нь мэдэхгүй гэсэн хариултыг өгчээ.

Тайлангийн 7-р бүлэгт дурдсанчлан, судалгаанд оролцогчдын дөнгөж 6.8% нь уур амьсгалын өөрчлөлтийг аж үйлдвэржсэн орнууд үүсгэж байна гэж үзсэн бол, 35.9% нь Монгол иргэд өөрсдөө уур амьсгалын өөрчлөлтийг үүсгэж байна гэж хариулжээ.

Түүнээс гадна, судалгаанд оролцогчдын олонх нь (67.8%) уур амьсгалын өөрчлөлт бол байгалийн өөрийнх нь мөн чанар, үргэлж өөрчлөгдөж байдаг үзэгдэл гэж ойлгож байна. Ялангуяа, уур амьсгалын өөрчлөлтийн талаарх ойлголт багатай хүмүүс уур амьсгалын өөрчлөлт болж байна гэсэн санааг эсэргүүцэж, цаг агаар үргэлж өөрчлөгддөг, байгалийн жам гэж ойлгох магадлал өндөр байдаг. Энэ нь уур амьсгалын өөрчлөлтийн шалтгаан, үр дагаврыг тайлбарладаг мэдлэгийг үгүйсгэх магадлал өндөр байгааг илтгэж байна.

Дээрх зургаас харахад, ‘уурамысгал өөрчлөгдсөөр ирсэн, байгалийн жам ёсны үзэгдэл юм’ гэж үзэж буй хүмүүсийн дунд уур амьсгалын өөрчлөлтийн

Зураг 20 Байгаль орчны өөрчлөлтүүдийн нөлөө, байршлаар (n=1330) хариулсан байдал, %

Байгаль орчны өөрчлөлтүүд нь танай орон нутаг дахь хүмүүсийн амьдрал, амьжиргаа, байгалийн нөөцөд яаж нөлөөлж байна вэ?



шалтгааныг хүний буруутай үйл ажиллагаа гэж үзэж буй хувь нь (65.6%) харьцангуй бага байна. Харин жам ёсны үзэгдэл биш гэж үзсэн оролцогчдын дунд уур амьсгалын өөрчлөлт нь хүний буруутай үйл ажиллагаанаас үүдэлтэй гэж үзсэн хувь нь харьцангуй өндөр (83.3%) байна.

Судалгаанд оролцогчдын бараг тал хувь нь (46.6%) сүүлийн 10 жилийн хугацаанд орон нутагт нь бий болсон байгаль орчны өөрчлөлт нь байгалийн нөөц, хүмүүсийн амьжиргаанд нөлөөлсөн гэж хариулжээ. Ялангуяа, байгаль орчны бохирдол (83.5%), амьдралын чанар (77.0%), эрүүл мэндэд заналхийлж буй зүйлс (75.8%), шилжилт хөдөлгөөн (75.3%), ядуурал (74.2%) зэрэг нь байгаль орчны өөрчлөлтөөс үүдэлтэй гол асуудал байсныг дурджээ.

Гэхдээ, судалгаанд оролцогчдын өгсөн хариултаас мэдэгдэхүйц ялгаа ажиглагдаж байна. Хөдөөгийн иргэд, улирлын байдалд гарч буй өөрчлөлт (88.8%), ядуурал (81.6%) зэрэг сөрөг үр дагаварт илүү санаа зовж байсан бол, хотын иргэдийн хувьд, орчны бохирдол (88.7%), эрүүл мэндэд учруулж буй аюул заналхийлэл (82.6%), амьдралын чанар (81.9%), шилжилт хөдөлгөөн (76.6%) зэрэг нь байгаль орчны өөрчлөлтийн сөрөг үр дагавар болохыг илэрхийлсэн байна.

Улаанбаатар хотод зохион байгуулсан ФБЯ-ын үр дүнгээс харахад, хотын иргэд голдуу эрүүл мэнд, аюулгүй байдал, амьдралын чанарт нөлөөлж байгаа агаар, хөрсний чанарын асуудалд санаа зовж байв. Байгаль орчны өөрчлөлт тэдний эрүүл мэнд, амьжиргаанд нөлөөлсөн тухай доор нэг оролцогчийн санал бодлыг хуваалцав.

“Хамгийн гол нөлөө бол эрүүл мэндийн асуудал. Хүмүүс эрүүл байх ёстой. Харамсалтай нь хортой утаанаас гадна өвөл цас, салхигүй байгаагаас агаар хангалттай цэвэршдэггүй. Үүнээс болж, бага насны хүүхдүүд, томчууд хүндээр өвдөж, эмнэлэгт хэвтэж байна. Миний

хувьд, ганц бие ээж, өмнө нь нэг гурилыг 45,000 төгрөгөөр худалдаж авдаг байсан бол өнөөдөр 82,000 төгрөгийн үнээр авч байна. Гурван хүүхэд маань сургуульд сурдаг, хөгшин ээжид минь эм хэрэгтэй. Харин миний цалин 370,000 төгрөг. Тиймээс надад хүүхдүүддээ хувцас авах уу, гэртээ хоол хүнс авах уу, эсвэл ээждээ эм худалдаж аваад эмнэлэгт хэвтүүлэх үү гэсэн эдийн засгийн олон хүндрэл бий болж байна.” (Өрхийн тэргүүн, Баян-Өлгий аймаг, эмэгтэй)

Нийт судалгаанд оролцогчдын 7% (n=195) нь сүүлийн 12 сард хамгийн багадаа нэг удаа гамшигт өртсөн бөгөөд ихэнх нь амьдарч буй орон нутагт нь гарз хохирол тохиосон гэж хариулжээ. Тэдний 43.1% нь шүүргэ/салхи, 37.2% нь үер, 12.5% зуд, 13.2% нь ганд өртжээ. Түүнчлэн, 69.4%-д нь өрхийн түвшинд, 68.1% (n=133)-д нь орон нутгийн түвшинд гарз хохирол учирсан гэжээ. Учирсан гарз хохирол нь байршлаас хамаараад харилцан адилгүй байна. Тухайлбал, хөдөө орон нутгийн оролцогчдын талаас илүү хувь нь (52.1%) ‘мал аж ахуй, газар тариалангийн үйлдвэрлэл алдагдсанаас өрхийн орлого буурсан’ гэсэн бол, хотынхон ‘эд хөрөнгөнд нь хохирол учирсан’ гэж хариулжээ.

Өрхөд нь мал, газар тариалангийн үйлдвэрлэл алдагдсантай холбоотойгоор өрхийн орлого нь буурсан (33.0%), өмч хөрөнгө, тоног төхөөрөмжид голдуу хохирол учирсан (32.9%) гэж судалгаанд оролцсон гурван оролцогч тутмын нэг нь хариулжээ. Харин, орон нутгийн түвшинд гарсан хохирлыг ажигласан оролцогчдын дөрөвний нэг нь ‘зам эвдэрсэн’ (33.3%), ‘орон нутаг дахь газар тариалан, бэлчээрийн талтай сүйрч, өртсөн’ гэж хариулжээ.


Зураг 21 Байгалийн гамшгаас учирсан хохирол, өрхийн түвшинд (сүүлийн 12 сард гамшигт өртсөн хүмүүс), (n=195)



Зураг 22 Амьдарч буй нутаг дэвсгэр ойр орчимд байгалийн гамшгаас учирсан хохирол, (сүүлийн 12 сард гамшигт өртсөн хүмүүс), (n=195)



Зураг 23 Орон нутгийн байгаль орчны байдалд сэтгэл ханамжтай эсэх, Монгол Улсад цаг агаарын төлөв байдалд ямар нэгэн өөрчлөлт гарч байгааг анзаарсан оролцогчид (n=2804)



Хөдөө, орон нутагт зохион байгуулсан ФБЯ-аар хөдөөгийн айл өрхүүд байгалийн гамшигт олон янзаар өртсөн байна. Баян-Өлгий аймгийн зарим оролцогчид дараах байдлаар туршлагаасаа хуваалцсан юм.

Үерт ер нь бүх зүйл, гэр, байшин барилга ч автсан. Бид 2018 онд Ховд голын эрэг дагуу амьдарч байсан юм. Маш хэцүү байсан. Манайх гэргүй болохоор хүүхдүүдтэйгээ хамт Мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төвийн дотуур байранд хэдэн сарыг өнгөрөөсөн. Энэ хэсэг хугацаанд жорлон, худаг ус бүгд л үерийн усаар дүүрсэн байсан” (Ажилгүй, Баян-Өлгий аймаг, эмэгтэй)

“Бороо орохгүй байгаа болохоор хашаанд тарьсан ногоо, мод ч ургахгүй байна. Өмнө нь бид усны зориулалттай худаг үрхдэг байсан. Гэвч усны түвшин бүүрснаас хойш худаг үсгүй болсон. Баруун аймгийн айл өрхүүд мал аж ахуйгаас өөр орлогогүй. Байгалийн гамшиг, үүр амьсгалын өөрчлөлт болоход хүмүүс гэр орноо орхиод л нүүсэн. Манай хамгийн хол орших

Булган сумыг буулгах уу, үгүй юу гэдэг асуудал хүртэл яригдаж байна.

Бэлчээрийн даац хэтэрсэн, нэмэлт тэжээл худалдан авч чадахгүй учраас малаа маллаж чадахгүй байгаа малчид ч байна. Тиймээс тэд санхүүгийн чадамжгүй болж, Казахстан руу нүүсэн”. (Малчин, Баян-Өлгий аймаг, эрэгтэй)

Орон нутгийнхаа байгаль орчны байдалд сэтгэл ханамж бага байгаа нь өмнөх гамшигт өртөж байсан туршлагатай холбоотой байна. Судалгаанд оролцогчдын орон нутгийнхаа байгаль орчны талаарх сэтгэл ханамжийн үнэлгээг харахад, дунджаар 5.68% (0 бүрэн сэтгэл ханамжгүй, 10 бүрэн сэтгэл ханамжтай) байна. Ерөнхийдөө, залуучууд, шилжин ирэгчид, боловсролын түвшин доогуур иргэд, хот суурин газар, ой тайгын экологийн бүсийн оролцогчдын сэтгэл ханамж бага байна.

Судалгаанд оролцогчдын цаг агаар, байгаль орчны өөрчлөлтийн талаарх ажиглалт болон өмнөх туршлагаас хамааран сэтгэл ханамжийн түвшин эрс ялгаатай байв. Монгол орны цаг агаарын төлөв байдалд гарсан өөрчлөлт (Зураг 23) болон байгаль орчны өөрчлөлт (Зураг 24)-ийг орон нутагтаа анзаарсан судалгаанд оролцогчид төдийлөн сэтгэл ханамжтай биш байна.

Зураг 24 Орон нутгийн байгаль орчны байдалд сэтгэл ханамжтай эсэх, Амьдарч буй нутаг дэвсгэр ойр орчимдоо байгаль орчны өөрчлөлтийг ажигласан оролцогчид (n=2804)





5. УУР АМЬСГАЛЫН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЛААРХ ХАНДЛАГА

Хандлага гэдэг нь аливаа үйлдэл, үйл явдал, санаа, эсвэл аливаа зүйлсийн талаар юм уу, нийгмийн шинжлэх ухааны салбарынхны нэрлэдгээр “хандлагын объект”-ын талаарх үнэлэлт дүгнэлтийг тоймлон харуулах танин мэдэхүйн илэрхийлэл юм.³² Энэхүү судалгааны хувьд, хандлагын объект нь уур амьсгалын

өөрчлөлт юм. Уур амьсгалын өөрчлөлтийн талаарх олон нийтийн хандлагыг нарийвчлан авч үзэхийн тулд тэдгээр хүмүүсийн өдөр тутмын амьдралын хэв маягт үндсээр нь өөрчлөлт, шинэчлэлт авчрахуйц олон ялгаатай бодлогуудыг дэмжиж байгаа эсэхийг шинжих асуултууд асуухыг эрмэлздэг.

Түүнчлэн хандлагын асуултууд нь олон нийтийн хувьд өдөр тутмын амьдралынхаа хэв маягийг, тухайлбал, хоол хүнс, гэр орноо дулаацуулж, сэрүүцүүлэх арга, аливаа бараа бүтээгдэхүүн, үйлчилгээг хэрхэн хэрэглэж буй байдал зэргээ өөрчлөхөд хэр бэлэн байгааг илрүүлэхэд чиглэдэг. Олон нийтийн түвшинд, аливаа бий болох нөлөөллөөс сэргийлж эмзэг байдлыг бууруулж, тэсвэртэй байдлыг бий болгох тухай хүмүүсийн ерөнхий хандлагыг тандах нь чухал бөгөөд энэ нь эцэстээ аливаа дасан зохицох, эсвэл бууруулах стратеги амжилттай байх эсэхэд нөлөөлөх юм.³³

32 Armstrong, Krasny, & Schultdt, Уур амьсгалын өөрчлөлтийн талаарх мэдээлэл өгөх багш нарт зориулсан гарын авлага, 2018

33 OECS Secretariat, Уур амьсгалын өөрчлөлтийн талаарх мэдлэг, хандлага, дадал, OECS, 2013


Хүснэгт 5 Уур амьсгалын өөрчлөлтөд хандах хандлагын талаарх гол асуултуудын үр дүнгийн хураангуй, хүйс, нас, байршил, эмзэг байдлаар (%), (n=2804)

#	Шалгуур асуултууд	Хүйс		Насны бүлэг				Байршил		Эмзэг байдал	
		Эм	Эр	18-24	25-34	35-59	> 60	Хот	Хөдөө	Их	Бага
1	Байгалийн гамшигт үзэгдлийн давтамж өснө гэдэгт итгэдэг	55.8	63.1	64.2	62.4	56.9	53.8	61.6	55.2	63.0	55.1
2	УАӨ дэлхий дахинаа явагдаж байгаад итгэдэг	90.7	89.2	89.3	90.3	90.3	89.0	91.5	87.2	91.6	84.8
3	УАӨ Монгол Улсад явагдаж байна	89.4	90.0	88.5	90.3	90.3	88.1	90.5	88.1	90.7	86.4
4	УАӨ-д санаа зовсон	71.5	66.2	48.7	65.1	77.5	79.2	69.0	68.9	67.9	72.2


5	УАӨ амьдралд нь богино хугацаанд нөлөөлнө гэдэгт итгэдэг	37.2	28.3	31.2	36.0	26.2	32.7	34.1	38.7	29.0	37.4
6	УАӨ сөргөөр нөлөөлнө гэдэгт итгэдэг	78.4	78.8	73.4	79.6	80.4	78.3	79.3	77.3	79.9	77.1
7	УАӨ тэдний ойр орчимд нөлөөлнө гэдэгт итгэдэг	56.3	56.3	49.3	57.1	59.3	54.7	56.3	56.4	56.7	55.2
8	Хэвлэл мэдээллийн хэрэгслээс УАӨ-ийн талаар илүү их мэдээлэл авах хүсэлтэй	86.1	83.9	80.9	84.9	86.9	85.5	82.6	89.6	85.3	84.8
9	УАӨ манай орны хувьд яаралтай арга хэмжээ авах шаардлагатай асуудал	86.5	84.7	75.0	84.1	89.5	92.1	85.5	85.9	85.2	86.2

Тайлбар: Статистикийн хувьд ач холбогдолтой үр дүнг өнгөөр тодруулсан болно. (p < 0.01)

Зураг 25 Уур амьсгалын өөрчлөлтөд санаа зовж буй байдал, бүлгээр (n=2804)



Зураг 26 Уур амьсгалын өөрчлөлтийн талаарх мэдрэмж (n=2804)



Зураг 27 Улс орны хэмжээнд уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөтэй холбоотой санаа зовоож буй гол



5.1 Уур амьсгалын өөрчлөлт, түүний үр дагавартай холбоотой асуудлууд

Судалгаанд оролцогчдын ихэнх нь (69.0%) уур амьсгалын өөрчлөлтөд санаа зовниж буйгаа илэрхийлсэн - (18.9% нь маш их санаа зовж байгаа, 50.1% үе үе санаа зовж байгаа) бол, 2.1% орчим нь уур амьсгалын өөрчлөлтөд огт санаа зовдоггүй, 5.3% орчим нь төдийлөн санаа зовдоггүй гэж хариулжээ. Тоон судалгааны дүнгээс харахад, судалгаанд оролцогчийн санаа зовж буй байдал нь амьдарч буй байршлаас үл хамааран жигд өндөр байна.

Гэсэн хэдий ч, уур амьсгалын өөрчлөлтөд санаа зовниж буй байдал нь эмэгтэйчүүд, малчид, эмзэг бүлгийнхэн, сүүлийн 10 жилд шилжилт хөдөлгөөнд ороогүй судалгаанд оролцогчдын дунд өндөр байна.

Уур амьсгалын өөрчлөлтөд санаа зовж буй байдал нь голдуу айдас, санаа зовох, харамсах зэрэг сөрөг сэтгэл хөдлөлөөр илэрсэн байна. Мөн уур амьсгалын өөрчлөлтийг хэрхэн хүлээн авч байгааг нь тодруулсан.

Судалгаанд оролцогчдын 32.6% нь уур амьсгалын өөрчлөлтөд санаа зовж байгаа, 19.2% нь айж түгшиж байгаа, 11.4% нь харамсах мэдрэмж төрж байгаагаа хуваалцсан бол, 8.8% нь энэ асуудалд ямар нэгэн онцгой мэдрэмж төрөхгүй байгаагаа илэрхийлжээ. Мөн, ямар нэгэн арга хэмжээ авах шаардлагатайг мэдэрч

байгаа (4.2%), арга хэмжээ авна гэж найдаж байгаа (1.3%) тун цөөн хүн байна. Ихэнх эмэгтэйчүүд, эмзэг бүлгийнхэн болон хөдөө аж ахуйн салбарт ажиллагсад уур амьсгалын өөрчлөлтөд сөрөг, гутранги байдлаар хандсан бол, ердөө 8.1% нь уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөнд санаа зовохгүй байгаагаа илэрхийлсэн байна.


Уур амьсгалын өөрчлөлттэй холбогдох хүн амын дунд зовниж буй гол асуудал нь байгаль орчин, эрүүл мэнд, хөдөө аж ахуй байна. Судалгаанд оролцогчдоос улсын хэмжээнд уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөтэй холбоотой тэдний санааг зовоож буй гол асуудлыг асууж тодрууллаа. Судалгаанаас харахад, байгаль орчинд хамгийн их санаа зовж (51.6%), гуравны нэг нь эрүүл мэнд (38.6%), хөдөө аж ахуйтай холбоотой асуудлууд (31.0%) гэж тус тус үзэж байна.

Бусад бүлэгтэй харьцуулахад, хөдөө эсвэл хөдөө аж ахуйн салбарт ажиллаж байгаа хүмүүс байгаль орчны асуудал, хөдөө аж ахуйтай холбоотой асуудалд илүү санаа зовж байна. Харин эрэгтэйчүүдтэй харьцуулахад, эмэгтэйчүүд эрүүл мэнд, хууль бус хог хаягдлын асуудалд санаа зовж байгаа нь харагдаж байна.

Орон нутагт гарч буй өөрчлөлтийг ажигласан байдал, гамшигтай холбоотой өмнөх туршлагауд нь уур амьсгалын өөрчлөлт бүгдэд нөлөөлж байгаад итгэн үнэмшүүлэхэд ихээхэн чухал үүрэгтэй байна. Судалгаанд оролцогчдоос дараа дараагийн хэдэн арван жилд уур амьсгалын янз бүрийн өөрчлөлт

гарах магадлал хэр байгааг асуухад, 44% нь уур амьсгалын өөрчлөлт нь өөр өөр бүлгүүдэд тодорхой хэмжээгээр нөлөөлж болзошгүй гэж үзсэн байна.

Зураг 28 Гамшигт үзэгдлүүдийн нөлөө үзүүлэх магадлал, туршлагаар, (n=2804)



Улмаар, судалгаанд оролцогчдын гамшигтай холбоотой өмнөх туршлага, орон нутагтаа бий болсон өөрчлөлтийг ажигласан эсэхээс хамааран цаашид үр нөлөө бий болох магадлалыг хэрхэн ойлгож байгаа нь мэдэгдэхүйц ялгаатай байв (Зураг 28). Үүнтэй адилаар, байгалийн онц ноцтой үзэгдлүүд хүн амын олон янз бүлэгт нөлөө үзүүлэх магадлал өндөр гэж хариулсан оролцогчдын хувь нь орон нутагтаа байгаль орчны өөрчлөлтийг ажигласан хүмүүсийн дунд илүү өндөр байна (Зураг 29). Судалгаанд оролцогчдын хувьд, байгалийн онц ноцтой үзэгдлүүд нь өөр өөр түвшин, олон янз бүлэгт нөлөөлнө гэдэгтэй ерөнхийдөө санал нийлж байсан. Харин Зураг 28 болон Зураг 29-т үзүүлсэнчлэн, эдгээр онц ноцтой үзэгдлээс үүсэж болзошгүй үр нөлөөнөөс аль болох өөрсдийгөө хол байгаа мэтээр ойлгосон байна. Харин өөрсдийгөө онц ноцтой үзэгдэлд өртөх магадлалтай гэж хариулсан оролцогчдын дунд хүн ам зүйн шинж, байршил, эмзэг байдал гэх


мэт нийгэм-эдийн засгийн статусаас хамаарсан ялгаа ажиглагдахгүй байна.

Зураг 29 Гамшигт үзэгдлүүдийн нөлөө үзүүлэх магадлал, төрөл бүрийн ажиглалтаар (n=2804)




Уур амьсгалын өөрчлөлт нь хүмүүсийн амьдралд урт хугацаанд сөргөөр нөлөөлөх төлөвтэй байна. Судалгаанд оролцогчдын олонх нь уур амьсгалын өөрчлөлт тэдний амьдралд сөргөөр нөлөөлнө гэж (78.6%) үзэж байна. Монголд уур амьсгалын өөрчлөлт бодитоор болж байгаа гэж хариулсан оролцогчид үүний сөрөг үр дагаварт санаа зовж (82.9%) байгаа бол, уур амьсгалын өөрчлөлт болоогүй гэж хариулсан оролцогчдын дунд энэхүү хувь харьцангуй бага (73.2%) байна.

Зураг 30 Уур амьсгалын өөрчлөлтийн талаарх итгэл үнэмшил (n=2804)



Зураг 31 Уур амьсгалын өөрчлөлтийн талаарх ажиглалт (n=2804)



Мөн судалгаанд оролцогчдын гамшигтай холбоотой өмнөх туршлага нь уур амьсгалын

өөрчлөлтийн үр нөлөөг хэрхэн ойлгож байгаатай ихээхэн хамааралтай байв. Тухайлбал, уур амьсгалын өөрчлөлтийг амьдралд нь сөргөөр нөлөөлнө гэж үзсэн хүмүүсийн хувь сүүлийн 10 жилд гамшигт өртсөн хүмүүсийн дунд илүү өндөр (88.3%) байгаа бөгөөд өртөж байгаагүй хүмүүсийн өгсөн хариултын хувьтай (77.8%) харьцуулахад их байна. Энэ нь өмнө тохиолдсон гамшигт үзэгдэлтэй холбоотой туршлага, үүссэн өөрчлөлтийн талаарх ажиглалт нь тэднийг энэ асуудалд сонор сэрэмжтэй, мэдрэмтгий болгодогийг харуулж байна. Түүнчлэн, уур амьсгалын өөрчлөлт амьдралд нь ямар нэг байдлаар нөлөөлнө гэж үзсэн оролцогчид (67.1%) тэдний өмнөх туршлага, мэдлэгээс үл хамааран уг өөрчлөлтийн нөлөөг урт хугацаанд мэдрэгдэнэ гэж үзжээ.

5.2 Хамгийн ихээр санаа зовоож буй гол асуудлууд

Ерөнхийдөө хүмүүсийн дунд тулгамдаж буй гол асуудлыг ойлгох нь чухал байдаг. Энэ нь уур амьсгал өөрчлөгдөх шалтгаан, үр дагаварт хандах хандлага, түүнтэй холбоотой үүсэж болох сонголт юм уу, боломж юу байж болохыг ойлгоход тусална.

Хүн амын санааг хамгийн ихээр зовоож буй асуудал нь эрүүл мэнд, агаарын бохирдол, ажлын байрны дутагдал, орлогын хүрэлцээгүй байдал зэрэг байна. Судалгаанд оролцогчдоос 'одоо таны санааг хамгийн их санаа зовоож буй гурван асуудал юу вэ?' гэсэн асуулт асуухад, гурав хүртэлх асуудлыг нэрлэж эрэмбэлсэн. Зураг 32-т 1, 2 болон 3-р эрэмбэд нэрлэгдсэн асуудлууд болон харгалзах тоон үтгүүдийг харуулав. Таамаглаж байсанчлан, хамгийн нийтлэг дурдагдсан асуудал нь эрүүл мэнд (17.0%), агаарын бохирдол (16.4%) гэж бараг тэн хагас нь нэрлэсэн юм. Дараа нь, оролцогчдын 40%-иас дээш нь ажлын байр хангалтгүй байх (ажилгүйдэл 15.1%), орлого Зураг 30 Уур амьсгалын өөрчлөлтийн талаарх итгэл үнэмшил (n=2804) Зураг 31 Уур амьсгалын өөрчлөлтийн талаарх ажиглалт (n=2804) хүрэлцээгүй байх, зах зээлийн үнэ, амьжиргааны зардал өндөр байх (14.9%) зэрэг эдийн засгийн асуудалд санаа зовж байгаагаа илэрхийлсэн. Харин, 9% нь байгаль орчин, мал аж ахуй, бэлчээрийн менежментийн асуудлыг нэрлэсэн. Агаарын бохирдлоос бусад дээр нэрлэгдсэн бүх асуудал нь саяхан орон

даяар явуулсан санал асуулгын олон нийтийн санаа зовнисон асуудлын үр дүнтэй төстэй байна (Санал асуулгад оролцогчдын 3% нь агаарын бохирдлыг хамгийн гол асуудал гэж дурдсан).³⁴

Эрэгтэйчүүд авлига, дэд бүтэц, байгаль орчинд, харин эмэгтэйчүүд эрүүл мэнд, агаарын бохирдол, COVID-19 тахлын асуудалд илүү санаа зовж байлаа. Дээрх асуудалд эмэгтэйчүүд, эрэгтэйчүүдийн дунд хүйсийн уламжлалт хэм хэмжээнээс үүдсэн зарим ялгаа ажиглагдаж байлаа. Эрэгтэйчүүдтэй харьцуулахад эмэгтэйчүүд нь эрүүл мэнд (бүх эмэгтэйчүүдийн 52.6%, эрэгтэйчүүдийн 41.4% нь хамгийн их санаа зовоосон гурвын эгнээнд), агаарын бохирдол (эмэгтэйчүүдийн 43.4%, эрэгтэйчүүдийн 40.4%), орлого, эдийн засгийн асуудал (эмэгтэйчүүдийн 43.9%, эрэгтэйчүүдийн 39.9%)-д хамгийн их санаа зовж байгаагаа илэрхийлсэн. Харин эмэгтэйчүүдээс илүү эрэгтэйчүүд нь авлига, (эрэгтэйчүүдийн 31.4%, эмэгтэйчүүдийн

34 2021 онд улс орон даяар хийгдсэн Монгол Улс дахь санал бодлын судалгааг IRI болон IRIM судалгааны хүрээлэн хамтран гүйцэтгэсэн бөгөөд ойролцоогоор судалгаанд оролцогчдын 8% нь байгаль орчин, хөдөө аж ахуйн асуудлыг хамгийн чухал асуудал гэж авч үзсэн. Гэвч, агаарын бохирдлын хувьд нэлээд ялгаатай байгаа бөгөөд ердөө 3 хувь нь л агаарын бохирдлыг сонгосон нь зөрүүтэй үр дүнг харуулж байна.

22.1%), дэд бүтэц (эрэгтэйчүүдийн 20.6%, эмэгтэйчүүдийн 17.2%), байгаль орчин, мал аж ахуйн менежментийн асуудалд (эрэгтэйчүүдийн 10.4%, эмэгтэйчүүдийн 6.8%) илүү санаа зовж байна. Түүнчлэн, эмэгтэйчүүдийн орлогын хэмжээнээс шалтгаалж, санаа зовж буй асуудал нь ихээхэн ялгаатай байв.

Орлого багатай өрхийн эмэгтэйчүүдийн санааг зовоосон асуудал нь орлого, эдийн засаг (20.0%), эрүүл мэнд (19.3%) байв. Харин дунд зэрэг, их орлоготой өрхийн эмэгтэйчүүдийн хувьд, агаарын бохирдол (16.4%), ажилгүйдэл (15.6%) зэрэг нь санаа зовоодог асуудал болж байна.

Хамгийн их санаа зовоож буй асуудал нь насны бүлгээс хамаарч ялгаатай байна. Залуусын хувьд, боловсрол (15-24 насны залуусын 27.7% нь боловсрол гэж хариулсан бол, 60 ба түүнээс дээш насныхны 8.0% нь энэ асуудлыг сонгосон), агаарын бохирдол (залуучуудын 45.1%, ахмад насныхны 37.5%), жендерт суурилсан хүчирхийлэл (залуучуудын 10.2%, ахмад насныхны 4.7%) зэрэг асуудлыг нэрлэсэн. Судалгаанд оролцогчдын нас ахих тусам авлига (ахмад настнуудын 28.8%, залуучуудын 20.7%), орлого, эдийн засгийн асуудал (ахмад

Зураг 32 Судалгаанд оролцогчдын санааг хамгийн их зовоосон гурван асуудал (1-р байр, 2-р байр, 3-р байр болон нийт (n=2804)



настнуудын 45.9%, залуучуудын 36.8%) болон байгаль орчин, мал аж ахуйн менежмент (ахмад настнуудын 10.9%, залуучуудын 6.4%) зэрэг асуудалд санаа зовж байна. Харин эрүүл мэнд, COVID-19 тахал, дэд бүтэцтэй холбоотой асуудалд насны онцлогоос хамаарсан ялгаа ажиглагдахгүй байна.

Хотынхон эрүүл мэнд (49.9% болон 42.3%), агаарын бохирдол (47.9% ба 31.1%), дэд бүтэц (22.3% ба 12.6%) зэрэг асуудалд хөдөө орон нутгийнхаас илүү санаа зовж байна. Харин, хөдөө орон нутгийнхан ажилгүйдэл (47.1% болон 41.8%), байгаль орчин, мал аж ахуйн менежмент (16.0% болон 4.5%)-д илүү санаа зовниж буйгаа илэрхийлсэн байна. Орлого, санхүүгийн асуудал, боловсрол, авлига, COVID-19-тэй холбоотой асуудалд статистикийн ач холбогдолтой ялгаа харагдахгүй байна.

Тайлангийн 4.4-р бүлгээс судалгаанд оролцогчдын олонх нь уур амьсгалын өөрчлөлт тэдний эрүүл мэндэд сөргөөр нөлөөлдөг гэж үзэж байгаа бөгөөд эрүүл мэнд нь бүх насныхны дунд, хот, хөдөө орон нутгийнхны аль алиных нь санааг зовоосон гол асуудал болсон нь харагдаж байна. ФБЯ-ын үеэр оролцогчид цусны даралт ихсэх, наранд цохиулах, ядаргаа, зүрх судасны өвчин зэрэг асуудлыг дурдаж байсан. Улмаар, хөдөө орон нутгийн иргэд уур амьсгалын өөрчлөлттэй холбогдуулан мал аж ахуй, амьжиргаатай холбоотой асуудалд санаа зовниж буйгаа доорх байдлаар илэрхийлжээ:

“Манай аймагт малын өвчлөл болон хээрийн түймэр гарах нь элбэгшсэн. Ялангуяа, өвлийн идэш бэлтгэдэг газруудад малын үл мэдэгдэх өвчлөл гарч байна. Монголчууд өвлийг давахад малын мах чухал бөгөөд махны нөөцийг хаана бэлтгэхээ мэдэхгүй байна. Эдгээр асуудал бүгд уур амьсгалын өөрчлөлттэй холбоотой. (Дорнод аймаг, ажилгүй, эрэгтэй)

“Уур амьсгалын өөрчлөлтөөс болж янз бүрийн халдварт өвчин гарч, гадаа хэт халуун үед ахмад настнууд гадагшаа гарч чадахгүй, даралт нь ихсэж, бидний мэдэхгүй шинэ төрлийн хорт хавдрын өвчин нэмэгдэж байна”. (Хувиараа бизнес эрхлэгч, Сэлэнгэ аймаг, эмэгтэй)

“Монголчууд хүрээлэн буй орчин, байгальдаа дасан зохицсон. Гэвч энэ байдал өөрчлөгдөж байгаагаас бидний эрүүл мэндэд нөлөөлж эхэлж байна. Хүүхдүүд маань байнга ханиад томуу тусч, дархлаа нь суларч байна. Байгалийн янз бүрийн гамшиг хүмүүсийн эрүүл мэндэд нөлөөлж, зарим тохиолдолд үхэлд хүргэж байна” гэлээ. (Хувиараа бизнес эрхлэгч, Улаанбаатар, эмэгтэй)

Уур амьсгалын өөрчлөлтөөс болж өвөлдөө салхилах нь багассан гэж бодож байна. Салхилахгүй болохоор хүмүүсийн бий болгосон агаарын бохирдол арилахгүй байна. Энэ нь хүчтэй мэдрэгдэж, иргэдийн эрүүл мэндэд сөргөөр нөлөөлж байна. (Баян-Өлгий аймаг, өрхийн тэргүүн, эмэгтэй)



6. БАЙГАЛЬ ОРЧИН, УУР АМЬСГАЛЫН ӨӨРЧЛӨЛТТЭЙ ХОЛБООТОЙ ДАДЛУУД

Олон нийтийн уур амьсгалын өөрчлөлтөд мэдрэг байдлыг бууруулж, тэсвэр хатуужилтай болгохын тулд илүү сайн мэдлэг олгож, дадал хэвшил бий болгоход туслах үр дүнтэй дасан зохицох стратеги зайлшгүй шаардлагатай.³⁵ Тиймээс энэхүү судалгааны дадалтай холбоотой асуултууд нь уур амьсгалын өөрчлөлтийг багасгахад дэм болохуйц дадал зуршил болон олон нийтийн өөрчлөхийг хүсэж буй зан үйлийн өөрчлөлтийн төрлийг тодорхойлоход чиглэсэн.

Дадалтай холбоотой энэ хэсэгт голчлон хувь хүний үйлдлүүд, уур амьсгалын өөрчлөлтийн үр дагавар, гамшгаас гэр бүлээ хамгаалахын тулд хийж буй өрхийн түвшин дэх дадлууд, хүрээлэн буй орчны нөлөөг бууруулахын тулд хийж буй байгаль хамгаалах зан үйлийн асуултууд багтсан.³⁶

Хүснэгт 6 Уур амьсгалын өөрчлөлттэй холбоотой дадлуудын гол асуултын үр дүнгийн хураангуй, хүйс, нас, байршил, эмзэг байдлаар (%), (n=2804)

	Шалгуур асуултууд	Хүйс		Насны бүлгүүд				Байршил		Эмзэг байдал	
		Эм	Эр	18-24	25-34	35-59	>60	Хот	Хөдөө	Их	Бага
1	Байгалийн гамшгаас урьдчилан сэргийлэх арга хэмжээ авсан	20.2	23.6	17.2	22.0	24.0	20.8	20.4	24.5	22.2	21.4
2	Дадал: Ашиглаагүй үедээ цахилгаан төхөөрөмжүүдээ залгаатай орхидог	29.9	32.6	39.8	35.2	28.7	17.6	33.4	27.1	35.2	26.7
3	Дадал: Нэг удаагийн хуванцар бүтээгдэхүүн хэрэглэдэг - аяга, таваг, соруул, сэрээ гэх мэт	44.6	52.3	48.6	53.3	48.5	36.6	49.5	46.2	55.2	40.5
4	Дадал: Хувийн тээврийн хэрэгслээр зорчдог, бусдад ч ингэхийг зөвлөдөг	61.8	66.5	50.3	70.0	68.1	58.8	59.8	71.8	67.3	60.3

³⁵ OECS Secretariat, Уур амьсгалын өөрчлөлтийн талаарх мэдлэг, хандлага, дадал, OECS, 2013

³⁶ Armstrong, Krasny, & Schuldt, Уур амьсгалын өөрчлөлтийн талаар мэдээлэл өгөх багш нарт зориулсан гарын авлага, 2018

5	Дадал: Нарны цахилгаан эрчим хүч ашигладаг (нарны хавтан)	26.6	30.5	35.1	26.4	27.2	26.4	14.7	53.6	20.2	37.9
6	Дадал: Нүүр гар, шүдээ угаахдаа усаа хаадаг	90.4	87.9	87.1	88.4	90.4	89.6	91.4	85.1	90.0	88.2
7	Дадал: Хүнсний уут, усны сав зэрэг дахин ашиглах боломжтой бүтээгдэхүүнийг ашигладаг	79.4	74.5	76.6	76.2	77.1	78.9	77.8	75.6	77.3	76.6
8	УАӨ-ийг даван туулах, шийдвэрлэх чадвартай гэж үздэг	34.9	33.9	28.9	28.3	30.2	28.1	29.6	28.6	32.3	25.8
9	УАӨ (байгалийн гамшиг)-аас учрах хохирлоос урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах мэдлэгтэй байх- сайн, маш сайн	8.9	11.6	10.6	9.1	9.7	13.5	9.6	11.4	10.8	9.5

Тайлбар: Статистикийн хувьд ач холбогдолтой үр дүнг өнгөөр тодруулсан болно. (p < 0.01).

6.1 Байгаль орчин, цаг агаар болон нөөцөд гарч буй өөрчлөлтүүдэд хариу арга хэмжээ авахад чиглэсэн даван туулах стратеги

Даван туулах стратеги гэдэг нь эмзэг байдлыг бий болгож буй аливаа хямрал, нөхцөл байдал, хэрэгцээ шаардлагыг зохицуулахын тулд хүмүүсийн хэрэгжүүлж буй сэтгэл зүйн, амьжиргааг тэтгэх, харилцаа холбоог сайжруулах үйл ажиллагаа юм. Үүнтэй холбоотойгоор, бид судалгаанд оролцогчдоос тэдэнд тохиолдсон байгалийн гамшигт үзэгдэл, байгаль орчны

Зураг 33 Байгаль орчны асуудлыг шийдвэрлэхийн тулд өөрчлөлт хийсэн судалгаанд оролцогчдын хувь (n=253)



өөрчлөлтийг даван туулах арга хэмжээ авч, хэрэгжүүлж байгаа эсэхийг тодруулсан юм.

Байгалийн өөрчлөлтийг ажигласан судалгаанд оролцогчдын өрх гэрийн хэмжээнд хэрэгжүүлсэн урьдчилан сэргийлж, даван туулах гол арга зам нь шилжин суурьших, ажил, амьжиргааны эх үүсвэрээ өөрчлөх зэрэг байв. Зургаан оролцогч тутмын нэг нь (16.4%) байгаль орчны асуудлыг давахын тулд одоогийн амьжиргааны эх үүсвэр - ажилдаа өөрчлөлт хийж байж. Ялангуяа, энэхүү хувь нь өнгөрсөн онд нүүн шилжсэн хүмүүсийн дунд (28.4%) илүү өндөр байна. Зураг 33-т үзүүлсэнчлэн, байгаль орчны өөрчлөлтийг давахын тулд авсан арга замуудаас хамгийн нийтлэг дурдагдсан өөрчлөлт нь ажил болон амьжиргааны эх үүсвэрээ өөрчлөх байжээ. Дурдсан өөрчлөлтүүдээс шилжин суурьших, байшиндаа засвар хийх гэсэн байршлаас хамаарсан мэдэгдэхүйц ялгаа ажиглагдаж байна. Шилжин суурьшсан (28.3%), ажил олж хийхээр

өөр тийш явсан (17.4%), байшин юм уу гэртээ нэмэлт засвар хийсэн (17.1%) гэсэн хотынхны хариултууд, орон нутгийнхны хариултаас (15.9%, 10.4%, 4.8%, тус тус) өндөр хувьтай байна.

Хөдөө орон нутгийнхантай харьцуулахад, хотынхон илүү олон янзын, идэвхтэй арга хэмжээ авсан байна. Судалгаанд оролцогчдоос үер, цөлжилт, ган гачиг, шуурга, элсэн шуурга, гал түймэр зэрэг байгалийн гамшгаас өөрийгөө хамгаалах урьдчилан сэргийлэх ямар нэгэн арга хэмжээ авсан эсэхийг асуухад 21.8% (n=355/514) нь тийм гэж хариулсан байна. Зураг 34-т харуулснаар, 'гэртээ томоохон засвар өөрчлөлт хийсэн' (22.4%), 'цаг агаарын урьдчилсан сэргийлэх мэдээ үзэж, сонсдог' (20.3%), 'үерээс хамгаалах арга хэмжээ авсан' (17.3%), 'мод тарьж, зүлэг ногоо ургуулсан' (15.6%) зэрэг нийтлэг арга хэмжээг дурдсан байна. Арга хэмжээний төрлийн тухайд, хотын оролцогчид, орон нутгийнхантай харьцуулахад

Зураг 34 Байгалийн гамшигт үзэгдлүүдээс урьдчилан сэргийлэх арга хэмжээ авсан судалгаанд оролцогчид,



олон төрлийн урьдчилан сэргийлэх арга хэмжээ авч байв. Зураг 34-т харуулсанчлан, хотынхон илүү шинэ чадварт илүү суралцсан (15.1%), яаралтай тусламжийн үед ашиглах багц бэлтгэсэн (12.3%), усны менежментийг сайжруулсан (9.9%), байшин, өмч хөрөнгөө даатгуулсан (6.7%) гэх мэт урьдчилан сэргийлэх илүү идэвхтэй арга хэмжээ авч байв. Харин орон нутгийнхан, уламжлалт арга ашиглаж эхэлсэн (8.1%), өөр газар луу нүүсэн (8.2%) гэсэн идэвхгүй, эрсдэлтэй нүүр тулсны дараах арга хэмжээнүүдийг авсан байна. Мөн, сүүлийн 10 жилд гамшигт өртсөн судалгаанд оролцогчдын 'өөр газар шилжин суурьшсан' гэж хариулсан хувь (30.8%) нь өртөөгүй оролцогчидтой (69.2%) харьцуулахад хоёр дахин бага байсан.

Улмаар, судалгаанд оролцогчид өөрчлөгдөн буй уур амьсгалын нөхцөлд тохируулан авч буй арга хэмжээ, түүнд нөлөөлөх хүчин зүйлс хийгээд өөрсдийн туршлагыг доорх байдлаар хуваалцсан юм:

"Би 2010-2015 оны хоорондох зүдэд их хэмжээний малын хохирол амссан. Миний бодлоор, 10 жилд нэг удаа байгалийн гамшиг болоод байх шиг санагддаг. 2010 онд малчид өдөр бүр малаа зүдэд хорогдуулаад, хамгийн хүнд байсан. Дараа нь, 2015 онд дахиад зүд болоход

малчид туршлагажиж, цаг агаарын мэдээ урьдчилан сонсох, малаа өвөлжөөнөөс хол бэлчээхгүй байх, малынхаа тэжээлийг урьдчилан бэлтгэх зэрэг арга хэмжээ авч байсан. Энэ жил өмнөх шиг нөхцөл байдал үүсэж магадгүй байгаа болохоор бид өнгөрсөн хугацаанд хүримтлуулсан туршлагаа хэрэгжүүлнэ." (Хувиараа хөдөлмөр эрхлэгч, Баян-Өлгий аймаг, эмэгтэй)

"Тухайн үед хэн ч бороо их орж, үер болохыг мэдээгүй. Тэнгэр бүрхэг, салхи шуургатай л байх шиг байсан. Гэтэл тэр өдөр 10-хан минут орсон борооноос болж бүх байшин, хашаа нурсан. Би цаг агаарын мэдээнд ач холбогдол өгдөг хэдий ч, анхаарч сонссон ч хэлийг нь ойлгохгүй байх байсан. Над шиг хөдөө төрсөн, сургуульд сураагүй, боловсролгүй казахчууд мэдлэг дутмаг, хэл мэдэхгүй. Амьдарч байгаа цагт итгэл найдвар байдагчлан бид газар худалдаж авч, дахин байшин барьсан. Тусламж авсан ч, тэр нь хүртээмжтэй байсангүй. Манайх шиг амьжиргааны түвшин доогуур хүмүүс танил талгүйгээс болж авч чадаагүй. Манай аймагт танил талтай, аль нэг намтай холбоотой хүмүүс л иймэрхүү тусламжид хамрагддаг. Одоо би өөрийгөө

бэлтгэлтэй байгаа гэж бодож байгаа ч, хэн ч байгалийн гамшигийг сөрж чадахгүй." (Баян-Өлгий аймаг, хөдөөгийн оролцогч, эрэгтэй)

Малчдын хувьд, уур амьсгалын өөрчлөлтийг давахын тулд авсан гол арга хэмжээ нь өвөлжөөгөө сайжруулах (96.2%), нэмэлт тэжээл бэлтгэх (92.2%), бусад малчидтай туршлага хуваалцах (88.2%) зэрэг байна. Харин байгалийн нөөц, экосистемд гарч буй өөрчлөлтөд авч буй хариу арга хэмжээ нь насны бүлгээс хамаараад нэлээд ялгаатай байна.

Нэн ялангуяа, малын төрөл зүйл болон амьжиргааны эх үүсвэрийг төрөлжүүлэх нь залуу малчдын дунд илүү түгээмэл байжээ. Хэдийгээр мал аж ахуйтай холбоотой дадлууд 18-55 насны малчдын дунд илүү олон янз байгаа ч, 56-аас дээш насны ахмад малчидтай харьцуулахад зарим зан үйл нь мал сүргийн тоо нэмэх, мал маллахдаа мотоцикл/машин ашиглах зэрэг сөрөг үр дагавар бүхий дадлуудтай байна.

Дорнод аймгийн малчид бэлчээр сэлгэхэд нь ямар сорилтууд тулгардаг талаар туршлагаасаа хуваалцсан юм:

"Дорнод аймагт нүүдэл хийх нь ашиггүй, бас хүндрэлтэй байна. Сүүлийн үед мод, чулууны үнэ ихэссэнээс өвөлжөө, хашааг маань зөөгөөд авч явах юм уу амьтан сүйтгээд дүүсгаж байна. Дараа жил нь буцаад ирэхэд өвөлжөө байхгүй болчихсон байдаг. Тэгсэн ч малчид

нүүхгүй байна. Үүнээс малчид суурин амьдралын хэв маягийг илүүд үзэх болсон нь харагдаж байна. Зарим айлын дөнгөж орхисон бэлчээрийг дахин ашиглаж, даац хэтрүүлж байгаа бөгөөд энэ асуудлыг сумын хурлаар хэлэлцсэн". (Дорнод аймгийн малчин, эмэгтэй)

6.2 Уур амьсгалын өөрчлөлтийн үр нөлөөг бууруулах дадлууд

Судалгаанд оролцогчдын дийлэнх нь өөрсдийгөө байгаль орчинд ээлтэй зан үйл хийдэг гэж хариулж байгаа ч, хагасаас илүү нь хувийн тээврийн унаагаар зорчдог, хуванцар бүтээгдэхүүн хэрэглэх дадал хэвшилтэй байна. Судалгаанд оролцогчдын өдөр тутмын дадлыг

Зураг 35 Уур амьсгалын өөрчлөлт, экосистем, байгалийн нөөцийн өөрчлөлтийг давахын тулд хэрэгжүүлсэн арга хэмжээ, насны бүлгээр (n=612)



Зураг 36 Оролцогчдын өдөр тутмын дадал зуршил, байршлаар (n=2804)



нэрлүүлэхэд усаа хаах (89.2%), дахин ашиглах боломжтой бүтээгдэхүүн ашиглах (77.0%), электрон төхөөрөмжүүдээ салгаж орхих (68.8%) зэрэг дадлыг хамгийн нийтлэг дурдаж, талаас илүү хувь нь хуванцар бүтээгдэхүүн ашигладаг (48.3%), хувийн унаагаар зорчдог (64.0%) гэсэн сөрөг дадлыг нэрлэжээ.

Хот, хөдөө орон нутгийнхны зан үйл нь ихээхэн ялгаатай байна. Ялангуяа, орон нутгийнхны дунд нарны эрчим хүч (53.6%) хэрэглэж, электрон хэрэгслүүдээ салгаатай орхидог (72.9%) нь илүү өндөр бол, хотынхны дунд усаа хааж (91.4%), дахин ашиглах боломжтой бүтээгдэхүүн хэрэглэх (77.8%) дадал илүү нийтлэг байна.

Ганцаарчилсан ярилцлагын үеэр өөрийг нь үнэлэх асуулт асууж байгаа тохиолдолд хариултууд бодит байдлыг үнэн зөвөөр тусгадаггүй гэдгийг анхаарах нь зүйтэй.

Хот, хөдөөгийн судалгаанд оролцогчид өөрсдийн дадал, түүнтэй холбоотой бэрхшээл сорилтыг дараах байдлаар хуваалцжээ:

“Нүүрсээр гал түлэхэд агаар бохирдуулдаг болохоор бид цахилгаан тень худалдаж авсан. Нүүрснээс илүү хэмнэлттэй, анхаарал бага шаарддаг ба хэт халж, хөлдөхгүйгээр орчны халаалтыг өөрөө тохируулах боломжтой. Өнгөрсөн жил


бид нэг сард 180 мянган төгрөг төлж байсан. Өдөр, шөнийн тоолуур суурилуулах нь хямд үнэтэй төдийгүй тухайн

газарт нүүрстөрөгчийн тоос, хөө тортог үүсгэдэггүй.” (Дорнод аймгийн өрхийн тэргүүн, эмэгтэй)

“Манай гудамж бохир усаар дүүрсэн. Сэтгэл дутсан эсвэл хашаандаа зүгээр л бохирын нүх ухаж чадахгүй байгаа хүмүүс олон байна. Хэдийгээр бид хашааны үүдийг өглөө бүр цэвэрлэдэг ч дахиад бохир ус, хогоор дүүрсэн байдаг. Өдөр бүр цэвэрлээд ч нэмэргүй”. (Эмэгтэй, хотын оролцогч, Улаанбаатар)

“Манайх нялх хүүхэдтэй айл учраас халаалт, цахилгааны эрчим хүчний хэрэглээ өндөр. Энэ хэрэглээгээ багасгах бараг л боломжгүй. Учир нь хоол хийх, хүүхдээ даарахаас сэргийлж цахилгаан тень асаах гэх мэт бүх зүйлд цахилгаан их зарцуулж байна. Хэрэглээ өндөр болохоор өндөр төлбөр төлдөг. Бас тоосгон байшинд амьдардаг учраас хүүхдээ дааруулахгүйн тулд нэлээд хэмжээний нүүрс хэрэглэдэг” (Залуу ээж, Улаанбаатар, эмэгтэй)

Зураг 37 Малчдын уламжлалт дадал, зуршил, насны бүлгээр (n=402)



Малчид хүрээлэн буй орчиндоо болж буй байгаль орчны өөрчлөлтийг илүү анзаарч (53.5%), санаа зовж (74.6%) байна. Малчдаас уламжлалт, өдөр тутмын зан үйлтэй холбоотой асуулт асуусан. Судалгаанд хамрагдсан 402 малчдын нийтлэг дурдсан дадлууд нь ‘Гол цэвэрлэж, усны эх үүсвэрийг хамгаалах’ (91.0%) болон ‘уул усны эздэд өргөл өргөх , уул овоо тахиж, мөргөх’ (90.6%) зэрэг байв.

Дээрх дадлуудад тэдний наснаас хамаарсан ихээхэн ялгаа ажиглагдаж байна (Зураг 37). Ялангуяа ахмад малчид нь залуу малчдаас илүү олон уламжлалт зан үйлийг ашиглах хандлагатай байна. Түүнээс гадна, 18-55 насны малчдын дунд хамгийн түгээмэл байдаг зан үйл нь ‘гол мөрнийг цэвэрлэж, усны эх үүсвэрийг хамгаалах’ явдал байсан бол, 56-аас өндөр настай малчдын дунд ‘уул усны эздэд өргөл өргөх , уул овоо тахиж, мөргөх дадал хамгийн түгээмэл байна.

Дорнод аймгийн нэгэн малчин зан үйл, дадлыг чиглүүлж буй эх сурвалжийг дор ийн өгүүлжээ:

“Шинэ цагийн шинж гээд Шагдарсүрэн гуай (цаг уурч) яриад байдаг, бид байнга сонсох дуртай. Яагаад гэхээр, дээр үед ахмад настай хүмүүс шинийн 2-нд ямар сартай байна, од мичдийн тохиол ямар байна вэ,

дээгүүрээ гарч байна уу, доогуураа гарч байна уу,

шувуугаа хар, шувуу ямаршуухан ирэв, энэ зуны шувуу цас мөс ямар байх нь вэ, гээд бүх амьтан ургамал, өвс ногоотойгоо бүгдийг зүйрлэж харуулдаг. Тэрэнтэй ижилхэн мэдээ мэдээллийг түгээсэн 90-ээд онд гарч байсан нэг гарын авлагад сарны 200-аад шинжийг зурагласан байсан. Яг тийм гарын авлага бидэнд хэрэгтэй байна. Тэр номд бүх нөхцөл, шинж тэмдгийг тодорхойлсон байдаг. Бид улирлынхаа шинж тэмдгийг сайн мэдэхгүй байна. Хэдэн сард ямар нөхцөл тохиодог, ямар шувуу жиргэдэг, ямар шүүрга дэгддэг гээд бүх юм товч тодорхой байдаг.” (Малчин, Дорнод аймаг, эрэгтэй)

Нүүдэлчдийн амьдрал байгалиас шууд хамааралтай учраас, байгаль орчноо хайрлан хамгаалах бусад уламжлал бий. Судалгаанд оролцогчдын зарим нь өөрсдийн мэдэх сургаал, зүйр үг, уламжлалт зан үйл, бичигдээгүй хуулиудаас хуваалцжээ. Жишээ нь, “үнсийг зуухнаас нь гаргахдаа ил бүү хая. Учир нь гал түймэр гарах, хүн, амьтны амь насанд аюул учруулж, хүрээлэн буй орчныг сүйтгэдэг гэж үздэг. Мөн “байгалийн усанд (гол, нуур) хог

Зураг 38 Уур амьсгалын өөрчлөлтийн сөрөг нөлөөг бууруулахад хувь хүний зүгээс авах арга хэмжээ, байршлаар (n=2804)



хаягдлаа хэзээ ч бүү хая. Учир нь гол мөрөн, нуур амьдралын эх үүсвэр болдог” гэж мөн үздэг.

6.3 Уур амьсгалын өөрчлөлтөд арга хэмжээ авах эрмэлзэл

Уур амьсгалын өөрчлөлтийн асуудлыг нэн тэргүүнд тавихад хүмүүсийг юу сэдэлжүүлдэг вэ? Энэхүү судалгаанд хүмүүсийн зөвхөн өнөөгийн дадал бус, өдөр тутмын дадал, хэвшлээ өөрчлөх эрмэлзэл хэр байгааг анхаарсан. Тайлангийн 4.3, 4.4-т дурдсанчлан Монголчуудын хувьд хамгийн том хөшүүрэг нь эрүүл мэнд, амьжиргаанд нөлөөлөхүйц эдийн засгийн асуудлууд болохын зэрэгцээ, байгалийн гамшигт илүү сайн бэлтгэлтэй байх, сөрөг үр нөлөөг бууруулах эрмэлзэл нь гол түлхэц болж байна.

Судалгаанд оролцогчдын уур амьсгалын өөрчлөлтийн шалтгааны тухай ойлголтын түвшин нь УАӨ-өөс үүдсэн хямралыг даван туулахад туслахуйц амьдралын хэв маягаа өөрчлөх эрмэлзэлд нь чухал үүрэгтэй байна. Ихэнх нь (99.6%) нь уур амьсгалын өөрчлөлтийн сөрөг нөлөөг бууруулахын тулд өөрчлөхийг эрмэлзэж буй дадлуудаас хамгийн багадаа нэгийг нэрлэжээ. Өөрчлөхийг эрмэлзэж буй эдгээр дадлаас хамгийн нийтлэг дурдагдсан нь нэг удаагийн хуванцрын хэрэглээг багасгах (94.5%), гэрээ илүү эрчим хүчний хэмнэлттэй болгох (93.0%), илүү их алхах, дугуйгаар явах (86.2%), эрчим хүчний хэмнэлттэй цахилгаан хэрэгсэл авах (85.5%) зэрэг байна.

Судалгаанд оролцогчдын олонх (99.6%) нь уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөг бууруулахын тулд амьдралын хэв маягаа өөрчлөхийг эрмэлзэж байгаа ч, уур амьсгалын өөрчлөлтийн учир шалтгааны талаарх мэдлэгээс хамааран энэхүү хувь харилцан адилгүй байна. Тухайлбал, Зураг 38-д үзүүлсэнчлэн, Монгол ба бусад улс орон дахь эдгээр байгаль орчны асуудлын үндсэн шалтгаан нь 'хүний буруутай үйл ажиллагаа биш' гэж хариулсан оролцогчид амьдралынхаа хэв маягийг өөрчлөх эрмэлзэл багатай байна.

Энэ нь уур амьсгалын өөрчлөлтийн талаарх суурь мэдлэг ихээхэн чухал болохыг харуулж байна.

Тайлангийн 7-р бүлэгт тайлбарласнаар, хувь хүний үйлдлүүд нь Монгол улс шиг орнуудын хувьд хүлэмжийн хийн хаягдлыг бууруулахад чухал үр нөлөөтэй байдаг. Тиймээс, бодлого, хөтөлбөрийн өөрчлөлтүүдэд анхаарал хандуулахын сацуу, эмзэг бүлгүүд, олон нийтийн дасан зохицох чадварыг сайжруулахтай холбоотой мэдлэг, чадварыг нь сайжруулахад туслахад мөн анхаарах шаардлагатай.

7. СЕГМЕНТИЙН ШИНЖИЛГЭЭ

Энэ бүлэгт хүн амын тоо, нийгэм эдийн засаг, газар зүйн хүчин зүйлс нь мэдлэг, хандлага, дадалд хэрхэн нөлөөлж байгаа талаар голлон авч үзнэ. Судалгааны баг нь хоёр эмпирик анализ – үндсэн бүрэлдэхүүн хэсгүүдийн шинжилгээ (PCA) болон энгийн хамгийн бага квадратын үнэлгээ(OLS)-ний үр дүнг танилцуулна.

7.1 Үндсэн бүрэлдэхүүн хэсгүүдийн шинжилгээ (PCA)

Үндсэн бүрэлдэхүүн хэсгүүдийн шинжилгээг³⁷ судалгааны хүн ам доторх өвөрмөц шинж чанар бүхий бүлэг, хэв маяг бий эсэхийг илрүүлэх зорилгоор явуулсан. Энэ нь өөр хоорондоо ялгаатай бүлгүүдийн тоог хялбарчилж, багасгах замаар ямар шинж чанар нь тэднийг онцлог болгож байгааг тодорхойлоход тусалдаг. Судалгаанд үндсэн бүрэлдэхүүн хэсгүүдийн шинжилгээг гүйцэтгэхэд 5 төрөл тодорхойлогдсон. Дроорх хүснэгтэд хэсэг тус бүр болон гол ялгарах шинж чанаруудыг нь харууллаа.

³⁷ Бид мэдлэг, хандлага, дадалд үзүүлэх нөлөөллийг задлан харахдаа 15 хувьсагчийг (хүйс, нас, боловсрол, ажил эрхлэлт, хадгаламж, орлогын бүлэг, шилжилт хөдөлгөөн, гамшигтай холбоотой туршлага, орчны өөрчлөлтийг анзаарсан байдал, малчин, хөгжлийн бэрхшээлтэй эсэх, эмзэг байдал, бүс нутаг, экологийн бүс, хот суурин) үндсэн хэсгүүдийн шинжилгээг гаргахад ашигласан. Дараа нь Eigenvalues ашиглан нэн чухал хэсгүүдийг гаргасан (15 хувьсагчийг ашиглан сонгосон гол хэсгүүдийг танилцуулсан илүү нарийвчилсан хүснэгтийг хавсралт 5-аас үзнэ үү).



Хүснэгт 7 Гол бүрэлдэхүүн хэсгүүд ба онцлог шинж чанарууд

Бүрэлдэхүүнүүд	Онцлог шинж чанарууд
Бүрэлдэхүүн 1	<ul style="list-style-type: none"> Бага боловсролтой Хөдөө орон нутгийн иргэд Хангай болон баруун бүсийнх
Бүрэлдэхүүн 2	<ul style="list-style-type: none"> Өндөр орлоготой биш ч хадгаламжтай Хот суурин газрын оршин суугчид
Бүрэлдэхүүн 3	<ul style="list-style-type: none"> Өмнө нь гамшигт өртсөн Нэг газраа 10 жилийн турш оршин суусан Эмзэг бүлэг
Бүрэлдэхүүн 4	<ul style="list-style-type: none"> Ахимаг настай Эмзэг бүлэг Өндөр орлоготой
Бүрэлдэхүүн 5	<ul style="list-style-type: none"> Эрэгтэй Эрхэлсэн ажилгүй

Хүснэгт 8 Гол хэсгүүд ба мэдлэг, хандлага, дадлын индекс

	Мэдлэг	Хандлага	Дадал
Бүрэлдэхүүн 1	-0.1576*	-0.1227*	-0.0844*
Бүрэлдэхүүн 2	0.0381	-0.0442	0.1477*
Бүрэлдэхүүн 3	0.0451	0.0971	0.1067*
Бүрэлдэхүүн 4	0.1061*	0.1918*	0.0690*
Бүрэлдэхүүн 5	-0.0342	-0.1122*	-0.0459

Үүний дараа, 7-р хүснэгтэд харуулсанчлан эдгээр үндсэн бүрэлдэхүүн хэсгүүд болон уур амьсгалын өөрчлөлттэй холбоотой мэдлэг, хандлага, дадлын түвшний хооронд ямар нэгэн уялдаа холбоо байгаа эсэхийг шинжлэх зорилгоор энгийн корреляцийн шинжилгээ хийсэн.

Бид үндсэн бүрэлдэхүүн хэсгүүд болон мэдлэг, хандлага, дадлын хоорондох уялдаа холбоог корреляцийн коэффициентууд дээр тулгуурлан, аль нэг хүн амын бүлэг нь мэдлэг, хандлага, дадлын түвшин нь өндөр эсхүл бага түвшинд байгаа эсэхийг ажиглаж болно. Дээрх хүснэгтээс харахад өндөр настай, эмзэг, өндөр орлоготой (Хэсэг 4) хүмүүсийн дунд мэдлэгийн түвшин өндөр байна. Нөгөө талаар, мэдлэг багатай

хүмүүс нь бага боловсролтой, баруун болон хангайн бүсийн хөдөө орон нутагт амьдарч байх магадлал өндөр (Хэсэг 1) байна. Бусад хэсгүүдийн хувьд ямар нэгэн ач холбогдол бүхий уялдаа холбоо байхгүй байна.

Хандлагын тухайд, өндөр настай, эмзэг бүлгийн, өндөр орлоготой (Хэсэг 4) хүмүүсийн дунд илүү өндөр байна. Үүний эсрэгээр, хандлагын түвшин нь бага боловсролтой, баруун болон хангайн бүсэд хөдөө амьдардаг хүмүүсийн дунд бага (Хэсэг 1) байна. Цаашилбал, эрэгтэй, ажил эрхэлдэггүй хүмүүсийн дунд хандлагын түвшин бага байх шинжтэй байна (Хэсэг 5). Өөр нэг сонирхолтой үр дүн бол мэдлэгийн түвшин доогуур байх нь хандлагын түвшин доогуур

байхтай холбоотой бөгөөд эсрэгээрээ их байх тусам хандлагын түвшин өндөр байна.

Дадлын түвшний хувьд хот суурин газарт амьдардаг, хуримтлалтай хүмүүсийн хувьд буюу орлогынхоо (Хэсэг 2) хувьд дундаж ангид байх магадлал өндөр хүн амын хувьд дадлын түвшин илүү өндөр байна. Цаашилбал, гамшигт өртсөн, сүүлийн 10 жилд шилжин суурьшаагүй, илүү эмзэг оролцогчдын хувьд дадлын түвшин нь өндөр байх хандлагатай байна (Хэсэг 3). Хамгийн чухал үр дүн нь мэдлэг, хандлагын түвшин нь бие биедээ эергээр нөлөөлдөг ч дадлын түвшинд ямар нэгэн чухал нөлөө үзүүлдэггүй аж. Үндсэн хэсгийн шинжилгээ нь хэд хэдэн сонирхолтой санааг өгч байна. Харин дараах дэд хэсэг нь хувь хүний түвшинд илүү дэвшилтэт эмпирик дүн шинжилгээний үр дүнг танилцуулна. Түүнчлэн бид хүн амын тоо, нийгэм эдийн засаг, газарзүйн хүчин зүйлсээр мэдлэг, хандлага, дадлын түвшнийг багцаагаар тодорхойлж чадна.

7.2 Энгийн хамгийн бага квадратын үнэлгээ

Эмпирик моделийг дараах хэсэгт харуулав:

$$Y_i = B_0 + BX$$

Үүнд, **Y** нь мэдлэг, хандлага, дадал, **X** нь үндсэн хэсгийн шинжилгээнд ашигласан 15 хувьсагчдыг илэрхийлнэ.

Үндсэн хэсгүүдийн шинжилгээтэй харьцуулахад энэ шинжилгээ нь хувь хүний түвшинд байна (Тооцоолсон коэффициентуудыг 41-р хүснэгтээс Хавсралт 5-аас харна уу). Шинжилгээгээр дараах гол үр дүнгүүд гарчээ:

- Мэдлэгийн түвшин нь нас, боловсрол, орлогын түвшин нэмэгдэх тусмаа хүрээлэн буй орчны өөрчлөлтийг анзаарсан хүмүүсийн тоо нэмэгдэж байна. Жишээ нь: нас нэг нэгжээр нэмэгдэхэд, мэдлэгийн түвшин 0.32%-иар өсөж байна. Бага боловсролтой хүмүүстэй харьцуулахад, бүрэн дунд, дээд боловсролтой хүмүүсийн мэдлэгийн түвшин 3.5 ба 5.8 хувиар тус тус өндөр байна. Цаашилбал, бүс нутгууд нь мэдлэгийн түвшинд

нэн чухал үүрэгтэй байна. Жишээлбэл, баруун бүсээс илүүтэйгээр хангай, зүүн бүс, Улаанбаатар хотод амьдарч байгаа судалгаанд оролцогчдын мэдлэг өндөр байна. Хамгийн нөлөө бүхий хувьсагч нь судалгаанд оролцогчдын амьдарч буй орчныхоо өөрчлөлтийг ажигласан эсэх нь болж байна. Ялангуяа байгаль орчны өөрчлөлтийг ажигласан хүмүүсийн мэдлэгийн түвшин 5.2 пунктээр илүү өндөр байна.

- Хандлагын түвшнээр ажилгүй эсвэл эрэгтэй судалгаанд оролцогчдын дунд доогуур байна. Мөн, байгаль орчны өөрчлөлтийг ажигладаг хүмүүсийн хандлага илүү өндөр байна. Түүнчлэн, Төв болон Улаанбаатар хотод амьдарч байгаа хүмүүсийн хандлага барууны бүсийнхэнтэй харьцуулахад өндөр байна. Байгалийн гамшигт өртөж байсан хүмүүсийн хандлага 1.7 хувиар илүү байна. Хавсралт 5-ын хүснэгтээс харвал, байгаль орчны өөрчлөлтийг ажигласан судалгаанд оролцогчдын хандлагын түвшин нь 5.0 пунктээр өндөр байна. Цаашилбал, хувь хүмүүсийн хандлагын түвшинд мэдлэг ихээхэн чухал нөлөөтэй байна. Шинжилгээний үр дүнгээс харахад 'орчны өөрчлөлтийг ажигласан байдал' нь мэдлэг, хандлагын түвшин өндөр байгааг тайлбарлах хамгийн ач холбогдолтой, тогтвортой үзүүлэлт юм.

- Дадлын түвшин нь нас, шилжилт хөдөлгөөн, хөдөө орон нутаг байх эсэхтэй сөрөг хамааралтай байна. Тухайлбал хөдөө орон нутагт амьдарч байгаа хүмүүсийн дадлын түвшин нь хот суурин газрынхтай харьцуулахад 1.8 хувиар бага байна. Үүнээс гадна хувиараа хөдөлмөр эрхлэгчдийнх 3.7% бага байна. Өөр нэг сонирхолтой үр дүн нь, орчны өөрчлөлтийг ажигласан талаарх хувьсагч нь мэдлэг, хандлагын түвшинд эергээр нөлөөлж байсантай адил дадалд ч эергээр нөлөөлж байна. Үндсэн хэсгийн шинжилгээний үр дүнд харуулсанчлан дадлын түвшин нь мэдлэг, хандлагын түвшнээс хамаарахгүй бөгөөд энэ нь ихээхэн чухал үр дүн болж байна (Хавсралт дахь 42-р хүснэгтэд эдгээр

бүлгүүдийн дундаж оноог хамгийн өндөр оноотой бүлэгтэй харьцуулж харуулсан байгаа.)

Хамгийн их дахин давтагдаж буй чухал үр дүн нь судалгаанд оролцогч байгалийн ямар нэгэн өөрчлөлтийг ажигласан бол түүний мэдлэг, хандлага, дадлын түвшин өндөр байх магадлалтай байдаг. Хэдийгээр хувь хүмүүсийн хүн амын шинж чанар нь мэдлэг, хандлага, дадлын янз бүрийн түвшнийг тайлбарлахад чухал боловч, тэдгээр түвшнийг өөрчлөхөд түршлага зэрэг гадаад хүчин зүйл чухал үүрэг гүйцэтгэж байгааг эдгээр үр дүн харуулж байна.



III ХЭСЭГ. ОРОЛЦОГЧ ТАЛУУДЫН ШААРДЛАГАТАЙ ҮЙЛ АЖИЛЛАГАА, ЧАДАВХЫН ТАЛААРХ ХҮЛЭЭЛТҮҮД

Энэхүү тайлангийн 3-р хэсэгт олон нийт, гол оролцогч талуудын (засгийн газар, олон улсын байгууллага, ТББ, хувийн хэвшил) дундах уур амьсгалын өөрчлөлттэй холбоотой нэн тэргүүнд хэрэгжүүлэх арга хэмжээ, хүлээлт, хэрэгцээтэй холбоотой үр дүнг танилцуулна. Тайлангийн 7-р бүлэгт холбогдох арга хэмжээ авч хэрэгжүүлэх үүрэг бүхий талууд болон ямар төрлийн арга хэмжээг яагаад хэрэгжүүлэх ёстой талаарх хүмүүсийн үзэл бодол, хүлээлтийг тусгахад голлон анхаарсан. Харин 8-р бүлэгт Монгол Улсад уур амьсгалын өөрчлөлтийн талаарх ойлголтыг түгээн дэлгэрүүлэхтэй холбоотой өнөөгийн бэлэн байдлын талаарх үнэлгээ, оролцогч талуудын байр суурийг түлхүү танилцуулна.

8. ХЭРЭГЖҮҮЛЭХ ШААРДЛАГАТАЙ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТАЛААРХ ОРОЛЦОГЧ ТАЛУУДЫН ХҮЛЭЭЛТ

7-р бүлэгт тавьсан гол асуултууд нь 'Хэн, ямар институт, байгууллагууд нь уур амьсгалын өөрчлөлтийг бий болгож байна вэ? Эдгээрээс арга хэмжээ авч хэрэгжүүлэх гол үүрэгтэй тал аль нь вэ?', 'Уур амьсгалын өөрчлөлтийг шийдвэрлэх талаарх Засгийн газрын нэн тэргүүний авч хэрэгжүүлэх арга хэмжээг юу гэж ойлгож байна вэ?' зэрэг асуулт болно.

Хүснэгт 9 Уур амьсгалын өөрчлөлттэй холбоотой гол үзүүлэлтүүдийн үр дүнгийн хураангуй, хүйс, насны бүлэг, байршил, эмзэг байдлаар, % (n=2804)

#	Шалгуур асуултууд	Хүйс		Насны бүлэг				Байршил		Эмзэг байдал	
		F	M	18-24	25-34	35-59	>60	U	R	LV	V
1	УАӨ нь Монгол улсын хувьд яаралтай арга хэмжээ авах асуудал мөн гэдэгт итгэдэг	86.5	84.7	75.0	84.1	89.5	92.1	85.5	85.9	85.6	86.1
2	ЗГ УАӨ-ийг бий болгож байгаа гэдэгт итгэдэг	24.6	26.6	18.9	28.2	26.9	26.4	27.7	21.7	23.8	27.5
3	УАӨ-ийг иргэд бий болгож байна гэдэгт итгэдэг	36.8	35.0	38.3	38.9	33.4	35.3	40.8	27.1	39.5	31.8
4	Аж үйлдвэрүүд УАӨ-ийг бий болгож байна гэдэгт итгэдэг	35.6	41.2	38.3	38.7	37.4	41.0	38.8	37.4	38.9	37.7
5	ЗГ арга хэмжээ авах үүрэгтэй гэдэгт итгэдэг	53.6	55.6	47.5	56.8	56.3	55.0	57.7	48.8	56.0	52.8
6	Иргэд арга хэмжээ авах үүрэгтэй гэдэгт итгэдэг	30.6	29.0	31.4	31.4	28.2	29.7	33.1	23.9	32.2	27.0
7	Аж үйлдвэрүүд холбогдох арга хэмжээ авах үүрэгтэй гэдэгт итгэдэг	9.1	10.6	8.7	11.0	9.3	11.0	11.3	7.0	10.3	9.3
8	УАӨ-ийг шийдвэрлэхийн тулд нийгэм бүхэлдээ өөрчлөгдөх ёстой гэдэгт итгэдэг	51.1	52.6	52.8	53.2	52.2	45.3	52.8	50.0	52.3	51.3

Уур амьсгалын өөрчлөлттэй холбогдох гол үзүүлэлтүүдийн үр дүнгийн хураангуйг дараах хүснэгтэд харуулав.

8.1 Уур амьсгалын өөрчлөлт нэн тулгамдсан асуудал болох нь

Уур амьсгалын өөрчлөлт нь нэн тулгамдсан асуудал мөн эсэх талаар асуухад судалгаанд оролцогчдын 85.7% нь тийм гэж үзжээ. Судалгаанд оролцогчдын 8.6% нь 'яаралтай биш', 5.7% нь 'Мэдэхгүй' гэсэн хариулсан байна. Хүснэгт 9-т харуулсанчлан яаралтай арга хэмжээ авах шаардлагатай гэж үзсэн ахмад настнуудын тоо залуу судалгаанд оролцогч нартай харьцуулахад өндөр байна. Уур амьсгалын өөрчлөлт бол яаралтай асуудал биш гэж хэлж байгаа хүмүүс залуучуудын дунд хамгийн их байна. Мөн энэхүү асуултын хариулт нь судалгаанд оролцогчдын амьдарч буй сууцны төрлөөс хамааран ихээхэн ялгаатай байна. Орон сууцанд амьдардаг хүмүүсийн уур амьсгалын өөрчлөлтийг яаралтай асуудал биш, эсхүл

яаралтай эсэхийг мэдэхгүй байна гэж хариулсан хувь өндөр байна. Харин байшин юм уу гэрт амьдардаг хүмүүсийн хувьд уур амьсгалын өөрчлөлт нь яаралтай шийдэх асуудал болж байна. Баруун аймаг, экологийн хуурай бүсэд амьдардаг иргэд яаралтай арга хэмжээ авах хэрэгтэй гэж хариулсан байна. Харин эмэгтэйчүүд, эрэгтэйчүүд, хөдөө, хот эсвэл орлогын ялгаатай оролцогчдын өгсөн хариултад статистикийн хувьд ялгаа ажиглагдсангүй.

Хүснэгт 10 Уур амьсгалын өөрчлөлт яаралтай шийдвэрлэх асуудал мөн эсэх, насны бүлэг, сууцны төрөл, бүс нутаг, экологийн бүсээр.³⁸


	Нийт	Яаралтай	Яаралтай бүс	Мэдэхгүй
Насны бүлгүүд				
18-24	551	75.0%	16.3%	8.7%
25-34	681	84.1%	9.1%	6.8%
35-55	1255	89.0%	6.3%	4.7%
60+	317	92.4%	4.4%	3.3%
Сууцны төрөл				
Хашаа байшин	973	87.2%	7.7%	5.1%
Гэр	735	87.9%	7.5%	4.6%
Орон сууц	1036	80.3%	11.8%	7.9%
Бусад (оюутны байр гэх мэт)	60	91.5%	1.7%	6.8%
Бүс нутаг				
Улаанбаатар	1253	83.8%	8.7%	7.5%
Баруун бүс	345	90.4%	8.4%	1.2%
Хангайн бүс	543	89.2%	5.5%	5.3%
Төвийн бүс	450	85.3%	10.7%	4.0%
Зүүн бүс	213	80.8%	12.2%	7.0%
Экологийн бүс				
Ойт хээрийн бүс	1669	84.4%	8.5%	7.1%
Уул, тайгын бүс	130	83.2%	6.9%	9.9%
Хээрийн бүс	760	87.0%	9.6%	3.4%
Хуурай бүс	65	85.9%	12.5%	1.6%
Хэт хуурай бүс	180	92.8%	5.6%	1.7%

38 Kruskal Wallis тестийн үр дүнд хүснэгтэд үзүүлсэн үр дүн нь мэдэгдэхүйц ялгаатай болохыг харуулсан, p < 0.01

Судалгаанд оролцогчдын талаас илүү хувь нь уур амьсгалын өөрчлөлтийн асуудлыг шийдвэрлэхийн тулд нийгэм бүхэлдээ өөрчлөлт хийх ёстой гэж үзэж байна. Уур амьсгалын өөрчлөлтийн асуудлыг (яаралтай эсэхээс үл хамааран) аль түвшинд шийдвэрлэх ёстойг асуухад нийт оролцогчдын 51.8% нь засгийн газар, иргэд, аж үйлдвэр, ашгийн бус салбар гэх мэт бүхий л талуудыг хамруулан 'нийгэм бүхэлдээ өөрчлөлт хийх ёстой' гэж хариулжээ. Доорх хүснэгтэд уур амьсгалын өөрчлөлтийн асуудлуудын нэн тулгамдсан байдал болон аль түвшинд- (хувь хүний түвшинд, засгийн газар эсвэл нийгэм бүхэлдээ)- шийдвэрлэх ёстой талаарх хариултаудыг нэгтгэн харуулж байна.

Хүснэгт 11 Уур амьсгалын өөрчлөлтийн эсрэг яаралтай арга хэмжээ, түвшний чиг хандлага, % (n=2804)

Бодомж	Хувь
Уур амьсгалын өөрчлөлт нь яаралтай шийдвэрлэх асуудал бөгөөд нийгэм бүхэлдээ өөрчлөгдөхөд чиглэгдэх ёстой	45.0%
Уур амьсгалын өөрчлөлт нь яаралтай шийдвэрлэх асуудал бөгөөд Засгийн газраас өөрчлөлтийг хийх хэрэгтэй	20.5%
Уур амьсгалын өөрчлөлт нь яаралтай шийдвэрлэх асуудал бөгөөд иргэд өөрчлөлтийг бий болгох ёстой	18.7%
Уур амьсгалын өөрчлөлт нь яаралтай шийдвэрлэх асуудал биш бөгөөд нийгэм бүхэлдээ өөрчлөлт хийх хэрэгтэй	4.3%
Уур амьсгалын өөрчлөлт нь яаралтай шийдвэрлэх асуудал биш бөгөөд иргэд хувь хүний түвшинд өөрчлөлтийг хийх хэрэгтэй	2.4%
Уур амьсгалын өөрчлөлт нь яаралтай шийдвэрлэх асуудал биш хэлийн ч өөрчлөлт засгийн газраас шалтгаална	1.6%
Мэдэхгүй	7.5%
Нийт	100.0%

Зураг 39 Уур амьсгалын өөрчлөлтийг бий болгогч болон хариу арга хэмжээ авч, шийдвэрлэх үүрэгтэй талуу.

Уур амьсгалын өөрчлөлтөд нэн яаралтай хариу арга хэмжээ авахуйц тулгамдсан асуудал гэдэгтэй санал нийлсэн хүмүүсийн тоо харьцангуй өндөр байгааг гайхах зүйл биш юм. Учир нь судалгаанд оролцогчдын хувьд уурын амьсгалын өөрчлөлт нь тэдний амьдралд болон улс орны амьдралд шууд эсвэл шууд бусаар нөлөөлөхүйц эдийн засаг, нийгэм, байгаль орчны бусад асуудлуудтай уялдаа холбоотой байгааг аль хэдийн анзаарсан байсан (4-р бүлэгт холбогдох үр дүнг дэлгэрэнгүй танилцуулсан байгааг).

8.2 Хариуцлага хүлээж буй байгууллага, институт

Тайлангийн 4-р бүлэгт байгалийн гамшиг, уур амьсгалын өөрчлөлтийг бий болгож буй аж

явдлууд зогсолтгүй үргэлжилбэл уур амьсгалын өөрчлөлт нь байгаль орчин, нийгмийн эрүүл мэнд, амьжиргаа (мал аж ахуй, газар тариалан)-нд сөргөөр нөлөөлж, эдийн засгийн өргөн хүрээтэй асуудал үүсгэж, хүнсний аюулгүй байдалд заналхийлж, нийгмийн асуудлыг улам хүндрүүлнэ гэж судалгаанд оролцогчид дурджээ. Тиймээс бид "Таны бодлоор уур амьсгалын өөрчлөлтийг бий болгож эсвэл улам дордуулж буй хариуцлагыг хэн хүлээх вэ?", "Уур амьсгалын өөрчлөлтийг шийдвэрлэхэд гол үүргийг хэн хүлээх вэ?" гэсэн асуултыг асуусан.³⁹

Судалгаанд оролцогчдын ихэнх нь Засгийн газар болон бусад үндэсний хэмжээний талуудыг уур амьсгалын өөрчлөлтөд голлон нөлөөлөгчөөр

39 Асуултуудын хариултын сонголтуудыг чангаар уншиж өгөөгүй бөгөөд судалгаанд оролцогчийг хариултаа хэлэх үед холбогдох хариултын утгад харгалзах сонголтоор орлуулан сонгож байсан бөгөөд хариултуудыг хураагуурт бичиж авсан нь хариултад алдаа гарахаас сэргийлж чадсан. Мөн бусад гэсэн сонголт байсан бөгөөд мэдэхгүй, хариултыг хүсэхгүй байна гэх мэт хариултуудыг мөн тусган оруулсан.

нэрлэж байгаа бөгөөд аж үйлдвэржсэн орнуудаас илүүтэйгээр тэд өөрчлөлт хийх үүрэгтэй гэж бодож байна. 12.0% нь аж үйлдвэржсэн орнууд уур амьсгалын өөрчлөлтийг бий болгож байна гэж үзсэнээс ердөө 6.8% нь тэд уур амьсгалын өөрчлөлтийг шийдвэрлэх үүрэгтэй гэж үзжээ. Уур амьсгалын өөрчлөлтийн асуудлаарх Засгийн газар хоорондын хороо (IPCC)-ны 6 дахь үнэлгээний тайланд онцлон тэмдэглэсэнээр "Одоогийн байдлаар хүлэмжийн хийг бага ялгаруулах технологийг нэвтрүүлэх чадвар болон инновацад чиглэсэн санхүүгийн эх үүсвэр, хэрэгжүүлэх чадвар нь хөгжсөн орнуудад төвлөрч байна". Үүнээс гадна, аж үйлдвэржсэн орнууд хүлэмжийн хийг ихээр ялгаруулдаг бөгөөд Хятад, АНУ, Энэтхэг нь дэлхийн хүлэмжийн хийн ялгаруулалтын 50% орчим хувийг эзэлдэг.⁴⁰

Хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах, мэдлэг, технологийг нэвтрүүлэхэд аж үйлдвэржсэн орнуудын үүрэг хариуцлага нэмэгдэж байгаа хэдий ч Монгол Улсад энэ талаар төдийлөн ойлголтгүй байна.

Хүлэмжийн хийн ялгаруулалтад аж үйлдвэржсэн орнуудын оруулж буй нөлөөллийг мэдэж байгаа хувь олон нийтийн дунд бага байгаа бөгөөд үүнийг мэдлэг нэмэгдүүлэх компани ажиллаар дамжуулж, сайжруулах шаардлагатай нь харагдаж байна.

Судалгаанд оролцогчдын үзэж буйгаар уур амьсгалын өөрчлөлтийг бий болгож буй гол хоёр тал нь бизнес эрхлэгчид ба иргэд (38.3%, 35.9%) байна. Хэдийгээр судалгаанд оролцогчдын дийлэнх нь үйлдвэрүүд, бизнесийнхнийг уур амьсгалын өөрчлөлтөд хамгийн их нэмэрлэгч гэж тодорхойлсон ч эдгээр талуудыг уур амьсгалын өөрчлөлтийн асуудлыг шийдэх үүрэгтэй гэж хариулсан хувь маш бага (9.8%) байсан. Үйлдвэрүүд болон бизнесийнхэн хариуцлага хүлээх ёстой гэж хариулсан 275 оролцогчдын 65.1% нь энэхүү талуудыг уур амьсгалын өөрчлөлтийг даван туулах хангалттай ажил хийж чадахгүй байна гэж үзжээ. ФБЯ болон талбарын ажлын үеэр оролцогчид бизнесийнхнийг уур амьсгалын өөрчлөлттэй тэмцэх үүрэг хүлээх гол тал гэж үзэхээс илүүтэйгээр түүний оронд нь Засгийн

40 IPCC, "Уур амьсгалын өөрчлөлтийг сааруулах" Бодлого боловсруулагчдад зориулсан хураангуй, 2022 https://www.ipcc.ch/report/ar6/wg3/downloads/report/IPCC_AR6_WGIII_SPM.pdf

газрын чиг үүрэгт төвлөрч ярьж байв. Учир нь Монгол Улсын томоохон олборлолт, эрчим хүч, хүнд үйлдвэрүүд нь төрийн өмчит байдаг учраас хүмүүс тэдгээрийг бизнес, үйлдвэрлэл гэхээсээ илүү төр гэж харах хандлагатай байж болзошгүй. Бизнесүүд болон аж үйлдвэрүүдийн үүргийн талаар тодруулан асуухад, оролцогчид гол төлөв бизнесүүдийн тухай төдийлөн мэдэхгүй гэж хариулж байсан бол зөвхөн цөөн хувь нь л уул уурхайн компаниудыг байгаль орчны сөрөг нөлөөлөл бий болгодог тухай дурдаж байв.

Судалгаанд оролцогчдын нэрлэсэнээр уур амьсгалын өөрчлөлтийн асуудлыг шийдвэрлэхэд чухал үүрэг бүхий тал нь "Иргэд"(29.8%) өөрсдөө гэж үзэж байна. Хотын судалгаанд оролцогчдын 33.1% нь иргэд өөрсдөө уур амьсгалын өөрчлөлтийг шийдвэрлэх ёстой гэж үзсэн бол хөдөөгийн судалгаанд оролцогчдын хувьд 23.9% нь ижил хариулт өгчээ. Мөн үүнээс гадна, судалгаанд оролцогчдын боловсролын түвшнээс хамаарсан мэдэгдэхүйц ялгаа ажиглагдаж байгаа бөгөөд боловсролын түвшин өндөр байх тусам "иргэд өөрсдөө арга хэмжээ авах шаардлагатай" гэж хариулах хандлагатай байгаа бөгөөд энэ боловсролын түвшин бага иргэдтэй харьцуулахад өндөр байна.

Доорх хүснэгтэд иргэд уур амьсгалын өөрчлөлтөд хэрхэн нөлөөлж байгаа болон эдгээр нөлөөллийг бууруулахын тулд ямар арга хэмжээ авах ёстойг ФБЯ-ын үеэр илрүүлсэн үр дүнг тайлбарлаж харууллаа. Иргэдийн хувьд илүү тохиромжтой бодлогыг шаардаж, санал өгөх, Засгийн газраас хариуцлага нэхэх зэрэг иргэдийн хүлээх үүрэг хариуцлагатай холбоотой зүйлсийг тэдний үүрэг хэмээн дурдахгүй байгаа нь харагдаж байна. Сегментийн дүн шинжилгээ бүлэгт дурдсанаар зөв мэдлэг, эерэг хандлагатай байх нь зөв дадалд бий болоход шууд нөлөөлөхгүй байгааг зайлшгүй цохон дурдах нь зүйтэй. Ямар нэгэн арга хэмжээ авах нь иргэдийн үүрэг гэж хариулсан судалгаанд оролцогчдын хувьд, 54.2% нь иргэд уур амьсгалын өөрчлөлттэй холбоотой хангалттай ажил хийж чадахгүй байна (Зураг 38) гэж хариулжээ. Хэдийгээр орон нутгийн түвшинд уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицоход чиглэсэн ажлуудад иргэдийг оролцуулах нь үр дүнтэй байж болох ч иргэдэд илүү их үүрэг хариуцлага оноох нь уур амьсгалын өөрчлөлттэй тэмцэхэд үр дүн багатай арга байж болзошгүй байна.

Хүснэгт 12 Иргэдээс үүдэлтэй уур амьсгалын өөрчлөлтийн шалтгаанууд (ФБЯ-ын үр дүн)

Хувь хүмүүс уур амьсгалын өөрчлөлтийг хэрхэн өдөөж байна вэ?	Хувь хүмүүс хэрхэн хариу арга хэмжээ авах вэ?
<ul style="list-style-type: none"> Уул уурхайн үйл ажиллагаа эрхлэх, малын тоо, толгойгоо өсгөх, хот суурин газар луу нүүх зэрэг нь хүмүүсийн амьжиргааны сонголт юм. Үерийн эрсдэлтэй бүс нутагт амьдрах, гамшиг тохиолдоход Засгийн газар болон бусдыг өөрсдийн сонголтод буруутгах Хувь хүмүүс хүрээлэн буй орчныг бохирдуулж байна- хуванцар ашиглах, хог хаягдал бий болгох, мал хариулахдаа мотоцикл ашиглах зэрэг нь агаарыг бохирдуулдаг ба нүүрс түлж гэр хорооллын хөрсийг бохирдуулдаг. Байгалийн нөөцийг хэтрүүлэн ашиглах, зүй бусаар ашиглах- Усны эх үүсвэрийг барилга барихдаа сүйтгэж, орон сууцанд хэт их ус хэрэглэж, ой модыг огтолж, хэт их эрчим хүч (түлш, цахилгаан) хэрэглэж байна. 	<ul style="list-style-type: none"> Хувь хүмүүсийн авч чадах арга хэмжээ нь зүүн талын багана дахь муу зуршлыг өөрчлөхтэй холбоотой. Илүү олон мод, цэцэг тарих Ойр орчмоо цэвэрлэх компанит ажилд оролцох, зохион байгуулах Нарны эрчим хүчийг ашигладаг болох Нүүрс шатаахаас зайлсхийх Байшингийн дулаалгыг сайжруулах Хувь хүмүүс байгалийн гамшгийн бэлэн байдлын талаарх мэдээлэл хайж, бэлтгэлтэй байх ёстой.

Судалгаанд оролцогчдын тэн хагасаас илүү нь Засгийн газар (мөн асуултад хариулсан хүмүүсийн дөрөвний нэг нь орон нутгийн засаг захиргаа) арга хэмжээ авах үүрэгтэй гэж үзэж байна. Судалгаанд оролцогчдын байршлаас хамааран ихээхэн ялгаа ажиглагдаж байна. Хотын судалгаанд оролцогчдын 57.7% нь хөдөөгийн оролцогчдын 48.8% нь иргэдээс илүүтэйгээр Засгийн газар хариуцлага хүлээх ёстой гэж үзжээ. Харин Орон нутгийн засаг захиргааны үүрэг хариуцлагыг хөдөөгийн оролцогчдын 31.9% нь онцолсон бол хотын оролцогчдын 21.0% нь ижил үзэл бодолтой байна. Орон нутгийн засаг захиргааны тухайд, насны бүлгээс хамааран хандлагын хувьд мэдэгдэхүйц ялгаа ажиглагдаж байгаа бөгөөд судалгаанд оролцогчдын нас ахих тусам асуултад орон нутгийн засаг захиргааны хариуцлагыг онцлох хандлагатай байгаа бөгөөд энэ үзүүлэлт нь залуу (34-өөс дээш насныхны 28% болон 18-24 насны залуусын 17.1% нь) судалгаанд оролцогчдын хувьд харьцангуй бага байна.

Нөгөө талаар, тайлангийн 7.3-р бүлэгт харуулснаар иргэд уур амьсгалын өөрчлөлтийн сөрөг нөлөөллийг бууруулахад чиглэсэн зохистой, үр дүнтэй хууль, бодлогын ач холбогдлыг чухалчлан авч үзэж байна. Нөгөөтэйгүүр, Зураг 40-өөс харахад, Засгийн


газар болон орон нутгийн засаг захиргаа нь (61.7%,48.8%түстүс)уурамьсгалынөөрчлөлтийг шийдэхэд хангалттай ажиллаж чадахгүй байна гэж дийлэнх нь үзэж байна. Эмэгтэйчүүдээс илүү эрэгтэйчүүд нь засгийн газар болон орон нутгийн засаг захиргааны зүгээс уур амьсгалын өөрчлөлтийн асуудлыг шийдвэрлэх чиглэлд авч хэрэгжүүлж буй одоогийн үйл ажиллагаанд сэтгэл дундуур байлаа.

Дорнод аймагт хийсэн фокус бүлгийн хэлэлцүүлгийн үеэр Дорнод аймгийн нэг малчин газрын доройтлыг бууруулахад түвшинд бүрд хүлээх үүрэг хариуцлагыг дараах байдлаар тайлбарлав:

“Дээр үед ‘сангийн аж ахуй’ гэж байсан. Малчид улсын стандарт, удирдамжийг дагаж мөрдөх ёстой байв. Тэр үед хүн бүр бэлчээрийг ээлж дараалан сэлгэхэд хялбар байхын тулд дүрэм журмыг дагах хэрэгтэй болдог байв. Одоо тийм зүйл байхгүй учраас гол төлөв хувь хүмүүс, олон нийтээс л өөрсдөөс нь хамаарч байна. Зүүн аймгуудад өвөлжөө барих нөөц бололцоо дутмаг, түүнтэй холбоотой зардал гарах зэрэг хүндрэлээс болж малчид хангалттай бэлчээрээ сэлгэж чадахгүй байна”. (Малчин, Дорнод аймаг, эрэгтэй)

41 МУЗГ (n=1529), Бизнес, аж үйлдвэр (n=275), Орон нутгийн засаг захиргаа (n=697), Иргэд (n=836), Байгаль орчны ТББ-ууд (n=356), хөгжсөн болон аж үйлдвэржсэн орнууд (n=275)

Зураг 40 Уур амьсгалын өөрчлөлттэй тэмцэхэд байгууллагууд хэр хангалттай ажиллаж байгааг судалгаанд оролцогчид үнэлсэн байдал.⁴²



Бусад насны бүлгүүдтэй харьцуулахад залуучуудын хувьд байгаль орчны ТББ болон ‘бүх талууд’ хариуцлага хүлээх ёстой гэж үзэж байна. Зураг 38-аас харахад, уур амьсгалын өөрчлөлтийг даван туулахын тулд байгаль орчны ТББ-ууд хариуцлага хүлээх ёстой гэж хариулсан 356 хүний (12.7% нь) 35.7% нь эдгээр ТББ-ууд хангалттай ажил хийдэггүй, 32.5% нь дундаж түвшинд ажил хийж байгаа гэж хариулсан бол 23.2% нь хангалттай ажиллаж байна гэжээ. Нийт 8.0% нь мэдэхгүй гэжээ.

8.3 Уур амьсгалын өөрчлөлтийг бууруулахад чиглэсэн Засгийн газраас хэрэгжүүлж байгаа арга хэмжээний талаарх судалгаанд оролцогчдын үзэл бодол

Өмнөх хэсэгт, судалгаанд оролцогчдын ихэнх нь Монголд уур амьсгалын өөрчлөлтийн

42 МУЗГ (n=1529), Бизнес, аж үйлдвэр (n=275), Орон нутгийн засаг захиргаа (n=697), Иргэд (n=836), Байгаль орчны ТББ-ууд (n=356), хөгжсөн болон аж үйлдвэржсэн орнууд (n=275)

нөлөөг бууруулахын тулд шинэ өөрчлөлтийг нэвтрүүлж хэрэгжүүлэх нь Засгийн газрын үүрэг гэж хариулжээ. Санаа зовоосон асуудалд эрүүл мэнд, агаарын бохирдол, эдийн засгийн асуудлыг нэрлэж, цаг агаар, байгалийн нөөцөд гарч буй өөрчлөлтүүд нь эрүүл мэнд, хөдөө аж ахуй, эдийн засагт сөргөөр нөлөөлнө гэж үзсэн байна.

Тиймээс бид уур амьсгалын өөрчлөлтийн асуудлыг шийдвэрлэхийн тулд хүмүүс юу хийвэл зохих, Засгийн газраас ямар арга хэмжээ авах ёстой гэж үзэж байгаа талаар тодруулсан. Нээлттэй асуулт болохоор оролцогчид олон үйл ажиллагааг дурдаж болох бөгөөд ярилцагч нь асуулгад орсон холбогдох хувилбарыг сонгох юм уу бусад гэсэн сонголт дээр нэмж бичих байдлаар мэдээлэл авсан.

Судалгаанд оролцогчдын хувьд, нэн тэргүүнд анхаарах асуудал нь эрүүл мэнд байсан ч уур амьсгалын өөрчлөлтийн асуудлыг шийдвэрлэхийн тулд хийх боломжит шийдэл, үйл ажиллагаанд нийгмийн эрүүл мэнд, эрүүл мэндийн тогтолцоог сайжруулахтай холбоотой асуудлыг тусгаагүй нь анхаарал татаж байна.

Зураг 41 Уур амьсгалын өөрчлөлт болон байгаль орчны асуудлыг шийдвэрлэхийн тулд хэрэгжүүлэх арга**Уур амьсгалын өөрчлөлт эсвэл байгаль орчны асуудлыг шийдвэрлэхийн тулд засгийн газар юу хийх хэрэгтэй вэ?**

Тэмдэглэл: Олон сонголттой тул нийт хувь нь 100.0% болохгүй. Оролцогчдын өгсөн харцуултуудыг бүлэглэсэн болно.

“Эрчим хүчний үр ашиг ба сэргээгдэх эрчим хүч”-тэй холбогдох үйл ажиллагаанд сэргээгдэх эрчим хүчийг (салхи, нар, ус) ашиглаж эхлэх, сэргээгдэх эрчим хүч рүү шилжих, усан цахилгаан станц барьж ашиглалтад оруулах, нүүрсний хэрэглээг зогсоох, халаалтын өөр эх үүсвэр олох, эрчим хүчний хэрэглээг бүх түвшинд бууруулах, эрчим хүчний салбарын үр ашгийг дээшлүүлэх, эрчим хүчний салбарт шинэчлэл хийх зэрэг хариулт багтаж байна. Агаарын бохирдлын асуудалтай өдөр тутам тулгардаг хотынхонд эрчим хүчний хэмнэлт, сэргээгдэх эрчим хүч чухал асуудал болж байна.

“Мал аж ахуй, газар тариалангийн менежментийг сайжруулах” гэдэгт бэлчээрийн чанар, менежментийг сайжруулах, малын тоо толгойг бууруулах, хөдөө аж ахуйн бүтээгдэхүүнийг

экспортлох гарц шийдэл олох, мал аж ахуй болон газар тариалангийн эдийн засгийн үнэ цэнг нэмэгдүүлэх зэрэг хариулт багтана.

“Хог хаягдлын менежмент”-ийн хүрээнд, хог хаягдлын асуудлыг шийдвэрлэх арга зам олох, хог хаягдлыг бууруулах, байгууллага, хувь хүн хүрээлэн буй орчноо цэвэрлэх, олон нийтийн цэвэрлэгээнд оролцох, хогийн савыг хүртээмжтэй, олноор байрлуулах, үйлдвэрийн хог хаягдал, аюулгүй байдлын зохицуулалтыг сайжруулах, хог хаягдлыг ангилан ялгах, дахин боловсруулах, дахин боловсруулах үйлдвэр байгуулах, улсын хэмжээнд хог хаягдлын менежментийг сайжруулах зэрэг хариулт орно.

“Байгаль хамгаалах үйл ажиллагаа”-нд хүрээлэн буй орчныг хамгаалах, нөхөн сэргээх, хор хөнөөл

үчруулж буй үйл ажиллагааг таслан зогсоох, мод тарих, тусгай хамгаалалттай газар нутгийг бэхжүүлэх чиглэлээр БОАЖЯ-ны үйл ажиллагааг эрчимжүүлэх, ус, ой гэсэн байгалийн нөөцийг хамгаалах, хотын ногоон байгууламжийг нэмэгдүүлэх, хамгаалах, талхлагдсан газар, ой модыг нөхөн сэргээх, шинэчлэх, тал хээрийн ургамлын олон янз байдал, бэлчээрийн чанарыг сэргээх төлөвлөгөө боловсруулах зэрэг багтана.

“Уур амьсгалд тэсвэртэй дэд бүтэц” үерт тэсвэртэй зам тавих, үерийн хамгаалалт байгуулах, бүх айл өрхийг цэвэр ус, жорлонтой болгох, усалгааг сайжруулах зэрэг үйл ажиллагаа багтана.

“Хууль тогтоомжийг боловсронгуй болгох, хэрэгжилт, зохицуулалтыг сайжруулах” үйл ажиллагаанд зохистой, шинэ бодлого боловсруулах, хууль тогтоох, зохицуулах (ихэвчлэн хориг гэсэн нэр томъёог хэрэглэдэг), байгаль орчныг бохирдуулж, доройтуулж буй хүмүүст хүлээлгэх хариуцлагыг нэмэгдүүлэх, хууль тогтоомжийг бодитоор хэрэгжүүлэх, хэрэгжилтийг сайжруулах, үр дүнтэй хэм хэмжээ, стандартын тоог нэмэгдүүлэх, холбогдох албан хаагч болон байгууллагын чадвар, уялдаа холбоог хангах, салбарын стандартыг боловсруулан мөрдүүлэх, судалгаа шинжилгээ, баримтад тулгуурласан шийдвэр гаргах зэрэг хариулт багтана.

“Гамшгийн менежмент, бэлэн байдлыг хангах” үйл ажиллагаанд төсвийг гамшгийн сөрөг нөлөөнөөс урьдчилан сэргийлэхэд зарцуулах, өмнөх нийгэмд байсан шиг иргэний хамгааллыг сайжруулах (коммунист дэглэмийн үед иргэний хамгаалалт үр дүнтэй байсан гэж судалгаанд оролцогчид дурдсан), иргэдийн дунд гамшигт хэрхэн бэлтгэлтэй байх талаарх сургалт, сурталчилгаа зохион байгуулах, шаардлагатай үед үүл буудаж, бороо оруулах зэргээр гангачгаас урьдчилан сэргийлэх, малчид өвөлжилтийн бэлтгэлээ сайн хангах, гэр хорооллын иргэдийг гамшгийн бүс нутгаас нүүлгэх зэрэг хариулт орно.

“Тээвэрлэлт”-ийн хүрээнд бүлэглэсэн хариултад хувийн унааг багасгах, нийтийн тээвэрт илүү хөрөнгө оруулалт хийх, цахилгаанаар ажиллах нийтийн тээврийн тоог нэмэгдүүлэх зэрэг багтсан.

“Барилга” гэсэн бүлэглэсэн хариултад эрчим хүчний нэгдсэн стандартыг барилгын салбартай уялдуулах, шинээр баригдаж буй барилгыг эрчим хүчний хэмнэлт, дулааны алдагдал багатай болгож сайжруулах, үр ашигтай барилга барьж буй барилгын компаниудад урамшуулах, байгаль орчинд ээлтэй барилгын материалын хэрэглээг нэмэгдүүлэх зэрэг багтсан.

“Орон нутгийн үйлдвэрлэгчдийг дэмжих” гэсэн агуулгад орон нутгийн үйлдвэрлэгчдийн мал аж ахуй болон төмс, улаан бүүдай зэрэг газар тариалангийн бүтээгдэхүүнийг сурталчлах, тэдний зах зээлийн хүртээмжийг нэмэгдүүлэх, амьжиргааг сайжруулахтай холбоотой хариулт багтана.

“Олон нийтийн ойлголт, мэдлэгийг дээшлүүлэх” гэдэг хариултад уур амьсгалын өөрчлөлтийг шийдвэрлэх, агаарын бохирдлыг бууруулах чиглэлээр засгийн газраас хэрэгжүүлж буй арга хэмжээний талаарх мэдээллээр хангах, цөлжилтийн өнөөгийн байдлын талаар тоо баримт, нотлох баримтаар хангах, холбогдох мэдээллийн хялбар байдал, хүртээмжийг нэмэгдүүлэх, уур амьсгалын өөрчлөлтийн талаарх ойлголтыг хүүхдэд багаас нь танилцуулах, сургалт зохион байгуулах, энэ чиглэлээр хэвлэл мэдээллийнхэнтэй хамтран ажиллах.

Засгийн газраас авах ёстой арга хэмжээний талаарх хариулт хөдөө орон нутаг болон хотын оршин суугчдын хооронд нэлээд ялгаатай байсан. Хотын иргэд ихэнхдээ эрчим хүч, дэд бүтэц, барилга, зам тээвэр, хог хаягдлын менежментийн талаар дурдсан бол, орон нутгийнхан мал аж ахуй, газар тариалангийн менежмент, байгаль орчныг хамгаалах, ашиглалтын тусгай зөвшөөрлийг багасгах зэрэг асуудлыг түлхүү илэрхийлж байв. Уур амьсгалын өөрчлөлтөд Засгийн газар ямар арга хэмжээ авах ёстойг мэдэхгүй байгаа иргэдийн ихэнх нь хөдөө орон нутгийн оршин суугчид байна.

Судалгаанд оролцогчдын нийгэм, эдийн засгийн бусад байдлыг харахад дараах ялгаатай зураглал харагдаж байна. Үүнд,

- Хүйс хоорондын ялгаа ажиглагдаагүй.
- Эмзэг байдлын ялгаа ажиглагдаж байсан бөгөөд эмзэг байдал нь бага бүлгийнхэн сэргээгдэх эрчим хүч, тээвэрлэлтийн

талаар илүү дурдаж байсан бол, хөдөө орон нутгийн эмзэг бүлгийнхэн мал аж ахуй, газар тариалангийн менежмент, байгаль орчныг хамгаалах асуудлыг илүү онцолсон байна.

- Авч хэрэгжүүлэх арга хэмжээнүүдэд ялгаа ажиглагдаагүй.
- Орлогоороо ялгаатай бүлгүүд цэвэр эрчим хүч, хог хаягдлын менежментийг онцолсон.
- Насны хувьд 18-24 насны залуучууд сэргээгдэх эрчим хүч, хог хаягдлын менежментийн төрөл бүрийн арга хэмжээг бусад бүлгүүдээс илүү чухалчилсан бол, 30-аас дээш насныхан хууль тогтоомж, хэрэгжилтийн үүргийг онцолж, ямар арга хэмжээ чухал болохыг мэдэхгүй байгаагаа илэрхийлжээ.

8.4 Монгол дахь итгэлцэл, хамтын үйлийн тухай ойлголт

Хүмүүс бие биетэйгээ хэрхэн хамтран ажиллаж, нийгэм, бусад байгууллага болон бусдад итгэх итгэх түвшин хэр байгааг судалсан.

Судалгааны дүнгээр суурь итгэлцэл бага гарсан нь өмнөх улс орон даяар хийсэн ижил төстэй судалгааны үр дүнтэй харьцуулахад доогуур үзүүлэлттэй байна. Монголчууд гэр бүл, ойр дотно хүмүүстээ итгэдэг ч, тэднээс бусад өөр өөр газар нутаг, үндэс угсаатай хүмүүст илүү

болгоомжтой хандаж байна. Энэ нь аливаа зан үйлийг өөрчлөх, олон нийттэй харилцах ажлуудыг алсын зайнаас биш, нүүр тулж шийдэх, олноороо хамтран ажиллах байдлаар зохион байгуулах нь чухал болохыг харуулж байна.

Хүмүүсийн дунд институт, ялангуяа төр ба шийдвэр гаргагчдад итгэх итгэл бага байна. Зураг 42, 43-аас харахад, улс төрч, хууль тогтоогчдод итгэх итгэлд 2.85 (0 хэзээ ч итгэдэггүй, 10 бүрэн итгэл) оноо өгсөн бол, засгийн газрын шийдвэр гаргагчдаас харьцангуй өндөр 4.65 оноо өгсөн байна. Хэдийгээр Монголчууд засгийн газрыг эрчим хүч, хөдөө аж ахуйн хог хаягдлын менежмент, дэд бүтэц, байгаль орчин зэрэг гол салбарт арга хэмжээ

авах шаардлагатай гэж үзэж байгаа ч, тэдэнд итгэх итгэл бага байгаа нь уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох арга хэмжээнд саад болж болзошгүй.

Хүмүүсийн дунд институт, ялангуяа төр ба шийдвэр гаргагчдад итгэх итгэл бага байна. Зураг 42, 43-аас харахад, улс төрч, хууль тогтоогчдод итгэх итгэлд 2.85 (0 хэзээ ч итгэдэггүй, 10 бүрэн итгэл) оноо өгсөн бол, засгийн газрын шийдвэр гаргагчдаас харьцангуй өндөр 4.65 оноо өгсөн байна. Хэдийгээр Монголчууд засгийн газрыг эрчим хүч, хөдөө аж ахуйн хог хаягдлын менежмент, дэд бүтэц, байгаль орчин зэрэг гол салбарт арга хэмжээ авах шаардлагатай гэж үзэж байгаа ч, тэдэнд итгэх итгэл бага байгаа нь уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох арга хэмжээнд саад болж болзошгүй.


Харин Цаг уур, орчны шинжилгээний газар, Онцгой байдлын ерөнхий газарт итгэх итгэл нь бусад байгууллагатай харьцуулахад өндөр байгааг анхаарах хэрэгтэй. Энэ нь хэвлэл мэдээллийн хэрэгслээр дамжуулан нийтийг хамарсан ажил зохион байгуулахад итгэл хүлээсэн шинжлэх ухааны байгууллагуудыг мэдээллийн эх сурвалж болгон ашиглах

боломжийг бүрдүүлж байна. Хэвлэл мэдээллийн хэрэгсэл, ТББ, олон улсын байгууллага, орон нутгийн засаг захиргаа, судалгааны байгууллагуудад итгэх итгэл нь дундаж байна..


Гамшгийн үе дэх туслах бүлгүүд

Газар хөдлөлт, ой хээрийн түймэр, үер, ган, зуд гэх мэт байгалийн гамшиг тохиолдсон үед та дараах бүлгүүдээс дэмжлэг авах, мөн хариу дэмжлэг үзүүлэхэд хэр зэрэг бэлэн байна вэ гэсэн асуулыг судалгаанд оролцогчдод тавьсан. Зураг 45-д харуулснаар, янз бүрийн бүлгүүдийг дэмжихэд бэлэн гэдэгт итгэлтэй хүмүүсийн тоо харьцангуй өндөр байна. Судалгаанд хамрагдсан бараг бүх хүн төрөл төрөгсөд, дотно найз нөхөд, онцгой байдлын мэргэжилтнүүд болон байгалийн гамшгийн үед анхны тусламж үзүүлэгчдэд туслахад бэлэн байгаагаа илэрхийлсэн нь тэргүүн эгнээний байгууллага, яаралтай тусламж үзүүлэгчдэд итгэх итгэл өндөр байгааг харуулж байна. Сонирхолтой нь, гамшгийн үед тусламжийн байгууллага, ТББ-уудаас тусламж авахаасаа (56.1%, 53.6%) илүүтэйгээр, эдгээр байгууллагад тусална гэж хариулсан хувь (73.6%, 70.1%) өндөр байна.


Зураг 42 Судалгаанд оролцогчдын бусдад итгэх байдал, % (n=2804)




Зураг 43 Судалгаанд оролцогчдын янз бүрийн бүлгийн хүмүүст итгэх байдал 0 (огт итгэдэггүй), 10 (бүрэн итгэдэг)



Зураг 44 Судалгаанд оролцогчдын байгууллагуудад итгэх итгэл, дундаж оноогоор (0-10 оноогоор), n=2804



Зураг 45 Байгалийн гамшигын үед бүлгүүдэд дэмжлэг үзүүлэх байдал (n=2804)



Онцгой байдлын ерөнхий газрын төлөөлөл болох ярилцагчийн тайлбарласнаар:

“Яаралтай үед иргэдийг тусламж үзүүлэх ажилд дайчлахад тэд улам идэвхтэй оролцож байна. Жишээ нь: хээрийн түймэр гарах үед жолооч нарын клубүүд [приус жолооч нарын клуб; Тоёота 200 жолооч; клуб гэх мэт] унаагаар тусалж, гишүүдээ оролцуулж байгаа. Бусад иргэд нь оролцогчдод хоол, цай авчирдаг. Гэхдээ, эдгээр сайн дурын оролцогчид зохих ёсоор бэлтгэгдээгүй, мэдлэггүй болохоор энэ талд илүү менежмент, зохицуулалт шаардлагатай байдаг. Фейсбүүк, бусад олон нийтийн мэдээллийн хэрэгслээр анхны тусламж үзүүлэгчид ажиллаж байгаа баримт зургийг хараад олон хүн тэдэнд туслахыг хүсдэг.” (ОБЕГ-ын төлөөлөгчид, эрэгтэй)

Холбоо байгууллага дахь гишүүнчлэл

Хүмүүс хоорондын хамтын ажиллагааны чухал үзүүлэлтийн нэг нь тэдний янз бүрийн сайн дурын, улс төрийн болон/эсвэл мэргэжлийн байгууллага, холбоодын гишүүнчлэлтэй эсэх

юм. Үүнд, хувь хүмүүст нийгэмтэйгээ өргөн цар хүрээнд холбогдож, өөрчлөлт хийхэд нь дэмжиж, тулгарч буй асуудлуудаа шийдвэрлэх боломж олгодог янз бүрийн байгууллага, бүлэг багтана.

Тиймээс судалгаанд оролцогчдоос янз бүрийн байгууллага, бүлгийн гишүүн мөн эсэхийг асуулгаар тодруулсан. Зураг 46-д гарсан үр дүнгээс харахад, хамгийн нийтлэг дурдагдсан байгууллага нь улс төрийн намууд (9.0% нь улс төрийн намуудад идэвхтэй гишүүд байсан) байна. Нийт 6.0% нь аймгийн зөвлөлд гишүүнчлэлтэй, 3.2% нь байгаль орчны хөдөлгөөн, бусад байгууллагын гишүүн болохоо илэрхийлжээ.

Энэнь нэг талаас, уурамьсгалын талаарх бодлого, эн тэргүүнд анхаарах зүйлс, асуудлуудын чиглэлээр байгаль орчны байгууллага, хөдөлгөөн, орон нутгийн зөвлөл, хамтран ажиллагч, улс төрийн намуудаар дамжуулан мэдлэг, чадварыг дээшлүүлж батжуулах орон зай байгааг харуулж байна. Ингэснээр иргэдэд илүү хүрч, санаа зовниж буй асуудлаа илэрхийлэх боломж олгоно. Нөгөө талаас хүмүүсийн дунд уур

Зураг 46 Судалгаанд оролцогчид ямар нэгэн байгууллагад гишүүнчлэлтэй эсэх (n=2804)



амьсгалын өөрчлөлтийг сааруулах, гамшгийн бэлэн байдлыг сайжруулах, өөрчлөгдөж буй орчин нөхцөлд илүү дасан зохицоход оролцох, хувь нэмрээ оруулах сонирхол, эрэлт хэрэгцээ харагдаж байгаа бөгөөд эдгээрийг тогтвортой, үр дүнтэй стратеги бүхий үйл ажиллагаануудаар дамжуулан хангаж болно.




9. УУР АМЬСГАЛЫН ӨӨРЧЛӨЛТИЙГ ТҮГЭЭН ДЭЛГЭРҮҮЛЭХ БЭЛЭН БАЙДАЛ БОЛОН ЧАДВАРЫН ХЭРЭГЦЭЭНИЙ ТАЛААРХ ОРОЛЦОГЧ ТАЛУУДЫН ҮЗЭЛ БОДОЛ

9.1 Уур амьсгалын өөрчлөлтийг түгээн дэлгэрүүлэх бэлэн байдлын талаарх оролцогч талуудын үнэлгээ

Чанарын өгөгдөл цуглуулах аргыг гол оролцогч талуудын уур амьсгалын өөрчлөлтөд бэлэн байдал, чадварыг үнэлэхэд ашигласан. Оролцогчдыг уур амьсгалын өөрчлөлтийн асуудалтай холбоотой албан тушаал, түршлагад нь тулгуурлан сонгосон бөгөөд төрийн албан хаагч, салбарын мэргэжилтэн, эрдэмтэн, хувийн хэвшил болон хэвлэл мэдээллийн хэрэгслийн салбарын төлөөллийг хамруулсан.

Зураг 47 Бэлэн байдлын үнэлгээ, дундаж оноо, n=49



Бусад салбарын баримт бичигт хийсэн шинжилгээ, бэлэн байдлын үнэлгээнд түлгүүрлан уур амьсгалын өөрчлөлтийг бүх түвшинд амжилттай нэвтрүүлэхийн тулд дараах хүчин зүйлс чухал ач холбогдолтой. Үүнд, ойлголт, мэдлэг, манлайлал, уур амьсгалын өөрчлөлтийн талаарх арга хэмжээний эрэлт хэрэгцээ, нөөц бололцоо (санхүү, технологи), техникийн чадавх, институтын зохион байгуулалт, үнэт зүйлс болон стандартууд багтаж байна. Эдгээр хүчин зүйл нь төрийн болон төрийн бус байгууллага, институтын аль алинд хамаатай. Хүчин зүйлсийг 1 (огт байхгүй), 2 (шинээр гарч ирж буй), 3 (дунд зэрэг), 4 (хүчтэй) хүртэлх онооны хэлбэлзлээр үнэлүүлээд, тус бүрийн шалтгаан, үр дагаврын талаар дэлгэрэнгүй ярилцсан.

Гол оролцогч талуудын хувьд, Монголд уур амьсгалын өөрчлөлтийг нэвтрүүлэхэд чиглэсэн чадавхын хүчин зүйлс нь аль хэдийн 'бий болж', түүнээс 'дунд' түвшин рүү (1-ээс 4 онооны хэмжүүрээс 2.6 оноо) чиглэн урагшилж байгаа бөгөөд хүчин чармайлтыг эрчимжүүлж, тогтвортой байлгах шаардлагатай байгаа талаар дурдаж байлаа. Гол оролцогч талуудын дурдаж байгаагаар ихэнх хүчин зүйл нь аль хэдийн бий болж, дунд түвшин рүү чиглэн хөгжиж байна. Хамгийн их үнэлгээ авсан хүчин зүйл нь улс орны хэмжээнд, мөн мэргэжилтнүүдийн дунд үүссэн (4 онооноос 3.1 оноо) уур амьсгалыг өөрчлөлтийг бууруулах, дасан зохицох арга хэмжээ авах эрэлт хэрэгцээ байсан. Харин байгууллагын зохион байгуулалт, мэргэжил, техникийн чадавхыг бага (2.1 ба 2.2 оноо) тус тус өгсөн бөгөөд энэ нь дөнгөж бий болж буйг илтгэж байгаа юм) оноогоор үнэлсэн байна.

Мөн ярилцлагад оролцогчид уур амьсгалын өөрчлөлтийн талаарх мэдлэг, хандлага, дадлыг бүх түвшинд сайжруулах шаардлагатайг онцолж, хэрэгжүүлэх ажлууд нь салбар салбарын онцлогоос хамаарч ялгаатай болохыг илэрхийлж байлаа. Тухайлбал, хөдөө аж ахуйн салбарынхан мал аж ахуйг төрөлжүүлэх, үнэ цэнг нэмэгдүүлэхэд анхаарах хэрэгтэйг, эрчим хүчний салбарынхан ногоон эрчим хүчний эх үүсвэрийг нэмэгдүүлэхийг зорих хэрэгтэйг, эрүүл мэндийн салбарынхан судалгаа, шинжилгээг эрчимжүүлэхийг зорьж ажиллах учиртайг тус тус дурдсан юм.

Ойлголт, мэдлэг

Ярилцлагад оролцогчид өөрсдийгөө бүх түвшинд, боломжит ойлголт, мэдээллийг олж авсан гэж үзэж байгаа хэдий ч, үүнийгээ хангалтгүй гэж дүгнэж байна. Ярилцлагын үр дүнгээс харахад, салбарын түвшинд найдвартай мэдлэг, мэдээллийг ихэвчлэн сургалт, семинар гэсэн албан ёсны эх сурвалжаас олж авдаг ч, олон нийтийн мэдээллийн хэрэгслээр дамжиж буй мэдээллийн үнэн зөв, найдвартай эсэхэд эргэлзэж байгаагаар илэрхийлж байв. Уур амьсгалын өөрчлөлтийн асуудлыг хариуцсан оролцогчдоос бусад нь ажилтай холбоотой мэдлэг, чадвараа хэрэгжүүлж, нэвтрүүлэх боломж бага тухай хуваалцжээ. Аймгийн түвшинд ажиллаж байгаа төрийн албан хаагчид уур амьсгалын өөрчлөлтийг нэн тэргүүний тулгамдсан асуудал гэж үзээд, ач холбогдлыг нь бодлого төлөвлөлт, шийдвэр гаргах түвшинд онцлон дурдаж байлаа.

Ойлголт, мэдлэг – Дундаж оноо: 2.4

Ерөнхий үр дүн:

- Мэдээллийн эх үүсвэр: Мэдээллийг сургалт, семинар, зөвлөлдөх уулзалтуудаас голлон авдаг, олон нийтийн мэдээллийн хэрэгслийн холбогдох мэдээллүүд хүртээмжтэй бус, хангалтгүй.
- Хандлага, соёл: Байгаль орчин, ногоон хөгжил гэдэг талаас нь холбож тайлбарлаж, ойлгох хандлага түгээмэл байна. УАӨ-д дасан зохицох, даван туулах гэсэн ойлголт хангалтгүй.
- Ажилдаа ашиглах байдал: УАӨ-тэй холбоотой мэдээллийг боловсруулах, ажилдаа эрэмбэлэн (тэргүүлэх чиг
- Олон нийт, эмзэг бүлгийн дүү хоолойг тусгах байдал: Олон нийт, эмзэг бүлгийнхэн нь өөрсдөө УАӨ-тэй холбоотой мэдлэг, мэдээллээр бага. Тэр утгаараа санал, санаачилга гаргах нь тааруу байдаг.

Салбар, оролцогч талуудаас хамаарсан онцлог:

Нутгийн удирдах байгууллага	Ерөнхий үр дүнтэй ижил.
Байгаль орчны салбар	Бусад байгууллагатай харьцуулахад ойлголт мэдээлэл харьцангуй сайн. Чиг үүргийн хувьд УАӨ-ийн асуудлыг хэрэгжүүлэгч салбар болдог учир мэдээллээ ашиглах, шийдвэр гаргахад ашиглах байдал сайн. "Ногоон хөгжил" гэдэг ойлголт талаас нь түлхүү хардаг.
Эрчим хүчний салбар	УАӨ-ийг хүлэмжийн хийн ялгарал, бууралт, сэргээгдэх эрчим хүч, эрчим хүчний хэмнэлт, ногоон эрчим хүч зэрэг сэдэвтэй холбон тайлбарлаж байсан. Салбарын төсөл, арга хэмжээ, ОУ-ын хамтын ажиллагаанд УАӨ-ийн талаас харсан төлөвлөлт шаардагддаг учраас ашиглалт сайн.
ХАА-н салбар	ХААИС-д суурилсан эрдэмтэн, судлаачдын нөөц сайтай. Энэ талаарх мэдээллийг судалгааны ажлуудаас түлхүү авдаг. УАӨ-д илүү өртөмхий салбар гэдэг утгаар газар тариалан, МАА-тай холбосон судалгааны ажлууд түгээмэл.
Эрүүл мэндийн салбар	УАӨ-өөс үүдэлтэй хүн амын эрүүл мэндийн асуудалд түлхүү анхаардаг. Одоо салбарт хамаарах байгууллага, албан хаагчдынхаа УАӨ-тэй холбоотой мэдлэг, үр чадварыг нэмэгдүүлэхэд голлон анхаарч ажиллаж байгаа.

Манлайлал

Судалгаанд оролцогчид нь засгийн газрын агентлагуудыг уур амьсгалын өөрчлөлтийн асуудлаар үр дүнтэй манлайлах бүрэн чадвартай хэмээн үнэлжээ. Удирдлагын манлайллыг гадагш чиглэсэн үйл ажиллагаанаас илүү дотоод нөөцөө бэхжүүлэх талаас нь дэмжин ажиллаж буй байдал нийтлэг байна. Ажилтнуудаа сургалт семинарт хамрагдахад нь дэмжих, чадваржуулах ажилд санхүүгийн эх үүсвэрийг хуваарилдаг зэрэг жишээг оролцогчид дурдаж байлаа.

Манлайлал – Дундаж оноо: 2.6	
Ерөнхий үр дүн:	
<ul style="list-style-type: none"> Салбарын шийдвэр гаргагчид УАӨ-ийн талаар улс төрийн манлайлал үзүүлдэг эсэх: Төрийн захиргааны төв байгууллагууд (ХАА, Эрчим хүч, Барилга)-ын үзүүлж буй манлайлал төрийн бусад байгууллагатай харьцуулахад сайн. Удирдлага болон мэргэжилтнүүдийн тогтвор суурьшилтай ажиллах байдалд анхаарч, манлайллыг нэмэгдүүлэх боломжтой. Байгууллагын шийдвэр гаргагчид чадвар бэхжүүлэх асуудлыг дэмжих байдал: УАӨ-ийн асуудлаар чадваржуулах үйл ажиллагаа, дээд шатны байгууллагаас зохион байгуулж буй сургалт, семинарт ажилтнуудаа хамруулах байдал бүх салбар, түвшний байгууллагад сайн. УАӨ-ийн асуудлаар талаарх дуу хоолой, нүүр царай болох байгууллага, хувь хүмүүс: Салбар бүрт энэ асуудлаар олон жил ажилласан мэдлэг, туршлагатай, хувь хүмүүсийг нэрлэх нь түгээмэл байв. Орон нутгийн оролцогчид, тухайн нутагт байгаль орчин, ногоон хөгжлийн асуудлаар үйл ажиллагаа эрхэлдэг ТББ-уудыг нэрлэж байна. 	
Салбар, оролцогч талуудаас хамаарсан онцлог үр дүн:	
Нутгийн удирдах байгууллага	Орон нутгийн удирдлагууд УАӨ-ийн асуудлыг бусад тулгамдсан асуудлаас илүү чухалчилж, өндөрт тавьдаггүй. Орон нутгийн хөгжлийн баримт бичгүүд (хөгжлийн үндсэн чиглэл, ЗД-ын мөрийн хөтөлбөр зэрэг)-д бодлогын томоохон баримт бичигт томъёолсны дагуу байгаль орчин, ногоон хөгжил гэсэн агуулгаар тусгадаг.
Байгаль орчны салбар	Манлайлал харьцангуй өндөр. Байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь нэгдсэн бодлого хэрэгжүүлэх, салбар хоорондын уялдааг хангах, чадваржуулах арга хэмжээг цогцоор нь УАӨ гэсэн нэгдсэн ойлголтын хүрээнд зохион байгуулдаг.
Эрчим хүчний салбар	Эрчим хүчний яам, зохицуулах хороо өөрсдийгөө УАӨ-ийн асуудлаар манлайлал сайн үзүүлдэг гэсэн бол, энэ салбарын зөвлөх, хувийн хэвшлүүд төрийн удирдах түвшний байгууллагуудын манлайллыг сул гэж үнэлж байв.
ХАА-н салбар	Ерөнхий үр дүнтэй ижил.
Эрүүл мэндийн салбар	Эрүүл мэндийн яамны хувьд салбарын ажилтнуудаа УАӨ-д тэсвэртэй эрүүл мэндийн үйлчилгээ үзүүлэх чиглэлээр чадваржуулах ажлуудыг сүүлийн үед тогтмол зохион байгуулж байна. Орон нутгийн түвшинд, УАӨ-ийн талаарх мэдлэг тааруу тул манлайлал хангалтгүй. Орон нутгийн эрүүл мэндийн салбар байгууллагуудын УАӨ-тэй холбоотой чадваржуулах ажлууд эхлэх шатандаа байна.

Нөөц (Санхүүжилт, тоног төхөөрөмж, дата гэх мэт)

Уур амьсгалын тэсвэртэй байдлыг бий болгоход чиглэсэн санхүүгийн эх үүсвэр нь нөхцөл байдал болон байгууллагаас хамааран харилцан адилгүй хуваарилагдаж байна. БОАЖЯ болон түүний харьяа агентлагуудаас бусад нь нийт төсвийн 10%-иас доошгүйг уур амьсгалын өөрчлөлтийн асуудалд (жишээлбэл, ногоон хөгжил, байгаль хамгаалал) зарцуулсан байна. Тэгэхдээ төсөл, санхүүгийн дэмжлэг нь зөвхөн уур амьсгалын

өөрчлөлтөд дасан зохицох, тэсвэрлэх чадвар бий болгох чиглэлээр хязгаарлагдаж байна.

Нөөц (Санхүүжилт, тоног төхөөрөмж гэх мэт) – Дундаж оноо: 2.5	
Ерөнхий үр дүн:	
<ul style="list-style-type: none"> Төсвийн эх үүсвэрийн хангалттай байдал: Улсын төсвөөс санхүүждэг. Гэхдээ УАӨ гэсэн тухайлсан төсөв байхгүй, салбар бүр дээр (ус, ой, бэлчээр, газар, сэргээгдэх эрчим хүч, дулааны хэмнэлт гэх мэт салбарын асуудлын томъёоллоор) холбогдох зардлууд төсөвт суудаг. Төсвийн эх үүсвэрийн асуудлыг гадаад, дотоод, улсын ба орон нутгийн төсөв, зэргээр ангилдаг. Байгалийн нөөцийг ашиглаж олсон орлогын тодорхой хувийг эргээд байгаль хамгаалах үйлд зарцуулах эрхтэй учраас аймаг болгон байгаль хамгаалах нөхөн сэргээх арга хэмжээний зардлаа батлуулж, зарцуулдаг. Гэхдээ энэ нь бодит байдалд төдийлөн сайн хэрэгжихгүй, хүртээмжгүй байдаг. Чадвар бэхжүүлэх арга хэмжээнд төсөв хязгаарлагдмал, голдуу гаднын төсөл хөтөлбөрийн хүрээнд тусгагдаж хэрэгждэг. УАӨ-ийн асуудалд хуваарилдаг санхүүгийн хэмжээ: Байгууллагын онцлогоос хамаарсан харилцан адилгүй төсвийг УАӨ-тэй холбоотой тэргүүлэх чиглэлийн асуудал, ҮТХН-ийн хэрэгжилтэд хамааралгүй байдлаар зарцуулдаг. Жилийн төсвийн 10 хүрэхгүй хувийг тухайн асуудлын хүрээнд хуваарилдаг. Жилээр төсөвлөгддөг учир урт хугацааны бодлого, зорилттой уялдсан бодлого, үйл ажиллагааг санхүүжүүлэх төсөв, нөөц, сан дутмаг байдаг. Улсын төсвөөс бусад санхүүгийн эх үүсвэр: Улсын хэмжээнд салбар яамдад олон улсын зээл тусламжаар санхүүжсэн төсөл, хөтөлбөрүүд хэрэгждэг. Мөн, орон нутгийн хөгжлийн сангийн төсвөөр тодорхой ажлуудыг хийх тохиолдол байдаг. Гэхдээ ОНХС-ийн журмаар заавал иргэдийн оролцоогоор шийдэгддэг тул баттай эх үүсвэр болж чаддаггүй байна. УАӨ-тэй холбоотой салбарын судалгаа, тайлан, дүн шинжилгээний хүртээмжтэй байдал: Төдийлөн хүртээмжтэй биш, хангалтгүй. Сүүлийн үед ТББ, БОАЖЯ-ны харьяа УАӨСХАТ зэрэг байгууллага нь УАӨ-д чиглэсэн судалгаа, төсөл хөтөлбөрүүдийг хэрэгжүүлж байна. Салбар бүр, байгууллага бүр хамааралтай судалгааны ажлуудаа нэгтгэх, уялдаа холбоогоо сайжруулах талаар санаачилга багатай ажилладаг. Байгаль орчны салбараас бусад төрийн байгууллага нь энэ асуудалд хавсарга байдлаар ханддаг тул судалгаа, мэдээлэл бүрдүүлэх чиглэлээр хангалттай ажиллаж чадахгүй байна. 	
Салбар, оролцогч талуудаас хамаарсан онцлог үр дүн:	
Нутгийн удирдах байгууллага	Ерөнхий үр дүнтэй ижил.
Байгаль орчны салбар	Ерөнхий үр дүнтэй ижил.
Эрчим хүчний салбар	УАӨ-ийн асуудалд тухайлсан төсөв байдаггүй учир сэргээгдэх эрчим хүч, эрчим хүчний үр ашгийг дээшлүүлэх төсөл хөтөлбөрүүдэд туссан төсвөөр шаардлагатай арга хэмжээг санхүүжүүлдэг.
ХАА-н салбар	Ерөнхий үр дүнтэй ижил.
Эрүүл мэндийн салбар	Улсын төсөвт тусгагдсан зардлаас гадна олон улсын хандивлагч байгууллагуудын санхүүжилтээр зарим шаардлагатай арга хэмжээг зохион байгуулдаг. ДЭМБ болон НҮБ-ын Хүүхдийн сан энэ чиглэлийн арга хэмжээнд зориулж илүү санхүүгийн дэмжлэг үзүүлсэн байна.

Техникийн чадвар болон чадварын хэрэгцээ

Уур амьсгалын өөрчлөлтийн чиглэлд мэргэшсэн, чадварлаг ажилтан, мэргэжилтэн (мөн салбарын болон байгууллагын түвшинд) дутагдаж байгааг

гол оролцогч талууд онцлон дурдсан. Ялангуяа хөдөө орон нутагт уур амьсгалын өөрчлөлтийн талаар сайн ойлголт, мэдлэгтэй мэргэжилтнүүд хангалтгүй байгааг судалгаанд оролцогчдын зүгээс илэрхийлж байв. Тэдний ихэнх нь мөн уур

амьсгалын өөрчлөлттэй холбоотой техник болон мэргэжлийн нэр томъёоны талаар мэдлэг, ойлголт нь хязгаарлагдмал байсан.

Техник чадвар, чадварын хэрэгцээ – Дундаж оноо: 2.2

Ерөнхий үр дүн:

- Хүний нөөцийн үр чадвар, чадварын хэрэгцээ: УАӨ-ийн асуудлаар мэргэшсэн боловсон хүчин аль аль шатанд дутмаг, хэрэгцээ өндөр байна. Мэдээлэл, ойлголтоор хангаж чадваржуулах, тодорхой хэмжээнд чадваржсан хүний нөөцөө ажлын байранд нь тогтвортой хадгалах шаардлагатай. Эхний ээлжид мэдээлэл, ойлголтоор хангах, цаашлаад бодлого, үйл ажиллагааны шатанд мэдлэг, мэдээллээ ашиглаж сурахад чиглэсэн хэрэгцээ байна.
- Хувийн хэвшлүүдийн УАӨ-ийн талаарх мэдлэг: Байгаль орчны чиглэлээр ажилладаг ТББ-ын УАӨ-ийн асуудлаарх мэдлэг, хандлага сайжирсан. Зарим байгууллагын хувьд өөрсдөө энэ чиглэлээр санал, санаачилга гаргаад төрийн байгууллагатай хамтрах сонирхлоо илэрхийлж, түүчээлж ажиллаж байгаа сайн жишээ байна.
- УАӨ-тэй холбоотой мэдээлэл цуглуулах тогтолцооны хүртээмж, хэрэглээ: Ихэнх оролцогч талуудын хувьд УАӨ-тэй холбоотой мэдээлэл цуглуулах тогтолцоо, тэдгээрийн ашиглалтын талаар мэдээлэл багатай байв. Байгаль орчин, эрчим хүчний салбарт ажилладаг оролцогч талууд хүлэмжийн хийн ялгарлыг тооцоолох систем зэргийн талаар тодорхой хэмжээний ойлголттой байгаа ч мэдээлэл нь олон нийтэд нээлттэй бус, ашиглах боломж бага гэдэг үүднээс шүүмжлэлтэй хандаж байна.

Салбар, оролцогч талуудаас хамаарсан онцлог үр дүн:	
Нутгийн удирдах байгууллага	УАӨ-тэй холбоотой хүний нөөц, техникийн боломж, чадвар хамгийн тааруу, холбогдох мэргэжлийн системүүдийн талаарх ойлголт, түүний мэдээллийг ашиглах байдал сул.
Байгаль орчны салбар	Ерөнхий үр дүнтэй ижил.
Эрчим хүчний салбар	Ерөнхий үр дүнтэй ижил.
ХАА-н салбар	Ерөнхий үр дүнтэй ижил.
Эрлийн мэндийн салбар	УАӨ-тэй холбоотой хүний нөөц, техникийн боломж, чадвар хамгийн тааруу, холбогдох мэргэжлийн системүүдийн талаарх ойлголт, түүний мэдээллийг ашиглах байдал сул.

Институтийн бүтэц, зохион байгуулалт

Ярилцлагад оролцогчдын олонх нь бүх түвшинд талуудын үүрэг, хариуцлагыг тодорхой болгохын тулд институтийн зохион байгуулалтыг бий болгож, нэн даруй арга хэмжээ авах шаардлагатай болохыг онцолж байна. Цаашилбал, байгаль орчин, уур амьсгал, цаг уур, орчны шинжилгээний байгууллагууд уур амьсгалын өөрчлөлттэй холбоотой үйл ажиллагааг хянах шаардлагатай гэж үзэж байна. Одоогоор, чиг үүрэг тодорхой бус, хоорондын уялдаагүй байдлаас болж бусад салбарын оролцоо хязгаарлагдмал байна. Мөн мэргэжилтнүүд нь уур амьсгалын өөрчлөлтийн асуудлыг шийдэх чиглэлд нэгдэж ажиллахаасаа илүүтэйгээр тус тусдаа, салангид байдлаар ажиллах нь нийтлэг байна.

Институтийн бүтэц, зохион байгуулалт – Дундаж оноо: 2.1

Ерөнхий үр дүн:

- Төрийн байгууллагуудын чиг үүргийн тодорхой байдал: УАӨ-тэй холбоотойгоор төрийн байгууллагуудын институт, орон нутаг, засаг дарга нь ямар чиг үүрэгтэй байх, юуг тайлагнах, хөгжлийн бодлогын асуудлуудтай юуг нь холбох, уур амьсгалын өөрчлөлтийн үндсэн бодлого нь юу байх зэрэг чиг үүрэг нь тодорхой бус.
- Өмнө нь БОАЖЯ үндсэн чиг үүргийн яам байсан бол, одоо зүгээр л чиг үүргийн яам болчихсон. Үндсэн чиг үүргийн яам нь салбар дундын чиг үүргийг зохицуулах үүрэгтэй байдаг. Бүх салбар УАӨ-тэй холбоотой учраас БОАЖЯ үндсэн чиг үүргийн байх нь зохистой.
- Салбар дундын төлөвлөлт, төсөв зэрэг нь уялдаа холбоогүй, УАӨ-ийн төв цэг гэж байдаг. Гэвч тэдний эрх мэдлийн хүрээ бага, эрх зүйн зохицуулалт байхгүйтэй холбогдсон асуудал үүсдэг.
- Орон нутгийн түвшинд удирдлага, зохион байгуулалтаар хангах байдал дутмаг, УАӨ-тэй холбоотой асуудалд оролцоо тааруу, хамтын ажиллагаа бага байдаг.
- Нэг том байгууллага энэ асуудлыг нэгтгэж, гадагшаа нэг цонхоор харьцдаг байх хэрэгтэй.
- Төр болон төрийн бус байгууллагуудын хамтын ажиллагаа: Төр, төрийн бус, хувийн хэвшлийн хамтын ажиллагаа тодорхой хэмжээнд явагддаг. ОУ-ын байгууллагуудтай төсөл, хөтөлбөрүүдийн хүрээнд хамтран ажилладаг.
- Хамтын ажиллагаа зөвхөн арга хэмжээн дээр суурилснаас, үр дүн нь байгууллагын төвшинд үлдэх, цаашид хөгжих боломж бүрддэггүй байна.
- Байгууллагад УАӨ-ийн асуудлыг тусгайлан хариуцдаг албан тушаалтан байгаа эсэх: Уг асуудлыг хариуцсан мэргэжилтний хувьд үндсэн ажлын чиг үүрэгт нь байхгүй, нэмэлт ажил байдлаар хавсран хэрэгжүүлдэг. Босоо бүтэц, тогтолцоогүй учраас мэргэжилтнүүдэд хийхийг шаардах эрх зүйн зохицуулалт байхгүй. Төрийн байгууллагын ажилтны цалин бага, ажлын ачаалал их учраас чадварын хувьд харилцан адилгүй.

Салбар, оролцогч талуудаас хамаарсан онцлог үр дүн:

Нутгийн удирдах байгууллага	Орон нутгийн хувьд, засаг даргын мөрийн хөтөлбөрт уур амьсгалын өөрчлөлттэй холбоотой ажлууд тусгагдсан эсэхээс хамаарч хэрэгжих үгүй нь шийдэгдэнэ.
Байгаль орчны салбар	Төр, төрийн бус, хувийн хэвшлийн хамтын ажиллагаа төдийлөн хангалттай биш. Бүх санхүүжилт болон ажлыг улс шийдэж чадахгүй учраас хувийн байгууллагатай хамтрах хэрэгтэй. Тухайлбал, бэлчээр ашиглалтын холбоо-бэлчээр ашиглалтын тооцоо хийх гэх мэт. Хувийн, мэргэжлийн байгууллагад зарим ажлыг хариуцуулж, төр ачааллаа багасгах хэрэгтэй.
Эрчим хүчний салбар	Төр, ТББ-ын хамтын ажиллагаа зөвхөн арга хэмжээн дээр л суурилж байна. Салбарын зөвлөх, экспертүүдийн саналыг сонсдог хэдий ч, ажил хэрэг болгох нь цөөн.
ХАА-н салбар	Ерөнхий үр дүнтэй ижил.
Эрлийн мэндийн салбар	УАӨ-тэй холбоотой хүний нөөц, техникийн боломж, чадвар хамгийн тааруу, холбогдох мэргэжлийн системүүдийн талаарх ойлголт, түүний мэдээллийг ашиглах байдал сул.

Үнэт зүйл ба стандарт

Судалгаанд оролцогчид уур амьсгалын өөрчлөлттэй холбоотой хууль эрх зүй, бодлогын баримт бичиг, стандартыг дурдаагүй. Гэхдээ, салбар бүрийн уур амьсгалын өөрчлөлтийн асуудалтай холбон ойлгож болох тусдаа баримт бичиг хэрэгтэй байгаа талаарх саналаа илэрхийлж байлаа. Ерөнхийдөө Монгол улсад хууль, стандарт сайн тогтсон боловч уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох, бууруулах арга хэмжээнүүдтэй хамаарах уялдаа холбоо нь хязгаарлагдмал байна.

<p>Үнэт зүйл, стандарт – Дундаж оноо: 2.4.</p> <p>Ерөнхий үр дүн:</p> <ul style="list-style-type: none"> Салбарын хууль тогтоомж, бодлогын зохицуулалтын байдал (Эрэлт хэрэгцээ): Салбар бүрд УАӨ-д хамааруулах, уялдаатай ажиллах бодлогын баримт бичгүүд бий. Цаашид бие даасан хууль, эрх зүйн баримт бичигтэй болох шаардлагатай. Салбарын онцлогт тохирсон заавар арга зүй, норм, мэргэжлийн стандарт байгаа эсэх: Энэ талаар оролцогч талуудад мэдлэг, мэдээлэл байхгүй. Манлайлал үзүүлж ажиллах шаардлагатай байгууллага: Байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага буюу Байгаль орчин, аялал жуулчлалын яам Салбар бүр уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох үйл ажиллагаатай холбоотой гарын авлага, стандарт, удирдамжийг боловсруулах хэрэгтэй. Тухайлбал, уур амьсгалын хувьд тэсвэртэй дэд бүтэц, барилга байгууламжтай холбоотой гол баримт бичгүүдийг Монгол хэл дээр гаргах шаардлагатай. Үүнийг салбарын мэргэжлийн холбоод, эсвэл Засгийн газрын эрх бүхий байгууллага, стандартын байгууллагуудаар дамжуулан эсхүл сайн дурын байдлаар хүлээн зөвшөөрсөн зохих хэм хэмжээ, зохицуулалт болгон ашиглахад дэмжлэг үзүүлэх шаардлагатай. <p>Салбар, оролцогч талуудаас хамаарсан онцлог үр дүн: Байхгүй. Ерөнхий үр дүнтэй ижил.</p>

9.2 Оролцогч талуудын уур амьсгалын өөрчлөлттэй холбоотой гүйцэтгэж буй гол үйл ажиллагаа, санаачилга

Монгол улсын ногоон хөгжлийн төлөвлөгөөнд бүх салбар ногоон хөгжлийн асуудлыг дэмжинэ гэсэн агуулга байдаг. Тэр утгаар оролцогч талууд ажилладаг салбар тус бүртээ УАӨ-ийн асуудалд анхаарч, тодорхой санал санаачилгуудыг ажил хэрэг болгож байна. Байгаль орчны салбарт хамаарах байгууллагууд, уг асуудлыг ерөнхийд нь удирдан чиглүүлж, бусад салбар, оролцогч талуудад мэдээлэл өгөх, чадваржуулах ажлыг голлон гүйцэтгэж байна. Эрчим хүч, хөдөө аж ахуйн салбарт хамаарах оролцогч талууд голлон салбарт тус бүрдээ хүлэмжийн хийн ялгарлыг бууруулахтай холбоотой зорилт дэвшүүлэн ажиллаж байна. Эрүүл мэндийн салбарт уур амьсгалын өөрчлөлтөөс үүдэлтэй хүн амын дундах өвчлөл, түүнд бэлэн байх талын судалгаа шинжилгээний ажлуудад төвлөрч байна.

Оролцогч талуудын УАӨ-тэй холбоотой гүйцэтгэж буй гол үйл ажиллагаа, санаачилга:	
Нутгийн удирдах байгууллага (Аймаг, дүүрэг, сумдын ЗДТГ, ИТХ гэх мэт)	<p>Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн үндсэн чиглэлд ногоон хөгжил (яг УАӨ гэсэн нэр томъёолол байхгүй)-ийн асуудлыг төлөвлөн хэрэгжүүлэх,</p> <ul style="list-style-type: none"> “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөнийг орон нутагтаа зохион байгуулах Орон нутагтаа цөлжилтийн эсрэг арга хэмжээ авч хэрэгжүүлэх Уст цэгийн тоог нэмэгдүүлэх, хөв цөөрөм байгуулах, булаг шандын эхийг хашиж хамгаалах Ногоон байгууламжийн тоог нэмэгдүүлэх Орчны бохирдлыг бууруулах, хог хаягдлын менежментийг сайжруулах гэсэн ерөнхий ажлуудыг хэрэгжүүлж байна.

<p>Байгаль орчны салбар (БОАЖЯ, УАЭСХАТ, Уур амьсгалын өөрчлөлтийн үндэсний хороо)</p>	<p>Монгол Улсад УАӨ-тэй холбогдох асуудлыг байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага байгаль орчны салбар хариуцан ажиллаж байна.</p> <ul style="list-style-type: none"> УАӨ-ийн чиглэлээр Монгол улсын нэгдсэн орсон олон улсын гэрээ, хэлэлцээр, конвенциудын хэрэгжилтийг хангах, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн 5.1.12 дугаар заалтын хэрэгжилтийг төлөвлөх, зохион байгуулах, хянах, Талуудад мэргэжил, арга зүйн зөвлөгөө өгөх, Хамаарах чиглэлээр төсөл хөтөлбөр боловсруулж, хэрэгжүүлэх, “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөнийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах, хянах, цөлжилт, газрын доройтлыг бууруулах
<p>Эрчим хүчний салбар (Эрчим хүчний яам, зохицуулах хороо, Европын сэргээн босголтын банк гэх мэт)</p>	<p>Монгол Улсад УАӨ-тэй холбогдох асуудлыг байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага байгаль орчны салбар хариуцан ажиллаж байна.</p> <ul style="list-style-type: none"> Сэргээгдэх эрчим хүчний эзлэх хувийг нэмэгдүүлэх – 2020 оны байдлаар 9 нар, салхины цахилгаан станцууд ажиллаж байна. Эрчим хүчний үйлдвэрлэлийн үр ашгийг дээшлүүлэх, хэмнэлттэй эрчим хүч бий болгох зорилгоор хэрэгжүүл буй төсөл хөтөлбөрүүдийн тоог нэмэгдүүлсэн.
<p>ХАА-н салбар</p>	<p>Мал аж ахуйн салбар дахь хүлэмжийн хийн ялгарлыг бууруулахтай холбоотой үйл ажиллагаа тус салбарт зонхилж байна.</p> <ul style="list-style-type: none"> Нэмүү өртөг шингэсэн эрчимжсэн МАА-г хөгжүүлэх замаар малын тоо толгойг бууруулахаар зорьж ажиллаж байна. Малын хөлийн татварын бодлогыг хэрэгжүүлж, татвараас бүрдсэн төсвийг эргээд бэлчээрийн менежмент, цөлжилтийг сааруулах, уст цэгийг нэмэгдүүлэх гэх мэт арга хэмжээнд зарцуулж байна. Бэлчээр болон хөрсийг хамгаалах арга хэмжээнүүдийг төлөвлөн хэрэгжүүлж байна.
<p>Эрүүл мэндийн салбар</p>	<p>Тус салбарт УАӨ-ийн чиглэлээр судалгаа шинжилгээ гүйцэтгэж, салбарын хэмжээнд хэлэлцүүлэх, мэдээлэл түгээх ажлуудыг голлон гүйцэтгэж байна.</p>

9.3 Оролцогч талуудыг чадваржуулах хэрэгцээ

Хэн?	What?	How? And any considerations?
Үндэсний түвшинд	<ul style="list-style-type: none"> Хүлэмжийн хийн ялгарлыг тооцоолох арга, аргачлалыг улам боловсронгуй болгох (салбар бүрээр бодит тооцоолол гаргах) УАӨ-ийг хариуцсан төрийн институт, бүтэц чиг үүргийн асуудлыг хууль эрх зүйн түвшинд нь тодорхой болгох шаардлагатай. Банк санхүүгийн асуудал 	<ul style="list-style-type: none"> Хүлэмжийн хийн ялгарлыг салбар бүрээр нь нарийн гаргах, мэдээллийн сан үүсгэж, зохих аргачлалыг бий болгох, Одоогийн БОАЖЯ нь үндсэн чиг үүргийн статусгүй чиг үүргийн яам болчихсон. Үндсэн чиг үүргийн яам гэдэг нь салбар дундын чиг үүргийг зохицуулах үүрэгтэй юм. УАӨ бол салбар дундын асуудал учраас БОАЖЯ бусад салбар яамнуудтай харилцан уялдуулж байх хэрэгтэй. Банкнүүдэн өгдөг ногоон зээл нь ХАА, эрчим хүчний салбарт хангалттай бус байдаг.
Орон нутгийн түвшинд	<ul style="list-style-type: none"> Боловсон хүчнийг чадваржуулах, тогтвортой байдлыг нь хангах, Уур амьсгалын өөрчлөлт нь аймаг, сумдад хэрхэн нөлөөлж байгааг таниулах, Орон нутгийн хөгжлийн хөтөлбөр болон дэд хөтөлбөрүүдэд УАӨ-ийн асуудлыг хэрхэн тусгах вэ? 	Улс төрийн халаа сэлгээ, цалин хангамж бага байдлаас шалтгаалан боловсон хүчин амархан солигддог. Ажлын ачаалал өндөр, УАӨ-тэй холбоотой асуудлыг хавсарга байдлаар хийж гүйцэтгэдэг.
Шийдвэр гаргагчид	<ul style="list-style-type: none"> Урт хугацааны бодлого, төлөвлөлтийг хэрэгжүүлэх төсөв, санхүүгийн нөөц бололцоог бий болгох, УАӨ-тэй холбоотой зарим тулгамдсан асуудлыг хувийн хэвшлийн оролцоотойгоор гүйцэтгэж, төр ачааллаа хуваалцах шаардлагатай. 	<ul style="list-style-type: none"> Аль аль шатанд төсөв, санхүүгийн нөөц дутагдалтай. Өнөө маргаашийн тулгамдсан асуудал, ялангуяа эдийн засгийн шинжтэй тулгамдсан асуудалд анхаарахаас бус УАӨ-ийн асуудалд төдийлөн ач холбогдол өгдөггүй учраас бодлого шийдвэрт тусгадаггүй. Төрд мэргэшсэн боловсон хүчин дутмаг учраас зарим төлөвлөгдсөн ажилд ахиц гарахгүй байдал ажиглагдсан.

Хэвлэл мэдээлэл ба сэтгүүлчид	<ul style="list-style-type: none"> Төрөл бүрийн сэдвээр дагнан бичдэг сэтгүүлчийн уур амьсгалын өөрчлөлтийн тухай мэдлэгийг нэмэгдүүлэх, тухайн сэдвүүд нь үүнтэй хэрхэн холбогдож буйг ойлгуулах сургалт, арга хэмжээг тогтмол зохион байгуулах, Байгаль орчны ба уур амьсгалын өөрчлөлтийн чиглэлээр ажиллаж буй хэвлэл мэдээллийн байгууллагууд ба сэтгүүлчдийн хамтын ажиллагааг нэмэгдүүлэх, Хэвлэл мэдээллийн байгууллагуудын редакцын бодлогыг байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сэдвүүд рүү чиглүүлэхтэй холбоотой стратегийн алхмуудыг зохион байгуулах. 	<ul style="list-style-type: none"> Сэтгүүлч мэргэжлээр буй оюутнууд ба сэтгүүлчээр ажиллаж буй мэргэжилтнүүдийн аль алинд нь зориулсан сургалтын хөтөлбөр бий болгох шаардлагатай. Ингэснээр сэтгүүлчид өдөр тутмын үйл явдлыг уур амьсгалын өөрчлөлтийн өнцгөөс харж, цаашлаад иргэдийн мэдлэг мэдээллийг нэмэгдүүлж чадна. Энэ чиглэлийн сэтгүүлчид, хэвлэл мэдээллийн байгууллагуудын хамтын ажиллагааг сайжруулахын тулд энэ сэдвээр ажилладаг, ажиллах сонирхолтой сэтгүүлчид ба хэвлэл мэдээллийн байгууллагуудын холбоо, клуб үүсгэх, байгаа холбоонуудыг чадваржуулж, дэмжлэг үзүүлэх Энэ сэдвээр ажилладаг сэтгүүлчийг чадваржуулж, энэ төрлийн мэдээ мэдээллийн чанар, давтамжийг нэмэгдүүлэх зорилготой урт хугацааны хөтөлбөр, компанит ажил зохион байгуулах нөөц бүрдүүлэх нь чухал. Уур амьсгалын өөрчлөлтийн чиглэлээр иргэд, олон нийтийн мэдлэг мэдээллийг нэмэгдүүлэхэд чиглэсэн нэгдсэн санг бий болгож, үүнд дотоод ба гадаадын санхүүжүүлэгчдээс нөөц, хөрөнгө бүрдүүлэх гэх мэт.
Иргэд	<ul style="list-style-type: none"> УАӨ, түүний нөлөөлөл, даван туулах, дасан зохицох арга замуудын талаар мэдлэг, ойлголттой болох шаардлагатай. Иргэд орон нутагтаа хэрэгжүүлж болохуйц дасан зохицох арга хэмжээний талаарх мэдлэг, ур чадвартай байх хэрэгтэй. Айл өрх болон хувь хүний түвшинд дасан зохицох арга хэмжээний талаарх мэдлэг, ур чадвар. 	Энгийн амьдралд хэрэгжүүлж болохуйц мэдлэг олгох, тэдэнд өөрсдийнхөө эмзэг байдал, тулгарч буй эрсдэлийг тодорхойлоход нь тусалж, өөрсдөө хийж болох энгийн, хялбар арга хэмжээнүүдийг дэмжих. Эдгээр эрсдэл нь тэдэнд, ахуй амьдралд нь хэрхэн нөлөөлж байгаа талаарх мэдээлэл, ойлголтыг түгээх.



10. ЕРӨНХИЙ БОЛОН БАЙГАЛЬ ОРЧНЫ ТУХАЙ ХЭВЛЭЛ МЭДЭЭЛЛИЙН ХЭРЭГЛЭЭ

Энэхүү судалгааны гол зорилгын нэг нь нийт хүн ам болон эмзэг бүлгүүдийн хэвлэл мэдээллийн хэрэглээг тодорхойлж, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох, бууруулахад шаардагдах мэдлэг, ур чадварыг олгоход туслах явдал юм. Энэхүү судалгааны үр дүнг Монгол дахь уур амьсгалын өөрчлөлтийн талаарх олон нийтийн мэдлэгийг нэмэгдүүлж, энэхүү асуудалтай тэмцэхэд шаардагдах мэдлэг, чадваруудыг олгох арга хэмжээг тодорхойлоход ашиглана. Сүүлийн үед Монголд хэвлэл мэдээллийн ерөнхий хэрэглээ, статистикийн талаар судалгаа цөөнгүй хийгдсэн учир судалгаа нь хүн амын байгаль орчны мэдээллийн эх сурвалжууд, хэвлэл мэдээллийн хэрэглээнд илүү чиглэх юм.

Хүснэгт 13 Уур амьсгалын өөрчлөлттэй холбоотой мэдээллийн хэрэглээний үр дүнгийн хураангуй, хүйс, насны бүлэг, байршил, эмзэг байдлаар, % (n=2804)

#	Шалгуур асуултууд	Хүйс		Насны бүлгүүд				Байршил		Эмзэг байдал	
		Эм	Эр	18-24	25-34	35-59	>60	Хот	Хөдөө	Бага	Их
1	Та сүүлийн 12 сарын хугацаанд "уур амьсгалын өөрчлөлт" эсвэл "дэлхийн дулаарал" гэсэн нэр томъёог ашигласан ямар нэгэн мэдээллийг хэвлэл мэдээллийн хэрэгслээр хүлээн авсан уу?	41.3	47.0	45.9	45.1	42.1	46.4	46.0	40.5	42.3	45.6
2	Та өнгөрсөн жил цаг агаарын байдал, байгалийн аюулт үзэгдлүүд тохиолдох давтамжид өөрчлөлт гарч байгаа тухай мэдээллийг хэвлэл мэдээллийн хэрэгслээс авсан уу? ⁴³	52.7	54.2	50.8	54.9	53.1	53.4	52.5	54.9	52.2	54.8
3	Та уур амьсгалын өөрчлөлтийн талаарх илүү мэдээллийг хэвлэл мэдээллийн хэрэгслээс авахыг хүсч байна уу?.	86.1	83.9	80.9	84.9	86.9	85.1	82.6	89.6	85.3	84.8

Тайлбар: Статистикийн хувьд ач холбогдолтой үр дүнг өнгөөр тодруулсан болно. (p < 0.01).

43 Цаг хугацаа заасан асуулгыг "энэ жилийн сүүлийн Цагаан Сарын баярын өдрөөс хойш хугацааг хамарсан" гэж ойлгоно.

10. ЕРӨНХИЙ БОЛОН БАЙГАЛЬ ОРЧНЫ ТУХАЙ ХЭВЛЭЛ МЭДЭЭЛЛИЙН ХЭРЭГЛЭЭ

10.1 Хэвлэл мэдээллийн ерөнхий хэрэглээ

тайланд дурдсаны дагуу, Монголд д 2022 оны байдлаар үндэсний өдөр тутмын 7 сонин, өргөн нэвтрүүлгийн 20 суваг, орон нутгийн 120 өргөн нэвтрүүлгийн суваг, 50 радио суваг болон 150 онлайн мэдээллийн байгууллагыг оролцуулаад, нийт 500 гаруй хэвлэл мэдээллийн байгууллага үйл ажиллагаа явуулж байна. Уг тайланд дурдсанаар Монгол Улсад 2013 оноос хойш уламжлалт хэвлэл мэдээний байгууллагуудын (жишээ нь зурагт, радио, сонин) тоо буурсаар байгаа бол онлайн мэдээллийн хэрэгслүүдийн тоо тасралтгүй нэмэгдсээр байна.⁴⁴ тайланд дурдсаны дагуу, Монголд д 2022 оны байдлаар

44 Монголын Хэвлэлийн Хүрээлэн, Монгол Мэдээ - Өнөөдөр, 2021

үндэсний өдөр тутмын 7 сонин, өргөн нэвтрүүлгийн 20 суваг, орон нутгийн 120 өргөн нэвтрүүлгийн суваг, 50 радио суваг болон 150 онлайн мэдээллийн байгууллагыг оролцуулаад, нийт 500 гаруй хэвлэл мэдээллийн байгууллага үйл ажиллагаа явуулж байна. Уг тайланд дурдсанаар Монгол Улсад 2013 оноос хойш уламжлалт хэвлэл мэдээний байгууллагуудын (жишээ нь зурагт, радио, сонин) тоо буурсаар байгаа бол онлайн мэдээллийн хэрэгслүүдийн тоо тасралтгүй нэмэгдсээр байна.


Дэлхийн чиг хандлагатай нэгэн адил,⁴⁵ Монгол Улсын хэвлэл мэдээллийн байгууллагууд олон хэрэглэгч татахын тулд дижитал платформ, тэр дундаа сошиал медиа сувгууд руу ихээр шилжиж байна. 2020 оны судалгаагаар нийт идэвхтэй ажиллаж байсан мэдээллийн байгууллагууд (цахим хэвлэл мэдээллийн байгууллагуудыг оролцуулан) өөрсдийн мэдээлэл болон контентоо түгээдэг албан ёсны фэйсбүүк хуудастай байсан байна. 2020 онд 500 хүний дунд явуулсан судалгаагаар⁴⁶ ихэнх хүмүүс фэйсбүүк дээр таарсан мэдээллийн эх сурвалжуудыг ялгаж салгаж мэдэхгүйг олж тогтоожээ.

Энэхүү судалгаагаар зурагт (73.6%) ба интернэт (63.7%) нь иргэдийн улс төр, эдийн засаг, эрүүл мэнд, боловсрол болон байгаль орчин зэрэг чухал сэдэвт хамаарах мэдээллийн үндсэн эх

45 Пею Судалгааны Төв, Дижитал Мэдээний Ертенц Хэр Том 63?, 2014 <https://www.pewresearch.org/journalism/2014/03/26/how-big-is-the-digital-news-world/>

46 Монголын Хэвлэлийн Хүрээлэн болон Олон Улсын Бүгд Найрамдах Хүрээлэн, Хэвлэл Мэдээллийн Хэрэглээний Онцлог болон Залуучуудын Боловсролын Түвшин, 2020

Figure 54: Most popular radio stations among those who listen to radio, by residency (n=454).




Зураг 49 Судалгаанд оролцогчдын хамгийн түгээмэл мэдээллийн гурван эх сурвалж, % (n=2804)

Улс төр, эдийн засаг, эрүүл мэнд, боловсрол, байгаль орчин зэрэг чухал сэдвийн талаарх таны мэдээллийн гол эх сурвалж юу вэ?



Зураг 50 Судалгаанд оролцогчдын дундах хамгийн түгээмэл мэдээллийн эх сурвалжууд, насны бүлгээр (n=2804)



сурвалжууд болох нь тогтоогдсон. Судалгаанд оролцогчдоос хамгийн түгээмэл гурван мэдээллийн эх сурвалжийг нэрлэнэ үү гэж асуухад (ярилцлага авч буй хүмүүст хариултыг үзүүлээгүй бөгөөд уншиж өгөөгүй болно) зурагт, интернэтийн дараа “хамт ажилладаг хүмүүс” болон “орон нутгийн удирдлагууд” гэсэн хүнээс хүн рүү чиглэсэн шууд харилцаанууд мэдээлэл авах хамгийн түгээмэл эх сурвалжууд байдгийг Зураг 49 дахь графикаас харж болохоор байна.

Интернэт нь залуучуудын дунд мэдээлэл авах үндсэн эх сурвалж болдог бол, ахимаг насныханд зурагт түгээмэл хэвээр байна. Зураг

50-д үзүүлснээр, 18-24 насны залуусын 88.6% нь мэдээлэл авах үндсэн гурван тэргүүлэх эх сурвалжийн нэгийг интернэт гэж нэрлэсэн бол, 60-аас дээш насныхны 4.3% ингэж нэрлэсэн нь эрс ялгаатай байгааг харуулж байна.

Засаг дарга нар, хороодын болон багийн дарга гэсэн орон нутгийн удирдлагууд хотын хүн амаас (1.6%) илүүтэй орон нутгийн хүн амд (3.4%) мэдээлэл өгөх үүргийг гүйцэтгэж байна. Мөн залуу насны бүлгийнхнийг (1.2%) бодвол илүү настай (35-аас дээш насныханд) бүлгийнхэн орон нутгийн удирдлагуудыг мэдээллийн гол эх сурвалжуудын нэгээр нэрлэжээ.

Зурагт, интернэт, ФМ радио болон бусдын амнаас⁴⁷ сонссоноо өөрсдийн мэдээллийн нийтлэг эх сурвалж гэж нэрлэсэн хүмүүс эдгээр эх сурвалжаас өдөр бүр мэдээлэл авах хандлагатай байна. Хамгийн их давтамжтай ашигладаг эх сурвалж нь интернэт бөгөөд ингэж нэрлэсэн оролцогчдын 77.9% нь, ФМ радиог мэдээллийн гол эх сурвалж гэж хариулсан хүмүүсийн 64% нь, ажлын газрынхнаа сонгосон хүмүүсийн 67.3% нь, зурагт сонгосон хүмүүсийн 58.9% нь, ФМ радиогоос мэдээлэл авдаг хүмүүсийн 59.5% нь тус тус эдгээр эх сурвалжуудыг өдөр тутам ашигладаг гэжээ. Тиймээс, үнэмлэхүй тоогоор, өдөр тутам интернэт ашиглагчдын тоо нь өдөр тутам зурагт ашиглагчдын тооноос илүү өндөр (судалгааны нийт оролцогчид тус тусдаа 49.3% болон 43.2%) байна.

Хүснэгт 14 Судалгаанд оролцогчдын мэдээллийн түгээмэл эх сурвалжуудын давтамж, %⁴⁸

Эх сурвалжийн төрөл	Тоо	Өдөр тутам	7 хоног тутам	Сар тутам
Зурагт	2057	58.9%	33.9%	6.9%
Интернэт (веб сайтууд болон социал медиа)	1778	77.9%	18.3%	3.8%
Бусдаас сонссон (гэр бүл, найз, хамт ажиллагч)	330	53.5%	36.8%	9.4%
ФМ радио	127	59.5%	28.9%	10.7%
Сэтгүүл болон сонин	125	31.5%	50.8%	16.1%
Орон нутгийн удирдлагууд	96	14.1%	29.4%	54.8%

Зурагт

Энэ судалгаагаар зурагт бол эмзэг бүлгийнхэн, орон нутгийн иргэд, дунд боловсролтой хүн ам, байшин, гэрт амьдардаг иргэдийн дунд хамгийн хүртээмжтэй мэдээллийн эх сурвалж болох нь тогтоогдсон. Судалгаанд оролцогчдын талаас илүү хувь нь (58.9%) өдөр болгон зурагт үздэг гэжээ. Зурагтыг мэдээллийн үндсэн эх

47 Word of mouth sources included - family members, work colleagues and civil servants (such as teachers and health workers).


48 Утга дутуу байгаа тул хувь нь 100.0% хүртэл нэмэгдэхгүй.

Зураг 51 Өдөр бүр зурагт үздэг судалгаанд оролцогчдын хувь, сууцны төрлөөр (n=1212)



сурвалжийн нэгээр сонгосон хүмүүсийн дунд орон нутгийн үзэгчид нь (49.5%) хотын үзэгчдээс (43.6%) ялимгүй өндөр дүнтэй байна. Өдөр бүр зурагт үздэг хүмүүсийн хувьд эмэгтэй (58.7%), эрэгтэй (59.1%) үзэгчдийн тооны хооронд ялгаа байхгүй байна. Өдөр тутамд зурагт үздэг өндөр настангуудын хувь (60-аас дээш настай судалгаанд оролцогчдын 84.3%) залуусынхаас (18-24 настай судалгаанд оролцогчдын 26.8%) нэлээд өндөр байна. Өдөр бүр зурагт үздэг гэж хариулсан судалгаанд оролцогчдын тал орчим хувь нь (45.3%) дунд боловсролтой, эдгээрийн ихэнх нь байшин (39.9%), гэрт (37.1%) амьдардаг гэж хариулжээ.

Зураг 52 Судалгаанд оролцогчдын хамгийн түгээмэл үздэг телевизийн сувгууд, байршлаар (n=2520)



Орон нутгийн хүн ам MNB, Малчин ТВ сувгуудыг хамгийн түгээмэл хэрэглэдэг бол Movie Box, Education TV, Mongol TV зэрэг сувгийг хот суурин газрын иргэд түгээмэл үздэг байна. Ихэнх үзэгчдийн зурагт үзэх цаг оройн 8 цагаас шөнө дунд хүртэл байдаг бол, оргил цаг нь оройн 9 цагаас оройн 11 цаг хүртэл байдаг гэж Зурагт Үзэгчдийн Хэрэглээг Хэмжих Жилийн Тайлан 2020-д дурдсан байна. Орон нутгийн болон хотын үзэгчдийн зурагтын оргил цагийн ялгаа бага зэрэг байна. Орон нутагт зурагтын оргил цаг нь оройн 6 цагаас оройн 10:30 байсан бол Улаанбаатарт 20158 онд оройн 7 цагаас оройн 11:30 цагийн хооронд байсан байна.

Интернэт

Өрхийн Мэдээлэл, Харилцаа Холбоо, Технологийн (ICT) хэрэглээний 2022 оны судалгаагаар,⁴⁹ Монгол Улс дахь нийт өрхийн 57.0% нь тогтмол интернэт холболттой (үүнээс 72.0% хот суурин газарт байсан ба үлдсэн хэсэг нь орон нутагт байжээ) гэсэн бол 80.0% нь ямар нэг байдлаар интернэтэд холбогдох боломжтой гэжээ (өрхүүдийн 86.3% нь хот суурин газарт ба 63.0% нь орон нутагт байжээ). 2011 оны байдлаар Монгол Улсын хүн амын ердөө 12.5% орчим нь интернэтэд нэвтрэх боломжтой байсантай харьцуулахад маш их өөрчлөлт гарсан байна.

49 Цахим Хөгжил, Харилцаа Холбооны Яам Болон Үндэсний Статистикийн Газрын Өрхийн мэдээлэл, харилцаа холбоо, технологийн хэрэглээ болон хүртээмжтэй байдлын судалгаа, 2022

Гэхдээ, интернэтэд холбогдох боломжтой байх, түүнийг ашиглаж өөрт хэрэгтэй мэдээлэл олж авах чадвартай байх нь хоорондоо ялгаатай. Мэдээллийн гол эх сурвалжийг интернэт гэж нэрлэсэн хүмүүсийн 63% нь голдуу залуу, хот суурингийн хүн ам байгаа нь судалгаагаар тогтоогдсон юм. Нийт судалгаанд оролцогчдын талаас илүү хувь нь (64.7%, n=1814) сүүлийн 3 сард өдөр тутам интернэт ашиглаж байсан бол 15.2% нь огт ашиглаагүй байна. Сүүлийн 3 сард (n=2408) интернэт ашигласан судалгаанд оролцогчдын ихэнх нь (98.4%) гар утсаар интернэтэд нэвтэрч байсан бол, 12.5% нь суурин болон зөөврийн компьютероор, харин 2.2% нь планшетаар нэвтэрч байжээ.

Интернэтэд өдөр тутам нэвтэрч байсан хүмүүсийн дийлэнх нь (74.0%) хот сууринд амьдардаг, 18-34 (83.5%) насныхан байв. Интернэт ашиглах үндсэн шалтгаан нь мэдээлэл хайх (23%), мэдээ унших (22.7%), социал медиа ашиглах (20.4%) болон бусадтай холбоо тогтоох (17.5%) шалтгаанууд байсан ба үлдсэн хүмүүс нь интернэт ашигладаггүй байна.

Үндэсний тайлангуудад дурдснаар интернэт болон социал медиа ашиглагчдын тоо нь ижил байна. Дижитал 2020: Монгол Улс⁵⁰ тайланд дурдсанаар 2020 оны нэгдүгээр сард Монгол Улсад 2.20 сая интернэт хэрэглэгч байсан ба социал медиа хэрэглэгчдийн тоо нь интернэт хэрэглэгчдийнхтэй адил байсан нь Монгол Улсын ихэнх интернэт хэрэглэгчид социал медиаг ашиглаж буйг илтгэж байна. Монгол Улсад социал медиа нэвтэрч, 2020 оны нэгдүгээр сард хэрэглээний түвшин 68%-д хүрчээ. Социал медиа нь ирээдүйн харилцаа холбооны компанит ажлуудад ашиглагдаж болох хамгийн түгээмэл платформ болохыг энэ тайлангаас гарсан үр дүнгүүд харуулж байна.

Фэйсбүүк нь Монгол Улсад хамгийн өргөн (дурдсан нийт платформуудын 59.4%) ашиглагддаг социал медиа, мессэжээр харилцах платформ гэдгийг энэхүү судалгаагаар олж тогтоов. Социал медиагийн платформууд (n=2409) ашигладаг судалгаанд оролцогчдын 95.1% нь фэйсбүүк ашигладаг гэжээ. Орон нутгийн иргэд, эмэгтэйчүүд, өндөр настнуудын дунд хамгийн өргөн ашиглагддаг социал медиа платформ болох нь судалгааны үр дүнгээс харагдаж байна. Түгээмэл ашиглагддаг бусад социал медиа платформууд нь инстаграм

50 Datareportal, Дижитал 2020: Монгол Улс, 2020 <https://datareportal.com/reports/digital-2020-mongolia>

болон юүтүби байна. Инстаграмыг хамгийн их ашигладаг хүмүүс гэвэл, хот сууринд амьдардаг, эмэгтэй, залуучууд байна. Юүтүбиг хот сууринд амьдардаг, эрэгтэй, залуу насныхан түлхүү ашигладаг байна.

Хүснэгт 15 Судалгаанд оролцогчдын фэйсбүүк ашигладаг байдал, байршил, хүйс, насны бүлгээр, % (n=2408)


Хот	Хөдөө	Эмэгтэй	Эрэгтэй	18-24	25-34	35-59	60-аас дээш
1516	774	1194	1096	501	629	1011	150
93.3%	98.6%	95.6%	94.5%	91.6%	95.7%	96.6%	93.9%

Монгол Улсад дижитал хуваагдал, интернэтийн хүртээмжийн асуудал буйг дурдах хэрэгтэй. Зорилтот бүлгийн иргэдийн цахим ур чадварыг үнэлэх чанарын судалгаа⁵¹ -ны дүнгээс харвал эмзэг бүлгийн иргэдийн (хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс, ахмадууд, алслагдсан болон орон нутгийн өрхүүд, дотооддоо шилжин суурьшсан болон орлого багатай өрхүүд) дунд дижитал төхөөрөмжүүдийн хүртээмж хэрэгцээг нь хангах хэмжээнд байж чадахгүй байгааг олж тогтоосон. Хэдийгээр өрх бүрт наанадаж нэг ухаалаг утас байгаа ч, тус бүлгийнхний хуучин загварын товчлууртай утасны хэрэглээ өндөр байна.

Гар утас

Ихэнх хүмүүс (84.4%) гар утсыг өдөр тутам ашиглаж байна. Гар утас (n=2781) ашигладаг судалгаанд оролцогчдын дунд, гар утас ашиглах хамгийн түгээмэл шалтгаан нь дуудлага хийх (39.7%), социал медиа ашиглах (19.4%), мэдээ унших (14.4%) болон зурвас мессэж илгээх (9.3%) байна.

Зураг 53 Судалгаанд оролцогчдын гар утас ашиглах давтамж, % (n=2804)



Гар утас бол бүх салбарынханд хүрэх хамгийн хэрэгцээт төхөөрөмж мөн. Гар утас ашигладаг

51 НҮБХХ & ИРИМ, Эмзэг бүлгүүдийн дижитал хэрэглээ болон чадварид хийсэн чанарын үнэлгээ, 2021

судалгаанд оролцогчдын 99.1%-иас илүү нь өөрийн юм уу хэн нэгний гар утсыг “өдөр бүр”, “хааяа нэг” ашигладаг гэж хариулжээ. Энэ нь 2022 онд Мэдээлэл, харилцаа холбоо, технологийн

өрхийн хэрэглээний судалгааны⁵² үр дүнтэй таарч байна. Энэ судалгаанд оролцогчдын бараг нийт (98%) оролцогч гар утастай бөгөөд боловсрол багатай хүмүүсийн 54.8% нь хуучин ухаалаг утастай байжээ.

Хүснэгт 16 Гар утас өдөр тутам ашигладаг судалгаанд оролцогчдын хувь, хүйсээр, насны бүлгээр, % (n=2781)

Хот	Орон нутаг	Эмэгтэй	Эрэгтэй	18-24	25-34	35-59	60 ба
88.3%	79.4%	86.5%	83.6%	90.7%	89.8%	83%	73.1%


Гар утас өдөр тутам ашигладаг хүмүүсийн дунд, хотын (88.3%), эмэгтэй (86.5%) бөгөөд илүү залуу (18-24 насны судалгаанд оролцогчдын 90.7%) хүмүүс байна.

Радио


Судалгаанд оролцогчдын дийлэнх нь (83.8%) радио огт сонсдоггүй гэж хариулжээ. Радио сонсдог хүмүүсийн (n=454), 21.3% нь сардаа багадаа нэг удаа, 37.7% нь долоо хоногт багадаа нэг удаа, 41.0% нь өдөр бүр сонсдог гэжээ. “Өдөр бүр” радио сонсдог гэж хариулсан судалгаанд оролцогчдын орон нутагт амьдардаг нь (47.1%) хот сууринд амьдардаг оролцогчдын тооноос (37.2%) бага зэрэг илүү байгаа ба эрэгтэйчүүд (42.8%) нь эмэгтэйчүүдийн (37.9%) тооноос үл ялиг илүү, өндөр настны тоо (35-59 настай судалгаанд оролцогчдын 45.7% ба 59 наснаас дээш насны судалгаанд оролцогчдын 63.6%) залуучуудын тооноос (тэдний 18-24 настай судалгаанд оролцогчдын 19.7% ба 25-34 настай судалгаанд оролцогчдын 29.5%) илүү байна.

52 Мэдээлэл, харилцаа холбоо, технологийн газар, Өрхийн Мэдээллийн хэрэглээний судалгаа, үндэсний тайлан, 2022

Зураг 54 Судалгаанд оролцогчдын хамгийн түгээмэл сонсдог радио сувгууд, байршлаар, % (n=454)



Зураг 55 Радио сонсдог оролцогчдын хамгийн түгээмэл сонсдог хөтөлбөрүүд, % (n=454)



Монголын радио, Гэр бүлийн радио 104.5-г хот суурин бүсэд хамгийн их, MNB радиог орон нутагт сонсох нь түгээмэл байна.

Өдөр тутам радио сонсдог хүмүүсийн 30.1% нь малчид, 26.3% нь ажил эрхэлдэг, 21.5% нь тэтгэвэрт гарсан иргэд байна.

Хамгийн түгээмэл сонсдог радио хөтөлбөр нь мэдээ (66.5%) юм. Бусад хөтөлбөрт хөгжим (24.4%), одоо үед болж буй үйл явдлын тайлбар (22.5%), гэр бүлийн хөтөлбөрүүд (10.2%) багтаж байна.

Подкаст

Судалгаанд оролцогчдын ихэнх нь (73.6%) подкаст огт сонсдоггүй гэж хариулсан бол, ердөө 3.8% нь подкаст өдөр тутамд сонсдог

гэжээ. Хамгийн түгээмэл сонсдог подкастууд нь Идэрээгийн подкаст (30.2%), Хүлээлгийн өрөө (13.3%), Коктэйл ба Гэмт Хэрэг (9.4%) зэрэг байв. Өөр бусад Харанхуй Өрөө (9.0%), Unlock Podcast (8.0%), Мандуулро (7.6%), Бизнес.мн подкаст (6.2%), 6-минутын Англи хэл (6.1%) зэрэг багтаж байна. Сардаа нэгээс дээш удаа подкаст сонсдог хүмүүсийн тоо хотынхны хувь (32.8%) орон нутгийн сонсогчид (17.5%)-оос илүү, эмэгтэйчүүд (27.1%) эрэгтэйчүүд (26.5%)-ээс илүү, мөн залуучууд (18-24 настай судалгаанд оролцогчдын 45.6% ба 25-34 настай судалгаанд оролцогчдын 35.1%) ахмад настнуудаас (35-59 настай судалгаанд оролцогчдын 19.7% ба 60-ээс дээш насны судалгаанд оролцогчдын 9.1%) илүү байна.


10.2 Хэвлэл мэдээллийн хэрэгсэлд итгэх итгэл болон буруу ташаа мэдээлэл

Өндөр настан (60-аас дээш насны судалгаанд оролцогчдын 49.5%), эмэгтэйчүүд (44.1%), орон нутгийн (46%) үзэгчид хамгийн итгэлтэй мэдээллийн эх сурвалжаар зурагтыг нэрлэжээ. Уг судалгаанд хамрагдсан бүх насны оролцогчдын дийлэнх нь (77%) зурагт бол хамгийн итгэлтэй мэдээллийн⁵³ эх сурвалж гэж хариулсан байна.

53 Монголын маркетингийн зөвлөх групп, Үндэсний мэдээллийн судалгаа, 2021

Судалгаанд оролцогчдын талаас илүү хувь нь интернэтийг мэдээллийн гол эх сурвалжуудын нэгээр нэрлэсэн хэдий ч, түүнд итгэх итгэл нь зурагтын мэдээнд итгэх итгэлийн хувь шиг өндөр биш байна. Ойролцоогоор судалгаанд оролцогчдын гуравны нэг хувь нь интернэт дээрх мэдээний найдвартай, үнэн зөв байдлыг дунджаас дээгүүр гэж үнэлсэн. Харин зурагтын мэдээний найдвартай, үнэн зөв байдлыг дунджаас дээгүүр үнэлсэн хүмүүсийн хувь нийт судалгаанд оролцогчдын талаас илүү байна. Интернэтийг мэдээллийн үндсэн эх сурвалжаа гэж сонгосон судалгаанд оролцогчдын тал нь (52.4%) өөрсдийн итгэх итгэлийн түвшинг “дунд зэргийн” (3) гэж үнэлсэн. Нас, хүйс, амьдарч буй газрын байршил, эмзэг байдал болон


Зураг 56 Телевизийн мэдээлэлд итгэх итгэлийн түвшнээр хамгийн өндөр үнэлсэн хүмүүс, насны бүлгээр (n=2057)




Зураг 57 Хэвлэл мэдээллийн хэрэгсэлд итгэдэг судалгаанд оролцогчдын хувь (n=2804)



Зураг 58 Судалгаанд оролцогчдын мэдээллийн эх сурвалжуудад итгэх байдал (n=2057)



Зураг 59 Судалгаанд оролцогчид уур амьсгалын өөрчлөлттэй холбоотой худал мэдээлэлтэй таарсан эсэх



боловсролын түвшинд үндэслэсэн хэвлэл мэдээллийн хэрэгсэл, харилцан адилгүй эх сурвалжуудад итгэх итгэлд статистикийн хувьд мэдэгдэхүйц ялгаа байгаагүй.

Ихэнх хүмүүст уур амьсгалын өөрчлөлттэй холбоотой найдвартай, найдваргүй мэдээллийг ялгаж салгах хангалттай мэдлэг дутмаг байдаг. Хэдийгээр судалгаанд оролцогчдын бараг хагас нь (44.5%) уур амьсгалын өөрчлөлттэй холбоотой худал гэж бодсон аливаа мэдээлэлтэй хэзээ ч таарч байгаагүй гэж хариулсан ч, нийт оролцогчдын ердөө 19.6% нь (n=243) уур амьсгалын тухай өөрсдийн мэдлэгээ дунджаас дээгүүр гэж үнэлсэн байна.

Хүмүүс уур амьсгалын өөрчлөлтийн талаар мэдлэгээ сул гэж хариулсан боловч үүнтэй холбоотой худал мэдээлэлтэй “хэзээ ч” таарч байгаагүй гэж итгэлтэй хариулсан нь анхаарал татаж байна. Уур амьсгалын талаар худал мэдээлэлтэй “огт” таарч байгаагүй гэж хариулсан оролцогч нийт судалгаанд оролцогчдын 44.5% байгаа ба тухайн хүмүүсийн талаас илүү нь (52.9%) уур амьсгалын өөрчлөлтийн тухай өөрсдийн мэдлэгийг “Сул” болон “Маш Сул” гэж үнэлжээ. Энэ нь магадгүй ихэнх хүмүүс уур амьсгалын өөрчлөлтийн мэдээллийг зурагтаар авсан байдагтай холбоотой байж болох ба энэ нь хамгийн итгэлтэй мэдээллийн эх сурвалж юм. Үндэсний хэмжээнд ташаа мэдээний талаар явуулсан сүүлийн үеийн санал асуулгаар арай өөр

үр дүн гарсан байна. 2022⁵⁴ оны Олон нийтийн санал бодлын судалгааны оролцогчдын талаас илүү хувь нь (63%) хэвлэл мэдээллийн сувгууд болон социал медиагаар худал ташаа мэдээтэй тогтмол тааралддаг гэж хариулжээ.

10.3 Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлттэй холбоотой хэвлэл мэдээллийн хэрэглээ


Энэхүү судалгааны хүрээнд оролцогчдоос өнгөрсөн хугацаанд уур амьсгалын өөрчлөлттэй

54 Олон улсын бүгд найрамдах институт, Олон нийтийн санал бодлын судалгаа, 2022
<https://www.iri.org/resources/public-opinion-poll-residents-of-mongolia-march-april-2022/>

холбоотой мэдээлэл хүлээж авч байсан эсэхийг тодорхойлох зорилготой асуултууд асуусан. Өөрсдийн хүлээн авсан мэдээллийг уур амьсгалын өөрчлөлттэй холбоотой гэдгийг судалгаанд оролцогчдын зарим нь мэдэхгүй байх магадлал өндөр байсан тул “уур амьсгалын өөрчлөлт” болон “дэлхийн дулаарал” гэсэн нэр томъёонуудыг асуултуудад шууд дурдаж оруулаагүй. Харин асуулгад “цаг агаарын төлөвт гарсан өөрчлөлт” ба “байгалийн аюулт үзэгдэл тохиолдох давтамжид гарч буй өөрчлөлтүүд” гэсэн үг хэллэгүүдийг ашигласан.

Судалгаанд оролцогчдын талаас ялимгүй илүү хувь нь (53.5%) сүүлийн нэг жилд уур амьсгалын төлөвт гарсан өөрчлөлт, байгалийн аюул, уур амьсгалын өөрчлөлтөд хамаарах мэдээллийг хэвлэл мэдээллийн хэрэгслээс хүлээн авсан байна.

Зураг 60 Уур амьсгалын өөрчлөлтөд хамаарах худал мэдээтэй “хэзээ ч” таарч байгаагүй гэж хариулсан судалгаанд оролцогчдын энэ талаар өөрсдийнхөө мэдлэгийг үнэлсэн байдал (n=1246)



Зураг 61 Цаг агаарын төлөв, байгалийн аюулт үзэгдлийн давтамжид өөрчлөлт гарч буй тухай мэдээллийг өнгөрсөн жилийн хугацаанд хэвлэл мэдээллийн хэрэгслээс сонссон судалгаанд оролцогчдын хувь (n=2804)



Судалгаанд оролцогчдын хариултаас харахад, Монголын хэвлэл мэдээллийн хэрэгсүүдээр уур амьсгалын өөрчлөлттэй холбоотой мэдээ мэдээлэл тодорхой хэмжээгээр гардаг гэж дүгнэж болохоор байна. Судалгаанд оролцогчдын мэдэгдэхүйц хувь нь (66.2%, n=1148) энэ төрлийн мэдээллийг зурагт болон интернэтээс (29.5%, n=511) хүлээн авсан гэж хариулсан. Ялангуяа, тэд уур амьсгалын өөрчлөлттэй холбоотой мэдээллийг MNB сувгийн “Цагийн Хүрд” (48.2%) хөтөлбөрөөс, TV9 сувгийн мэдээний тайлбар хөтөлбөр “Монгол коммент”-оос (12%), Малчин ТВ (7%1) болон Фэйсбүүкээс (35.4%), zarig.mn (12.8%), ikon.mn (6.4%) мэдээний вебсайтууд болон цаг уур, орчны шинжилгээний газрын албан ёсны цаг агаарын урьдчилан сэргийлэх мэдээний сайт tsag-agaag.mn-ээс (5.2%) хүлээн авсан гэжээ. Өнгөрсөн жилийн хугацаанд хэвлэл мэдээллийн хэрэгслээс уур амьсгалын өөрчлөлттэй холбоотой мэдээлэл хүлээн авсан судалгаанд оролцогчдын дунд орон нутгийн болон хотын хүн ам, нас, хүйсийн хооронд илэрхий ялгаа байхгүй байна.

Орон нутгийн болон хотын бүсэд бүлгийн хэд хэдэн ярилцлагын үеэр Малчин ТВ-ийн нэвтрүүлэгч, цаг агаар судлаач Дамбын Шагдарсүрэн байгаль орчинтой холбоотой мэдээллийн найдвартай үндсэн эх сурвалжуудын нэгээр нэрлэгдсэн. “Салбартаа арвин мэдлэгтэй аль хэдийн олонд танигдсан, уур амьсгалын өөрчлөлтийн талаар олон нийтийн мэдлэг дээшлүүлэх хүмүүс байх хэрэгтэй. Жишээлбэл, малчид нэвтрүүлэгч

Хүснэгт 17 Сүүлийн 12 сард ‘уур амьсгалын өөрчлөлт’ эсвэл ‘дэлхийн дулаарал’ гэсэн нэр томъёог хэвлэл мэдээллийн хэрэгслээс сонссон эсэх

	Мэдлэгийн оноо		Хандлагын оноо		Практик оноо	
	Тийм	Үгүй	Тийм	Үгүй	Тийм	Үгүй
Дундаж	0.5591	0.4849	0.7125	0.6617	0.4691	0.5053
Статистик хэлбэлзэл	0.14817	0.19750	0.11725	0.15929	0.17421	0.18530

Шагдарсүрэнд итгэж, хүндэлдэг. Учир нь түүний хэлсэн бүхэн үнэн бодитой, найдвартай байдаг” гэж Улаанбаатар дахь судалгаанд оролцогч хариулжээ. Үүнээс гадна, бүлгээр ярилцах хэлэлцүүлгүүдийн үеэр цаг агаарын мэдээний хөтөлбөр болон TV9 сувгийн Монгол Коммент хөтөлбөр байгаль орчны онцлогтой мэдээллийн үндсэн эх сурвалжуудын нэг байсан гэж дурдсан байна.

Судалгаанд оролцогчдын тавны хоёр нь (45.3%) ‘уур амьсгалын өөрчлөлт’ эсвэл ‘дэлхийн дулаарал’ гэсэн нэр томъёог дурдсан ямар нэг мэдээлэл хэвлэл мэдээллийн хэрэгслээс хүлээн аваагүй гэжээ. Нийт судалгаанд оролцогчдын 44.1% нь сүүлийн 12 сард байгаль орчны ТВ хөтөлбөр, подкаст болон албан ёсны сошиал медиа хуудсууд зэрэг хэвлэл мэдээллийн хэрэгслээс мэдээлэл авсан байна. Судалгаанд оролцогчдын амьдарч буй газрын байршилд суурилсан илэрхий ялгаанууд энд гарсан байна (орон нутгийн 46.5% болон хотын 40.5% оршин суугчид мэдээлэл хүлээн авсан). Хэдийгээр статистик үзүүлэлтээр илэрхий биш ч, эмэгтэйчүүдээс илүүтэй эрэгтэйчүүд мэдээлэл авсан (47.0% ба 41.3%) байна. Үр дүнд нь дэлгэрэнгүй мэдээлэл, хандлага, практикийн оноогоор харьцуулалт хийвэл, мэдээлэл хүлээж авсан хүмүүсийн мэдлэгийн түвшин илүү өндөр бөгөөд хандлагын оноотой байна. Үүнээс харахад, хэвлэл мэдээллийн хэрэгслээс мэдээлэл хүлээн авах нь хүн амын мэдлэгийг сайжруулж, эерэг хандлагыг идэвхжүүлэх маш үр дүнтэй арга замын нэг байж болохоор байна.

Өмнө дурдсанчилсан өмнө нь байгалийн аюултай үзэгдэлтэй учирч байсан хүмүүсийн дунд энэ төрлийн мэдээллийг хэвлэл мэдээллээс авах хандлага түгээмэл байна. Байгалийн аюултай үзэгдэлтэй учирч байсан хүмүүс хэвлэл мэдээллээс “уур амьсгалын өөрчлөлт” болон “дэлхийн дулаарал” гэсэн нэр томъёог дурдсан мэдээлэл авсан гэж хариулсан байна. (62.6%).

Доорх зурагт үзүүлснээр, боловсролын түвшин доогуур хүмүүсийн ердөө 28.0% нь

өнгөрсөн жил хэвлэл мэдээллийн хэрэгслээс “уур амьсгалын өөрчлөлт”, “дэлхийн дулаарал” гэсэн нэр томъёог сонссон гэж хариулсан ба энэ үзүүлэлт нь боловсролын түвшинтэй уялдан нэмэгдэж байна. Нийтдээ, бүрэн дунд боловсролтой хүмүүсийн 42.9%, техникын болон дипломын боловсролтой хүмүүсийн 50.2%, түүнчлэн бакалавр, магистр, докторын түвшний боловсролтой хүмүүсийн 53.3% нь уур амьсгалын өөрчлөлт, дэлхийн дулаарлын талаарх мэдээллийг хүлээж авсан байна.


Зураг 62 “Уур амьсгалын өөрчлөлт”, “дэлхийн дулаарал” гэсэн нэр томъёог хэвлэл мэдээллийн хэрэгслээс сонссон судалгаанд оролцогчдын хувь, боловсролын түвшнээр (n=1237)



Зураг 63 Хамгийн олон үзэгчид хүрсэн байгаль орчны тэргүүлэх эх сурвалжууд (n=2804)



Зураг 64 Уур амьсгалын өөрчлөлтийн талаарх мэдээлэл хүлээн авахыг хүссэн судалгаанд оролцогчдын хувь (n=2804)



Зураг 65 Уур амьсгалын өөрчлөлтийн талаарх судалгаанд оролцогчдын мэдэхийг хүсэж буй сэдвүүд (n=2385)



“Хүрээлэн” баримтат нэвтрүүлэг, ‘Ногоон шошго’ гэсэн зурагтын хөтөлбөр зэрэг байгаль орчны нэвтрүүлэг үзэгчдэд хамгийн ихээр хүрсэн байна. Судалгаанд оролцогчдыг байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлттэй холбоотой хөтөлбөр, сувгуудаас аливаа мэдээлэл хүлээн авч байсан эсэхийг тодорхойлохын тулд тэднээс өнгөрсөн хугацаанд мэдээлэл хүлээж авсан эх сурвалжуудыг сонгохыг хүссэн. Дараагийн хоёр нийтлэг эх сурвалж нь Экологийн Цагдаагийн Алба ба Байгаль Орчин Аялал Жуулчлалын Яамны албан ёсны Фэйсбүүк хуудсууд байв.

Судалгаанд оролцогчдын олонх нь (85.1%) хэвлэл мэдээллийн хэрэгслээс уур амьсгалын өөрчлөлттэй холбоотой мэдээлэл хүлээн авах хүсэлтэй байгаага илэрхийлсэн байна. Судалгааны дүн уур амьсгалын өөрчлөлтийн талаар илүү их мэдээлэл авах хэрэгцээ өндөр байгааг харуулсан. Өнгөрсөн жил судалгаанд оролцогчид (92.1%) байгалийн гамшигт өртөөгүй гэж хариулсан ч, ирээдүйд уур

амьсгалын өөрчлөлтийн талаар мэдээлэл авах хүсэлтэй байгаага илэрхийлсэн байна. Хэвлэл мэдээллийн хэрэгслээс уур амьсгалын өөрчлөлтийн мэдээлэл авахыг хүсэхгүй байна гэж хариулсан хүмүүсийн (нийт оролцогчдын 11.6%) ихэнх нь (энэ төрлийн мэдээлэл авахыг хүсэхгүй байна гэсэн оролцогчдын 76.7%) энэ төрлийн мэдээллийг огт сонирхохгүй байна гэж хариулжээ.

Уур амьсгалын өөрчлөлттэй холбоотой мэдээлэл авахыг хүссэн судалгаанд оролцогчдоос ихэнх нь уур амьсгалын өөрчлөлтийн шалтгаан, уур амьсгалын өөрчлөлтийг бууруулах болон дасан зохицох арга замуудын талаар мэдээлэл түлхүү авах хүсэлтэй байна. Хэт мэргэжлийн үг хэллэг ашиглаж, судалгаанд оролцогчдыг төөрөгдүүлэхээс зайлсхийхийн тулд энэхүү судалгааны асуулгад “уур амьсгалын өөрчлөлтөөс

Зураг 66 Судалгаанд оролцогчдын мэдэхийг хүсэж буй ерөнхий сэдвүүд (n=2804)



сэргийлэх” (climate change mitigation) гэдгийг “уур амьсгалын өөрчлөлтөөс зайлсхийж, сэрэмжлэх арга замууд” гэж, харин “уур амьсгалын өөрчлөлттэй дасан зохицох” (climate change adaptation) гэдгийг “уур амьсгалын өөрчлөлтөд бэлтгэх, дасан зохицох арга хэмжээнүүд” гэдэг хэллэгээр найруулж оруулсан. Судалгааны үр дүнгээс харвал ард иргэд цаг үеийн өнгөц, уур амьсгалын өөрчлөлтөөс үүдэж буй үйл явдлуудын мэдээллээс илүү нарийн мэдлэг хүлээн авахыг хүсэж байна.

Судалгаагаар уур амьсгалын өөрчлөлттэй холбож болохуйц, ард иргэдийн дунд аль хэдийн эрэлт хэрэгцээ өндөр байгаа сэдвүүдийг илрүүлэхийг зорьсон. Хотын судалгаанд оролцогчид эрчим хүч хэмнэх, ус хэмнэх, агаар болон хөрсний бохирдлыг бууруулах арга замуудтай холбоотой сэдвүүдэд илүү ихээр сонирхож байсан бол орон нутгийн оролцогчдын дунд цөлжилтийг бууруулах, бэлчээрийн доройтлыг бууруулах, зооноз, халдварт өвчнөөс сэргийлэх арга зам болон байгалийн гамшигт үзэгдэлд бэлтгэх

зэрэг сэдвээр илүү их мэдээлэл авахыг хүсэж байгаага илэрхийлжээ.

Судалгаанд хэвлэл мэдээллийн салбараас оролцогчид уур амьсгалын өөрчлөлтийн сэдэв нь бусад сэдвүүдтэй харьцуулахад үзэгчдийн анхаарлыг харьцангуй бага татдаг хэмээн онцолж байв. Иймд уур амьсгалын өөрчлөлт ард иргэдийн өдөр тутмын амьдралд хэрхэн нөлөөлж буйг энгийн, ойлгомжтой байдлаар харуулах нь нэн чухал байна. Өдөр тутмын мэдээний сонингийн нэг сэтгүүлчийн хэлснээр:

“Хүмүүсийн өдөр тутмын амьдралд уур амьсгалын өөрчлөлтийн үзүүлэх нөлөөллийг ойлгуулахын тулд, үүнийг зүгээр байгаль орчны асуудал гэж харахаас илүү амьдралын бусад асуудалтай холбож үзэх нь амин чухал”.

НМонголд олон нийтийг уур амьсгалын өөрчлөлтийн тухай тогтмол, найдвартай мэдээллээр хангах хөтөлбөр, чанартай контентууд хомс байна. Гэвч уур амьсгалын өөрчлөлтийн сэдвээр мэдээлэл авах хэрэгцээ

ард иргэдийн дунд их буйг энэхүү судалгаа харуулж байна. Иймээс төрийн ба төрийн бус байгууллага, хэвлэл мэдээллийн байгууллага, иргэий нийгмийнхэн энэ боломжийг ашиглан иргэдийг тухайн орон нутагт хамааралтай, онцлогт нь тохирсон найдвартай мэдээллээр хангах шаардлагатай.

Монголын хүн амын олонх нь (судалгаанд оролцогчдын 76% нь уур амьсгалын талаарх өөрсдийн мэдлэгээ дунд зэрэг болон дундаас доогуур гэж үнэлсэн) нь уур амьсгалын өөрчлөлттэй холбоотой мэдээлэл хүлээн авсан, уур амьсгалын өөрчлөлт, дэлхийн дулаарал гэсэн нэр томъёог сүүлийн 12 сард хэвлэл мэдээллийн хэрэгслээс сонссон гэж хариулсан ч, түүнийг даван туулах ойлголт, арга замын талаарх мэдлэг дутмаг байна.

Судалгааны нэг оролцогч ихэнх хэвлэл мэдээллийн байгууллагуудын редакцийн бодлогод байгаль орчны сэдэв нь чухал байр суурь эзэлдэггүй талаар тодотгосон. Ялангуяа хэвлэл мэдээллийн байгууллагын редакциуд илүү цөөн сэтгүүлчтэй, илүү уламжлалт биш болж байгаа энэ цаг үед, олны анхааралд байдаггүй сэдвүүд орхигдох аюултай байдаг. Сэтгүүл зүйн нэгэн багш (эрэгтэй):

“Хэвлэл мэдээллийн байгууллагуудын редакциуд байгаль орчны сэдэв болон

уур амьсгалын өөрчлөлтийг өөрсдийнхөө редакцийн бодлогод стратегитэйгээр оруулж ирэхгүй л бол, энэ сэдэв хөндөгдөхгүй хэвээр байх болно. Энэ асуудлыг олны анхааралд оруулахын тулд төрийн, төрийн бус байгууллага, хэвлэл мэдээллийн редакциудад энэ сэдвийг онцлох тал дээр дэмжлэг үзүүлэх шаардлагатай байна” хэмээн онцолсон билээ.


Судалгааны дүнгээс харвал хэвлэл мэдээллийн хэрэгслээс уур амьсгалын өөрчлөлттэй холбоотой мэдээлэл хүлээн авах сонирхолтой хүмүүс, өнгөрсөн жил энэ төрлийн мэдээлэл авсан хүмүүсийн хооронд тооны ихээхэн ялгаа байна. Өнгөрсөн хугацаанд уур амьсгалын өөрчлөлтийн талаар мэдээлэл хүлээн авсан хүмүүс, уг асуудал, үүний нөлөөллийг даван туулах арга замуудыг ойлгодог хүмүүсийн хоорондын зөрүүг мөн анхаарууштай. Хэдийгээр нийт судалгаанд оролцогчдын бараг хагас нь “уур амьсгалын өөрчлөлт”, “дэлхийн дулаарал” гэсэн нэр томъёог сонссон боловч тун цөөхөн хүн (9.9%) уур амьсгалын өөрчлөлтийн үр дагавруудыг давж гарах арга замуудыг мэднэ гэж хариулсан байна. Судалгаанд оролцсон нийт оролцогчдын хувийг доор үзүүлэв.

Хүмүүс ихэвчлэн сүүлийн үед болсон байгалийн гамшгийн талаарх сурвалжлага буюу цаг


үеийн мэдээллийн дундуур л уур амьсгалын өөрчлөлтийн талаар сонссон байна. Энэ төрлийн мэдээллийг хүлээн авсан ихэнх хүмүүсийн эх сурвалж нь голдуу MNB News (48.2%), TV9 Монгол Коммент (11.6%), Малчин ТВ (7.1%) зэрэг мэдээний хөтөлбөр байсан байна.

Монголын Хэвлэлийн Хүрээлэнгийн сэтгүүлч, багш хэлэхдээ:

“Ихэнх тохиолдолд Монгол Улсын хэвлэл мэдээллийн байгууллагууд мэдээ мэдээлэх болон гадаад мэдээ орчуулах үед уур амьсгалын өөрчлөлтийн талаарх нэр томъёог дурддаг. Бараг бүх тохиолдолд хүмүүс ийм нэр томъёог барууны хэвлэл мэдээллийн хэрэгслээс ирсэн уур амьсгалын өөрчлөлтөөс үүдсэн байгалийн гамшгийн тухай олон улсын мэдээнээс сонссон байдаг.”



Зураг 67 Уур амьсгалын өөрчлөлтийн талаар мэдээлэл хүлээн авах хүсэлтэй хүмүүс, уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөг бууруулах арга замыг мэддэг хүмүүс хоорондын зөрүү (n=2804)



11. ХҮН АМЫН БҮЛГҮҮДИЙН МЭДЛЭГИЙГ ДЭЭШЛҮҮЛЭХ СТРАТЕГИ БОЛОН ГОЛ ОРОЛЦОГЧИД

Монголчуудын ихэнх нь амьдралынхаа туршид цаг агаарын эрс тэс үзэгдэл, хэмийн огцом өсөлт зэрэг цаг агаарын төлөв байдалд гарах өөрчлөлтийг биеэрээ мэдэрсэн гэдгийг энэ судалгаагаар олж тогтоосон. Гэвч нийт хүн амын, түүнчлэн иргэдийг мэдлэг мэдээллээр хангахад чухал үүрэг гүйцэтгэх учиртай төрийн болон орон нутгийн байгууллагын төлөөлөгч нар, иргэний нийгмийн байгууллага, хэвлэл мэдээллийн хэрэгсэл, сэтгүүл зүйн салбарынхан зэрэг гол оролцогч тал ч уур амьсгалын өөрчлөлтийн тухай ойлголтоор хязгаарлагдмал байна.

Уур амьсгалыг бий болгоод буй хүчин зүйлс, агаар мандал дахь хүлэмжийн хий хэт нэмэгдсэнээс уур амьсгал өөрчлөгдөж байгааг ард иргэд төдийлэн мэдэхгүй байна. Хүний үйл ажиллагаанаас болж уур амьсгалын өөрчлөлт болж буйг мэдэж байгаа ч, нарийн учир шалтгаан, холбоо хамаарлын талаарх үндсэн ойлголтоор тун дутмаг байна. **Малчид, тариаланчид гэсэн орон нутгийнхны ихэнх нь уур амьсгалын өөрчлөлтийн гол шалтгааныг уул уурхайн олборлолт, бэлчээрийн даацыг хэтрүүлэх зэрэг байгаль орчны түгээмэл асуудалтай холбон ойлгож байгаа бол, хот суурингийнхан хог хаягдал, агаарын бохирдол зэрэг уур амьсгалын өөрчлөлтийн шууд бус хүчин зүйлстэй холбож байна.**

Энэ бүлгээр бид уур амьсгалын өөрчлөлтийг хүн амын гол бүлгүүдэд ойлгуулах мэдлэг дээшлүүлэх контент, боломжууд, мэдээ



мэдээллийг хүргэхэд хамгийн үр дүнтэй сувгууд, харилцааны гол хэрэгсэл болон стратегийг хүн амыг найдвартай, тогтвортой уур амьсгалын өөрчлөлтийн мэдээллээр хангах, мэдлэг дээшлүүлэх чиг үүрэгтэй оролцогч талуудыг танилцуулах болно.

Монголчуудын уур амьсгалын өөрчлөлтийн талаарх ойлголтыг сайжруулахад тулгарч буй том бэрхшээлийн нэг нь энэ талын үйл ажиллагаанд манлайлал дутагдаж буй явдал юм. Хэдий бусад гол оролцогч тал дунд уур амьсгалын өөрчлөлтийн тухай мэдлэг мэдээлэл түгээх чиглэлээр манлайлах боломжтой олон тооны төрийн, төрийн бус байгууллага, агентлаг байгаа ч, нөөц бололцоо дутмаг, мөн уур амьсгалын өөрчлөлтөд хариу үзүүлэхэд олон нийтийг мэдээ мэдээллээр хангахыг чухалд үзэхгүй байгаатай холбоотой. Өнгөрсөн хугацаанд олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгслүүдээр энэ сэдвээр ард иргэдийн мэдлэгийг дээшлүүлэх нэлээд оролдлогууд хийгдэж байсан ч, байгууллагуудын хамтын ажиллагаа, хоорондын харилцаа холбоо дутмаг байснаас өргөн хүрээг хамарч, дорвитой үр нөлөө үзүүлж чадаагүй нь судалгаанаас харагдаж байна.

Холбогдох төрийн байгууллагууд ард иргэдийн мэдлэг чадваржуулах, мэдлэг мэдээллийг нэмэгдүүлэх, түгээх ба энэ төрлийн үйл ажиллагааны зохицуулалт хийх чиг үүрэгтэй байдаг ч тогтворгүй байдлаас болж үйл ажиллагаанууд нь үр өгөөж багатай байсаар байна. Шийдвэр гаргалт, бодлого боловсруулалт болон хэрэгжүүлэлтийн тал дээр олон талын оролцогчдын хамтын ажиллагааны тун дутмаг байна. Тиймээс, уур амьсгалын өөрчлөлтийн чиглэлээр мэдлэг мэдээлэл дээшлүүлэх тогтсон механизмийг бий болгож, манлайлалыг дэмжих нь энэ талаар мэдлэгийг үр өгөөжтэй дээшлүүлэх хамгийн чухал алхам байх болно. Тухайлбал уур амьсгалын өөрчлөлтийн мэдлэг дээшлүүлэх компанит ажлууд, ирээдүйн уур амьсгалын өөрчлөлт, харилцаа холбооны хүчин чармайлтуудыг тогтвортой хөгжүүлэх, энэ салбарт ажиллаж буй оролцогч талуудын хоорондын уялдаа холбоог сайжруулахад тусламж үзүүлж чадах, уур амьсгалын өөрчлөлтийн мэдлэгт тусгайлан зориулагдах санхүүгийн эх үүсвэр бүхий сан бий болгох боломжтой.

Мэдлэг дээшлүүлэхэд гарч буй бусад бэрхшээл нь хүн амын бүлгүүд, хэвлэл мэдээллийн хэрэгсэл, сонин зэрэг гол оролцогч талын дундах уур амьсгалын өөрчлөлтийн асуудлыг чухлаар авч үзэхгүй байгаа тал байна.

Монголчуудын анхааралд байдаг томоохон асуудлууд нь эрүүл мэнд, агаарын бохирдол, ажилгүйдэл, орлого болохыг олж тогтоосны зэрэгцээ, бага дурдагдсан асуудлын нэг нь байгаль орчин байв. Судалгаанд оролцогчдын хариулснаар, байгаль орчин нь Монгол Улсын хэвлэл мэдээллийн хэрэгсэл, сэтгүүлч нар, хэвлэл мэдээллийн байгууллага редакциудын хамгийн бага хандалт авдаг сэдвийн нэг гэсэн байна. Улс төр, эдийн засаг зэрэг бусад салбарт мэргэшсэнээс бага боломж болон урамшуулал ирдэг бөгөөд уг асуудлын ач холбогдлын талаар мэдлэг дутуу зэрэг шалтгаанаар нэвтрүүлэгч, сэтгүүлчид энэ сэдвээр хөөцөлдөх дургүй хэмээн өдөр тутмын нэгэн сонингийн сэтгүүлч дурдаж байсан. Гэхдээ, уур амьсгалын өөрчлөлтийн нөлөө, олон нийтийн санаа зовних асуудал хооронд хамаарал байгаа бол, энэ хоёрын харилцаа холбоог үр өгөөжтэй болгоход зууч болгон ашиглаж болно.

Уур амьсгалын өөрчлөлтийн талаар ойлголт бага, давах арга замуудын талаар мэдлэг бага байгааг боломж болгон ашиглах хэрэгтэй.

Судалгаагаар уур амьсгалын өөрчлөлттэй холбоотой найдвартай, тогтвортой мэдээлэл эрэлттэй болохыг харуулсан. Судалгаанд оролцогчдын олонх нь (85.4%) хэвлэл мэдээллийн хэрэгслээс энэ сэдвээр илүү мэдээлэл авах сонирхолтой байгаагаа илэрхийлсэн. Нутгийн захиргааны албан хаагч, төрийн албан хаагч, цаашлаад сэтгүүл зүй, хэвлэл мэдээллийн хэрэгслийн салбарынхан энэ талаарх олон нийтийн ойлголтыг нэмэгдүүлэхэд чухал үүрэгтэй нь уг эрэлт хэрэгцээнд нийцнэ гэсэн хүлээлттэй байгаа. Гэвч олон нийтэд мэдээлэх болон итгүүлэх чиг үүрэг бүхий хүмүүс мөн л энэ талаар ойлголт муутай, энэ чиглэлд ажиллах нөөц дутмаг байна.

Улсын төсвөөс санхүүжилтыг хязгаарлавал энэ талын ажилд зарцуулагдах гадаадын хөрөнгө оруулалттай санхүүгийн эх үүсвэрийг нэмэгдүүлэх зайлшгүй шаардлагатай. Түүнчлэн

хувийн хэвшлээс санхүүжүүлэх боломжийг хайх хэрэгтэй. Харилцаа холбоо, мэдээлэл, мэдлэг дээшлүүлэх санаачилгууд Монгол Улсын уур амьсгалын өөрчлөлтөд хариулт өгөх гол ажлууд байх болно. Энэ бүлгийн бусад хэсэг, судалгааны үр дүнг энэ ажилд ашиглаж болохуйц үр ашигтай стратеги төлөвлөгөө боловсруулахад дөхөм болно.

11.1 Олон нийтэд чиглэсэн стратеги төлөвлөгөө

Иргэд, олон нийтийн мэдлэгийг дээшлүүлэх стратегийг энэхүү судалгааны үр дүнд үндэслэн боловсрууллаа. Хүснэгт 18 дэлгэрэнгүй харуулсан стратегид зорилтууд, уур амьсгалын өөрчлөлтийг өөр өөр хүн амын бүлгүүдэд ойлгуулах, гол хүргэх санаа, үр өгөөжтэй сувгууд, арга барил, хийгдэх ажлууд, ирээдүйн мэдлэг дээшлүүлэх санаачилгад тус болох харилцааны гол сувгуудыг багтаасан болно.



Хүснэгт 18 Олон нийтэд зориулсан ерөнхий стратеги

	Хүн ам	Хотын хүн ам		Орон нутгийн хүн ам	
		Залуу хүн ам (35 нас хүртэлх)	Ахмад настай хүн ам (35 наснаас дээш)	Залуу хүн ам (35 нас хүртэлх)	Ахмад настай хүн ам (35 наснаас дээш)
Зорилтууд	1.1 Оролцогч талуудын дунд уур амьсгалын өөрчлөлтийн талаар нэгдсэн ойлголт бий болгох 1.2 Уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөгөөр давтамж, хор уршиг нь нэмэгдэж буй байгалийн гамшиг, үүнээс үүдэх урт хугацааны нөлөөг иргэдэд мэдээлэх, урьдчилан анхааруулах 1.3 Уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох талаар практик мэдлэг, ур чадваруудыг олгох 1.4 Оролцоог хангах замаар уур амьсгалын өөрчлөлтэй тэмцэхтэй холбоотой бодлого шийдвэрүүдийг шаардахад олон нийтийн оролцоог нэмэгдүүлэх				
Стратеги	1.1 “Фрэйминг” буюу Уур амьсгалын өөрчлөлтийн сэдвийг онцлох нь 1.2 Хувь хүний түүхүүдийг ашиглах 1.3 Айдас төрүүлэх тактик ашиглах 1.4 Нийгмээр хүлээн зөвшөөрөгдсөн хэм хэмжээ тогтоох стратеги ашиглах				

	Хүн ам	Хотын хүн ам		Орон нутгийн хүн ам	
		Залуу хүн ам (35 нас хүртэлх)	Ахмад настай хүн ам (35 наснаас дээш)	Залуу хүн ам (35 нас хүртэлх)	Ахмад настай хүн ам (35 наснаас дээш)
Хүргэх гол санаа	1.1 Хүмүүсийн анхаарлын төвд байдаг сэдвүүдэд уур амьсгалын өөрчлөлтийн нөлөө салшгүй холбоотой байдаг тухай 1.2 Уур амьсгалын өөрчлөлтийг бууруулах болон дасан зохицох чиглэлд иргэдийн авч болох арга хэмжээг түгээн дэлгэргүүлэх 1.3 Орон нутгийн, төрийн байгууллагын авах шаардлагатай арга хэмжээнүүд	3.1.1 Нийтийн эрүүл мэндийн асуудал, агаарын бохирдол, дэд бүтцийн дутагдал, боловсролын чанар болон боловсрол эзэмших асуудал 3.2.1 Эрчим хүчний хэрэглээг бууруулах арга замууд 3.3.1 Уур амьсгалын өөрчлөлтөд хариу үйлдэл үзүүлэх зорилгоор ашиглагдах орон нутгийн төсөв; Монголын төр энэ асуудалд ач холбогдох өгөх шаардлагатай	3.1.2 Нийтийн эрүүл мэндийн асуудал, агаарын бохирдол, дэд бүтэц 3.2.2 Эрчим хүчний хэрэглээг бууруулах арга замууд 3.3.2 Уур амьсгалын өөрчлөлтөд хариу үйлдэл үзүүлэх зорилгоор ашиглагдах орон нутгийн төсөв; Монголын төр энэ асуудалд ач холбогдох өгөх шаардлагатай	3.1.3 Нийтийн эрүүл мэнд, ажилүйдэл, бохирдол, дэд бүтэц, боловсролын чанар болон эзэмшилт, бэлчээрийн доройтол, малын менежмент 3.2.3 Уур амьсгалд таатай мал аж ахуй, тариалангийн практик 3.3.3 Уур амьсгалын өөрчлөлтөд хариу үйлдэл үзүүлэх зорилгоор ашиглагдах орон нутгийн төсөв; Монголын төр энэ асуудалд ач холбогдох өгөх шаардлагатай	3.1. 4 Нийтийн эрүүл мэнд, ажилүйдэл, бэлчээрийн доройтол, малын менежмент 3.2.4 Уур амьсгалд таатай мал аж ахуй, тариалангийн практик 3.3.4 Уур амьсгалын өөрчлөлтөд хариу үйлдэл үзүүлэх зорилгоор ашиглагдах орон нутгийн төсөв; Монголын төр энэ асуудалд ач холбогдох өгөх шаардлагатай
Үр өгөөжтэй сувгууд	1.1 ТВ сувгууд 1.2 Интернет болон социал мэдиа 1.3 Гар утас, мессэж ба хөтөлбөрт утсаар оролцуулах 1.4 Биечилсэн уулзалт, ажлууд	4.1.1 Movie Box, Education TV, Mongol TV 4.2.1 Facebook, Instagram, Youtube, Podcasts, ikon.mn 4.3.1 Мессэж мэдэгдэл, хөтөлбөрт утсаар оролцуулах 4.4.1 Сургуульд суурилсан ажлууд	4.1.2 MNB, TV9, Eagle TV, MN25 4.2.2 Facebook, ikon.mn 4.3.2 S Мессэж мэдэгдэл, хөтөлбөрт утсаар оролцуулах 4.4.2 Иргэд олон нийтийг хамруулсан арга хэмжээнүүд	4.1.3 MNB, TV9, Malchin TV 4.2.3 Facebook, Youtube, tsag-agaar.mn, zarig.mn 4.3.3 Мессэж мэдэгдэл, хөтөлбөрт утсаар оролцуулах 4.4.3 Сургуульд суурилсан ажлууд	4.1.4 MNB, TV9, Malchin TV 4.2.4 Facebook, tsag-agaar.mn, zarig.mn 4.3.4 Мессэж мэдэгдэл, хөтөлбөрт утсаар оролцуулах 4.4.4 Бүлгийн ажил

Зорилтууд

- Уур амьсгалын өөрчлөлтийн талаар нэгдсэн ойлголтыг бий болгож, энэ нь иргэдийн анхааралд байдаг асуудлуудтай хэрхэн холбогдож байгааг нэмэгдүүлэх – Стратегийн эхний зорилго нь хүн амын дунд уур амьсгалын өөрчлөлтийн шалтгаанууд, шууд, шууд бус нөлөө зэрэг үйл явцын талаар мэдлэг дээшлүүлэх, мэдээллийн чанартай мэдээгээр дамжуулан уур амьсгалын өөрчлөлтийн талаар нэгдсэн ойлголтыг бий болгох явдал юм. Ихэнх хүмүүс уур амьсгал өөрчлөгдөж байгааг мэдэж байгаа хэдий ч, тэр нь ямар процессоос бий болоод буй, түүнд нөлөөлөх хүчин зүйлийн талаар мэдлэг дутмаг байдаг нь тогтоогдсон. Цаашлаад, уур амьсгалын өөрчлөлтийн талаар ерөнхий ойлголт нь өөр өөр, заримдаа оролцогч талууд уур амьсгалын өөрчлөлтийн асуудал, агаарын бохирдлыг нэг ижил зүйл гэж хязгаарлагдмал хүрээнд ойлгох тохиолдол байна. Тиймээс нэгдсэн ойлголт, тайлбарыг олон нийт, оролцогч талуудад өгөх нь маш чухал юм.
- Уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөгөөр давтамж, хор уршиг нь нэмэгдэж буй байгалийн гамшгууд, үүнээс үүдэх урт хугацааны нөлөөг иргэдэд мэдээлэх, урьдчилан анхааруулах – Хоёр дахь зорилт нь гамшиг тулгарах бэлэн байдлыг хангаж уур амьсгалын өөрчлөлтөөс шалтгаалсан одоо, мөн ирээдүйд үүсч болох үзэгдлүүдийн талаарх цаг үеийн мэдээллээр иргэдийг хангаж, анхааруулах юм.
- Уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох талаар практик мэдлэг болон үр чадваруудыг олгох – Судалгааны үр дүнгээс харахад Монголчууд уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох талаарх практик мэдлэг, мэдээлэл байхгүй тул үүнийг сайжруулах Монгол Улс уур амьсгалын өөрчлөлтөд хариу үйлдэл үзүүлэх ажиллагааны чухал хэсэг болно.
- Оролцоог хангах замаар уур амьсгалын өөрчлөлтэй тэмцэхтэй холбоотой бодлого шийдвэрүүдийг шаардахад олон нийтийн оролцоог нэмэгдүүлэх – Стратегийн энэ сүүлчийн зорилт нь төрийн болон орон

нутгийн уур амьсгалын өөрчлөлтийн бодлогуудыг дэмжих ажиллагаанд олон нийтийг татан оролцуулах бөгөөд Монголчуудад тулгамдаж буй асуудлууд болон тэдний хэрэгцээний асуудлаар төрөөс олон улсын түвшинд илүү сайн төлөөлөн ажиллахад түлхэц болох юм.

Стратеги

- “Фрэйминг” буюу Уур амьсгалын өөрчлөлтийн сэдвийг онцлох нь – Уур амьсгалын өөрчлөлтийн нөлөө, олон нийтийн анхааралд байх асуудал болох эрүүл мэнд, агаарын бохирдол, эдийн засаг хоорондын харилцан хамаарлын талаар олон нийтийн ойлголтыг сайжруулахад тэдэнд хүргэх арга барил чухал үүрэгтэй. Үзэгчдэд аливаа зүйлийг тодорхой нэг өнцгөөс харуулдаг нийтийг хамарсан харилцааны арга барил болох “фрэйминг” стратеги нь аливаа мэдээллийг хүмүүс хэрхэн хүлээн авахад нөлөөлөх хүчтэй юм.⁵⁵ Хүмүүсийн өдөр тутмын амьдралд уур амьсгалын өөрчлөлтөөс болж гарах үр дагаврууд, эрүүл мэнд, эдийн засаг, үндэсний аюулгүй байдал, байгаль орчны асуудлууд зэргийг онцолж олон нийтэд хүргэх нь уур амьсгалын өөрчлөлтийн талаарх Монголын хүн амын ойлголтыг өөрчлөх болно.
- 2.2 Хувь хүмүүсийн түүх ашиглах – Хувь хүний түүхэд суурилан тодорхой сэдвийг хөндөх нь нь олон нийтийн анхаарлыг татах, сэтгэл хөдлөлтэй хариу үйлдэл үзүүлэх, уур амьсгалын өөрчлөлтөд хариу үйлдэл үзүүлэх асуудлыг хойшлуулахгүй авч үзэх гол хэрэгсэл байх болно. Оксфамын Судалгааны Аргачлалд дурдсанаар, хувь хүний түүхүүдийг ашиглах тактик нь нэг эсвэл бүлэг хүмүүсийн туршлага, жишээн дээр суурилан аливаа хөгжлийн асуудлыг хөндөх арга юм.⁵⁶ Уур амьсгалын өөрчлөлтөд өртсөн хүмүүс, бүлэг хүмүүсийн түүх нь илүү өргөн хүрээнд уур амьсгалд дасан зохицох туршлагаа олон

55 Нийтийн харилцааны онол, Олон нийтэд хүргэх онол – Практик хэрэглээний онол <https://masscommtheory.com/theory-overviews/framing-theory/>

56 Оксфам судалгааны аргачлал, Хүний сонирхол татах түүхийн судалгаа, 2019 https://www.academia.edu/6004930/Researching_human_interest_stories

нийттэй хуваалцах үр өгөөжтэй стратеги болно.

- Айдас төрүүлэх тактик ашиглах – Судалгааны үр дүнгээр Монголчууд уур амьсгалын өөрчлөлтөд нийтээрээ хариу үйлдэл үзүүлэхээс зайлсхийхэд хүргэж буй хүчин зүйлсийн нэг нь энэ асуудал тэдний өдөр тутмын амьдралд нөлөөлөхгүй гэж бодох, эсвэл энэ нь алс холын асуудал гэж хүлээж авдгийг олж тогтоосон. Тодорхой зан байдлыг өдөөхөөр уур амьсгалын мэдээлэгч нарын ашигладаг түгээмэл стратеги нь мэдлэг дээшлүүлэх компани ажуудад үр өгөөжтэй стратеги байх болно. Айдас төрүүлэх стратегийг үр дүнтэй санаа өгөх аргатай хослуулж, хүмүүсийг автсан айдсаас.⁵⁷ This strategy was recommended during multiple focus group discussions conducted as part of the research.
- Нийгмээр хүлээн зөвшөөрөгдсөн хэм хэмжээ тогтоох стратеги ашиглах – Энэхүү арга нь мэдлэг олгох, хандлагыг өөрчлөх, зан төлөвт бодитоор нөлөөлөх зэрэгт хэрэгтэй нэн чухал стратеги байх болно. Нийгмээр хүлээн зөвшөөрөгдсөн хэм хэмжээ тогтоох стратеги нь эргэн тойрны хүмүүсийн хандлага, зан үйл нь бидний өөрсдийн зан, үйлд дам, дам бус байдлаар нөлөөлдөг гэх нийгмийн маркетингийн арга юм.^{58 59}

Хүргэх гол санаанууд

- Хүмүүсийн анхаарлын төвд байдаг сэдвүүдэд уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөллүүд салшгүй холбоотой байдаг тухай. Жишээ нь:
 - Сүүлийн хэдэн арван жилийн аж үйлдвэржилтээс Хүлэмжийн Хий агаар мандалд их хэмжээгээр нэмэгдсээр байгаа нь хүний үйл ажиллагаатай холбоотой бөгөөд засгийн газраас

57 Victoria University of Wellington, Climate Catastrophe: Уур амьсгалын өөрчлөлтийн харилцаа холбоон дахь айдас төрүүлэх аргачлалын гүйцэтгэх үүрэг, 2022 https://openaccess.wgtn.ac.nz/articles/thesis/_Climate_Catastrophe_The_Role_of_Fear_Appeals_in_Climate_Change_Communication

58 Jessica M. Nolan, Уур амьсгалын өөрчлөлтийн өмнө хэрэгсэл болгон ашиглах Философи, нийгмийн хэм хэмжээний интервенцийн санал, 2021 <https://www.sciencedirect.com/science/article/pii/S2352250X21000701>

59 Үндэсний нийгмийн хэм хэмжээний төв, Michigan State University, Нийгмийн хэм хэмжээний хандлага, 2019 <https://care.berkeley.edu/wp-content/uploads/2019/07/Overview-of-the-Social-Norms-Approach.pdf>

хувь хүн хүртэлх бүх түвшинд түүнийг бууруулах, үр дагаварт нь дасан зохицох шаардлагатай арга хэмжээг даруй авах хэрэгтэй. Уур амьсгалын өөрчлөлтөд хариу үзүүлэх нь дан ганц засгийн газар эсвэл хувь хүний хариуцлага бус, харин нийгмийн бүх бүлгийн хүчин чармайлт шаардлагатай асуудал юм.

- Олон нийтийн эрүүл мэндийн асуудал болон агаарын бохирдол зэрэг Монголчуудад тулгарч буй томоохон асуудлууд бүгд ямар нэг байдлаар уур амьсгалын өөрчлөлттэй харилцан хамааралтай байна. Уур амьсгалын өөрчлөлт нь зөвхөн байгаль орчны биш, хүн бүрийн амьдралд заналхийлж буй асуудал юм.
- Уур амьсгалын өөрчлөлтийг бууруулах, дасан зохицоход иргэдээс авч болох арга хэмжээнүүдийг түгээн дэлгэрүүлэх
 - Уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицож, түүнийг бууруулахад таны авч хийж чадах, хувь нэмрээ оруулах олон үйлдэл, туршлага бий.
- Орон нутгийн болон төрийн байгууллагаас авах шаардлагатай арга хэмжээнүүд
 - Монгол орон бол уур амьсгалын өөрчлөлтөд хамгийн ихээр өртөж буй орнуудын нэг тул төр энэ асуудалд ач холбогдол өгч, холбогдох бодлого боловсруулж, хөрөнгө төсөвлөх шаардлагатай.

Үр өгөөжтэй сувгууд

Зурагт (73.6%), интернэт (63.7%) хоёр нь орон нутгийн болон хотод амьдардаг Монголчуудын аль алиных нь дундах түгээмэл мэдээллийн эх сурвалж болохыг судалгаа харуулсан. Тиймээс эдгээр сувгийг олон нийтийн дунд уур амьсгалын өөрчлөлтийн мэдлэг дээшлүүлэх нэвтрүүлгийн суваг болгож ашиглах хэрэгтэй. Интернэт, фейсбүүк нь залуу, хотын үзэгчдэд хүрэхэд үр дүнтэй платформ байх бол, илүү ахимаг насны, орон нутгийн хүн амд зурагт чухал суваг болох болно. Гэвч хэвлэл мэдээллийн хэрэгслээр компани ажил төлөвлөхөд хүмүүс зурагтаар гарч буй мэдээлэлд интернэтээс илүү итгэлтэй байдгийг анхааралдаа авах шаардлагатай. Ихэнх

хүмүүс фейсбүүкээс хүлээж авсан мэдээллийн эх сурвалжуудыг санадаггүй, ялгаж салгаж чаддаггүй бол, зурагтын сувгуудыг санах хандлагатай байсан.⁶⁰

Эдгээр шалтгааны улмаас, харилцаа холбоог дамжуулагчид дан ганц сувагт анхаарахаас гадна контентуудыг олон тооны суваг, интернэт, фейсбүүкээр түгээхэд төвлөрөх хэрэгтэй. Нөгөөтээгүүр, зурагтаар мэдээлэл нэвтрүүлэх сувгууд, цаг хугацааг нарийн төлөвлөж сонгох шаардлагатай. MNB, Малчин ТВ орон нутгийн хүн амд, Movie Box, Education TV, Монгол ТВ-ийн сувгууд хотын хүн амд хүрэх нь илүү байгаа бол, TV9-н сувгуудыг хүн амын аль аль бүлэгт ашиглаж болно. Контентуудыг орон нутагт оройн 6 цагаас 10:30 минутын хооронд, харин Улаанбаатарт оройн 7 цагаас 11:30 минутын хооронд зурагтын оргил цагаар нэвтрүүлэх нь үр дүнтэй байна.⁶¹

Интернэт болон социал медиа

Интернэт, социал медиа платформууд, ялангуяа фейсбүүкийг мэдлэг дээшлүүлэх зорилгоор нийт хүн амд хүрэхэд ашиглах нь үр дүнтэй суваг байх болно. Фейсбүүкээс гадна, илүү залуу (35-аас доош насны), хотын хүн амд инстаграмм, ютүби зэрэг платформ үр дүнтэй байна. Мэдээний вебсайтууд, тухайлбал ikon.mn сайт энэ бүлгийн дотор интернэтийн түгээмэл мэдээллийн эх сурвалж гэж тогтоогдсон бол tsag-agaar.mn, zarig.mn сайтууд залуу, орон нутгийн хүн амын дунд байгаль орчин, цаг агаартай холбоотой мэдээллийн эх сурвалжууд болох нь тогтоогдсон юм.

Гар утас, мессеж болон хөтөлбөрт утсаар оролцуулах

Монголчуудын дунд, эмзэг бүлгийн дунд ч гар утасны хэрэглээ сайн нэвтэрсэн тул, суртал ухуулга хийх ажлуудыг мессеж мэдэгдэл, утсаар дуудан хөтөлбөрт оролцуулах зэргээр гар утсаар дамжуулан хийх нь олон нийт болон хүн амын өөр өөр бүлэгт хүрэх үр өгөөжтэй сувгууд байх болно.

Биечлэн хийх уулзалт, арга хэмжээнүүд

60 Монголын хэвлэлийн хүрээлэн, IRI, Залуучуудын мэдээллийн хэрэглээний зан төлөв, боловсролын түвшин, 2020

61 Монголын хэвлэлийн хүрээлэн, Мэдээлэл хэрэглэгчийн судалгаа, 2015 https://mongolia.mom-rsf.org/uploads/tx_ifrogmom/documents/5-243_import.pdf

Биечлэн хийх уулзалт, арга хэмжээнүүд нь олон нийтэд хүрч, уур амьсгалын өөрчлөлтийн мэдлэг дээшлүүлэх хамгийн үр дүнтэй, өртөг өндөр сувгуудын нэг байж болно.

Арга барилууд ба хийгдэх ажлууд

Видео контентууд

- Айдас төрүүлэх болон нийгмээр хүлээн зөвшөөрөгдсөн хэм хэмжээ тогтоох стратегиудыг ашиглаж олон нийтийн дунд уур амьсгалын өөрчлөлттэй тэмцэх арга хэмжээнүүдийг сурталчлах,
- Боловсролын контентуудыг түгээж, уур амьсгалын өөрчлөлт хэрхэн болдгийг салбаруудын мэргэжилтнүүдээр тайлбарлуулах,
- Хэвлэл мэдээллийн хэрэгслийн контентуудаар болон Шийдлийн сэтгүүл зүй зэрэг сэтгүүл зүйн аргаар дамжуулан хүмүүс, нийгмийн бүлэг болон бусад орнуудын уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицохын тулд хэрэглэж буй арга болон сайн туршлагыг хуваалцах⁶²

Хэвлэмэл материалууд

- Байгаль орчныг хамгаалах уламжлалт туршлагыг баримтжуулж, илүү өргөн хүрээнд олон нийт, залуучуудад сурталчлах,
- Дасан зохицох туршлагын талаар гарын авлагыг бэлтгэж, тараах,
- Уур амьсгалын өөрчлөлттэй холбоотой бодлого, шийдвэрүүдийг хялбар бөгөөд олон нийтэд хүртээмжтэйгээр гаргаж, товч мэдээллүүдийг тараах.

Өргөн нэвтрүүлгийн хөтөлбөрүүд

- Боловсролын контентуудыг түгээж, уур амьсгалын өөрчлөлт хэрхэн болдгийг салбаруудын мэргэжилтнүүдээр тайлбарлуулах,
- Хөтөлгөч, цаг агаарын нэвтрүүлэгч нараар одоогийн үйл явдлыг уур амьсгалын өөрчлөлттэй холбож тайлбарлуулах,
- Шоу ярилцлага, утсаар дуудаж хөтөлбөрт оруулах ажил, олон нийтийн мэтгэлцээнээр

62 Шийдлийн сэтгүүл зүйн сүлжээ, Шийдлийн сэтгүүл зүй: Энэ юу вэ, би яагаад анхаарах ёстой гэж?, 2020 <https://thewholestory.solutionsjournalism.org/solutions-journalism-what-is-it-and-why-should-i-care-e5acd0ab5332>

дамжуулан санаа бодол, мэдээлэл, шалгарсан туршлага солилцох орчин бүрдүүлж, уур амьсгалын өөрчлөлтөд үзүүлэх хариу үйлдэл, авах арга хэмжээний талаар ойлголт өгч, үйл ажиллагаагаа төлөвлөх.

Мэдлэг дээшлүүлэх ажлууд

- Сургуулийн хөтөлбөр, хичээлээс гадуурх үйл ажиллагаануудаар дамжуулан хүүхэд, оюутнуудад уур амьсгалын өөрчлөлтийн үндсэн ойлголтын тухай мэдлэг олгох,
- Уур амьсгалын өөрчлөлтөд өртсөн хүмүүсийн фото зургийн үзэсгэлэнг баримттайгаар гаргах, нийтийн цэвэрлэгээний ажил зохион байгуулах гэх мэт олон нийтийг хамарсан үйл ажиллагаа зохион байгуулах.

Сошиал медиагаар хийх компани ажлууд

- Алдартай хүмүүс болон нөлөө бүхий манлайлагч нарын тусламжтайгаар айдас төрүүлэх, түүнчлэн уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох болон түүнийг бууруулах туршлагын талаар нийгмийн хэм хэмжээ бий болгох компани ажлуудыг болон сорилтуудыг сошиал медиагаар дамжуулан зохион байгуулах
- Уур амьсгалын өөрчлөлтэй холбоотой бодлого, шийдвэрүүдийг хялбар болон олон нийтэд хүртээмжтэй аргаар гаргаж, бодлогын талаар товч мэдээллийг тараах
- Уур амьсгалын өөрчлөлтийн үндсэн асуудлын талаар мэдээлэл өгөх мэдээллийн график, зурагт хуудаснуудыг боловсруулж тараах

Хийгдэх бусад ажлууд

- Мессеж, утсаар дуудаж оролцуулах хөтөлбөр, мэдээллийн чат-бот, мэдэгдлүүдээр дамжуулан гамшигт үзэгдэлд бэлтгэлтэй байхад зориулж, цаг агаарын ирж буй үзэгдлүүдийн тухай анхааруулга, мэдээлэл өгөх

Гол дамжуулагчид

Хэвлэл мэдээллийн байгууллагууд

Хэвлэл мэдээллийн байгууллагууд болон



уламжлалт ба уламжлалт бус хэвлэл мэдээллийн байгууллагуудын сэтгүүлч нар Монголын хүн амын дунд мэдлэг дээшлүүлэх болон уур амьсгалын өөрчлөлтийн ойлголтыг сайжруулахад голлох үүрэг гүйцэтгэх оролцогч нарын нэг байх болно. Тухайлбал, хамгийн нөлөөтэй бөгөөд нэрд гарсан сэтгүүлч нар болон сонингийн редакциуд уур амьсгалын өөрчлөлтийн мэдээллийн чанар болон тогтвортой байдлыг сайжруулахад голлох үүрэгтэй байна.

Цаг агаарын мэдээний нэвтрүүлэгч

Онлайнаар цаг агаарын мэдээ авах программ, бусад платформ нэмэгдэж байгаа ч олон хүн цаг агаарын мэдээний хөтөлбөрт анхаарал хандуулж, итгэдэг хэвээрээ байгаа нь судалгаанаас харагдсан. Тиймээс, мэдээг үзэгчдэд хүргэхдээ уур амьсгалын өөрчлөлтийн асуудлыг хөндсөн цаг агаарын мэдээний хөтөлбөрүүдээр энэ талын мэдээллийг харилцан солилцох нь их үр өгөөжтэй байх болно.

Олны танил хүмүүс, нөлөө бүхий манлайлагч нар

Нөгөөтээгүүр, алдартнууд, олонд танигдсан манлайлагч нар уур амьсгалын өөрчлөлттэй холбоотой олон нийтийн зан төлөв болон хандлагыг өөрчлөх мэдээлэл түгээх болон харилцаа тогтооход тустай байх болно. Энэхүү хүн амын бүлэгтэй харилцаа тогтоох ажиллагааг шинжлэх ухааны фактууд болон зөвшилцлөөс илүүтэй олон нийтийн одоогийн ойлголт дээр үндэслэн хийх шаардлагатай. Алдартнууд болон нөлөө бүхий манлайлагчид энэ сэдвээр итгэл төрөхүйц мэдээлэл өгнө гэж судалгаанд оролцогч нарын ердөө 1% нь хариулсан тул шинжлэх ухааны баримтыг олны танил хүмүүс, нөлөөлөгч нараар хэлүүлэх шаардлагагүй. Түүний оронд тэдгээрийг зөвхөн олон нийтийг хамарсан ярилцлага төдийгүй, харин олон нийтийн зан байдлыг өөрчлөх ажилд оролцуулна. Уур амьсгалын өөрчлөлтийн ажилд алдартнуудын гүйцэтгэх үүрэг эрүүл мэнд⁶³ болон байгаль орчныг оролцуулан⁶⁴ олон тооны

63 William J Brown & Michael D. Basil. Хэвлэл мэдээллийн салбарын алдартнууд болон нийтийн эрүүл мэнд: 'Magic' Johnson'-ы Хүний дархлалын вирусын талаар мэдээлэл илчлэх үед үзүүлсэн хариу үйлдэл болон түүний ДОХ өвчний эрсдэл болон өндөр эрсдлийн зан төлөвт үзүүлэх нөлөөлөл, 2009 https://www.tandfonline.com/doi/abs/10.1207/s15327027hc0704_4

64 Sejung Park, Twitter-т алдартнуудын өгөх ногоон мессеж уур амьсгалын өөрчлөлтийг сааруулахад чиглэгдсэн олон нийтийн хандлага, зан төлөвт

салбарт дэлхий даяар нийгмийн норм бүрдүүлэх, зан байдлын өөрчлөлтийг дэмжихэд үр дүнтэй гэдэг нь нотлогдсон. Шинжлэх ухааны өгүүлэлд өгүүлснээр, "Алдартнууд шинжлэх ухааны өгөгдөлгүйгээр олон нийтийн өдөр тутмын амьдрал дахь уур амьсгалын өөрчлөлттэй илүү сэтгэл хөдөлгөсөн, сэтгэлд мэдрэгдсэн урьд өмнө нь байгаагүй холбоо үүсгэх боломжтой. Орчин үеийн алдартнууд үзэгчид болон олон нийт уур амьсгалын өөрчлөлтийг хэрхэн мэдрэх ёстойг дүрслэхээр ажиллаж, олон нийтийг арга хэмжээ авахад хүргэх эсвэл тэдний зан байдлыг өөрчлөхөөр ажилладаг болсон"⁶⁵

ЦУОШГ болон ОБЕГ-н мэргэжилтнүүд

Гэр бүл, найз нөхөд болон хамаатан садан зэрэг хувийн холбоо хамаарал нь хамгийн итгэлтэй бүлгүүд байдаг бол хотын болон орон нутгийн аль аль Монголчуудын хувьд өөр үндэстний болон өөр шашны хүмүүс тэдний хамгийн бага итгэдэг бүлгийнхэн байна. ЦУОШГ болон ОБЕГ зэрэг байгууллагуудад хүмүүсийн итгэх итгэл орон нутгийн захиргаа болон хэвлэл мэдээллийн хэрэгсэл, сониноос илүү байсан тул эдгээр нь хамгийн итгэлтэй байгууллагууд хэмээн тогтоогдсон. Эдгээр байгууллагаас ирэх төлөөлөгчид болон мэргэжилтнүүд факт баримт түгээх болон уур амьсгалын өөрчлөлтийн одоогийн нөхцөл байдалд мэдээлэл гаргах улмаар нийт хүн амд төлөвлөгөө гаргаж өгөх хамгийн итгэл төрүүлэхүйц харилцааны суваг болж чадна. Монголчуудын хамгийн их сонирхдог түгээмэл уур амьсгалын өөрчлөлтийн сэдэв нь бууруулах стратеги (судалгаанд өгүүлснээр уур амьсгалын өөрчлөлтөөс зайлсхийж, сэргийлэх арга замүүд) ба дасан зохицох стратегиудын (судалгаанд тайлбарласнаар уур амьсгалын өөрчлөлтөд бэлтгэх болон зохицуулах арга хэмжээнүүдийг авах) араас уур амьсгалын өөрчлөлтийн шалтгаан болон нөлөөллийг тогтоох талаар сонирхож байгааг судалгаанаас олж мэдсэн. Хэрэв дээр дурдсан сэдвүүдийг авч үзвэл энэ байгууллагуудын гаргах мэдээлэл болон харилцаа холбоо хамгийн шилдэг байх болно. Судалгаанд оролцогчдын дийлэнх нь (74.6%) эрдэмтэд болон цаг уурчид уур амьсгалын өөрчлөлтийн талаар хамгийн итгэлтэй мэдээлэлтэй байдаг гэж хариулсан.

хэрхэн нөлөөлдөг вэ, 2020 <https://www.mdpi.com/2071-1050/12/19/7948>

65 Julie Doyle, Nathan Farrell and Michael K. Goodman, Алдартнууд болон уур амьсгал, 2017 <https://oxfordre.com/climatescience/display/>

Гэвч эдгээр агентлагууд болон хувь хүмүүсээс ирэх мэдээлэл нь өөр мэргэжил, боловсролтой хүмүүст ойлгогдох түвшинд байхаар дүрслэгдсэн байх шаардлагатай. Судалгаанд оролцогчид уур амьсгалын өөрчлөлтийн талаар харилцан ойлголцох энгийн хэллэгтэй байхын ач холбогдлыг онцолж байсан. Эдгээр агентлагууд болон хэвлэл мэдээллийн хэрэгслийн болон сонины мэргэжилтнүүдийн харилцаа болон суртал ухуулга нь эрдэмтэд болон нийт хүн амын хооронд ойлголтын завсар зайг нөхөж чадна. Энгийн бөгөөд шинжлэх ухааны хувьд хүчинтэй оюун санааны моделиудыг уур амьсгалын өөрчлөлт хэрхэн явагдаж байгаа талаар зүйрлэл ашиглан бүтээх нь олон нийтийн мэдлэг дээшлүүлэх эд чухал алхам болно.

ЦУОШГ болон ОБЕГ-н мэргэжилтнүүд

Гэр бүл, найз нөхөд болон хамаатан садан зэрэг хувийн холбоо хамаарал нь хамгийн итгэлтэй бүлгүүд байдаг бол хотын болон орон нутгийн аль аль Монголчуудын хувьд өөр үндэстний болон өөр шашны хүмүүс тэдний хамгийн бага итгэдэг бүлгийнхэн байна. ЦУОШГ болон ОБЕГ зэрэг байгууллагуудад хүмүүсийн итгэх итгэл орон нутгийн захиргаа болон хэвлэл мэдээллийн хэрэгсэл, сониноос илүү байсан тул эдгээр нь хамгийн итгэлтэй байгууллагууд хэмээн тогтоогдсон. Эдгээр байгууллагаас ирэх төлөөлөгчид болон мэргэжилтнүүд факт баримт түгээх болон уур амьсгалын өөрчлөлтийн одоогийн нөхцөл байдалд мэдээлэл гаргах улмаар нийт хүн амд төлөвлөгөө гаргаж өгөх хамгийн итгэл төрүүлэхүйц харилцааны суваг болж чадна. Монголчуудын хамгийн их сонирхдог түгээмэл уур амьсгалын өөрчлөлтийн сэдэв нь бууруулах стратеги (судалгаанд өгүүлснээр уур амьсгалын өөрчлөлтөөс зайлсхийж, сэргийлэх арга замууд) ба дасан зохицох стратегиудын (судалгаанд тайлбарласнаар уур амьсгалын өөрчлөлтөд бэлтгэх болон зохицуулах арга хэмжээнүүдийг авах) араас уур амьсгалын өөрчлөлтийн шалтгаан болон нөлөөллийг тогтоох талаар сонирхож байгааг судалгаанаас олж мэдсэн. Хэрэв дээр дурдсан сэдвүүдийг авч үзвэл энэ байгууллагуудын гаргах мэдээлэл болон харилцаа холбоо хамгийн шилдэг байх болно. Судалгаанд оролцогчдын дийлэнх нь (74.6%) эрдэмтэд болон цаг уурчид уур амьсгалын өөрчлөлтийн талаар хамгийн итгэлтэй мэдээлэлтэй байдаг гэж хариулсан.

Гэвч эдгээр агентлагууд болон хувь хүмүүсээс ирэх мэдээлэл нь өөр мэргэжил, боловсролтой хүмүүст ойлгогдох түвшинд байхаар дүрслэгдсэн байх шаардлагатай. Судалгаанд оролцогчид уур амьсгалын өөрчлөлтийн талаар харилцан ойлголцох энгийн хэллэгтэй байхын ач холбогдлыг онцолж байсан. Эдгээр агентлагууд болон хэвлэл мэдээллийн хэрэгслийн болон сонины мэргэжилтнүүдийн харилцаа болон суртал ухуулга нь эрдэмтэд болон нийт хүн амын хооронд ойлголтын завсар зайг нөхөж чадна. Энгийн бөгөөд шинжлэх ухааны хувьд хүчинтэй оюун санааны моделиудыг уур амьсгалын өөрчлөлт хэрхэн явагдаж байгаа талаар зүйрлэл ашиглан бүтээх нь олон нийтийн мэдлэг дээшлүүлэх эд чухал алхам болно.

Боловсролын байгууллагууд

Боловсролын байгууллага, баг, сурган хүмүүжүүлэгч нар олон нийтийн дунд бага наснаас нь эхлэн мэдлэг олгох асуудалд шийдвэрлэх үүрэг гүйцэтгэх болно. Судалгаанд оролцогчид уур амьсгалын өөрчлөлтийн талаар олон нийтэд мэдлэг олгоход боловсролын ач холбогдлыг онцолж байсан. Уур амьсгалын өөрчлөлтийн сэдвийг сургалтын стандарт хөтөлбөрт оруулах, энэ асуудлаар багш нарын мэдлэг, ойлголтыг сайжруулах нь Монголчуудын мэдлэгийг ахиулахад тус дөхөм болох алхам юм.

Уур амьсгалын өөрчлөлтөд өртсөн хүмүүс

Уур амьсгалын өөрчлөлтийн тухай харилцаа үүсгэхэд итгэлтэй харилцааны суваг болж үйлчилж чадах өөр нэг бүлэг нь уур амьсгалын өөрчлөлтөд өртсөн хүмүүс юм. Судалгаанд оролцогчдоос мэдэгдэхүйц тооны хүмүүс (9.1%) уур амьсгалын өөрчлөлтөд өртсөн хүмүүс уур амьсгалын өөрчлөлтийн талаар хамгийн сайн мэдээлэлтэй байгаа гэдэгт итгэлтэй байсан. Энэ бүлэг нь сайн туршлага, дасан зохицох арга, мөн бодлогыг сурталчлах болон олон нийтийн мэтгэлцээнд дэмжлэг үзүүлэхэд хамгийн тохиромжтой байх болно. Ирээдүйн харилцаа холбоонд зориулан эдгээр итгэлтэй харилцааны сувгуудаар дамжуулан орон нутгийн ба хотын хүн амд уур амьсгалын өөрчлөлтийн талаар ойлгуулах зарим туршлага, төлөвлөгөөг энэ бүлгийн үлдсэн хэсэгт танилцуулав.

11.2 Гол оролцогч талуудын чадварыг бэхжүүлэх стратеги төлөвлөгөө

Энэ хэсэгт бид судалгаанаас олсон чанартай үр дүнгүүд болон бусад баримт материалд үндэслэн уур амьсгалын өөрчлөлтийн ажилд харьяалагдах гол оролцогч талуудын мэдлэг, ойлголт болон үр чадваруудыг сайжруулах ерөнхий төлөвлөгөө боловсруулав.

Судалгааны үр дүнгийн дагуу, эрх мэдэлтнүүдэд мэдлэг, мэдээлэл, нийтлэг ойлголтыг системчилсэн байдлаар олгох нь чухал. Үндэстний түвшинд, 14 бүлэгт.⁶⁶ ялгаж, ангилсан уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох асуудлуудад хандах эрх мэдэл, үүрэг хариуцлага, чадвар бүхий нийт 89 оролцогч тал байна. Бид судалгаагаараа оролцогч талуудын 49 төлөөлөгчийг багтааж, 4 бүлэгт (Шийдвэр гаргагч нар болон төр, хувийн хэвшил, ЗГ-н бус болон мэргэжлийн байгууллагууд, хэвлэл мэдээллийн хэрэгсэл) хувааж, өөрсдийн ирээдүйн төлөвлөгөөг боловсрууллаа.

66 БОАЖЯ, УАНС, UNEP, Үндэсний дасан зохицох төлөвлөлтийн үйл явцад олон талт оролцогчдыг хамруулах стратегийн зураглал, 2021

Хүснэгт 19 Оролцогч талуудад зориулсан төлөвлөгөө

	Шийдвэр-гаргагч нар болон Төр	Хувийн хэвшил	Мэргэжлийн байгууллагууд (ТББ, судалгааны)	Хэвлэл мэдээллийн хэрэгсэл
Зорилгууд	<ul style="list-style-type: none"> Шийдвэр гаргагч нарт зориулан уур амьсгалын өөрчлөлтөд хамаарах мэдлэг, мэдээллийг болон бодлого төлөвлөлт, шийдвэр гаргах шатан дахь уур амьсгалын өөрчлөлтийн асуудлуудыг зохицуулах, авч үзэх үр чадваруудыг түгээх 	<ul style="list-style-type: none"> Оролцоог тодорхойлж, уур амьсгалын өөрчлөлтийн талбар дахь хүлэмжийн хийг тооцоолох, бүртгэх, тайлагнах нэгдмэл арга барилыг гаргах 	<ul style="list-style-type: none"> Амьд организмын амьсгалахад гардаг өөрчлөлтийн асуудлыг нийтэд мэдээлж, оролцогч талуудыг энэ сэдвээр судалгаа, академик мэдээлэл гаргах шаардлагатай мэдээлэл болон үр чадвараар хангах. 	<ul style="list-style-type: none"> Нэртэй сонины редакцын олонд танигдсан, нөлөөтэй сэтгүүлчид, редакторууд болон сурвалжлагч нарын ойлголтыг сайжруулах, Монголын уламжлалт болон уламжлалт-бус хэвлэл мэдээллийн хэрэгсэлд уур амьсгалын өөрчлөлтийн мэдээллийн чанар, тогтворт байдлыг сайжруулж, үзэгчдийн эрэлт хэрэгцээнд нийцүүлэх, Өөрсдийн редакторын бодлогодоо уур амьсгалын өөрчлөлтөд давуу эрх олгодог сонины реакциудын тоог нэмэгдүүлэх, Уламжлалт болон уламжлалт-бус хэвлэл мэдээллийн хэрэгслийн хүчин чадлыг нэмэгдүүлж, Монголд уур амьсгалын өөрчлөлтийн талаар илүү үр өгөөжтэй мэтгэлцээн явуулахад дэмжлэг үзүүлнэ. Сэтгүүлчдийн уур амьсгалын өөрчлөлтийн бодлогуудыг болон санхүүжилтийг дэмжих хүчин чадлыг бүрдүүлж, мөн тэдний ажил үүрэгт "хяналт" тавина.

	Шийдвэр-гаргагч нар болон Төр	Хувийн хэвшил	Мэргэжлийн байгууллагууд (ТББ, судалгааны)	Хэвлэл мэдээллийн хэрэгсэл
Үндсэн санаанууд	<ul style="list-style-type: none"> Монгол дахь одоогийн нөхцөл байдалд болон уур амьсгалын өөрчлөлтийн урт-хугацааны нөлөөллүүдэд ойлголт өгнө. Уур амьсгалын өөрчлөлтийг даван туулах болон түүнд дасан зохицоход мэргэжлийн байгууллагын судалгаа хийж, баримт материал гаргана. Уур амьсгалын өөрчлөлтийн асуудлуудыг бодлого, төлөвлөлт болон шийдвэр гаргах ажиллагаанд хэрхэн тусгах талаар санал зөвлөмж өгнө. 	<ul style="list-style-type: none"> Урт хугацааны бизнесийн давуу тал болон эрсдэлүүдийг тогтооно. Олон нийтийн болон хувийн хэвшлийн хамтын ажиллагааны боломжуудыг судална. Уур амьсгалын санхүүжилттэй холбоотой боломжуудын талаарх мэдлэгийг нэмэгдүүлнэ. Уур амьсгалын өөрчлөлтийг сааруулах, түүнд дасан зохицоход хувийн хэвшлийн үүрэг, оролцооны талаар мэдээлэл олох Манлайлал болон сайн жишиг тогтоосон хувийн хэвшлийн байгууллагуудыг тогтоож, эдгээрийг урамшуулж буй тогтолцоо, хууль дүрмүүдийг нийтлэх. Шалгарсан хэргийн судалгаануудыг нийтлэх 	<ul style="list-style-type: none"> Уур амьсгалын өөрчлөлтийг даван туулах болон түүнд дасан зохицох ажиллагаа дахь олон нийтийн оролцоо, үүргийн талаар олон нийтэд таниулах, Уур амьсгалын өөрчлөлтийн одоогийн болон урт-хугацааны нөлөөллүүд. 	<ul style="list-style-type: none"> Уур амьсгалын өөрчлөлтийн сэдэв нь зөвхөн байгаль орчинд бус, бүх салбарт хамааралтай тул энэ нь анхаарал татсан сэдвийн нэг болох болно. Уур амьсгалын өөрчлөлттэй холбоотой мэдээллийн хэрэгцээ, ялангуяа уур амьсгалын өөрчлөлтийг олон нийтийн зүгээс бууруулах, дасан зохицох тал дээр их байгаа. Анхаарал татсан сэдвүүдийн нэг болсон болохоор уур амьсгалын өөрчлөлтийн сэдвийг хамааруулж буй сэтгүүлч нар болон сонины реакциудад илүү санхүүжилт олгох бөгөөд мэргэжилдээ ахих боломжууд олноор нээгдэх болно.
Үр дүнтэй сувгууд	<ul style="list-style-type: none"> Албан ёсны сургалт, семинар Төрийн байгууллагын уулзалт, хурлууд Холбогдох оролцогч талуудад хамаарах хэлэлцүүлэг болон уулзалт хийх 	<ul style="list-style-type: none"> Хамтын ажиллагаа эхлүүлэх уулзалтууд, мэдээлэл солилцох болон танилцуулга хийх хурлууд Олон нийтийн хэлэлцүүлэг ба уулзалтууд Сошиал медиа (зурагт, сошиал медиа платформууд) 	<ul style="list-style-type: none"> Мэдлэг дээшлүүлэх оролцоот ажлууд- шинжлэх ухаанд үндэслэсэн хэвлэл, гарын авлага, брошур. 	<ul style="list-style-type: none"> Сэтгүүлчдийн клубүүд Хэвлэл мэдээллийн хэрэгслийн болон сонины агентлагуудын холбоод Сэтгүүл зүйн сургуулиуд Сошиал медиа хуудаснууд болон сэтгүүлчдийн бүлгүүд Мэдээллийн самбарууд, мэйлүүд болон утасны лавлах.
Харилцааны гол сувгууд	<ul style="list-style-type: none"> Уур амьсгалын өөрчлөлтөөр мэргэшсэн сургагч, эрдэмтэд Салбарын мэргэжилтэн, судлаачид Уур амьсгалын өөрчлөлтийн асуудлыг хариуцсан төрийн захиргааны байгууллагын нэгжүүд болон албан тушаалтнууд 	<ul style="list-style-type: none"> Уур амьсгалын өөрчлөлт хариуцсан төрийн агентлагуудын төлөөлөгчид Худалдаа, Аж Үйлдвэрийн Танхимын холбогдох нэгжүүд ба албан хаагчид Хувийн байгууллагуудын төлөөлөл Монголын Банкны Холбоо 	<ul style="list-style-type: none"> Уур амьсгалын өөрчлөлт хариуцсан төрийн байгууллагын төлөөлөгч Салбарын нэр хүнд бүхий эрдэмтэд болон судлаачид 	<ul style="list-style-type: none"> Сонины редакцын редакторууд Энэ асуудлаар аль хэдийн ажиллаж эхэлсэн байгаль орчны сэтгүүлч нар Уур амьсгалын өөрчлөлтийн мэргэжилтнүүд Хөгжүүлэлтийн партнерууд болон Төрийн бус байгууллага/иргэний нийгмийн байгууллагууд

	Шийдвэр-гаргагч нар болон Төр	Хувийн хэвшил	Мэргэжлийн байгууллагууд (ТББ, судалгааны)	Хэвлэл мэдээллийн хэрэгсэл
Стратегиуд	<ul style="list-style-type: none"> - Олон оролцогч талтай ажиллах нэгдсэн стратеги төлөвлөгөө, - Уур амьсгалын өөрчлөлтийн гол бүсүүдэд мэдлэг дээшлүүлэх болон хүчин чадлыг сайжруулах хүчин чармайлтуудад бүхэлд нь зохицуулалт хийх. 	<ul style="list-style-type: none"> - Хувийн хэвшлийн оролцоог идэвхжүүлэх урамшуулал, харилцааны аргуудыг танилцуулах. 	<ul style="list-style-type: none"> - Тогтмол, тогтвортой хамтын ажиллагаа, мэдээллийн солилцоог урьтал болгох, олон нийтэд мэдээлэл өгөх - Бүлгүүдэд болон оролцогч талуудад мэдээлэл түгээх стратегийг нэгтгэх. 	<ul style="list-style-type: none"> - Хамгийн түгээмэл сонины редаксаас хамгийн нөлөөтэй бие даасан сэтгүүлчид болон редактор, сурвалжлагч нарыг онцолж, хүчин чадлаа бататгах, - Сэтгүүлчдийг зоригжуулах болон бэхжүүлэх урамшууллын стратегийг ашиглах.
Арга барил/хийгдэх ажлууд, арга хэмжээ	<ul style="list-style-type: none"> - Сургагч/дадлагажуулагч нарыг сургах - Цуврал сургалт зохион байгуулах - Гол/эмзэг бүсүүдэд тохирсон хүчин чадлыг бий болгох 	<ul style="list-style-type: none"> - Хувийн хэвшлийн байгууллагуудад хамтран ажиллах боломжтой талаар ойлгуулах - Уулзалт/хэлэлцээр хийх - Сурталчилгааны болон урамшуулалт хөтөлбөр болон контентыг гаргах 	<ul style="list-style-type: none"> - Хамтран ажиллах боломжийн мэргэжлийн байгууллагуудыг тогтоох, ангилах мөн ярилцах - Уулзалт, хэлэлцээр хийх - Сурталчилгааны болон урамшуулалт хөтөлбөр болон контентыг гаргах 	<ul style="list-style-type: none"> - Зорилтот бүлгийн сэтгүүлчид болон хэвлэл мэдээллийн хэрэгслийн мэргэжилтнүүдийн дунд жил тутмын Уур Амьсгалын Тайлан гаргах Хамтын хөтөлбөр бий болгох - Уур амьсгалын тайлан гаргасан сэтгүүлч нар болон сонины редакцуудын дунд тэтгэлэг олгох боломж санал болгох - Бүх сэтгүүлчид болон сонины редакцуудын дунд уур амьсгалын тайлан гаргах тэмцээн зохион байгуулах - Сэтгүүлчид болон сонины редакцуудын гаргасан нийтлэлүүд болон контентуудад хамаарах бүх уур амьсгалын өөрчлөлттэй холбоотой онлайн платформ үүсгэх - Бүх сэтгүүлчдийн дунд мэдээлэл хуваалцах зөвлөгөөнийг тогтмол зохион байгуулах

Шийдвэр гаргагч нар болон төр

Шийдвэр-гаргагчид болон төрийн бусад байгууллагууд “уур амьсгалын өөрчлөлтийн асуудлыг чухал асуудал гэж үздэггүй” болох нь чанарын судалгааны үр дүнгээс илэрхий харагдсан. Уур амьсгалын өөрчлөлтийн хурд болон үр дагавар нь жилээс жилд нэмэгдэж байгаа гэдэгт эрдэмтэд итгэлтэй байгаа ба Монгол орон түүнд хамгийн их өртсөн орны нэг хэвээр байна. Манай орны хувьд, бид уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөллийг бууруулах болон байгаль орчныг хамгаалах зэрэг асуудлуудад анхаарал хандуулахын оронд бид эдийн засгийн хөгжилд үндэслэсэн бодлогын төлөвлөлт гаргахад анхаарлаа хандуулж байна.

Тийм учраас, шийдвэр гаргагчдын болон төрийн байгууллагуудын түвшинд доорх асуудлуудаар мэдлэг, мэдээлэл олгож, энэ салбарт тэдний үр чадварыг сайжруулах зайлшгүй шаардлагатай байна.- “Монгол дахь уур амьсгалын өөрчлөлтийн одоогийн нөхцөл байдал хэрхэн өөрчлөгдөх вэ, үүний ирээдүйн хандлагууд болон нөлөөллүүд эдийн засгийн хөгжил болон нийгмийн хөгжилд үрт хугацаанд нөлөөлөх болно, бодлого төлөвлөлт болон шийдвэр гаргалт дахь уур амьсгалын өөрчлөлтийн асуудлуудыг хэрхэн авч үзэх вэ, салбар хоорондын зохицуулалтыг хэрхэн уялдаа холбоотой болгох вэ гэх мэт асуудлууд байна.” Мөн, шийдвэр гаргагч нар болон төрийн байгууллагын албан тушаалтнуудыг судалгаа болон салбарын статистик мэдээлэлд тулгуурлан ухаалаг, нотолгоо болон шинжлэх ухаанч шийдвэр гаргахад дэмжлэг үзүүлэх зайлшгүй шаардлагатай байна.

Чанарын судалгааны үр дүнгээс харахад, бодлогын шийдвэр болон амьсгалын өөрчлөлтийг сааруулах, дасан зохицох ажлуудын төлөвлөгөөнд уур амьсгалын өөрчлөлтийн асуудлуудыг авч үзэх үед дараах асуудал нийтлэг ажиглагдаж байсан. Үүнд:

- Шийдвэр гаргагчид, төрийн байгууллагад уур амьсгалын өөрчлөлтийн талаар илүү мэдлэг, ойлголт шаардлагатай байгаа ба салбарууд, холбогдох асуудал хоорондын нягт уялдаа холбоог хөгжүүлэх хэрэгтэй.
- Уур амьсгалын өөрчлөлтийг чухал асуудал гэж үздэггүй учир үүнийг жагсаалтын доогуур байрлуулсан.

- Уур амьсгалын өөрчлөлтийг зөвхөн байгаль орчны асуудлуудыг хариуцсан төрийн захиргааны төв байгууллагын асуудал гэж үзэх хандлага байдаг.

- Хэдийгээр тэд үндсэн салбарын оролцоо, хувь нэмрийг ойлгодог ч, хэрхэн хувь нэмэр оруулахаа мэддэггүй.

- Уур амьсгалын өөрчлөлтийн асуудлуудыг засгийн газрын мөрийн хөтөлбөр болон орон нутгийн дунд болон урт-хугацааны стратеги төлөвлөлтөд орон нутгийн түвшнээр тусгахгүй бол энэ чиглэлээр арга хэмжээ авах боломжгүй болно.

- Улс төрийн намын сонгуулийн тогтолцооноос болж, энэ асуудлын шийдэлд сөргөөр нөлөөлөх албан тушаалтан солигдох, төрийн албан хаагчдын тогтворгүй байдал түгээмэл байна. Үүнээс шалтгаалан бодлогын залгамж холбоо алдагдаж, цаашдаа асуудлыг үр өгөөжтэйгөөр хэрэгжүүлэх боломжгүй болгоно.

- Салбарын түвшинд уур амьсгалын өөрчлөлт хариуцсан албан тушаалтан байхгүй: үүнийг хувааж хариуцдаг. Уур амьсгалын өөрчлөлтөд хамаарах даалгаварт ажлууд нэмэлт ажил байдлаар гүйцэтгэгдэж байгаа ба үндсэн ажлын гүйцэтгэх үүргүүдэд багтаагүй.

- Ихэнх хүмүүс Монгол бол уур амьсгалын өөрчлөлтөд хамгийн их өртөгдсөн орнуудын нэг гэдгийг хүлээн зөвшөөрөх боловч уур амьсгалын өөрчлөлтийн дэлхийн уур амьсгалын өөрчлөлтөд үзүүлэх нөлөөлөл нь бага түүнчлэн үүнээс ялгарах Хүлэмжийн Хий маш бага хэмжээтэй гэж итгэдэг.

Ийм учраас, эдгээр асуудлыг анхааралдаа авч, үндсэн санааг оролцогч талуудад хүргэх үед эдгээрийг алхам алхмаар шийдвэрлэх нь чухал байна.

Гол санааг төрийн байгууллагын албан тушаалтнуудад хүргэхэд дараах ажлууд хийгдэх болно:

- Сургагчдыг бэлтгэх: уур амьсгалын өөрчлөлтийн бүх оролцогч талуудад мэдлэг, мэдээллийг дамжуулах

чадвартай мэргэжлийн сургагчдыг бэлтгэхэд өмнө дурдсанаар зөвхөн уур амьсгалын өөрчлөлтийг хариуцсан ажилтан байхгүй бөгөөд энэ ажлыг өөр ажилтнаар түр хавсран гүйцэтгүүлж байна. Үүнийг хийхийн тулд хэрэв бид мэргэжлийн холбоод болон төрийн бус байгууллагуудтай хамтарсан бэлтгэл хийвэл илүү үр дүнтэй болно.

- Төрийн байгууллагын институтууд болон шийдвэр гаргагчдад өөр түвшинд сургалт зохион байгуулах: Сургалт, семинар нь төрийн байгууллагууд болон шийдвэр гаргагч нарт мэдлэг, мэдээлэл өгөх үндсэн зам юм. Гэвч энэ ажлыг олон нийтэд зориулахаас гадна, салбар салбараар, түвшин бүрээр зохион байгуулах зайлшгүй шаардлагатай ба уялдаа холбоог хангуулна. Үүний тулд 1-2 удаагийн сургалт зөвлөгөө хийх биш, цуврал байдлаар болон системтэйгээр зохион байгуулбал илүү үр өгөөжтэй болно.

Хувийн хэвшил

Энэ стратеги нь тээвэр, барилга, эрчим хүч, хөдөө аж ахуй, хог хаягдал болон ойн аж ахуйн салбарын дунд болон том үйлдвэрүүдэд чиглэсэн. Хувийн хэвшилд хүргэх үндсэн санаа нь төрийн болон хувийн хэвшлийн хооронд хамтран ажиллах боломжийн тухай, уур амьсгалын өөрчлөлтийг сааруулах болон түүнд дасан зохицоход хувийн хэвшлийн үүрэг, оролцоо, түүнчлэн уур амьсгалын өөрчлөлтөөс үүдсэн эрсдэлүүд болон боломжуудын талаар мэдээлэл юм. Үүнээс гадна, энэ чиглэлээр манлайлал гаргаж, сайн, шалгарсан жишиг тогтоосон хувийн хэвшлийн байгууллагуудыг урамшуулах, хууль, дүрэм, журам батлах, түүнчлэн шалгарсан жишгийг олон нийтэд түгээх нь үр ашигтай гэж үздэг.

Түүнчлэн Хүлэмжийн Хийн чиглэлээр дагнан үйл ажиллагаа эрхэлдэг хувийн хэвшлийн байгууллагуудад уур амьсгалын өөрчлөлтийг сааруулах болон түүнд дасан зохицох ажилд оролцохын ач холбогдлыг мэдээлэх нь чухал байна бөгөөд хэрэв тэдгээрийн хангалтгүй

хэмжээнд үзүүлсэн хариу арга хэмжээ тэдгээрийн үйл ажиллагаанд сөргөөр нөлөөлж болзошгүй юм.

Гол санаагаа дараах ажлуудаар дамжуулан хувийн хэвшлийн байгууллагуудад хүргэх нь илүү үр дүнтэй.

- Хамтран ажиллах боломжтой хувийн хэвшлийн байгууллагуудыг олж тогтоож, ангилах: гол салбаруудад (тээвэрлэлт, барилга, эрчим хүч, хөдөө аж ахуй, хог хаягдал болон ойн аж ахуй) үйл ажиллагаа явуулж байгаа дунд болон том хэмжээний хувийн байгууллагуудыг олж тогтоож, хамтран ажиллах, ирээдүйд бизнесийн эрсдэлтэй эсэхийг мэдэх, боломжуудын талаар мэдлэг, ойлголт өгөх болон тэдэнтэй ярилцах.
- Уулзалт, хэлэлцээр зохион байгуулах.
- Тэргүүлэх чиглэлийн хувийн хэвшлийн байгууллагуудыг олж тогтоож, дэмжлэг үзүүлэх бөгөөд тэдэнд урам зориг өгөх контентуудыг бэлтгэх: Ажиллагааг явуулахдаа эрчим хүчний хэмнэлттэй бөгөөд бага хүчин чадлын зарцуулалттай тоног төхөөрөмж нэвтрүүлэхийг урамшуулах дүрэм, журмуудын механизмуудыг дэмжих. Түүнчлэн банкны болон санхүүгийн байгууллагуудтай хамтран ажиллахад ногоон зээлийн шаардлагууд болон шалгуур, хүүгийн ханш болон бусад санхүүжилтийн эх сурвалжуудыг эрэлхийлж, арга замыг ярилцах.

Төрийн бус байгууллагууд, мэргэжлийн холбоод

Төрийн болон хувийн хэвшлийн байгууллагуудаас гадна төрийн бус байгууллага, мэргэжлийн холбоод уур амьсгалын өөрчлөлтийг сааруулах, түүнд дасан зохицох ажиллагаанд чухал үүрэгтэй байна. Эдгээр байгууллагын хүргэх үндсэн санаа нь “уур амьсгалын өөрчлөлтийг даван туулах, түүнд дасан зохицоход тэдний үүрэг, оролцоог олж тогтоох, зайлшгүй шаардлагатай мэдээлэл, сүүр судалгаа, үнэлгээний өгөгдлийг цуглуулах, шаардлагатай хамтын ажиллагааг тогтоож, бэхжүүлэх нь чухал. Ингэснээр тэд хөгжлийн явцад тулгарч болох уур амьсгалын өөрчлөлтийн сөрөг нөлөө, саад бэрхшээлийг хямрал багатайгаар даван туулахын тулд

өөрсдийн нөөц боломжийг үр өгөөжтэйгөөр удирдах боломжтой болох юм”.

Нотолгоо болон шинжлэх ухааны судалгаанд үндэслэн шийдвэр гаргах зарим төрийн бус байгууллага болон мэргэжлийн холбоодтой ажиллах нь төрд ашигтай байж болно. Жишээ нь, бэлчээрийн хэрэглээний тооцооллыг “Монголын Бэлчээр Ашиглагчдын Нэгдэл”-ээр гүйцэтгүүлэх болон нүүрстөрөгчийн давхар исэл шингээх тооцооллыг “Монголын Ой Судалгааны Нийгэмлэг”-ээр гүйцэтгүүлэх шаардлагатай гэх мэт. Мөн төрийн байгууллагуудын статистик мэдээллийг нээлттэй хуваалцаж, эдгээр өгөгдлийг шийдвэр гаргахад ашиглах нь чухал юм.

Эдгээр гол санааг доорх ажлыг гүйцэтгэх замаар төрийн бус байгууллага, мэргэжлийн холбоодод хүргэх нь илүү үр дүнтэй.

- Хамтран ажиллах боломжтой хувийн хэвшлийн байгууллагуудыг олж тогтоож, ангилах: Гол салбаруудад үйл ажиллагаа явуулж буй (тээвэрлэлт, барилга, эрчим хүч, хөдөө аж ахуй, хог хаягдал болон ойн аж ахуй) хувийн хэвшлийн дунд болон том байгууллагуудыг олж, хамтран ажиллах боломжийг ярилцах,
- Уулзалт, хэлэлцээр зохион байгуулах.
- Голлох салбаруудын төрийн бус байгууллага болон мэргэжлийн холбоодтой хамтран ажиллахад судалгаа, анализ, нөлөөлөл үзүүлэх ажлуудыг зохион байгуулах, гэх мэт. Судалгаа, анализ болон зөвлөх үйлчилгээний үр дүнгүүдийг тогтмол хүргүүлж, шийдвэр гаргагч нарт тайлагнаж байх хэрэгтэй.

Хэвлэл мэдээллийн хэрэгсэл ба сэтгүүлч нар

Гол санааг урамшуулал болон учир шалтгаанд чиглэсэн доорх аргуудаар дамжуулан төрийн бус байгууллагууд болон мэргэжлийн холбоодод хүргэх нь илүү үр өгөөжтэй болно:

- Зорилтот бүлгийн сэтгүүлч нар болон хэвлэл мэдээллийн мэргэжилтнүүдийн дунд жил бүрийн Уур Амьсгалын Тайлан гаргах Хамтын хөтөлбөр бий болгох,
- Уур амьсгалын тайланг гаргасан бүх сэтгүүлч болон сонины редакцуудын дунд тэтгэлэг зарлах,

- Бүх сэтгүүлчид болон сонины редакцуудын дунд уур амьсгалын өөрчлөлтийн тайлан гаргах тэмцээнийг бэлэн мөнгөн шагнал эсвэл зөөврийн компьютер, камер болон мэргэжлийн үр чадварт нь дэм болох өөр тоног төхөөрөмж зэрэг хувилбарт шагналуудтайгаар зохион байгуулах,
- Сэтгүүлчид болон сонины редакцуудын гаргасан уур амьсгалын өөрчлөлттэй холбоотой бүх нийтлэл болон контентуудад холбогдсон онлайн платформыг үүсгэж, уур амьсгалын өөрчлөлтийн талаарх найдвартай мэдээлэл болон нөөц боломжуудыг олон нийт ашиглахад нээлттэй болгох. Энэ платформ нь цаашилбал сэтгүүлч нарт хэрэгтэй холбогдох өгөгдөл болон нөөц материалуудыг агуулсан байж болно.
- Оролцогч нарыг дэлхийн уур амьсгалын чуулга уулзалт болон COP зэрэг хуралд оролцуулах урамшуулал болон шагналаар шагнаж болно.
- Орон нутагт болон олон улсад ажиллаж байгаа бүх сэтгүүлч нарын дунд мэдээлэл солилцох зөвлөгөөнийг тогтмол зохион байгуулж, уур амьсгалын өөрчлөлтийн тайлан гаргасан сэтгүүлчид тэтгэлэг олгоно.

ХАВСРАЛТУУД

Хавсралт 1. Нэр томьёоны тайлбар

Нэр томьёо	Тодорхойлолт
Дасан зохицох	Бодит болж буй эсвэл бий болох гэж буй уур амьсгалын өөрчлөлт, тэдгээрийн нөлөөллийн хариуд хор хөнөөлийг бууруулах эсвэл үр ашигтай боломжуудыг ашиглахад чиглэсэн байгалийн болон хүний тогтолцоонд хийж буй зохицуулалт. ¹
Дасан зохицох чадавх	Уур амьсгалын өөрчлөлтийн асуудлаар Засгийн газар хоорондын хорооны тодорхойлсноор дасан зохицох чадвар гэдэг нь болзошгүй хохирлыг бууруулах, боломжуудыг ашиглах эсхүл гарсан үр дагаврыг даван туулах зэрэг уур амьсгалын өөрчлөлтөд зохицуулга хийх системийн чадамж бөгөөд энэ нь олон утгаараа тэсвэрлэх чадвартай холбогддог ойлголт юм.
Антропоген гаралтай хүлэмжийн хий	Хүний үйл ажиллагаанаас үүдэлтэй хүлэмжийн хийн ялгаруулалт
Хандлага	Хандлага гэдэг нь тодорхой нөхцөл байдалд тодорхой байдлаар хариу үйлдэл үзүүлэх байдлыг хэлдэг; үйл явдлыг тодорхой урьдач нөхцөл байдлын дагуу харж, тайлбарлах; эсвэл санал бодлоо уялдаа холбоотой, харилцан уялдаатай бүтэц болгон зохион байгуулахыг илэрхийлнэ. ²
Ойлголт (уур амьсгалын өөрчлөлт)	Ямар нэг зүйл байгаа гэдгийг мэдэх, эсвэл мэдээлэл, туршлага дээр үндэслэн тухайн үеийн нөхцөл байдал, сэдвийг ойлгох. ³
Нүүрстөрөгчийн шингээлт	Агаар мандлаас нүүрстөрөгчийг барьж авах буюу зайлуулж, хадгалах үйл ажиллагаа юм. ⁴
Уур амьсгалын өөрчлөлт	Уур амьсгалын өөрчлөлт гэдэг нь температур, цаг агаарын төлөв байдалд гарч буй урт хугацааны өөрчлөлт юм. ⁵
Уур амьсгалын өөрчлөлтийг нэвтрүүлэх нь	Уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох зохих арга хэмжээг тогтвортой хөгжлийн бодлогын төлөвлөлт болон салбарын бодлогыг боловсруулалтад шууд тусгах, нэвтрүүлэх
Харилцаа (уур амьсгалын өөрчлөлтийн)	'Харилцаа' гэдэг нь нийгмийн бүлгүүд хооронд мэдээлэл солилцох үйл явц бөгөөд энэ нь хүн хоорондын харилцаа эсхүл олон нийтийн харилцаа зэрэг олон төрлийн сувгаар дамжуулан уур амьсгалын өөрчлөлттэй холбоотой мэдээлэл солилцож буйг хэлнэ.
Даван туулах стратеги	Даван туулах стратеги гэдэг нь "хямрал, нөхцөл байдал, бэрхшээлийг даван туулахад ашигладаг зан үйл, танин мэдэхүйн тактикийг" хэлдэг

1 UNFCCC, Уур амьсгалын өөрчлөлтийн нэр томьёоны тайлбар, товчлол <https://unfccc.int/process-and-meetings/the-convention/glossary-of-climate-change-acronyms-and-terms>

2 Ibrahim G. Badran, Knowledge, attitude and practice the three pillars of excellence and wisdom: a place in the medical profession, 1995 https://apps.who.int/iris/bitstream/handle/10665/116905/emhj_1995_1_1_8_16.pdf?sequence=1&isAllowed=y

3 Robert Treveltham, Нийгмийн эрүүл мэндийн судалгаан дах ойлголт, мэдлэгийг үнэлэх нь , 2017 <https://www.ncbi.nlm.nih.gov/pmc/articles/PMC5545880/>

4 ibid

5 UN, Уур амьсгалын өөрчлөлт гэж юу вэ?

Нэр томьёо	Тодорхойлолт
Хүлэмжийн хийнүүд (GHG)	Дулааныг агаар мандалд барьж буй хийг хүлэмжийн хий гэж нэрлэдэг. ⁶ Агаар мандал дах эдгээр хий нь дэлхийн дулаарал, уур амьсгалын өөрчлөлтийн гол учир шалтгаан юм. Дэлхийн агаар мандалд зонхилох хүлэмжийн хийнүүд нь нүүрс төрөгчийн дахар исэл (CO ²), метан (CH ⁴), нитро буюу N ² O гэсэн хийнүүд юм. Тархалт багатай боловч маш хүчтэй хүлэмжийн хий нь гидрофтор нүүрстөрөгч (HFCs), перфтор нүүрстөрөгч (PFC) болон хүхрийн гексафторид (SF ⁶) юм. ⁷
Мэдлэг (уур амьсгалын өөрчлөлтийн талаарх)	Мэдлэг нь 'шинжлэх ухааны' ойлголт, мэдлэгийн цогц юм. Мөн төсөөлсөн бодох чадавх, аливаа зүйлсийг ойлгож буй арга зам юм ⁸ . Уур амьсгалын өөрчлөлтийн талаарх мэдлэгийг маш олон талаас нь судалж болох боловч гол төлөв уур амьсгалын өөрчлөлтийн талаарх ерөнхий мэдлэг, уур амьсгалын өөрчлөлтийн учир шалтгаан, үр дагаврын талаарх мэдлэг, уур амьсгалын өөрчлөлтийн үр нөлөөний талаарх мэдлэг зэргийг голчлон авч үздэг. ⁹
Хэвлэл хэрэглээ мэдээллийн	Хэвлэл мэдээллийн хэрэглээ гэдэг нь хэвлэл мэдээллийн хэрэглэгчдийн (үзэгчдийн) телевиз, сонин, радио, интернэт зэрэг олон нийтийн мэдээллийн хэрэгслийн платформ дээр хуваалцсан мэдээллийг хэрэглэх зан төлөвт хийсэн дүн шинжилгээ.
Бууруулах	Уур амьсгалын өөрчлөлтийн асуудлын хүрээнд, бууруулах үйл ажиллагаа гэдэг нь хүлэмжийн хийн эх үүсвэрийг багасгах, шингээлтийг нэмэгдүүлэхэд чиглэсэн хүмүүсийн авч хэрэгжүүлж буй нөлөөллийн ажил юм. Тухайлбал, аж үйлдвэрийн үйл явц эсвэл цахилгаан эрчим хүч үйлдвэрлэхэд шатдаг түлшийг илүү үр ашигтайгаар ашиглах, нарны эрчим хүч эсвэл салхины эрчим хүч рүү шилжих, барилга байгууламжийн дулаалгыг сайжруулах, агаар мандлаас илүү их хэмжээний нүүрстөрөгчийн давхар ислийг барьж авах буюу зайлуулахын тулд ой мод болон бусад «шингээгч» -ийг өргөжүүлэх зэрэг орно. ¹⁰
Үндэсний тайлан-илтгэл	Конвенцод (болон Протоколд) заасны дагуу, уур амьсгалын өөрчлөлттэй тэмцэх талаар авч хэрэгжүүлсэн үйл ажиллагааныхаа талаар бусад талууддаа мэдээлдэг баримт бичиг. Одоогийн байдлаар, хөгжингүй орнуудынх ихэнх нь тав дахь үндэсний тайлан-илтгэлээ илгээсэн байгаа бөгөөд хөгжиж буй орнуудын олонх нь үндэсний анхны тайлан-илтгэлээ илгээж, хоёр дахь тайлан-илтгэлээ бэлтгэх шатандаа явж байна. ¹¹
Үндэсний хэмжээнд тодорхойлсон хувь нэмэр	Парисын хэлэлцээрийн 4-р зүйлийн 2-р хэсэгт зааснаар, талууд өөрсдийн оруулахыг зорьж буй үндэсний хэмжээний хувь нэмрээ тодорхойлж, хэрэгжүүлж, тогтворжуулах үүрэгтэй. Талууд нь тодорхойлсон хувь нэмрийнхээ хүрээнд тавьсан зорилгодоо хүрэхийн тулд дотоодоо нөлөөллийг бууруулах арга хэмжээ авахыг эрмэлзэнэ. ¹²
Дадал	Дадал, зан төлөв нь өдөөлтөд хариу үйлдэл үзүүлэх хувь хүний ажиглаж болохуйц үйлдэл юм. ¹³
Тэсвэртэй байвал	Хувь хүн, өрх, олон нийт болон үндэстнүүдийн уур амьсгалын цочролыг тэсэж гарах, түүнээс эргэн сэргэх чадавх бөгөөд урт хугацааны цочрол, тодорхойгүй байдалд дасан зохицох чадавх юм.
Эмзэг байдал (уур амьсгалын өөрчлөлтөд)	Эмзэг байдал нь гэдэг нь тухайн систем нь уур амьсгалын өөрчлөлтийн сөрөг нөлөөлөлд өртөмтгий, даван туулах чадамжгүй байдлын зэргийг нь илтгэн харуулдаг. Эмзэг байдал бол тухайн системийн өртөж буй уур амьсгалын өөрчлөлтийн шинж байдал, цар хүрээ, хэр хэмжээ болон мэдрэг байдал, дасан зохицох чадавхыг нь харуулдаг. ¹⁴
Эмзэг бүлгүүд	Уур амьсгалын өөрчлөлтөөс үүдэлтэй нөлөөлөлд илүү эмзэг, өртөмтгий бүлгүүд ба олон нийт. ¹⁵

6 АНУ Байгаль Орчныг Хамгаалах Агентлаг, Хүлэмжийн хийн тойм [Overview of Greenhouse Gases | US EPA](#)

7 НҮБ/УАӨСК, Уур амьсгалын өөрчлөлтийн нэр томьёо, товчлолын тайлбар

8 Médecins du Monde, Мэдлэг, Хандлага, Дадлын Судалгааны Загвар – Мэдлэг, Хандлага, Дадал, 2011

9 Gazzaz & Aldeseet, Шинжлэх Ухаан, Хөдөө Аж Ахуйн Чиглэлийн Оюутнуудын Уур Амьсгалын Өөрчлөлтийн Талаарх Мэдлэгийн Түвшиний Үнэлгээ, 2021

10 НҮБ/УАӨСК, Уур амьсгалын өөрчлөлтийн нэр томьёо, товчлолын тайлбар

11 ibid

12 ibid

13 Médecins du Monde, Мэдлэг, Хандлага, Дадлын Судалгааны Загвар – Мэдлэг, Хандлага, Дадал, 2011 <https://www.im-portal.org/help-library/the-kap-survey-model-knowledge-attitude-and-practices>

14 ibid

15 НҮБ, Уур Амьсгалын Өөрчлөлтийн Тухай Конвенцын Хүрээ, 2018

Хавсралт 2. Түүвэрлэлт ба жинлэлтийн тайлбар

Түүвэрлэлтийн хүрээ ба стратеги

Ажлын даалгавар болон техникийн саналд өгсний дагуу, IRIM нь олон үе шаттай давхраат кластерын түүврийн аргыг ашиглан үндэсний хэмжээнд төлөөлөхүйд судалгааг гүйцэтгэсэн. Нийт түүврийн давхрааг харьцангуй ижил төрөл рүү шилжүүлэх нь давхраа доторх хазайлт, холбогдох түүврийн алдааг багасгах замаар судалгааны үр дүнг илүү нарийвчилдаг. Энэ нь хамгийн үр дүнтэй, зардал хэмнэдэг арга юм. Давхраат түүврийг нэг нэгээс нь хараат бусаар сонгож авна.

Хүснэгт 20 Судалгааны түүвэрлэлтийн үе шат

	Үе шат-1	Үе шат-2	Үе шат-3	Үе шат-4	Үе шат-5
Түүврийн нэгж	Аймаг/Дүүрэг	Сум/Хороо	Баг/хэсэг	Өрх	Судалгаанд оролцогч
Түүврийн хүрээ	13 аймаг 9 дүүрэг: Үндэсний статистикийн хорооны албан ёсны статистик	Сум/хороогоо түүвэрлэнэ	Сум/хорооноос баг/ хэсгээ түүвэрлэнэ.	Баг/хэсгээс судалгаанд оролцох өрхөө түүвэрлэнэ.	Өрхөөс судалгаанд оролцох 18-аас дээш насны оролцогчийг сонгоно.
Түүврийн арга	Санамсаргүй түүврийн аргаар Аймаг/дүүргийг сонгоно.	Энгийн санамсаргүй түүврийн аргаар түүвэрлэсэн аймаг/дүүргүүдээс сум/ хороодыг сонгоно.	Түүвэрлэсэн сум/хороодоос баг/хэсгээ энгийн санамсаргүй түүвэрээр түүвэрлэнэ	Түүвэрлэсэн баг/хэсэг бүрээс өрхүүдийг санамсаргүй байдлаар сонгож авна	Квотын түүвэрлэлт болон Kish Grid арга

Түүврийн гол нэгж нь аймаг/дүүрэг бөгөөд давхраа тус бүрд санамсаргүйгээр сонгосон. Үүний дараа, ижил түүвэрлэлтийн арга зүйг ашиглан сум болон хороог сонгож авсан. Энэхүү аргыг баг болон хороог (1-ээс 3-р шат) сонгохдоо мөн ашигласан. Түүвэрлэлтийн 4-р шатанд, кластер доторх түүврийн хазайлтыг зохист хэмжээнд барихын тулд системчилсэн түүвэрлэлтийн аргыг ашиглан сонгогдсон баг/хэсэг тус бүрээс санамсаргүй байдлаар 20 өрхийг сонгож авна. Кластер тус бүр дэх эдгээр 20 өрх нь уг түүврийн дизайныг зардал/цаг хугацааны хувьд үр ашигтай, чанартай/үр дүнтэй болгож өгдөг. Кластерын тоо нь нийт хүн амтай пропорциональ байна.

Түүврийн хэмжээ

Нийт 5 давхраа – бүсүүд байна. Давхраа тус бүрийн түүврийн хэмжээг тооцохдоо дараах томъёог ашигласан¹⁶.

Үүнд,

n = h давхраанаас сонгогдсон хүний тоо

N = нийт хүн амын тоо (эсвэл 'хүн ам')

h = h давхраа дах нийт хүн амын тоо

= давхраа дах h хүн амын хазайлт

16 Richard L. Scheaffer, William Mendenhall III et al., (2006). Elementary Survey Sampling, Sixth Edition; and United Nations New York., (2005). Household Sample Surveys in Developing and Transition Countries

e = алдааны хязгаар

z = ач холбогдлын түвшний хязгаарын утга

$deff$ = дизайны нөлөө

gr = хариулт болон хамрах хүрээний тохируулга

18 болон түүнээс дээш насны хүмүүсийн тоог нарийн тодорхойлох боломжгүй. Хамгийн оновчтой түүврийн хэмжээг тодорхойлохын тулд бидэнд Монгол Улс дах 18-аас дээш насны хүн амын тоо шаардлагатай. Гэвч ҮСХ-оос ашигладаг насны бүлэг нь зөвхөн 15-аас 19 насны бүлгээс эхэлдэг. Тиймээс, судалгааны багш 15-аас 19 насны хүмүүсийн тоог ашиглан түүврийн оновчтой хэмжээг тооцсон бөгөөд зорилтот хүн амын тоо их байх тусам (18 болон түүнээс дээш насныхан бүс 15 болон түүнээс дээш насныхан болж өөрчлөгдсөн) түүврийн хэмжээ их байна гэсэн үг юм. Тиймээс, түүврийн оновчтой хэмжээг тодорхойлохдоо 15 болон түүнээс дээш насны хүмүүсийн тооноос тооцсон бөгөөд энэ нь 18 болон түүнээс дээш насны хүн амыг үндэсний хэмжээнд төлөөлөхүйд болж чадна.

Хүснэгт 21 Түүврийн хүрээ

18 болон түүнээс дээш насны хүн ам	
	2021 оны байдлаар, нийт хүн амын дунд 15 болон түүнээс дээш настай 2,227,674 хүн бүртгэлтэй байна. Үүнийг давхаагаар нь хуваан авч үзвэл: Баруун бүс: 276,735, Хангайн бүс: 415,216, Төвийн бүс: 352,828, Зүүн бүс: 154,558, Улаанбаатар: 1,028,337
h	(нийт өрхийн тоонд харгалзах тухайн давхраа дах өрхүүдийн харьцаа): Баруун бүс: 0.12, Хангайн бүс: 0.19, Төвийн бүс: 0.16, Зүүн бүс: 0.07, Улаанбаатар: 0.46.
Z	Ач холбогдлын түвшин 95%, z тархалтын хязгаарын утга нь 1.96
	Давхраа тус бүрд -ыг тооцох нь боломжгүй. Тиймээс, бид үүнийг -ээр орлуулах бөгөөд, -г 0.5 хэмээн таамагласан.
e	0.028
	Энэхүү загварын үр нөлөөг тооцох боломжгүй байсан тул Монголд нийтлэг ашиглаж буй туршлагын дагуу (ҮСХ-ны өрхөд суурилсан түүвэр судалгаа) уг түвшнийг 2.0 байхаар тооцлоо.
	Хариултын хувь нь $\geq 80\%$. Үндэсний хэмжээнд төлөөлөхүйд судалгаануудад судалгааны хариултын хувь нь 90% байдаг. Тиймээс, энэхүү судалгааны хариултын хувь нь, 1.1 байна.
n	2,800

Эх сурвалж: Багийн тооцоолол

18 болон түүнээс дээш насныхныг үндэсний хэмжээнд төлөөлөхүйд судалгааны түүврийн оновчтой хэмжээ нь 2,800 бөгөөд хариултын хувийг 90% байна гэж тооцсон болно.

Түүврийн хуваарилалт

Бодит байдал дээр, давхаргын хэмжээ ихээхэн ялгаатай байдаг тул бид пропорциональ хуваарилах аргыг голчлон ашигладаг. Бид мөн энэхүү аргыг ашигласан.

Эдгээр хувийн жинг ашиглан давхарга бүрээс түүвэрлэж авсан 18 ба түүнээс дээш насны хүмүүсийн тоог доор харуулав.

Хүснэгт 22 Зорилтот хүн ам, кластерын тоо

Бүс нутаг	Түүврийн үндсэн нэгж	Зорилтот хүн ам (мянга)		Кластер	
		Хот	Хөдөө	Хот	Хөдөө
Төв	4	104,935	154,371	10	12
Хангай	4	142,783	163,639	11	15
Баруун	3	58,894	117,926	6	11
Зүүн	2	46,769	63,796	4	6
Улаанбаатар	7	1,028,337	0	65	-
Нийт	20	1,381,718	499,732	96	44

Эх сурвалж: ҮСХ ба багийн тооцоолол

Түүврийн жин

Түүврийн дизайны хүрээнд пропорциональ бус хуваарилалт бүхий түүвэрлэлтийг ашигласан учраас түүвэр дэх 18 болон түүнээс дээш насны хүмүүсийн тоо, хүйс болон насны төлөөлөхүйц байдлыг хангахын тулд судалгааны үр дүнд шинжилгээ хийхдээ түүврийн жинлэлтийг хийх шаардлагатай. Давхаргажилтын дараах жинлэлтийг тооцохдоо, дараах томъёог ашигласан.

Үүнд, нь давхаргажилтыг илэрхийлнэ.

Үүний дараагаар, судалгааны баг нь урвуу магадлалын жинг ашиглаж сүүлийн жинг тодорхойлно.

Энэхүү жинг зорилтот бүлэгт энэ дээжийг түгээхэд ашигладаг. Энэхүү эцсийн жингээр үржүүлснээр ажиглалтын тоо нь 1.3 сая орчим буюу зорилтот хүн ам болж байна гэсэн үг. Тиймээс энэхүү стандарт ажиллагаа нь дундаж утгыг ашиглан энэ жинг түүвэрт хэвийн болгох явдал юм. Хэвийн байдалд оруулсны дараа түүврийн хэмжээ 2,804 болно. Энэ түүвэр нь хүйс болон насны хувьд зорилтот хүн амыг статистикийн хувьд төлөөлнө.

Түүврийн алдааны тооцоолол

Түүвэр судалгаануудад нөлөөлдөг хоёр төрлийн мэдээллийн алдаа байдаг: (1) түүвэрлэлтийн алдаа, (2) түүвэрлэлтийн бус алдаа. Түүвэрлэлтийн алдаа нь сонгогдсон өрхүүд нь түүврийн хүрээнээс сонгогдож болохуйц олон боломжит түүврийн нэг байхтай холбоотой үүсдэг түүвэрлэлтийн алдаа юм. Эдгээрийн аль аль нь бие биеэсээ ялгаатай үр дүнг бий болгох бөгөөд нийт хүн амаас ялгаатай байх магадлалтай. Түүврийн бус алдаа нь асуумж боловсруулалт, мэдээлэл цуглуулалт, мэдээлэл боловсруулалт зэрэг судалгааны бүхий л үйл ажиллагааны явцад гарах магадлалтай. Түүвэрлэлтийн алдааг түүвэрлэлтийн стандарт алдааг тооцох замаар тоогоор илэрхийлж болдог бол, түүвэрлэлтийн бус алдааг статистикийн хувьд үнэлэхэд бэрхшээлтэй байдаг.

Дараах арга замуудыг авч хэрэгжүүлнэ:

- Стандарт алдаа, нарийвчлалтай байдлын тооцоолол.
- 95%-н итгэх түвшин, боломжит түүврийн үр дүнгийн 95% нь онох магадлалтай утгын хязгаар giving the range of values within which 95% of possible sample results is expected to fall.
- Харьцангуй алдаа, стандарт алдааны ач холбогдлын тооцоолол.

Those measures indicate the statistical reliability of this survey, for key indicators next to the point estimate.

Эдгээр арга хэмжээнүүд нь гол шалгуур үзүүлэлтүүдийн судалгааны статистикийн хувьд найдвартай байдлыг нь илтгэн харуулах бөгөөд

Судалгаанд оролцогчдыг сонгох шалгуур

Судалгаанд оролцогч нь дараах шалгуурыг хангасан байх ёстой.

- Сүүлийн 6 сарын хугацаанд тухайн өрхийн гишүүнээр бүртгэгдсэн байх,
- 18 болон түүнээс дээш настай байх.
- Өрхийн орлого болон бусад дэлгэрэнгүй асуултуудад хариулт өгч чадахуйц байх.

Судалгаанд оролцогчдын эрэгтэй, эмэгтэй хүйсийн тэнцвэрийг хангах үүднээс, эхний оролцогч эрэгтэй байсан бол дараагийн оролцогчоор эмэгтэй хүнийг сонгон авна.

Хүснэгт 23 Түүврийн хэмжээ, түүврийн нэгжээр (n=2,800)

Бүс нутаг	Үе шат			Түүврийн хэмжээ	Бүс нутаг	Үе шат			Түүврийн хэмжээ
	I	II	III			I	II	III	
Төвийн бүс	Дархан	Дархан	I, VII, XIII, XVII	80	Баруун бүс	Баян-Өлгий	Өлгий	VIII, XI	40
		Хонгор	III	20			Буянт	III, IV	40
	Сэлэнгэ	Сүхбаатар	III, VII	40			Ногооннуур	VI, VIII	40
		Мандал	II, VIII	40		Увс	Улаангом	III, XI	40
		Шшаамар	I, III	40			Баруунтуруун	I, II	40
	Төв	Зуунмод	II, VI	40			Түргэн	III	20
		Баянхангай	I, II	40		Завхан	Улиастай	I, II	40
		Заамар	I, III	40			Алдархаан	II, V	40
	Өмнөговь	Даланзадгад	I, V	40			Яруу	II, III	40
		Мандал-Овоо	I, II	40		Зүүн бүс	Дорнод	Хэрлэн	VII, VIII
Номгон		I	20	Баян-Уул	III, VI			40	
Хангайн бүс	Баянхонгор	Баянхонгор	II, IV	40	Халх гол			I, V	20
		Баян-Өндөр	II, IV	40	Хэнтий	Хэрлэн	I, V	40	
		Галуут	IV, V	40		Биндэр	III, VI	40	
	Орхон	Баян-Өндөр	I, IX, XIII, XIV, XXI	100		Өмнөдэлгэр	V, VII	20	
		Жаргалант	I, IV	40	Улаанбаатар	Баянгол	Хороо	-	160
	Өвөрхангай	Арвайхээр	III, XII	40		Баянзүрх	Хороо	-	200
		Баян-Өндөр	II, III	40		Налайх	Хороо	-	40
		Хужирт	I, II	40		Сонгинохайрхан	Хороо	-	320
	Хөвсгөл	Мөрөн	II, X	40		Сүхбаатар	Хороо	-	200
		Алаг-Эрдэнэ	III, IV	40	Хан-Уул	Хороо	-	180	
Галт		III, IV	40	Чингэлтэй	Хороо	-	200		
Цагааннуур		I	20						

Хавсралт 3. Судалгаанд оролцогчдын шинж чанар¹⁷

Хүснэгт 24 Судалгаанд оролцогчдын тоо, бүс нутаг, байршлаар, болон хүйсээр

Бүс нутаг	Хот/Хөдөө		Хүйс		Нийт
	Хот	Хөдөө	Эмэгтэй	Эрэгтэй	
Баруун	121	224	162	183	345
Хангай	212	331	289	254	543
Төв	187	262	243	207	449
Зүүн	35	178	116	97	213
Улаанбаатар	1253	0	645	608	1253
Нийт	1808	995	1455	1349	2803

Хүснэгт 25 Судалгаанд оролцогчдын тоо, аймгаар, хүйсээр, болон насны ангиллаар

	Хүйс		Насны бүлэг				Нийт
	Эмэгтэй	Эрэгтэй	18-24	25-34	35-59	>60	
Завхан	53	64	10	26	65	15	116
Баян-Өлгий	63	70	29	33	61	10	133
Увс	47	49	2	23	54	16	95
Орхон	84	44	11	23	65	29	128
Өвөрхангай	56	69	19	29	59	18	125
Баянхонгор	56	64	5	31	68	18	122
Хөвсгөл	93	78	61	44	55	11	171
Төв	64	68	30	29	59	14	132
Сэлэнгэ	76	46	13	24	73	10	120
Дархан-Уул	54	36	16	20	39	14	89
Өмнөговь	49	57	23	26	44	14	107
Дорнод	61	39	16	28	43	11	98
Хэнтий	55	58	31	29	41	14	115
Улаанбаатар	645	608	285	315	529	124	1253
Нийт	1456	1350	551	680	1255	318	2804

17 Тоог бүхэл утгаар нь харуулсан учир эдгээр хэсэгт харуулж буй тоонуудын нийлбэр нь нийт судалгаанд оролцогчдын тоотой (n=2804) эн тэнцүү харагдахгүй байж болзошгүй.

Хүснэгт 26 Судалгаанд оролцогчдын тоо, хүйсээр, насны бүлгээр, болон бүс нутгаар

Хүйс	Насны интервал	Бүс нутаг					Нийт
		Баруун	Хангай	Төв	Зүүн	Улаанбаатар	
Эмэгтэй	18-19	8	20	25	6	71	130
	20-24	12	25	17	18	68	140
	25-29	10	33	25	10	72	150
	30-34	27	34	26	18	83	188
	35-39	27	36	25	6	73	167
	40-44	16	23	29	10	66	144
	45-49	14	24	27	12	55	132
	50-54	12	23	21	8	49	113
	55-59	13	23	16	10	37	99
	60-64	8	16	13	8	32	77
65-69	5	10	7	6	18	46	
70+	11	21	11	3	20	66	
Эрэгтэй	18-19	5	28	17	10	76	136
	20-24	17	21	23	13	69	143
	25-29	23	23	26	14	68	154
	30-34	22	38	22	15	91	188
	35-39	23	18	27	10	85	163
	40-44	25	27	22	8	55	137
	45-49	22	28	18	5	47	120
	50-54	22	20	14	4	38	98
	55-59	8	22	18	10	25	83
	60-64	9	13	7	3	25	57
65-69	3	8	7	2	13	33	
70+	4	8	7	3	17	39	
Total		346	542	450	212	1253	2803

Хүснэгт 27 Судалгаанд оролцогчдын тоо, боловсролын түвшин, бүс нутгаар

	Баруун	Хангай	Төв	Зүүн	Улаанбаатар	Нийт
Боловсролгүй	9	5	0	2	3	19
Бага	22	38	15	5	15	95
Дундаас доогуур	62	95	70	43	70	340
Бүрэн дунд	146	263	208	79	617	1313
Техникийн	13	23	25	12	40	113
Мэргэжлийн	14	10	18	2	36	80
Дипломын (Бакалаврын бүс)	10	15	10	3	24	62
Дээд (бакалавр)	64	88	92	63	390	697
Дээд (магистр)	6	7	11	2	53	79
Доктор болон түүнээс дээш	0	0	0	2	4	6
Нийт	346	545	449	213	1253	2804

Хүснэгт 28 Судалгаанд оролцогчдын тоо, боловсролын түвшингээр, насны бүлгээр, хүйсээр

	Хүйс		Насны бүлэг				Нийт
	Эмэгтэй	Эрэгтэй	18-24	25-34	35-59	>60	
Боловсролгүй	13	7	0	4	12	4	20
Бага	52	43	0	11	46	37	95
Дундаас доогуур	161	179	38	45	183	75	340
Бүрэн дунд	645	668	394	240	585	94	1313
Боловсролгүй	62	51	8	12	56	36	113
Бага	45	35	8	17	41	13	80
Дундаас доогуур	45	17	11	11	25	14	62
Бүрэн дунд	393	304	91	312	259	34	697
Боловсролгүй	38	41	0	28	42	8	79
Бага	1	5	0	1	6	0	6
Дундаас доогуур	1455	1350	550	681	1255	315	2805

Хүснэгт 29 Судалгаанд оролцогчдын тоо, гэрлэлтийн байдал, бүс нутгаар

	Баруун	Хангай	Төв	Зүүн	Улаанбаатар	Нийт
Огт гэрлэж байгаагүй	40	94	95	36	352	617
Гэрлэсэн: батлуулсан	242	324	229	114	557	1466
Гэрлэсэн: батлуулаагүй	15	47	79	42	199	382
Хамтран амьдрагчтай	4	19	0	4	24	51
Тусдаа амьдардаг	6	5	2	1	8	22
Салсан	2	10	11	7	52	82
Бэлэвсэн	36	44	34	9	62	185
Нийт	345	543	450	213	1254	2805

Хүснэгт 30 Судалгаанд оролцогчдын тоо, гэрлэлтийн байдал, насны бүлгээр

	Хүйс		Насны бүлгээр				Нийт
	Эмэгтэй	Эрэгтэй	18-24	25-34	35-59	>60	
Огт гэрлэж байгаагүй	276	341	438	125	53	1	617
Гэрлэсэн: батлуулсан	747	719	36	370	877	183	1466
Гэрлэсэн: батлуулаагүй	193	189	62	156	155	9	382
Хамтран амьдрагчтай	23	28	11	12	26	2	51
Тусдаа амьдардаг	13	8	2	6	11	3	22
Салсан	50	32	0	10	62	10	82
Бэлэвсэн	152	32	1	2	71	109	183
Нийт	1454	1349	550	681	1255	317	2803

Хүснэгт 31 Судалгаанд оролцогчдын тоо, ажил эрхлэлтийн байдал болон бүс нутгаар

	Баруун	Хангай	Төв	Зүүн	Улаанбаатар	Нийт
Цалинтай ажил	227	357	288	135	731	1738
Хувиараа бизнес эрхлэгч:	133	203	118	67	186	707
Ажилгүй	38	19	14	16	51	138
Ажиллах хүчнээс гадуурх оролцогч	80	167	148	61	470	926
Нийт	345	543	450	212	1252	2802

Хүснэгт 32 Судалгаанд оролцогчдын тоо, хүйс, насны бүлгээр

	Хүйс		Насны бүлэг				Нийт
	Эмэгтэй	Эрэгтэй	18-24	25-34	35-59	>60	
Цалинтай ажил	764	974	246	519	913	61	1739
Хувиараа бизнес эрхлэгч:	271	436	84	180	398	46	708
Ажилгүй	65	74	32	36	71	0	139
Ажиллах хүчнээс гадуурх оролцогч	625	301	272	127	271	256	926
Нийт	1454	1349	550	682	1255	317	2804

Хүснэгт 33 Судалгаанд оролцогчдын тоо, эдийн засгийн үйл ажиллагаа, бүс нутгаар

	Баруун	Хангай	Төв	Зүүн	Улаанбаатар	Нийт
МАА	105	155	95	51	12	418
Газар тариалан	14	9	9	1	5	38
Ойн аж ахуй, загасчлал, ан агнуур	0	0	1	3	2	6
Уул уурхай	3	9	12	2	47	73
Боловсруулах үйлдвэрлэл	5	7	5	0	44	61
Цахилгаан, хий, уур, агааржуулалт	4	5	4	2	16	31
Ус хангамж,	1	5	4	3	14	27
Барилга	9	24	9	2	115	159
Худалдаа	11	35	23	10	118	197
Тээвэр	6	7	19	4	27	63
Зочид буудал, байр, сууц болон нийтийн хоолны үйлчилгээ	11	15	8	3	42	79
Мэдээлэл, харилцаа холбоо	0	2	1	2	22	27
Санхүү	2	3	5	3	29	42
Үл хөдлөх	0	0	0	0	2	2
Мэргэжлийн үйл ажиллагаа	4	3	7	2	18	34
Захиргааны, удирдлагын үзүүлэх үйл ажиллагаа	2	20	31	7	57	117
Төрийн удирдлага, батлан хамгаалах	10	31	18	15	48	122
Боловсрол	25	28	31	10	51	145
Хүний эрүүл мэнд, нийгмийн хамгаалал	13	12	10	2	44	81
Үзвэр үйлчилгээ, тоглоом наадам	1	0	4	17	16	38
Олон улсын байгууллагууд	0	0	2	0	2	4

Өрхийн үйл ажиллагаа	3	1	1	4	13	22
Бусад	0	1	0	0	1	2
Нийт	229	372	299	143	745	1788

Хүснэгт 34 Судалгаанд оролцогчдын тоо, эдийн засгийн үйл ажиллагаа, хүйс, насны бүлгээр

	Хүйс		Насны бүлэг				Нийт
	Эмэгтэй	Эрэгтэй	18-24	25-34	35-59	>60	
МАА	182	236	72	90	219	38	419
Газар тариалан	14	24	4	5	28	1	38
Ойн аж ахуй, загасчлал, ан агнуур	1	5	2	1	3	0	6
Уул уурхай	5	67	8	24	41	0	73
Боловсруулах үйлдвэрлэл	30	31	6	17	36	2	61
Цахилгаан, хий, уур, агааржуулалт	5	26	4	11	16	1	32
Ус хангамж,	9	18	2	5	20	0	27
Барилга	23	137	15	55	87	2	159
Худалдаа	100	97	26	66	101	5	198
Тээвэр	12	51	5	21	35	2	63
Зочид буудал, байр, сууц болон нийтийн хоолны үйлчилгээ	44	35	23	21	33	1	78
Мэдээлэл, харилцаа холбоо	10	16	5	12	9	1	27
Санхүү	24	17	6	19	17	0	42
Үл хөдлөх	0	2	0	0	2	0	2
Мэргэжлийн үйл ажиллагаа	13	20	8	10	14	1	33
Захиргааны, удирдлагын үзүүлэх үйл ажиллагаа	88	29	6	26	83	2	117
Төрийн удирдлага, батлан хамгаалах	49	73	15	49	55	2	121
Боловсрол	97	48	26	40	76	2	144
Хүний эрүүл мэнд, нийгмийн хамгаалал	53	27	3	33	42	1	79
Үзвэр үйлчилгээ, тоглоом наадам	13	25	8	14	16	1	39
Олон улсын байгууллагууд	3	0	2	0	2	0	4
Өрхийн үйл ажиллагаа	9	13	2	6	13	1	22
Бусад	0	3	0	1	1	0	2
Нийт	784	1000	248	526	949	63	1786

Хүснэгт 35 Судалгаанд оролцогчдын тоо, эдийн засгийн үйл ажиллагаа, бүс нутгаар

	Бүс нутаг					Нийт
	Баруун	Хангай	Төв	Зүүн	Улаанбаатар	
Цалин (мөнгө болон орлого)	271	368	382	162	512	1695

Борлуулалтын орлого (МАН-н бүтээгдэхүүн)	134	199	129	66	34	562
Борлуулалтын орлого (ХАА-н бүтээгдэхүүн)	22	5	16	2	5	50
Өрхийн бизнесийн орлого	18	72	61	17	195	363
Улсаас өгөх тэтгэвэр	73	130	121	63	238	625
Тэтгэмж	275	396	302	143	887	2003
Өрхийн аж ахуйгаас үнэгүй авсан зүйл	2	30	21	53	17	123
Бусдаас үнэгүй авсан зүйл	2	1	3	7	87	100
Бусад орлогын эх үүсвэр	3	4	3	5	40	55
Нийт	800	1205	1038	518	2015	5576

Хүснэгт 36 Судалгаанд оролцогчдын тоо, борлуулалтын орлого, эдийн засгийн үйл ажиллагаа, хүйс, насны бүлгээр

	Хүйс		Насны бүлэг			Нийт	
	Эмэгтэй	Эрэгтэй	18-24	25-34	35-59	>60	
Цалин (мөнгө болон орлого)	854	839	366	500	778	49	1693
Борлуулалтын орлого (МАН-н бүтээгдэхүүн)	266	295	111	126	274	51	562
Борлуулалтын орлого (ХАА-н бүтээгдэхүүн)	25	24	1	10	34	4	49
Цалин (мөнгө болон орлого)	161	202	63	99	181	20	363
Улсаас өгөх тэтгэвэр	354	270	64	74	210	276	624
Тэтгэмж	1074	929	342	577	933	151	2003
Өрхийн аж ахуйгаас үнэгүй авсан зүйл	63	56	28	20	58	13	119
Бусдаас үнэгүй авсан зүйл	60	40	28	18	49	5	100
Бусад орлогын эх үүсвэр	29	25	16	12	22	4	54
Нийт	2886	2680	1019	1436	2539	573	5567

Хүснэгт 37 Судалгаанд оролцогчдын тоо, сууцны төрөл, бүс нутгаар

	Баруун	Хангай	Т в	З н	Улаанбаатар	Нийт
Гэр	191	303	184	67	228	973
Орон сууц	1	20	48	29	637	735
Хашаа байшин	151	213	204	112	356	1036
Амины орон сууц	2	2	7	0	23	34
Дотуур байр	0	0	0	0	5	5
Ажилчдын нийтийн сууц	0	1	0	0	3	4
Бусад олон нийтийн сууц	0	4	7	4	1	16
Орон гэргий	0	0	0	0	0	0
Бусад	0	0	0	0	0	0
Нийт	345	543	450	212	1253	2803

Хүснэгт 38 Судалгаанд оролцогчдын тоо, сууцны төрөл, хүйс, насны бүлгээр

	Хүйс		Насны бүлэг				Нийт
	Эмэгтэй	Эрэгтэй	18-24	25-34	35-59	>60	
Гэр	509	464	175	224	458	116	973
Орон сууц	375	360	217	191	249	78	735
Хашаа байшин	545	492	148	249	522	117	1036
Амины орон сууц	14	20	2	8	20	5	35
Дотуур байр	1	4	5	0	0	0	5
Ажилчдын нийтийн сууц	2	1	1	1	2	0	4
Бусад олон нийтийн сууц	8	7	3	8	4	1	16
Орон гэргүй	0	0	0	0	0	0	0
Бусад	0	0	0	0	0	0	0
Нийт	1454	1348	551	681	1255	317	2804

Хавсралт 4. Шалгуур үзүүлэлтүүдийн товч тайлбар

Байршил

